



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН


ХУУЛЬ ДЭЭДЛЭХ **ЁС**

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ



2008 №1(20)

ШИНЭ НОМ



Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний төвийн хамтран гаргасан "Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль" ном хэвлэгдэн гарлаа.

Энэ номд Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 2008 оны 2 дугаар сарын 1-нд орсон нэмэлт, өөрчлөлтийг тусган нийтэлжээ.



Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний төв, Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сан хамтран "САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ" нэртэй номыг хэвлүүллээ. Санхүү, бүртгэл, аудит, хяналт шалгалт, татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн харилцаа, аж ахуйн үйл ажиллагаа, өмчийн харилцаанд холбогдох эрх зүйн актуудыг уг номд эмхтгэн нийтэлсэн байна.



2007 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдөр Хууль зүйн үндэсний төвд зохион байгуулагдсан "Монгол ба Буриадын заншил, Заншлын эрх зүй" Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлаар хэлэлцүүлэгдсэн илтгэлүүдийг эмхтгэн "МОНГОЛ БА БУРИАД ЗАНШИЛ, ЗАНШЛЫН ЭРХ ЗҮЙ" номыг гаргажээ. Энэ ном нь Буриад, Монголын заншил, заншлын эрх зүйг харьцуулан судлахад болон хөгжүүлэхэд ач холбогдолтой юм.

ХОЛБОО БАРИХ УТАС: 319144

ЭНЭ ДУГААРТ:

"Эрх зүйт төр-Хууль ёсны хэрэгжилт" Үндэсний зөвлөгөөнд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярын хэлсэн ҮГ4-8

"Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь" /"Эрх зүйт төр-Хууль ёсны хэрэгжилт" Үндэсний зөвлөгөөнд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилын тавьсан илтгэл/.....9-12

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухайд /Цагдаагийн дээд сургуулийн багш, докторант **Б.Нармандах**/.....13-17

Золиослох сэтгэлгээ /Үндсэн хуулийн цэцийн ажилтан **Э.Лхагвасүрэн**/.....18-20

Шүүх эрх мэдэл

Шүүхийн жишгийг ашиглах нь /Өмгөөлөгч /Япон/ **Танабэ Масанори**/.....21-23

Гомдлыг урьдчилан шийдвэрлэх хүрээнд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөлийг үнэлэх асуудал /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан **Б.Эрдэнэхуяа**/.....24-27

Иргэний нэр төрийг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, түүнийг шүүх хэрэглэж буй байдал /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан **Б.Мэргэн**/.....28-31

Криминология

Монгол Улс дахь 2007 оны гэмт хэргийн нөхцөл байдал /ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн дарга, цагдаагийн хурандаа **П.Ихзааяа**/.....32-38

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, арга зүйн зарим асуудал /НЦГ-ын Олон нийтийн харилцааны хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч, магистрант **Л.Цэрэнням**/.....39-41

Шинэ төрлийн зарим гэмт хэргийн шалтгаан, нөхцөл /ХЗУТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр **Г.Оюунболд**/.....42-46

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн асуудалд /ОХУ-ын ДЯА-ны Их сургуулийн докторант, цагдаагийн дэд хурандаа **Г.Гантөмөр**/.....47-53

Эрх зүйч мэргэжилтний бэлтгэх стандарт ба "Криминалистикын хичээл" /НЦГ-ын Эрэлч нохойн алба, үнэрийн лабораторийн эрхлэгч **Б.Жаргалсайхан**/.....54-55

Эрүүгийн эрх зүй дэх давтан гэмт хэргийг авч үзэх нь /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан **С.Энхцэцэг**/.....56-58

Прокурорын байр сууриас Криминологийн асуудалд хандах нь /Сүхбаатар аймгийн прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх, МУИС-ийн докторант **Ц.Мөнхбат**/.....59-60

Прэвний хууль тогтоомж

Хувь хүний нэр төр, алдар хүндийг хамгаалж хүндлэх асуудлын мөн чанар /МУИС-ийн докторант **Ш.Сүхбаатар**/.....61-63

Хөршийн эрх /Хууль зүйн магистр **Н.Баярмаа**/.....64-67

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

Гадаад орнуудын Иргэний эрх зүй болон иргэний хууль тогтоомж дахь "Эзэмшил"-ийн талаарх эрх зүйн зохицуулалт /МУИС-ийн ХЗС-ийн магистрант **А.Дэлгэрмаа**/.....68-74

АНУ-ын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн тухай ойлголтыг авч үзсэн нь /ТЕГ-ын Дээд сургуулийн ахлах багш, докторант **Ц.Доржням**/.....75-78

Гадаад орнууд дахь гадаадын хөрөнгө оруулалтын төлөв байдал, эрх зүйн зохицуулалт /ХЗУТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан **Ж.Соёлмаа**/.....79-81

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Ял ногдуулах нийтлэг зарчим, түүний хэрэгжилт /Цагдаагийн академийн магистрант, цагдаагийн ахмад **Д.Батжаргал**/.....82-83

Монгол Улсын дээд шүүхийн тогтоол

Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай /Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдөр, Дугаар 9 /.....84-88

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай /Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2008 оны 3 дугаар сарын 7-ны өдөр, Дугаар 11 /.....89

Монгол Улсын Олон улсын эрх зүйн төлөөлөгч 80 жилийн өдөр

Энэрэнгүй үйлстний байгууллага /Өмгөөлөгч **Д.Тогтохжаргал** /.....90-92

359

CONTENT:

President of Mongolia N Enkhbayal speech on the Symposium "Rule of law and law implementation".....	4-8
Minister of Justice and Home Affairs Ts Munkh-Orgil report on "Development of work impact" on the Symposium "Rule of law and law implementation".....	9-12
International Law	
About Amendments to the Constitution /Narmandakh B., Teacher, Police Academy, Ph.D candidate/.....	13-17
Sacrifice thinking /Lkhagvasuren.E, Officer of the Constitutional Court's department/.....	18-20
Judicial precedent	
Use of the Judicial precedent /Tanabe Masanori, an advocate (Japanese)/.....	21-23
Administrative Court evaluation of establishing right to claim by resolving crime within pretrial procedure /Erdenekhuyag.B, Student, Mongolian National University Law school/.....	24-27
Legal regulation about reputation protection of citizens and its statement implemented by Court /Mergen.B, Student, Mongolian National University Law school/.....	28-31
Criminology	
Criminal situation in Mongolia, in 2007 /Ikhsaya.P, The colonel of police, Head of information and research, General Police Department/.....	32-38
Theory and methodological issues on crime prevention /Tserennyam.L, The mayor of police, Senior inspector of Metropolitan Police Department, master student/.....	39-41
Reason and circumstances of some new typical crimes /Oyunbold.G, Researcher, Criminology research sector of the National legal center, Master/.....	42-46
Issue on legal sources of Mongolian criminal legislation /Gantumur.G, The lieutenant colonel of police, Ph.D candidate, Home Affairs University, Russia/.....	47-53
Standards for preparing the legal professionals and Criminalistics classes /Jargalsaikhan.B, Head of Odontology laboratory, Police canine service of Metropolitan Police Department/.....	54-55
Issuing the subsequent offence in Criminal law /Enkhtsetseg.S, Student, Mongolian National University, Law school/.....	56-58
Prosecutor's point of view about Criminological issues /Munkhbat.Ts, Ph.D candidate, Prosecutor of Sukhbaatar aimag, legal trusted advisor/.....	59-60
International Law	
The nature of guarding and respecting issues of individuals reputation and dignity /Sukhbaatar Sh., Ph.D candidate, Mongolian National University Law school/.....	61-63
Neighbour's rights /Bayarmaa N., Master/.....	64-67
International Law	
Legal regulation on "ownership" in the foreign civil legislation and Civil law /Delgermaa.A, master student, Mongolian National University, Law school/.....	68-74
Concept of Crime in US criminal law /Dorjnyam.Ts, Ph.D candidate, Superior teacher, University of Mongolian intelligence agency/.....	75-78
Tendency of foreign investment in foreign countries and its legal regulation /Soyolmaa.J, Researcher, International law sector of the National legal center/.....	79-81
Judicial execution procedure	
Common principles of sentencing penalty and it's implementation /Batjargal.D, a master student, Police Academy/.....	82-83
Supreme Court's resolution	
Use of universally recognized principles of international treaties to which Mongolia's a party, in Court proceeding /Supreme Court's resolution, Number 9, February, 28, 2008/.....	84-88
Interpreting some provisions of article 33, Law of Mongolia on Disaster prevention /Supreme Court's resolution, Number 11, March, 7, 2008/.....	89
For the Mongolian Association of Advocate's 80th anniversary	
The merciful organization /Togtokhjargal.D, an advocate/.....	90-92

Сэтгүүлийн зөвлөлийн гишүүд:

Ц.БАТ-ОРШИХ Сэтгүүлийн зөвлөлийн ерөнхий эрхлэгч

ГИШҮҮД:

Л.Бямбаа	- Улсын дээд шүүхийн шүүгч, доктор
Д.Даваа-Очир	- Хууль зүйн доктор, хурандаа
Н.Дагва	- Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга
А.Доржготов	- Улсын дээд шүүхийн шүүгч
Э.Лхагвасүрэн	- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
Д.Наранчимэг	- Отгонтэнгэр Их сургуулийн захирал
А.Оюунчимэг	- Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч
Б.Пүрэвням	- Үндсэн хуулийн цэцийн гишүүн
Т.Уранцэцэг	- Сонгино хайрхан дүүргийн шүүхийн шүүгч
Ш.Үнэнтөгс	- ХЗДХЯ-ны мэргэжилтэн
Б.Цэрэнбалтав	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Б.Чимид	- ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор
Н.Чинбат	- Оюуны өмчийн газрын дарга

Дугаарыг эрхэлсэн: Р.Болормаа

Эрхлэн гаргагч: Хууль зүйн үндэсний төв

Редакцын хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7

Утас: 315736 Факс: 315736

Вэб сайт: www.legalcenter.mn

И-мэйл: magazine_info@legalcenter.mn

Улсын бүртгэлийн дугаар: 279

“ЭРХ ЗҮЙТ ТӨР-ХУУЛЬ ЁСНЫ ХЭРЭГЖИЛТ” ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨГӨӨНД МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯРЫН ХЭЛСЭН ҮГ

/2008 оны 2 дугаар сарын 18-ны өдөр, Төрийн ордон/



Монгол Улсын ерөнхийлөгч
Н.ЭНХБАЯР

Эрхэм хүндэт ноёд, хатагтай Та бүхний энэ өглөөний амар амгаланг эрэн мэндчилье.

Бид өнөөдөр манай улс орны өмнө тулгамдаад байгаа нэгэн чухал асуудлыг үндэсний хэмжээнд зөвлөлдөн, оршин буй дутагдал доголдоос хэрхэн ангирах танаар оновчтой шийдлийг хэлэлцэж олохын тулд энд хурал цуглаараад байна. Энэ бол эрх зүйт төрийг төлөвшүүлэх, үүний тулд хууль ёсыг дээдлэх, чандлан хэрэгжүүлэх явдал юм.

Монгол Улс эрх зүйт төртэй Мардчилсан нийгмийг хөгжлийнхөө замнал болгон Үндсэн хуульдаа тодорхойсноос хойш даруй 16 дахь жилтэйгээ золгож байна. Манай ард түмэн ардчилсан ёс, зах зээлийн эдийн засгийн харилцаанд хэвшиж, дадах шилжилтийн үеийн ялангуяа, эдийн засгийн хамгийн хүндрэл бэрхшээлтэй он жилүүдийг ардаа орхисныг нотлох нааштай үзүүлэлтүүд гарч эхэллээ.

Ийм үр дүн гарахын хэрээр шударга ёсыг үгүйлэн нийгмийн мэдрэмж огцом нэмэгдэж байна. Хүмүүс шинэ нийгмийн учир утгыг ойлгож дасах тусмаа усгүйгээр загас амьдрахгүйн нэгэн адил хууль ёсгүйгээр ардчилсан төр оршин тогтнох нөхцөлгүй гэдгийг улам бүр ухаарч, нийгэмд нэгэн үе дур зоргод “бууж өгөх” хандлага давамгайлж байсан нь үндсэндээ өөрчлөгдөж, хууль хэрэгжилтийг хангах, нийтээр хүлээн зөвшөөрсөн сахилга, дэг журмыг хэвшүүлэхийг эрхэмлэн хүсэмжлэх боллоо. Товчхон хэлбэл юуны түрүүн “Ардчилсан нийгэм бол хууль хэрэгждэг, хуульд захирагддаг нийгэм мөн” гэж судлаачид тодорхойлж байна.

Манай ард түмэн эрх зүйт төр, нийгмийн шударга ёсны асуудлыг өнөө маргаашийн амь зуулга, үнэ мөнгөний ханшнаас ч илүү чухалчлан үздэг болжээ гэвэл хэтрүүлсэн болохгүй бизээ.

Төр энэхүү зүй ёсны эрэлт шаардлагад соргог мэдрэмжтэй хандаж, шаардлагатай хариу алхмыг цаг алдалгүй хийх ёстой. Чухамхүү энэ зорилтын үүднээс Ерөнхийлөгч миний бие хууль тогтоох, хэрэгжилтийг нь зохион байгуулах түүнийг хэрэглэх үйл ажиллагаанд шууд оролцдог байгууллага, албан тушаалтан, эрдэмтэд, судлаачид иргэний нийгмийн өргөн төлөөлөлтэйгөөр энэхүү зөвлөгөөнийг өөрийн ивээл дор зохион байгуулж байгаа юм.

Эрх зүйн шинэтгэлийг үе шаттай хийсний үр дүнд одоогоор манай оронд нийгмийн төрөл бүрийн харилцааг зохицуулсан 380 гаруй бие даасан хууль үйлчилж байна.

Засгийн газраас зохион байгуулсан эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, өгсөн үнэлгээнд

тус хөтөлбөрийн зорилт хууль тогтоох агуулгаараа үндсэндээ биелсэн тухай өнгөрсөн долоо хоногт Хууль зүй, дотоод хэргийн сайд надад танилцуулсан юм. Өнгөрсөн хугацаанд эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардсан нийгмийн харилцааны ихэнхийг ямар нэгэн хэмжээнд хуульчилж чадсан нь яах аргагүй энэ чиглэлд гарсан ахиц, амжилт мөн.

➤ Гэвч зөвхөн хууль тогтоомжийг шинэчилсэн буюу шинээр хууль тогтоосон тоон үзүүлэлтээр эрх зүйн шинэтгэлийн үр дүн хэмжигдэхгүй нь тодорхой. “Хуулийг шүүмжлэхийн тулд бүс хэрэгжүүлэхийн тулд баталдаг” гэж манай нэрд гарсан хуульч эрдэмтэн хэлсэн байдаг.

➤ Өнөөдөр хуулийг биш, харин чухамхүү хуулийн хэрэгжилтийг нийгэм даяараа үгүйлэх боллоо. Нийгмийн бухимдал, бусармаг явдлын гол шалтгаан бол хууль тогтоомжийн хэрэгжилт сул, үүнийг дагалдсан бүх шатанд сахилга хариуцлагагүй байдал газар авсантай холбоотой байна.

Сүүлийн үед дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгаагаар авлигагүй, шударга ёс төлөвшсөн нийгэмд амьдрах хэрэгцээ иргэдийн хамгийн их санааг зовниулж байгаа асуудлуудын эхэнд нэрлэгдсэн байна. Төрийн тэргүүндээ хандан иргэдээс ирүүлж байгаа захидал, гомдол, хүсэлтийн ихэнх нь мөн л ийм агуулгатай байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан санаа бодлоо илэрхийлж буй хүмүүсийн үзэл бодол, иргэний нийгмийн байр суурь бас л энэ сэдэв дээр голлон төвлөрч байна. Эдгээр нь энгийн тохиолдол биш, харин хууль ёсны хэрэгжилтийн дутагдал, түүнээс үүдэлтэй нийгмийн шударга ёсны хомсдолос

үүдсэн зүй ёсны эрэлт, шаардлагын давалгаа үүсч байгаа хэрэг юм.

Наад захын жишээ дурдахад, улаан цайм сурталчилгаа явуулж, хадгаламж, зээлийн хоршооны халхавчин дор олон мянган иргэний мөнгөний зүй бусаар төвлөрүүлэн завшиж байхад, гадаад орнуудын виз гаргах, гадаадад сурч ажиллах, гэр бүл болоход нь зуучлах гэх мэт төрөл бүрийн хэлбэрээр хүмүүсийг залилан мэхлэх үйлдлийг тухайн үед энэ үйлдлийг хянаж шалгаж байх үүрэгтэй байсан байгууллагуудын эрүүн дор ил тод байж байхад тэдгээр байгууллага, албан тушаалтнууд үнийг таслан зогсоохгүй, хаашаа харж, юу хийж байсан бэ гэдгийг манай ард иргэд асууж байна. Тэд асуух ч эрхтэй.

Төмөр замын болон агаарын тээврийн салбарт гарсан томоохон осол, сүйрэлд үүргээ биелүүлж явсан олон иргэн амь насаараа, эрүүл мэндээрээ хохирсон. Хүмүүсийг цочирдуулж, олон гэр бүлд хагацал авчирч, үй гашуу амуулсан энэ эмгэнэлт хэргүүдэд урьдчилан бүрдсэн шалтгаан, түүнийг гарахад нөлөөлсөн нөхцөл, үүнд хариуцлага хүлээх ёстой гэм буруутай байгууллага, хүмүүс байгаа нь тодорхой. Хэний хариуцлага, юунаас болов цаашид энэ осол сүйрэлд адил нөхцөл, шалтгаанаас үүдэн хэн нэгэн энэхгүй байх баталгааг эрхэн бүрдүүлэв, татвар төлөгчдийн хуримтлалд учруулсан хохирлыг хэн хариуцаж төлөх вэ гэдгийг нийгэм даяараа харж хүлээж байна.

Химийн хорт болон аюултай бодисын хяналтгүй зүй бус хэрэглэнээс үүссэн хүн, мал, байгаль орчны хордолтын удаа дараагийн тохиолдлууд түгшүүр төрүүлж байгаагийн буруутан нь зөвхөн түүнийг хадгалж, хэрэглэж байсан ганц нэг иргэний хариуцлагаар хязгаарлагдах уу гэдэг асуудал ч хүмүүсийн аюулгүй амьдралын хувь заяатай холбоотойгоор асуултын тэмдэгтэй хэвээр байна. Эдгээр бодисыг дотоодод үйлдвэрлэдэггүй. Ганц нэг гадаадын иргэн үүрч, дүүрч оруулж ирүүлэх боломжгүйг хэн

бүхэн мэдэж байгаа. Хонгор сумын эмгэнэлт байдал энэ бүхний тод томруун жишээ мөн.

Саяхан шинэ, хуучин оны зааг дээр хүнсний бус спиртээр бэлтгэсэн согтууруулах ундаанд олон хүн хордож, амь нас, эрүүл мэндээрээ хохирч бас л уй гашуу, бухимдал, харуусалд нийгмийг автууллаа. Хүмүүс хоол хүнсээ өөрийн үзэмжээр сонгодог нь үнэн боловч зах зээлд байгаа аливаа бүтээгдэхүүнийг итгэл үнэмшилтэйгээр авч хэрэглэх бүрэн боломжоор хангагдсан байх ёстой. Уг нь энэ боломжийг бүрдүүлэхийн төлөө төр, засгийн байгууллагууд, түүний дотор мэргэжлийн хяналтын болон бусад олон байгууллага татвар төлөгчдийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгвэл эдгээр байгууллагууд яагаад үүргээ биелүүлж чадаагүй вэ? гэсэн асуулт мөн л хариултаа хүлээж байна.

Манай улсад илүү түдхүү хөгжиж байгаа газрын харилцаа, ашигт малтмалын болон барилгын салбарт хууль бус, чанарын стандарт хангахгүй үйл ажиллагаа явуулдаг талаар иргэд гомдол ирүүлэх нь улам нэмэгдэж байна. Ойн тухай хуулиар гол мөрний ай саваас 1000 метрээс дотогш зайд айл буулгах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон боловч энэ хэрэгжихгүй байна. Өнгөрсөн онд тус хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр дээрх зайг 10 дахин багасгаж 100 метр болгосон боловч хаяанд байгаа Туул, Сэлбийн голын захаар явахад л үүний хэрэгжилт огт хангагдаагүйг харж болно. Нийслэлийн хот байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газар эзэмших зөвшөөрөл олгогдсоноос хот байгуулалтын ирээдүйд хүндрэл учрах болсныг мэргэжлийн хүмүүс битгий хэл жирийн иргэд хэлж шүүмжилж байна.

Хуулийн дагуу орон нутгийн санал, зөвшөөрлийг авахгүйгээр бүхэл бүтэн сумын нутаг дэвсгэр дээр төр аяараа ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лицензад хамрагдсан бүх асуудлыг тэдний орлооцгоогчээр төрийн

төв болон мэргэжлийн хяналтын байгууллагууд шийдвэрлэж байдаг журмыг өөрчлөх шаардлагатай байгаа тухай захидлыг сумын засаг дарга, иргэдээс надад байнга ирүүлж байна.

Барилгыг барихдаа чанарын стандартын шаардлага хангаагүй материал ашиглаж байгаа, шаардлага хангаагүй барилгыг улсын комисс хүлээж авдаг, хүлээж аваагүй ч барилгуудыг ашиглаж байдаг талаар ихээхэн ярьж, бичиж байна. Энэ бүхэн эцэстээ ямар үр дагавар учруулдаггүй САПУ-гийн хохирогчдын түүх бэлхэнэ харуулж байна.

Тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон бол хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуульд тодорхой заасан байхад хувиараа ашигт малтмал олборлодог "чинжа" гэж нэрлэгдэх болсон хүмүүс яагаад отог, тосгон болтлоо өргөжиж, хөдөлмөрийн аюултай нөхцөл, баталгаагүй химийн бодисыг улмаас амь нас, эрүүл мэнд, удам хоёоноо хүртэл хохироон байж иргэдийн маань нэг хэсэг нийтийн хууль, нийгмийн халамж анхаарлын гадна амьдрахад хүрвэ. Энэ хэцүү үзэгдлийг ердийн мэт үзэж гэнэд нь орших эрхтэйсэн билүү? гэсэн асуулт өөрийн эрхгүй хурцаар тавигдаж байна.

Гадаадын иргэд манай улсын нутаг дэвсгэрт виз хэтрүүлэн оршин суух зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхлэх, мансууруулах бодис, хүний наймаанд оролцох, охид эмэгтэйчүүдийг биеийг нь үнэлүүлэн садар самуун явдалд уруу татах, иргэдийг залилан мэхлэх зэргээр хууль зөрчих явдал нь олшрох болоо. Гадаадын иргэдийг хилээр нэвтрүүлэх, хяналт тавих тоглоцлооны аль нэг орон зайд энэ бүхэн болж байгаа нь гарцаагүй. Гаалиар чанарын стандарт хангаагүй болон хориглосон бараа, бүтээгдэхүүн нэвтрүүлэх явдал гарсаар байгаа тухай шүүмжлэл тасрахгүй байна. Гэтэл эдгээр асуудлыг шалгаж шийдвэрлэсэн үр дүн бас л тодорхой бус хэвээр байна.

Үндэсний аудитын байгууллагаас хийсэн шалгалтаар байгууллага, албан тушаалтнуудын төсөв, санхүү, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой анхаарал татахуйц томоохон зөрчлүүд илэрсэн тухай жил бүр танилцуулдаг. Эдгээр зөрчил, дутагдлуудын шалтгааныг холбогдох байгууллагууд шалгаж гэжт буруутай үйлдэл мөн эсэхийг цаг тухайд нь олон нийтэд мэдээлж байгаа тохиолдол бараг алга гэхэд болно. Нийт 30 орчим мянганхан төгрөгийн хохиролтой хулгай хийсэн хөхүүл хүүхэдтэй эмэгтэй 10-аас дээш жилийн ялаар шийтгэж байхад хэдэн сая, тэрбум төгрөгөөр илэрхийлэгдсэн дутагдал, хэтрүүлсэн зардал хаа нэг тийш багтаж шингэн замхардаг явдал шударга ёсны ноцтой гажуудал биш гэж үү? Иргэдийн захирал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлээс харахад олон тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн “Хадгаламж” банкны асуудлыг хэзээ шударгаар шийдэхийг нийгэм харсан, хүлээсэн хэвээр байна.

Хэрэв төрийн алба зөв төлөвшил, төрийн албан хаагчид мэргэшсэн, хуулийн дагуу ажилладаг ухамсартай бөгөөд чадвартай байсан бол төмөр зам, агаарын тээвэрт гарсан томоохон осол, хадгаламж, зээлийн хоршоодын хэрэг, Хонгор, Багануур дүүрэгт болсон явдал зэрэг алдаа дутагдлыг гаргахгүй байж болох байсан гэж хүмүүсийн эвлэл, шүүмжилж байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Гэтэл Ерөнхийлөгчийн санаачлал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан “Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэхгүй хойш тавьж, хойрго хандсаар өдий хүрлээ. Энэ хуулийн төсөлд төрийн жинхэнэ албан хаагчдыг чанаржуулан мэргэшүүлэх, дээр дурдсан алдаа дутагдал гаргадаггүй болгох, хууль хэрэгжилтийг чанарын өөр түвшинд гаргахын тулд төрийн албан хаагчдыг намын харьяалахгүй болгож, намчирхан талцах зүй бус зуршлаас салгах, хуулийг чанд баримтлан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх амин чухал асуудал

тусгагдсан юм. Төрийн албаны шийтгэлийн энэ асуудлыг 2007 онд багтааж хуульчлан шийдвэрлэхээр 2008 он хүртэл хууль тогтоомжийг шинэчлэх тухай тогтоолд заасныг ч Улсын Их Хурал ийнхүү зөрчиж байгааг засах шаардлагатай байна. Жинхэнэ мэргэшсэн, өндөр ёс суртахуунтай, намчирхан талцдаггүй, аль нэгэн намын харьяаллаар бус, харин мэдлэг чадвар, эзэмшсэн боловсролоороо албан тушаалд дэвшдэг зарчим үйлчилдэг төрийн албатай болох нь ойрын, хойшуулшгүй зорилт болж байгаа нь дээрх хууль хэрэгсэнтэй холбогдон гарч буй алдаа дутагдлаас тодорхой харж болох тул миний бие энэ шаардлагыг тавьж байгаа юм.

Бур цаашилбал, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хууль зөрчиж баталсныг нэгэнт тогтоосон “Авлигын эсрэг хууль”, “Ашигт малтмалын тухай хууль”-ийн зарим заалтыг өдий хүртэл яагаад анхны байдалд нь оруулж, засч залруулахгүй байгааг хүмүүс гайхашран харж, энэ талаар санаа бодлоо илэрхийлж байна.

Энэ мэт шилээ дарсан олон ноцтой асуулт хариултгүйгээр хуримтлагдахын хэрээр ард иргэдийн төрд итгэх итгэл суларч, бухимдал нь уурсан шаардах, учирлан хүсэх, урам хугарч цөхрөх янз бүрийн хэлбэрээр илэрч байна. Хууль бус томоохон асуудлыг илрүүлэн шийдвэрлэхийн оронд их ярьж, эзэнгүйдүүлэн саармагжуулах нь элбэг байгааг хүмүүс шүүмжилж, хууль алагчлан үйлчилж байгаа тухай ч дургүйцэн ярьж байна.

Төр нь ард түмэндээ дэвшээ тэнгэр хол, доошоо газар хатуугийн зовлонг үзүүлэх учиргүй, харин үүнээс ангид байлгах нь түүний үндсэн үүрэг юм. Гэтэл бидэнд хуулийн зохицуулалт, түүнийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, хүч бололцоо тэглээ дутаагүй. Гагцхүү хууль тогтоох, сахиулах, хэрэглэх тогтолцоо хоорондоо уялдаагүй, урэгшгүй ажиллаж, түүний доторх бүтэц харилцан уялдаатай, хөнгөн шуурхай, шударга журамтай байж чадахгүй байгаагаас хяналт, хариуцлагын хомсдол үүссэнээр

өнөөгийн энэхүү үлбэгэр байдал тайлбарлагдаж байна.

Дахин зориуд тэмдэглэн хэлэхэд Үндсэн хуульд заасан эрх зүйт төрийн үндсийн үндэс нь хуулийг дээдлэх, түүнийг бүх нийтээр сахин биелүүлж явдал билээ.

Нийгэмд ардчилал гүнзгийрэх тусам эрх зүйт төрийн ёс амьдралд улам сайн эвшин хэрэгжиж байх жамтай. Гэтэл сүүлийн жилүүдэд хууль ёсны хамш суларч, дур зорын үйл даамжирснаас үүссэн гашуун үр дагаваруудыг нийгмээрээ амсах болж байгаа нь бид эрх зүйт төрийн зарчмаар биш, харин эсрэг явж байгаа мэт дүр төрхийг бүрдүүлж байна. Одоо л нэг цаг тавьж, байдлыг байх ёстой чигт нь залахгүй бол улс орны хөгжлийн хурдац, хүн ардын амьдралын баталгааг нааштай шийдвэрлэх аргагүйд хүрнэ. Эрх зүйт төрийн ёсыг дээдэлдэг улсад хуулийн хэрэгжилтээс тухайн орны эцсийн хувь заяа бүхэлдээ хамаарна гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч ажил амьдралаа зохицуулдаг. Миний бие Улсын Их Хурлыг чуулганд болон бусад арга хэмжээний үед хэлсэн үгэндээ хуулийн хэрэгжилт сул байгааг цохон тэмдэглэж, энэ талаар дорвитой арга хэмжээ авах ёстойг удаа дараа сануулж байсан. Хууль ёсны хэрэгжилт муу байгаа нь олон хүчин зүйлтэй холбоотой нь ойлгомжтой. Үүнд шууд эндээс гараад зохин байгуулах асуудал ч бий. Гадаад тооцоодын эрх зүйн харьцуулсан судалгаа хийж байх, ул суурьтай шийдвэрлэх хэрэгжүүлэх ажил ч багтана. Бид энэ асуудалд шинжлэх ухаанч байр сууринаас олон талаас нь хандаж, цогц арга хэмжээ авч байж үр дүнд хүрнэ.

Юуны өмнө хууль тогтоох ажлын чанарт анхаарах цаг болсон байна. Одоогийн байдлаар үйлчилж байгаа зарим хуульд өөр хоорондоо зөрчилтэй, хийдэл ихтэй, амьдралд хэрэгжүүлэхэд төвөгтэй, зарим зохицуулалт нь нийгэмд шударга ёсыг бус харин эсрэг үйлгийг өөгшүүлэн дэвэрлэх агуулгатай ч байдаг талаар хуульчид, хуулийг сахиулах үүрэг хүлээсэн зарим ажилтан шүүмжлэн хэлэлцдэг нь нууц биш. Голдуу

тухайн салбарын мэргэжилтэн, ажилтнууд зонхилсон ажлын хэсгээр хуулийн төсөл "зохиолгодог" практикаас цаашид татгалзаж, аливаа хуулийн төслийг мэргэжлийн байгууллагын урьдчилсан тооцоо судалгаанд үндэслэн, мэргэшсэн нарийн мэргэжилтний хүчээр боловсруулж өргөн барьдаг тогтолцоонд шилжих нь энэ асуудлыг шийдвэрлэх оновчтой арга зам гэж үзэж байна. Ингэхийн тулд хуулийн төсөл боловсруулах чиглэлээр мэргэжилтнийг сургаж бэлтгэх, энэ чиглэлийн судалгааны боломж нөхцөлийг өргөжүүлэн дагуулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай. Эрх зүйн зохицуулалт харьцангуй төгөлдөрсөн хөгжилтэй орнуудад ч эрх зүйн шийдвэрлэлт бие даасан нэгж байнгын үйл ажиллагаа явуулдаг туршлагыг авч хэрэглэх нь уг асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой байх болно. Түүнээс гадна "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль"-д олон нийтийн саналыг авах боломжийг аль болох нээлттэй байлгах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах нь хуулийн чанарт үр дүнгээ өгнө.

Түүнчлэн Улсын Их Хурал ямар ч нөхцөлд Үндсэн хууль болон бусад хуулийг чанд баримталдаг байх, Улсын Их Хурлын гишүүд үйл хэргээрээ хуулийг сахин биелүүлэх, сахилга, хариуцлагатай байхын жинхэнэ үлгэр дуурайл болж чадаг байх нь эрх зүйт төрийн ёсыг улс орондоо бэхжүүлэхэд ихээхэн чухал ач холбогдолтой байх болно.

Үүнтэй холбогдуулж хэлэхэд, удахгүй болох Улсын Их Хурлын сонгуульд улс төрийн намуд хуулийг чанд баримталж, аливаа хэлбэрийн гүтгэлэг гүжирдлэг түгээлгүй, бэлэг сэлт өгөх, мөнгө төгрөг тараах, хоосон амлах зэргээр "санал худалдаж авах" ямар нэгэн оролдлого хийхгүйгээр улс орны хөгжлийн төлөх мөрийн хөтөлбөрөөрөө өрсөлдөн, ёс зүйтэй оролцох асуудал одооноос анхаарах хэрэгтэйг сануулж байна. Сонгуулийн ерөнхий хороо ч үүнд анхаарвал зохино.

Хууль тогтоомжийн хэрэгжилт

төрийн албадлагаар баталгааждаг гэдгийг хэрхэвч мартаж болохгүй. Хууль хэрэгжихгүй байгаагийн гол шалтгаан энэхүү ажил учир дутагдалтай байгаагаар шууд холбоотой. Засгийн газар түүний бүрэлдэхүүнд багтаж буй албан байгууллага, албан тушаалтнууд хуулийг хэрэгжүүлэхэд хүсэх, шаардах, албадах бүхий л аргыг хослуулан чадмаг хэрэгжүүлснээр жинхэнэ эрх зүйт төрийн үлгэр загварыг бүрдүүлж чадна. Юуны өмнө төрийн албанд хуулийг дээдлэн биелүүлдэг сахилга, ухамсрыг хэвшүүлэн тогтоох ажлыг цаг алдалгүй үр нөлөөтэй хийх хэрэгтэй байна.]

→ Хуулийг сурталчлах гэхээсээ илүү батлагдсан хууль, тогтоомжийг шуурхай мэдээлэх, хэрэглэгчдэд нэн даруй хүргэх чиглэлээр холбогдох байгууллагууд ажлын арга барилаа шинэчлэх шаардлагатай. Хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр нөлөөг судалж, зөрчил, хийдлийг нь арилган уялдаа холбоог сайжруулан төгөлдөржүүлэх ажлыг хийх нь чухал. Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 16 жилийн хугацаанд түүнд нийцүүлэн 400 орчим бие даасан хуулийг боловсруулан баталсныг та бид сайн мэдэж байгаа. Эдгээр хуулийг боловсруулан батлах ажлыг амжуулсан нь томоохон ололт амжилт мөн гэж дахин онцлон тэмдэглэе. Гэхдээ ний нуугүй хэлэхэд зарим хуулийн зүйл, заалтууд хоорондоо зөрчилтэй байдаг, энэ нь хуулийн хэрэгжилтэд муугаар нөлөөлдөг ч та бид сайн мэднэ. Тийм учраас эдгээр хуулийн хоорондын зөрчлийг арилгах, кодчилох ажлыг цогцоор хийх нь тулгамдсан зорилт болж байна. Энэ талаар сүүлийн жилүүдэд нэлээд ярьж байгаа боловч нүдэнд харагдаж, гарт баригдахуйц ажил хийгдээгүй байна.

Энэ чухал ажлыг Хууль зүйн үндэсний төвийн хүч бололцоог түшиглэн амжуулбал хамгийн зохимжтой гэж үзэж байна. Ийм бэлэн бүтэц байгааг ашиглах нь зүйтэй бөгөөд тус төвийг бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн хувьд бэхжүүлэх талаар ХЗДХЯ, СЗЗЯ зориуд анхаарч холбогдох

арга хэмжээ авах шаардлагатай.

Эзэн богд Чингис хаан "Миний зарлигийг аман дээрээ даган алсдаа зөрчиж, уснаа унагасан чулуу, өвснөө гээсэн зүү мэт хөсөрдүүлэгсэд болбоос нийтийг захирч үл чадмой" хэмээн сургасан байдаг. Хууль ёсыг сахиулах үүрэгтэй төрийн байгууллагад шударга бус явдал орших орон зай байх учиргүй. Гэтэл хууль сахиулах мэргэжлийн байгууллагууд шударга бус ажиллаж байгаа тухай гомдол, дургүйцэл олон жилийн турш тасрахгүй гарсаар байна. Тал засдаг, гэр хардаг, хөшүүн хойрго, хүнд сурталтай гэх мэт дутагдал эдгээр байгууллагад бүгшиж олон түмнийг ихээхэн чирэгдүүлж, бухимдуулдаг байна. Энэ алдаа дутагдлыг засахын төлөө эдгээр байгууллагын удирдлага санаачилгатай, идэвхтэй ажиллах хэрэгтэй.

Авлигатай тэмцэх газарт олон нийт ихээхэн найдвар тавьж байгаа. Энэ найдварыг итгэл болгож, эх орноо авлигын хорто үзэгдэлс ангигзуулахад улс орондоо байгаа бүх нөөц бололцоог нэгтгэн зангидаж, аль болох богино хугацаанд мэдэгдэхүйц үр дүн гаргахыг цаг үе шаардаж байгааг анхааруулж байна.

Шүүх эрх мэдлийн байгууллага нийгмийн шударга ёсны баталгаа болдгийн хувьд үйл ажиллагааныхаа шударга бодитой байдалд онцгой анхаарах ёстой. Шүүхийн шударга бус үйл ажиллагаа хүнийг аргагуйдуулэн мухардуулж, эцсийн найдварыг нь тасалдуулдаг гэдгийг энэ салбарт ажиллаж байгаа хүн бүр нэг ч хором мартаж болохгүй.

Шүүхийн үйл ажиллагаатай холбоотой гомдол өнгөрсөн жил надад хандан ирүүлсэн иргэдийн гомдлын 30 гаруй хувийг эзлэж байсныг энд бас зориуд анхааруулан хэлье. Шүүгчээр ажиллах ёстой хүн ёс зүйтэй, эрдэм мэдлэгтэй, ажлын болон амьдралын дадалга туршлага тэгширч жигдрэсэн байх шаардлагыг цаашид хуульчлан хэрэгжүүлэх нь зүйтэй. Шүүхийг бүтэц тогтолцооны хувьд ч шинэчилж, үйл ажиллагаа нь иргэдэд ойр, шийдвэр нь илүү

шударга, бодитой байх арга замыг судалж шийдвэрлэх хэрэгтэй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шүүх эрх мэдлийн байгууллага хянаж нөлөөлөх тогтолцоо ч үгүйлэгдэж байгааг сануулъя.

3 асаг дарга нар, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал харьяалах нутаг дэвсгэртээ хуулийг чандлан сахиулах ажлыг хяналтандаа бүрэн авч, эзний ёсоор хариуцаж тэр бүр чадахгүй байгааг зориуд тэмдэглэн хэлье. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрт энэ ажлыг үр дүнтэй сайн зохион байгуулж чадсан нөхцөлд л хуулийн хэрэгжилт улсын хэмжээнд жигдэрнэ.

→ **Эрх** зүйт төрийн нэг чухал баталгаа бол олон нийтийн оролцоо юм. Иргэний нийгмийн байгууллагууд, иргэд аливаа шударга бус, хуулиас гадуур үйлдлийг тэвчихгүй байж, түүнийг засч залруулахад төрийн байгууллагатайгаа хамтран ажилладаг итгэлцлийн үр ашигтай харилцаа тогтооход хаана хаанаа анхаарах хэрэгтэй. Иргэний нийгмийн зүгээс ийнхүү ажиллах бүх боломж нөхцөлийг төрийн байгууллагуудын зүгээс бүрдүүлэх нь чухал. Нөгөө талаар иргэн бүр хууль чанд баримталдаг, хуулийн хүрээнд ажиллаж амьдардаг

байх ухамсартай болох хэрэгтэйг сануулах юун. Ухамсартай иргэн улс орны ноён нуруу мөн билээ.

→ **Ш** илжилтийн үед бидний бий болгосон хуулийг сахин биелүүлэх тогтолцоо төгс төгөлдөр биш нь ойлгомжтой. Өнгөрсөн хугацаанд тухайн тогтолцоог ажиллуулж хуримтлуулсан туршлага, мэдлэг, сургажид тулгуурлан тогтвортой, үр ашигтай ажиллах илүү сайн хувилбарыг судалж шийдвэрлэх хэрэгтэй байж болно. Иймээс хууль тогтоомжийг сахин биелүүлэхтэй холбоотой бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны харилцан уялдаа холбоог өнөөгийн түвшинд дахин сайтар хянаж үзүүштэй байна. Хууль сахиулах үйл ажиллагаа олон нийтэд ойлгомжтой, ил тод, шуурхай байх бүхий л нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг бүх шатанд анхаарах нь зүйтэй.

Ноёд, хатагтай нар аа,
2006 онд Та бид Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг ёслол төгөлдөр, өргөн дэлгэр тэмдэглэсэн. Энэ үед гадаадын Төрийн тэргүүнүүд, нэр цууд гарсан эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн захидалд Чингис хааны их гүрний бодлогоо хэрэгжүүлсэн амжилтын нууц нь сахилга, дэг журам, хууль ёсыг чанд сахиулж чадсанд байсан

гэдгийг олонтаа дурдсан байсныг энд зориуд сануулан хэлье. "Тэнгэрийн дор төрж, хуулийн дор амьдардаг" гэсэн гүн агуулгатай мэргэн үг чухамхүү тэр үеэс гаралтай. Бидний эх орон үсрэнгүй хөгжлийн түүхэн боломжийн гараанд тулж ирээд байгаа үед энэ зөвлөгөөнийг хийж байна. Эрх зүйт төрийн ёсыг хэвшүүлэхгүйгээр, хууль ёсыг жинхэнэ ёсоор хэрэгжүүлэхгүйгээр энэ сайхан боломжийг бүрэн дүүрэн ашиглаж том зорилгодоо хүрч чадахгүй. Шинэ зуунд хүмүүн төрөлхтөний соёл иргэншил, хууль ёсыг албаны болон хувийн соёлын хүрээнд үздэг болж буй жишгээс бид хоцрох учиргүй. Эрх зүйт төрийн ёсыг улс орондоо мөн чанараар нь хэвшүүлэн төлөвшүүлж, шударга ирээдүйг хамтдаа цогцлоох ариун үйлсэд эв, эеэ хичээн нэгэн хүч болж оролцохыг Та бүхэнд хандан уриалж байна. Улсын Их Хурал, Засгийн газар ч энэ зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх бүх талын арга хэмжээг цаг алдалгүй авна гэдэгт итгэлтэй байна. "Эрх зүйт төр-Хууль ёсны хэрэгжилт" сэдэвт үндэсний зөвлөгөөнд амжилт хүсье.

Шударга ёс мандаж, сайн үйлс дэлгэрэх болтугай!



"ЭРХ ЗҮЙТ ТӨР-ХУУЛЬ ЁСНЫ ХЭРЭГЖИЛТ" ҮНДСЭНИЙ
ЗӨВЛӨГӨӨНД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Ц.МӨНХ-ОРГИЛЫН ТАВЬСАН ИЛТГЭЛ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Эрхэм хүндэт Ерөнхийлөгч өө!
Хатагтай, ноёд оо!

Та бүхний энэ өдрийн амар
амгаланг айлтгая.

Эрх зүйн хэм хэмжээг шинэтгэн тогтоож, зөв ойлгож, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь Монголын нийгмийн бодит хэрэглээ байсаар байна. Үүнийг иш үндэс болгон эрх зүйн шинэтгэлийг дараах зорилтын хүрээнд явуулж ирлээ:

Нэгдүгээрт, хууль тогтоомжийг шинэтгэх;

Хоёрдугаарт, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх;

Гуравдугаарт, хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх;

Дөрөвдүгээрт, хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх;

Тавдугаарт, нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлэх зэрэг юм.

Эдгээр зорилтын хэрэгжилтийг дүгнэж, цаашдын бодлого, чиглэлээ тодорхойлох нь Үндсэн хуульд заасан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэх эрхэм зорилгоо гүйцэлдүүлэхэд зарчмын ач холбогдолтой юм.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойшхи 16 жилийн хугацаанд үндэсний эрх зүйн тогтолцоог шинэтгэх төгөлдөржүүлэх амаргүй зорилгыг хэрэгжүүлж, ардчилал, зах зээлийн эдийн засгийн суурь зарчмуудад нийцсэн, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад тохирсон хууль тогтоомжийн санг бий болгож чадсан байна.

Манай улсад өнөөдөр 380 гаруй бие даасан хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Үүний зэрэгцээ Монгол Улс



Хууль зүй, дотоод хэргийн сайд
Ц.МӨНХ-ОРГИЛ

олон талт олон улсын 208 гэрээнд нэгдэн орж, 1050 гаруй хоёр талт гэрээг 75 улстай байгуулжээ.

Хэдийгээр хууль дээдлэх зарчим төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим боловч Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, Сайд, агентлагийн дарга, бусад эрх бүхий албан тушаалтны тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан олон тооны эрх зүйн акт нийгмийн харилцааг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Тодруулан хэлбэл, хууль тогтоомжийг шинэтгэх зорилт үндсэндээ биелэгдсэн гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэдэгтэй олон хүн санал нийлсэн болов уу. Ийм дүгнэлт хийснээр хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгож, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах нийгмийн харилцааны хүрээг өргөжүүлэх шаардлагыг үгүйсгэсэн хэрэг биш гэдгийг тэмдэглэв.

Хэдийгээр хууль тогтоомжийг шинэтгэх зорилт амжилттай

хэрэгжиж байгаа боловч "Эрх зүйн шинэтгэл"-ийн бусад үндсэн зорилт, ялангуяа хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах арга ажиллагааг шинэтгэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаарх нийгмийн эрх зүйн шинэ ухамсарыг төлөвшүүлэх зорилт хангагдаагүй байгааг энд онцлон дурдах нь зүйтэй. Ийм дүгнэлтийг ХЗДХ-ийн сайд миний бие төдийгүй Монгол хүн бүр хийж, цаашид энэ байдлыг өөрчлөхийг хүсэж байна.

Өнгөрсөн онд хийсэн социологийн судалгааны дүнгээс үзэхэд, судалгаанд оролцсон иргэдийн 69.8 хувь нь хууль тогтоомж төдийлөн хэрэгжихгүй байна гэж үнэлэжээ. Мөн хууль хэрэгжихгүй байгаа шалтгааныг 30.9 хувь нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага, албан тушаалтан үүргээ биелүүлэхгүй байгаа гэсэн бол 23 хувь нь нийгэмд шударга бус явдал газар авсан, төрийн байгууллагад итгэх итгэл алдарсан гэжээ. Тэгвэл хуульчдаас авсан судалгаанд оролцогчдын 74.3 хувь нь хууль төдийлөн хэрэгжихгүй байна гээд үүний шалтгааныг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага, албан тушаалтан үүргээ биелүүлэхгүй байна гэж 41.2 хувь нь хариулсан байна.

Энэ үүднээс авч үзвэл, Ерөнхийлөгчийн ивээл дор болж буй өнөөдрийн үндэсний зөвлөгөөн тун цаг үеэ олсон, эрх зүйн шинэтгэлийн цаашдын чиглэлийг оновчтой тодорхойлоход үнэтэй хувь нэмэр болно гэж надад байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасны дагуу Засгийн газар нь хуулийн биеллэлийн үея даяар зохион байгуулж хангах чиг үүргийг хүлээж, Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу Ерөнхий сайд нь төрийн

хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцахаар заасан. Энэхүү чиг үүргийг өнөөдрийн байдлаар, Засгийн газар, түүний харьяа байгууллага буюу 13 яам, тохируулга 13, хэрэгжүүлэгч 20 агентлаг, 21 аймаг, нийслэл, 340 суман дахь орон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрт ажиллаж буй төрийн албан хаагчид гүйцэтгэж байна. УИХ-аас томилогддог байгууллага, тухайлбал, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Авлигатай тэмцэх газар ч мөн өөрсдийн хэмжээний хүрээнд хууль биелүүлэх ажлыг зохион байгуулах, хуулийг сахин биелүүлж буй байдалд хяналт тавих чиг үүрэг хүлээдэг.

Өнөөдөр хууль хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг шууд хүлээсэн 30 гаруй мянган төрийн албан хаагч ажиллаж байгаа нь бага тоо биш юм.

Товч дүгнэж хэлбэл, хууль хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт, Үндсэн хууль батлагдсаны дараа үндсэндээ шинэчлэгдэн бүрэлдсэн бөгөөд өнгөрсөн 16 жилийн хугацаанд төрийн алба хүний нөөц, эдийн засаг техник хангамжийн хувьд бэхжиж, төрийн албан хаагчдын ажиллах арга барил, чадавхи төлөвшиж байна. Гэхдээ бид бүгдийг шинээр эхлээгүй, Монголын төрт ёсны түүхэн уламжлал, өмнөх үеийн төрийн байгууллага, тэнд ажиллаж төр улсаа зүтгэж явсан ахмад үеийн туршлага, арга барилыг өвлөн авсныг тэмдэглэн хэлье.

Дээр дурдсан хүч бололцоог оновчтой ашиглаж, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь эрх зүйн шинэтгэлийн өнөөгийн шатны эн тэргүүний тулгамдсан зорилт болж байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргааргүй.

Засгийн газрын хууль хэрэгжүүлэх ажлыг дараах гурван хүрээнд ангилан үзэж болно.

Нэгдүгээрт, Засгийн газрын байгууллага, төрийн албан хаагчдын бүрэн эрх, чиг үүрэг,

харилцан ажиллагаанд холбогдох харилцааг зохицуулсан хуулийг хэрэгжүүлэх ажил.

Энэ бол төрийн үндсэн үйл ажиллагаа биш бөгөөд төрийн дотоод зохион байгуулалтын шинжтэй юм.

Төрийн албан хаагч нь өөрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчмыг баримталж, зөвхөн хуулиар олгосон эрх мэдлийн хүрээнд хуулиар хүлээлгэсэн үүргээ чанд биелүүлэх, хуулиар зөвшөөрөөгүй аливаа үйлдэл хийхээс зайлсхийх ёстой. Хууль биелүүлэх ёс зүй, сахилгын шаардлага, ажлын арга ажиллагааг төрийн албан хаагч, түүний дээд шатны албан тушаалтан хангаж ажиллавал зохино.

Төрийн албан хаагчийн ажиллах, бүрэн эрхээ хэрэгжүүлэх, чиг үүргээ гүйцэтгэх эрх зүй, эдийн засаг, нийгэм, улс төр, мэргэжил, албаны бүхий л баталгаа, боломж, нөхцлийг хангах явдал хууль биелэгдэх нэгэн чухал нөхцөл болно. УИХ, Засгийн газраас энэ нөхцлийг хангах талаарх арга хэмжээг тогтмол авч зохиж үр дүнд хүрч байгаа. Тухайлбал, төрийн жинхэнэ албан хаагчдын цалин, нэмэгдэл, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, орон сууцаар хангах чиглэлээр багагүй ахиц гарч байна. Шүүгч, прокурор, авлигатай тэмцэх байгууллагын ажилтны дундаж цалингийн хэмжээ 500-800 мянган төгрөгт хүрээд байна. 2007 онд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын чадавхийг дээшлүүлэх, эдийн засаг, техник тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах чиглэлээр дорвитой ахиц гарлаа. Төрийн захиргааны байгууллагад ажиллагчдын цалин хангамж, нийгмийн баталгаа ч мөн дээшилж байна.

Засгийн газрын байгууллагуудын хууль зүйн албыг бэхжүүлэх явдал хууль дээдлэх зарчмыг мөрдөх, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад багагүй нөлөө болно гэж үзэж байна.

Нөгөө талаар, хууль биелүүлэх үүрэг бүхий этгээдэд уг хуулийн биелэлтийг даатган орхиж болохгүй бөгөөд ийнхүү биелүүлж буй явдалд хөндлөнгийн хяналт, хариуцлага, албадлагын арга хэрэгсэл зайлшгүй шаардлагатай.

Өнөөдөр манай хууль тогтоомжоор төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаанд Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл хяналт тавьж байгаа бөгөөд иргэд, хуулийн этгээдийн гомдлын дагуу Захиргааны хэргийн шүүх хууль бус захиргааны актыг хянан шийдвэрлэх эрх хэмжээг эдэлж байна. Эдгээр байгууллагуудын төрийн байгууллага, албан тушаалтны хууль биелүүлэх үйл ажиллагаанд холбогдох хяналтын ажлын үр нөлөөний талаар Та бид салбар хуралдаан дээр ярилцах болно.

→ Хоёрдугаарт, иргэд, хуулийн этгээд хуулийг сахин биелүүлж буй байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулах.

Энэ ажлын зорилт нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хэрэглэгч олон нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн дэг журам, хувь журмыг сахиулах, эдийн засгийг удирдахад төрийн оролцоог хангах зэрэг төрийн нийтлэг чиг үүргээр тодорхойлогдож байна.

Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагаас бүртгэл хийх, зөвшөөрөл олгох, үзлэг шалгалт явуулах, ажиглах, мэдээлэл цуглуулах аргаар иргэд, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрх зүйн хяналтыг хэрэгжүүлдэг.

Энэ ажлын чар хүрээг доорхи баримтаас харж болох юм.

Эдийн мэргэжлийн хяналтын газар 26 чиглэлээр 130 хууль, Монгол Улсын олон улсын 42 гэрээ, конвенц, Улсын Их Хурлын 30 тогтоол, Засгийн газрын 234 тогтоол, Монгол Улсын 2531 стандарт, сайдын хамтарсан тушаалаар батлагдсан 123, салбарын сайдын тушаалаар батлагдсан 459 дүрэм, журам агентлагийн даргын тушаалаар батлагдсан 72, бусад байгууллагаас баталж гаргасан 89 дүрэм, журам, заавар, 338 норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавьж, захиргааны аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг таслах чиг үүрэгтэй ажиллаж ирсэн байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай

хуулийн дагуу яам, агентлаг, Засаг дарга нар 94 төрлийн тусгай зөвшөөрлийг олгож, иргэд хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжор тогтоосон тодорхой журам, стандартыг мөрдүүлэх, төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хэдийгээр энэ нь төрийн зохицуулалт, оролцоог хангаж байгаа боловч хүнд суртал, авлигыг өөгшүүлэх, улмаар хууль ёсыг гажуудуулах нэгэн хүчин үйл болж иргэд, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, улс орны хөгжилд чөдөр тушаа болох муу үр дагавартай байж болзошгүйг анхаарч учиртай.

Татвар, гааль, шударга бус өрсөлдөөний хянан зохицуулах, байгаль орчин, газрын асуудал эрхэлсэн байгууллагууд, иргэн, хуулийн этгээд, өмчийн бүртгэл эрхэлсэн байгууллага, гадаадын иргэн, харьяатан алба зэрэг нь хариуцсан чиглэлийн хуулийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэж байгааг зориуд тэмдэглэн хэлэе.

Дээр дурдсан төрийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа ч ажлын эцсийн үр дүн хангалттай биш байгаа нь сүүлийн үед нийгмийг дотоосон хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан "Ми-8-ын" "Хонгорын", "Багануурын" зэрэг тодотголтой гэмт явдал, осол, сүйрэл, гамшгаас харагдаж байна.

Түүнчлэн 2004 онд явуулсан Авлигатай тэмцэх явдлын хөтөлбөрийн хэрэгжилтийн мониторингийн судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх олон буюу 88.9 хувь нь Монголд авлига дэлгэрсэн гэж хариулсан. Транспаренси Интернешнлийн авлигын талаарх төсөөллийн индексээ үзэхэд 2005 онд Монгол Улс 158 орноос 85-87 дугаар байрт орж, 3.0 индекстэй буюу бараг "хяналтгүй" гэсэн ангилалд орсон үзүүлэлтийг анзаарахгүй байж болохгүй байна.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас Азийн сантай хамтран 2005 оны 6, 7 сард хийсэн судалгааны тайланд "Монгол Улсын хувьд гол нь захиргааны болоод улс төрийн түвшний аль алинд нь байгаа авлигач байдлыг

хязгаарлах талаар үр дүнтэй арга хэмжээнүүдийг хамгийн түрүүнд авах шаардлагатай байна" гэж дурдсан бөгөөд энэ талаар дорвитой зэрэг үр дүнд хүрч чадаагүй байна.

Дан ганц хяналт, албадлагаар хуулийг сахин биелүүлэх явдлыг хангах боломжгүй. Нийгмийн эрх зүйн ухамсар нь хуулийг хүндэтгэн сахих суурь нөхцөл болно. Мөн нийгмийн харилцааг зохицуулах, хяналт тавих, хууль биелүүлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог өргөжүүлэх, аль болох өөрийгөө зохицуулах арга механизмыг бүрдүүлэх нь чухал үр дүнтэй. Харамсалтай нь, энэ чиглэлээр бид тун бага анхаарч иржээ.

Гуравдугаарт, Хувь этгээд хоорондын иргэний хэрэг, иргэний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэсэн шүүх, арбитрын шийдвэрийг албадан хэрэгжүүлэх.

Энэ ажлын хүрээнд хувь этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор төрийн албадлагын арга хэмжээг авдаг. Зарим тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэд, хуулийн этгээдэд учирсан хохиролыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх шаардлага үүсдэг.

Энэ чиглэлээр нааштай ахиц, өөрчлөлт гарч байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэлийн ажлын тайланд үзэхэд нөхөн төлүүлсэн зүүллэг жилээс жилд сайжирч байна. Харин хөдөлмөрийн маргаан бүхий хэргийн талаарх болон төрийн байгууллага, албан тушаалтанд үүрэг ногдуулж даалгасан шийдвэр гүйцэтгэлийн ажил нилээд бэрхшээлтэй хэвээр байна.

Манай эрд түмний ололт, амжилт, Монгол Улсын төр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин, Монгол хүний эрх, эрх чөлөөний баталгааг өнөөдөр бүрэлдэн бий болсон эрх зүйн тогтолцоо хуулийг хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөнөөс тусад нь авч үзэх боломжгүй. Бид үндэсний хуулийн тогтолцоогоо бүрдүүлсэн

ба улмаар хуулийн хэрэгжүүлэх зохих хэмжээнд зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрч байгаатай хэн ч маргахгүй биз дээ. Гэхдээ хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах арга ажиллагааг шинэтгэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх талаарх нийгмийн эрх зүйн шинэ ухамсарыг төлөвшүүлэх зорилтыг хангалттай биелүүлж чадаагүй байна. Үүнд дараах хэдэн шалтгаан байна:

1. Хуулийг сайн боловсруулсан, хууль хэрэгжүүлэх бэлтгэл ажил сайн хийгдсэн тохиолдолд хууль хэрэгжүүлэх, биелүүлэх ажлыг зохион байгуулахад илүү хялбар болно. УИХ-аас баталсан хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар хуульчлан журамласан зүйл чадахгүй байна. Үүнд дараах бэлтгэл ажил хангалттай түвшинд хийгдэхгүй байна. Үүнд:

- Хуулийг нийтлэх, олон нийтэд хүргэх, тэд унших судлах, агуулгыг ойлгож мэдэх боломжоор хангах. Энэ зорилгоор хууль үйлчилж эхлэх хугацааны товьг аль болох урт хугацааны дараа байхаар тогтоож байвал зохимжтой. УИХ-ын зүгээс энэ талаар бага анхаарч байна.

- Хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар УИХ болон Засгийн газраас зохих шийдвэр гаргаж, санхүүгийн эх үүсвэр, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэж байх. Ийнхүү тусгайлан шийдвэр гаргах явдал ховор байна.

- Ерөнхий сайд, сайд болон хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хуулийн үзүүлсэн өгөх, бүртгэл ажилтны мэдээллийн сан бий болгох, албан хаагчдыг тухайн хуулийг биелүүлэх ажиллагаанд сургаж бэлтгэх. Хууль батлагдсаны дараа ийм арга хэмжээг авах явдал бараг байхгүй бөгөөд харин Засгийн газар, сайд, даргын шийдвэрийг картлан хүлээн авч, хэрэгжилтийг мэдээлдэг бүртгэл хяналтын тогтолцоо бий.

Хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан нь хууль хэрэгжүүлэх, биелүүлэх талаар аргачилсан зөвлөмж, тоодод журам бэлтгэн гаргах, ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын

байрны тодорхойлолтыг шинэчлэх, өөрчлөх, зохих төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах. Зарим хуулийн хувьд ийм ажил хийгдэж байгаа боловч гаргасан төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал хангалтгүй байна.

Хуулиар зөвхөөрсөн **Т**охиолдолд нийтээр дагаж мөрдөх журмын төслийг боловсруулан зохих журмын дагуу батлуулах, уг журмыг нийтлэх замаар олон нийтэд хүргэх. Ийм үйл ажиллагааны журмыг хуульчлах шаардлагатай боловч өнөө хүртэл Засгийн газрын тогтоолоор зохицуулагдсан хэвээр байна.

2. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хуулийг сахин биелүүлж буй байдалд хяналт тавих, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох, захиргааны албадлага хэрэглэх үйл ажиллагаанд дараах дутагдал, бэрхшээл байсаар байна.

→ Хууль хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, санхүүгийн болон хүний хуваарилалтыг зохистой хийх чадавхи, арга ухаан төрийн байгууллага, албан хаагчдад дутагдаж байна.

Хуулийг сахин биелүүлж буй байдлыг байнга хянах, ажиглах үр өгөөжтэй тогтолцоог бүрдүүлэх, энэ талаархи мэдээллийн найдвартай эх үүсвэр, сувгийг бий болгох шаардлагатай.

→ Хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх, албадах болон урамшуулах арга хэлбэрийг зөв сонгож хэрэглэх явдал урсгал, дүр зоргын шинжтэй ба захиргааны хариуцлага хүлээлгэсэн талаарх нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бий болгож чадаагүй байна.

• Олон нийт, төрийн бус байгууллага, бизнесийн

байгууллагатай гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хамтран ажиллах зохистой арга хэлбэрийг олоогүй байна.

→ 3. Хууль хэрэгжүүлэх ажил, түүний явц, үр дүн, хуулийн үр нөлөөг үнэлэх, дүгнэх, хянаж зорилгоор хяналт, үнэлгээ, мониторинг, тайланг хэлэлцэх ажлыг зохион байгуулах шаардлагатай бөгөөд энэ шатанд дараах зүйлд анхаарах шаардлагатай байна.

• Хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих бүтцийг оновчтой тогтоох асуудал өнөөдөр бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Хөндлөнгийн байгууллага, тухайлбал, мэргэжлийн хяналтын байгууллага, авлигатай тэмцэх газар, олон нийт, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагын зүгээс хяналт тавих арга ажиллагаа төлөвшүүлэх шаардлагатай.

• Захиргааны байгууллагын зарим төрлийн үйл ажиллагаанд дүгналт гаргадаг байгууллага, тухайлбал, Хүний эрхийн үндэсний комисс, төрийн аудитын байгууллагын санал, зөвлөмжийг ажил хэрэг болгох явдал хангалтгүй байна.

• Хэдийгээр бүх яамны бүтцэд мониторингийн алба байгууллагдсан боловч тэдгээрийн ажлын үр дүн мэдрэгдэхгүй, мониторинг хийх чадавхи бүрэлдээгүй ба хөндлөнгийн мониторинг хийх бүтэц үгүйлэгдэж байна.

Хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх нийгмийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх явдал тулгамдаж байгааг харгалзан дээр дурдсан дутагдал, бэрхшээлийг арилгаж зорилгоор дараах арга хэмжээг авах саналтай байна.

1. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж Үндсэн хуульд

нийцэж байгаа болон хоорондоо уялдаж байгаа эсэхийг нягтлэн системчлэх ажлыг эхлүүлэх.

2. Хууль, нийтээр дагаж мөрдөх журам агуулсан эрх зүйн хэм хэмжээний актын төслийг боловсруулах, хянах, батлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, төсөл боловсруулах арга ажиллагааг шинэчлэх, хуулийн төсөл боловсруулах ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгадаг болох.

3. Хуулийн биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангах Засгийн газрын (Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь заалтын 1) төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцах Ерөнхий сайдын (Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг) үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих болон хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог дахин хянаж өөрчлөх.

→ 4. Хууль болон хуулийн хэрэгжилт, хууль хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд урьдчилан болон явцад нь хяналт шинжилгээ (мониторинг), үнэлгээ тасралтгүй хийж байх, ийм чиг үүрэг бүхий бүтцийг (мониторингийн институт) бий болгож бэхжүүлэх зэрэг болно.

Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх талаар зарим санал боллоо хуваалцахад ийм байна.

Энэ талаар салбар журалдаанд илүү тодорхой, жишээ баримттай санал солилцож, цаашид хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний үүдийн талаар ярилцаж ажил хэрэг зөвлөмж гаргана гэдэгт итгэж байна.

Тө бүхний ажилд амжилт хууь. Анхаарал тавьсанд баярлалав.



ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙД

Үндсэн хууль нь нийгмийн харилцааг бататган бэхжүүлсэн гол тулгуур хууль юм. Ийм учраас аливаа улсын оршин тогтнолын үндэс, хөгжлийн алс хэтийн хандлагыг тодорхойлоход Үндсэн хуулийн судалгаа онцгой үүрэгтэй.

Дэлхий дахины хэмжээнд авч үзвэл Үндсэн хууль нь 220 гаруй жилийн түүхтэй, хүн төрөлхтөний төрт ёс, хууль цаазын түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн улс төр, эрх зүйн баримт бичиг мөн бөгөөд орчин үед Үндсэн хуулийг нэг талаас, орчин үеийн нийгмийн араг ясыг бүрдүүлэгч, нөгөө талаас хүнлэг байдлын үүднээс хэзээ ч өөрчилж болох агуулга, гуравдугаарт, удирдлагын ардчилсан хэлбэр, эрх зүйт төрийн мөн чанарыг тээгч үндсэн элементүүдийг агуулсан өөрийн суурь бүтэц бүхий матер гэх зэргээр ойлгох болжээ.

Үндсэн хуулийн шинэ хандлага, шинэ арга зүй, аргаар шинжлэн судлах нь түүний хэв маяг, мөн чанар, үүрэг, ач холбогдлыг үнэн зөвөөр үнэлж, бодит дүгнэлт хийх, сургажмж авах анхдагч нөхцөл болно гэж гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид гуай "Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс" хэмээх бүтээлдээ бичжээ.

Үүнийг харгалзан үзвэл Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн агуулга, үзэл санаа

Гардчиллын хийгээд нийгэм, улс төрийн үнэт зүйлсийн баримжааллыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулах, төрийн эрх мэдлийг хуваарилах гэх мэт/ хийгээд түүний хууль зүйн хүчин чадлыг бататган бэхжүүлэх нь нэн чухал юм.

Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хангахад түүнд яаран сандран нэмэлт, өөрчлөлт оруулах явдлыг



Цагдаагийн академийн багш,
докторант
Б.НАРМАНДАХ

хязгаарлах, журамлах шаардлага нэн түрүүнд тавигдана. Ихэнх улс орон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хязгаарлах журмыг Үндсэн хуульдаа тусгасан байдаг бөгөөд тийнхүү тухайлан тусгаагүй ч гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн онол, шинжлэх ухааны чиг баримжаагаараа дамжуулан хязгаарладаг практик элбэг байна. Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн журам нь Үндсэн хуулийн өөрчлөлт хэр хүчинтэй юм бэ гэдгийг хэмжихэд гол үзүүлэлт болдог.

Дэлхийн улс орнуудын практикаас харахад Үндсэн хуульдаа тэр бүр өөрчлөлт оруулаад байдаггүй, харин түүнийг хэрэгжүүлэх үүднээс түүнд нийцсэн үзэл баримтлал, хэм хэмжээг тодотгосон, дэлгэрүүлсэн "органик" хууль, ердийн хуулиудыг өргөнөөр батлан гаргадаг. Ингэхдээ тус салбар эрх зүйн хүрээнд судалгаа шинжилгээ хийдэг онолын чиглэлийн эрдэмтэд, судлаачдын нийтлэг үзэл баримтлал, номлолыг тусгахаас гадна өөрийн улсын Үндсэн хуулийн шүүхээс гаргасан шийдвэр /тайлбар/-ийг ч харгалзан

үздэг байна.

Гэвч улс нийгэм хөгжихийн хэрээр түүний суурь харилцааг зохицуулагч Үндсэн хуульд дутагдал, сул тал илрэхийг үгүйсгэх аргагүй юм. Энэ тохиолдолд Үндсэн хуульдаа төр нийгэм нь зохицон ажиллах эсвэл Үндсэн хуульд байгаа сул тал дутагдлыг цаг алдалгүй оношилж, бодитойгоор засаж залруулах гэсэн хоёр хувилбараар бэрхшээлийг даван туулдаг байна.

Улс гүрнүүд дээрх хоёр баримтлалын алиныг нь ч хэрэглэж болох бөгөөд эхний тохиолдолд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй. Энэ талаар АНУ-ын профессор Д.Кори, Г.Эбрэгем нар "Үндсэн хууль бол Засгийн газрын машины хөдөлгөөр ажилладаг тийм хүрээ мөн" гэж тодорхойлжээ.¹ Өнөөдөр энэхүү зарчмын дагуу олон улс орон Үндсэн хуулийг төрийн механизм дагаж ажиллах ёстой гэсэн зарчмыг баримтлан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг хатуу тогтоосон байна. Энэ нь Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлбэрийн бус агуулгын өөрчлөлт байх үндэс болдог байна.

Үндсэн хуульд хэлбэрийн шинжтэй өөрчлөлтүүдийг хөнгөн хуумгай байдлаар хийвэл нөгөө төрөөс дээгүүр орших хууль зүйн дээд хүчин чадал бүхий гол хууль маань үнэ цэнээ алдах, аажмаар түүнээс улбаалан ардчилсан нийгэм, эрх зүйт төр, шударга ёсны хэмжүүр алдагдаж болохыг үгүйсгэх аргагүй юм. Тиймээс Үндсэн хуулиар бататгасан тухайн улсын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын харилцааны үндсийг явцуу ашиг сонирхлын үүднээс бус ард түмний нийтлэг ашиг сонирхолд нийцүүлэн, хүн төрөлхтөн нийтээр хүлээн зөвшөөрсөн дэвшилтэт үзэл санааг бататган бэхжүүлэх зорилгоор өөрчлөх нь зүйн хэрэг мөн.

Нөгөө талаар Үндсэн хууль нь тухайн цаг үеийнхээ хөгжлийг даган мөн адил боловсронгуйгаар

¹ Мишин А.А. "Государственное /конституционное/ право зарубежных стран" М., 1998 г.

өөрчлөгдөж байх ёстой гэсэн үзэл байдаг. Учир нь Үндсэн хууль баталж байсан, тэр үеийн туршлага дутагдсан, мэдээллийн хомсдоос юм уу санал өгөх эрхтэй хууль тогтоогчийн эрх зүйл ухамсар нь төлөвшөөгүй ч юм уу эсхүл хууль боловсруулах техник ажиллагаа нь яв цаа хийгдээгүй байж болдог. Энэ тохиолдолд улс орнуудад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу засвар хийх асуудал үүсэх бөгөөд Үндсэн хуульд өөрчлөлт оруулах эрхийг тодорхой нэмэгдээд олгосон байдаг боловч, нөгөө талаас байнга өөрчлөлд байдаг тогтоол, журам биш болохоор улс орон бүр Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулахдаа няхуур нямбай хандахыг үүрэг болгодог байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг нь аливаа улс гүрэн тухайн цаг үеэ мэдэрч, ирээдүй харсан урт удаан жилээр нийгмийн харилцааг зохицуулж чадахуйц зүйл, заалтаар урьд нь орхигдсон буюу дутагдалтай тусгагдсан зүйл, заалтыг нэмж оруулах буюу өөрчлөх явдал юм. Үндсэн хууль судлалын өнөөгийн түвшинд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмаар нь Үндсэн хуулийг хатуу хийгээд уян хатан гэж ангилах нь бий.

Хатуу Үндсэн хуулийн хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах аргачлалыг нарийн түвэгтэй байдлаар тогтоосон байдаг. Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг ард түмний төлөөлөгчдийн дээд байгууллага буюу парламентаас хуулиуд ердийн олонхийн саналаар батлагддаг бол Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг дийлэнх олонхийн буюу гуравны хоёр, дөрөвний гурав, тавны гуравны саналаар батлах эсхүл хууль тогтоох эрх бүхий байгууллагаас гадна өөр субъектүүдийн оролцоог хуралчилсан байдаг байна. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь дан ганц хууль тогтоох байгууллагын эрх ашгт үндэслэгдэх бус ард нийтийн санал хураалтаар батлах, эсвэл холбооны улсын субъектүүдээс хүлээн зөвшөөрснөөр, хөрв удаагийн парламентаар хэлэлцэгдэж зөвшөөрснөөр гэх зэрэг онцгой

нөхцөл байдлууд шаардагддаг байна.

Уян хатан Үндсэн хууль нь нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хувьд харцангуй хялбар, Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн төлөөлөгчдийн дээд байгууллага буюу парламентаар батлахад ямар нэг тусгай журмыг үл шаардах ба энэ талаар Үндсэн хуульд тусгайлан заагаагүй байна. Өөрөөр хэлбэл ердийн хуулийг батлахтай адил журам хэрэглэдэг байна. Ийм төрлийн Үндсэн хуультай улс оронд Их Британи, Шинэ Зеланд, Израил, Саудын Араб зэрэг улс багтана.

Орчин үед ихэнхдээ энэ хоёр журмаас гадна Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах холимог хэлбэрийн журам бий болгох хандлага ажиглагдах болжээ. Тухайлбал, Үндсэн хуулийн зарим бүлэг, зүйл, заалтыг нь өөрчилж үл болохоор, заримыг нь хатуу журмаар өөрчлөхөөр, үлдсэн хэсгийг нь хялбарчилсан буюу уян хатан аргаар өөрчилж болохоор тодорхойлдог болжээ.² Мөн зарим оронд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмаа сонгох бололцоотойгоор зохицуулсан байдаг байна. Тухайлбал, АНУ, Франц зэрэг улсыг нэрлэж болно.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь нэг талаас Үндсэн хуулийн хямрал гарахаас урьдчилан сэргийлэх зэрэг нөлөөтэй боловч, нөгөө талаас нийгэм тогтвортой байдлаа алдахад хүргэх сөрөг үр дагавартай. Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа аль болох хатуу аргыг хэрэглэх нь чухал. Үндсэн хууль хэдий чинээ тогтвортой байж чадна төдий чинээгээр төр, нийгмийн хөгжил тогтворжиж, хөгжлийг түргэтгэх боломж нэмэгдэнэ. Жишээ нь: АНУ-ын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал Конгресст нийт 10 мянга гаруй удаа хэлэлцэгдэж, үүнээс өрдөө 27 удаа нь нэмэлт оруулсан байна. Мөн Японы 1947 оны Үндсэн хууль, Данийн 1953 оны Үндсэн хуульд өнөөг хүртэл нэг ч нэмэлт ороогүй байна.

Үндсэн хуулийн үзэл санаа

эрх зүйн тогтолцооны хөдөлбөргүй чиг шугам болж хуулиас дээгүүр буюу гадуур хэн нэгний ямар нэг хүсэл зориг үл ноёрхоно. Төрөөс баталсан тэрхүү Үндсэн хууль дээд хүчин чадалтай бөгөөд түүнийг эрх олгогдоноос бусад ямар ч субъект өөрчлөх болон хүчингүй болгох эрхгүй. Тодотговол улс үндэстэн Үндсэн хуулиа өргөн төлөөлөлтэй улс төрийн бүх хүчин харилцан зөвшилцөж оролцох бололцоог хангасан нэр хүндтэй зөвшөөрөгдөхүйц субъектуудын оролцоо бүхий түр хурлаар хэлэлцэж баталдаг оршино. Өдгөө Үндсэн хуулийг бүх ард түмнээр хэлэлцүүлэх, бүх ард түмний санал асуулгаар шинэчлэх буюу нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал өргөжиж буй нь төрийн засаглалын зөвшөөрөгдөх байдлыг гүнзгийрүүтгэхэд чухал алхам болж байна.

Знэмэлт, өөрчлөлт оруулахад ард түмний санал чухал нөлөөтэй байдаг. Тухайлбал: Италид 50 мянган сонгогчийн санал, Австрид 100 мянган сонгогчийн саналыг үндэслэн дээрх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжтой болно.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажиллагаа нь гол төлөв:

- ◆ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргасан байх;
 - ◆ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хууль тогтоох байгууллага хэлэлцээд энэ нь олонхийн дэмжлэг авсан байх;
- Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг эцэслэн дэмжиж, сайшаан батлах гэсэн үе шатыг дамждаг байна.
- Гэхдээ энэ нь улс орнуудын засаглалын онцлог, төрийн байгууллагуудын эрх хэмжээ зэргээс хамааралтайгаар харилцан адилгүй үе шат, арга-чиглэлтэй байна. Тухайлбал, Испани улсад Үндсэн хуулийн ерөнхий зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахад нэгээд хатуу журмыг баримтлах ба хүний эрх, эрх чөлөө хийгээд, эзэн хааны

² Чиркин В.Е. Конституционное право зарубежных стран. Москва, 1997. С. 42

эрх зүйн байдлын тухай асуудалд нэмэлт, өөрчлөлт оруулахад танхим бүрийн нийт гишүүний гуравны хоёр хувийн санал авах шаардлагатай байдаг байна.

Мөн Нидерланд улсад Үндсэн хуулийн ерөнхий зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, олон улсын гэрээ хэлэлцээр Үндсэн хуульд нийцэхгүй тухай асуудал, парламентын гишүүний эрх зүйн байдал хийгээд эзэн хааны санхүүгийн байдал, хаан ширээ залгамжлах тухай асуудалд нэмэлт, өөрчлөлт оруулахад дийлэнх олонхийн буюу парламентын нийт гишүүдийн гуравны хоёр хувийн санал мөн адил авах шаардлагатай байдаг бол Португали улсад Үндсэн хууль, түүнд нэмэлт оруулахаас бусад үед шийдвэр гаргахад ердийн олонхийн, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад гуравны хоёрын, бүр чухал асуудлыг тавны дөрвөөс доошгүйн саналаар батална.

Энэтхэгт Ерөнхийлөгчийн сонгууль, гүйцэтгэх хийгээд шүүх эрх мэдлийн асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд парламентын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар, бусад асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэдэг байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бодит шаардлагыг дэлхий нийтийн жишигт үндэслэн үзвэл:

- Парламентын эрхийг зохистойгоор хягаарлах;
- Гүйцэтгэх эрх мэдлийн дээд түвшинд хуваагдмал байдал үүсгэхгүй байх;
- Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай Үндсэн хуулийн заалтыг ард нийтийн санал асуулгатай уядуулан нарийсгах;
- Үндсэн хуулийн агуулга, зарчмыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимтай нийцүүлэх;
- Иргэний нийгмийн оролцоор нэмэгдүүлэх;
- Хүний эрхийг хамгаалах, албан тушаалтны хариуцлагыг өндөржүүлэх

зэрэг явдалтай уялдуулан өөрчилдөг байна.

Гэхдээ дээрх шаардлагын дагуу оруулж буй нэмэлт, өөрчлөлтүүд нь Үндсэн хуулийнхаа суурь бүтцийг хөндөөгүй байх нь чухал. Тиймээс ч улс гүрнүүд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах тодорхой нөхцөл байдал буюу үндэслэл, журмыг тогтоосон байдаг. Үүнд:

1. Нэмэлт, өөрчлөлтөд үл хамаарах зүйл, заалт;
2. Нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэхийг хориглосон хугацаа;
3. Нэмэлт, өөрчлөлтийг санаачлах эрх бүхий субъект;
4. Нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх ирц, батлах арга, саналын хувь хэмжээ;
5. Нэмэлт, өөрчлөлтөд хориг тавих эсэх тухай асуудал;
6. Нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх хугацаа зэргийг тусгайлан зааж өгсөн байна.

1.Зарим орны Үндсэн хуульд суурь бүтцийг тодорхойлогч харилцааг зохицуулж буй Үндсэн хуулийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт огт оруулж болохгүй эсхүл тодорхой хугацааны дотор оруулж болохгүй зэргээр хуульчилсан байх нь түгээмэл байна. Тухайлбал, Грек, Итали, Франц, Алжир зэрэг оронд төрийн тогтолцоог бататган бэхжүүлсэн Үндсэн хуулийн заалтад өөрчлөлт оруулахыг, Алжирын Үндсэн хуульд төрийн шашин, иргэдийн эрх, эрх чөлөө, газар нутгийн бүрэн бүтэн байдал зэрэг асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулахыг тус тус Үндсэн хуулиараа хориглодог байна. Мөн Франц, Итали зэрэг улсад Бүгд найрамдах төрийн хэлбэр, ХБНГУ-д Холбооны улс нь мужид хуваагдах, муж улс нь хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох тухай асуудлыг зохицуулан хуулийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж үл болохоор хуульчилсан байна. АНУ 221 жилийн түрш Үндсэн хуулиа дагаж мөрдөхдөө төрийн засаглалын байгууллагуудын харилцан тэнцвэртэй орших хийгээд биеийн хэрэгт үйл оролцох,

харилцан бие биеэ хянах бүтэц, зохион байгуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байна.

2.Зарим орны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг тодорхой хугацаанд хянан үзэж болохгүй тухай заалт байдаг. Энэ нь нэг талаас Үндсэн хуулийн үзэл санаа буюу дархлааг төлөвшүүлэх, нөгөө талаас улс орны тогтвортой байдлыг хангах, Үндсэн хуулиа аль болох өргөн төлөөлөлтэйгөөр өөрчлөх зорилготой холбоотой ажээ. Жишээ нь, Грек улсын Үндсэн хуулийн 110 дугаар зүйлд зааснаар өмнөх өөрчлөлтөөс хойш жил болоогүй бол Үндсэн хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглохоор заажээ.

Мөн Бельги улсын Үндсэн хуулийн 196 дугаар зүйлд зааснаар Дайны эхэн буюу үргэлжилж байгаа үед парламентын танхим нь холбооны нутаг дэвсгэрт чөлөөтэй цугларах боломжгүй үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглохоор; Франц улсын Үндсэн хуульд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд халдах үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглохоор; Монгол Улсын Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх 6 сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болохоор тус тус заасан байна.

3.Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг санаачлах эрх бүхий субъект нь хууль тогтоох үйл ажиллагааны ерөнхий журамтай ихэвчлэн адил байх ба ердийн хуулийн төслийг ихэвчлэн парламентын нэг гишүүн санаачилдаг бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг гол төлөв төрийн тэргүүн, парламент болон түүний гишүүдийн бүлэг, Ерөнхий сайд, ард түмэн эсхүл холбооны улсын субъектүүд, нийгмийн тодорхой нийтлэгээс санаачлан оруулдаг практик байна. Тухайлбал, ОХУ-д Ерөнхийлөгч, Холбооны Зөвлөл, Төрийн Дум,

ОХУ-ын субъектуудын хууль тогтоох байгууллага, Төрийн Дум

болон Холбооны Зөвлөлийн тавны нэгээс доошгүй депутатуудын бүлэг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг гаргадаг бол Туркт парламентын гишүүдийн гуравны нэгийн саналаар, Бразилд холбооны улсын штатуудын талаас илүү хувь нь оруулахаар Үндсэн хуульдаа заажээ.

Харин Австри, Итали зэрэг оронд Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтөд ард түмний санаачилга чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Жишээ нь, Австрид 100.000 сонгогч гарын үсэг зурсан бол, Италид 500 000 сонгогчийн гарын үсэг зурснаар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг санаачилдаг байна. Австрали, ОХУ, Швед зэрэг оронд Үндсэн хуулийн төсөл бэлтгэх, зөвлөлдөх байгууллага, хороо, комисс байгуулагдан ажилладаг байна². Ийнхүү улс гүрнүүдийн Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг санаачлах эрх бүхий субъектүүдийг нэрлэн заасны ач холбогдол нь нийт ард түмний эрх ашгийн илэрхийлэл болсон Үндсэн хуульд улс төрийн аливаа хүчнүүд, явцуу ашиг сонирхлын үнднээс өөрчлөх боломжийг хязгаарах зорилготой нягт холбоотой юм.

4. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд зайлшгүй хөндөгддөг дараагийн нэг чухал асуудал нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах парламентын гишүүдийн ирц, саналын хувь хэмжээний асуудал мөн. Жишээ нь, Люксембургийн вант Улсын Үндсэн хуульд зааснаар парламентын гишүүний олонх нь буюу 50 хувь +1 хувь нь ирснээр хуралдааны ирц бүрдэнэ. Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад парламентын нийт гишүүний гуравны хоёр нь хүрэлцэн ирсэн байх шаардлагатай дээр Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа дөрөвний гуравны саналаар батална.

Грек улсын парламентад нэрээр санал хураах үед нийт гишүүний дөрөвний гуравас доошгүй

нь байх ёстой. Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг парламентаар хэлэлцэх үед танхимын нийт гишүүний тавны гурав нь байлцах шаардлагатай. Санал хураахад гишүүдийн дөрөвний нэг нь байх ёстой бөгөөд тэдний туйлын олонхиор шийдвэрладаг байна.

Нидерландын вант улсын парламентад танхимын гишүүдийн ердийн олонх хүрэлцэн ирснээр хуралдааны ирц бүрддэг бөгөөд шийдвэрийг ердийн олонхын саналаар гаргана. Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх үед дийлэнх олонх нь байх ёстой гэсэн ерөнхий жишиг байна.

5. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд үүсдэг өөр нэг анхаарал татсан асуудал нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Ерөнхийлөгчөөс хориг тавих эсэх тухай асуудал мөн. Үндсэн хууль, түүний нэмэлт, өөрчлөлтөд тавих хоригийн тухайд дэлхийн дийлэнх оронд нэгэнт батлагдсан бол төрийн тэргүүний зүгээс хориг тавьдаггүй байна. Зарим улс энэ талаар Үндсэн хуульдаа шууд заан бэхжүүлсэн нь ч байдаг. Жишээ нь, Португалийн Үндсэн хуулийн 286 дугаар зүйлийн 3-т "Ерөнхийлөгч нэгэнт сайшаагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг татгалзах үл болно" гэж заасан байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь улс гүрэн дэх аль нэг эрх мэдлийн дангаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа бус Үндсэн хуулийн заалтыг боловсронгуй болгох хүрээнд дэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъектууд хоорондын харилцаа, итгэлцэл, бодит хандлага зэрэгт үндэслэсэн байвал зохино. Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг нийтэд ил тод мэдээлж, олон түмний зүгээс бодол санаагаа илэрхийлэх бололцоог олгох, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч санал нэгдсэн байх, Үндсэн хуулийн шүүхээс төслийг бүхэлд нь буюу тухайн заалтуудын төлөөр үл зөвшөөрсөн санал ирүүлээгүй байх

зэрэг нөхцөл байдал бүрдсэн бийх нь нэн чухал юм.

А хуульд яаран сандрал гар хүрээд байдаггүй нь нийтлэг жишиг юм. Үүний тулд улс гүрнүүд Үндсэн хуульдаа тусгайлан хамгаалалтуудыг хийж өгдөг ажээ. Жишээ нь Грек, Норвеги, Финланд, Швед зэрэг улсад дараалж сонгогдсон хоёр парламентаар дамжуулан хэлэлцсэний дүнд Үндсэн хуулийг шинээр батлах буюу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэдэг байна. Мөн сонгуулийн бүрэн эрхийн хугацааны сүүлчийн чуулганаар Үндсэн хуультай холбоотой асуудлыг авч хэлэлцдэггүй нь нийтлэг зүйл гэж хэлж болно.

Гэтэл Дани зэрэг оронд Үндсэн хуулийг парламентаар хэлэлцэж баталсны дараа зургаан сарын дотор ард түмний санал асуулга явуулж, сонгогчдын 40 хувийн дэмжлэг авбал монархи батламжлан сан мөрдөж эхэлдэг аж. Иймэрхүү жишиг Ирланд, Испани, Франц зэрэг оронд байдаг. Харин Франц улсад Ерөнхийлөгч парламентаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, парламентын гишүүдийн тавны гуравны санал авсан бол референдумаар санал хураалгахгүй байж болдог онцлогтой. Сонгогчдын санал асуулгаар Үндсэн хуулиа баталдаг ч улс бий. Сенегал 1963 онд, Гамби 1970 онд, Камерун, Филиппин 1972 онд ийм зарчмаар Үндсэн хуулиа баталжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам нь ихэвчлэн процессын хэм хэмжээнээс бүрдэх боловч, зарим нэг материаллаг хэм хэмжээ тухайлбал, үндсэн хуулийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон, тодорхой хугацааны дотор нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэхийг хориглосон гэх зэрэг хэм хэмжээнээс бүрддэг байна.



² Лундэжянцан Д. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онол, арга зүйн харьцуулалт, үндэслэл. УБ., Шинэ толь сэтгүүл, 2000 он, №2

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага, үндэслэлийн талаарх онол арга зүйн зарим асуудал

Үндсэн хууль нь хууль зүйн болон мөн чанарын хувьд дархлагдсан байхын ач холбогдлыг бид дээр тодорхойлсон. Гэхдээ энэ хоёр дархлаа хоёулаа нэгэн зэрэг тогтож байж сая Үндсэн хуулийн хууль цаазын дээд хүчин чадал нийтэд илэрхий болж, аливаа улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны үндсэн чиг баримжаа болно. Үндсэн хууль нь дан ганц хэлбэрийн хувьд дархлагдах нь "Үндсэн хууль нь хуулийн дээд хүчин чадалтай гол тулгуур хууль мөн" гэсэн идеализмыг бий болгоход хүргэх сөрөг талтай. Иймээс улс гүрэн Үндсэн хуулийн дээрх хуулийн дээд хүчин чадлыг хүлээн зөвшөөрч, нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг тусгайлан тогтоохын зэрэгцээ, түүний суурь бүтцийг тодорхойлогч ухагдахууны дархлагдах байдлыг бий болгоход онцгой анхаарах нь чухал.

Монгол Улсын хувьд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг Үндсэн хуулийн 6 дугаар бүлэгт заасан бөгөөд хуулийн уг заалтаас үзвэл Монгол Улсын Үндсэн хууль нь хатуу зэрэглэлийн Үндсэн хуульд хамаарна.

Үндсэн хуулийн 68 дугаар зүйлд зааснаар "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан⁴ гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Мөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга⁵ явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна" гэж заажээ.

Энэ нь Үндсэн хуулиар

баталгаажуулсан засгийн эрх бүх ард түмний мэдэлд байх болон ард түмэн төрийг удирдах хэрэгт шууд оролцох эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажээ. Харин ард түмэнд хуулиар олгогдсон энэхүү эрхийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар баталж, ард түмэнд өөрсдийн эрхээ хэрэгжүүлэх бололцоог олгож байгаа нь нэг талаас ард түмэнд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг олгосон мэт боловч, нөгөө талаас энэхүү эрх нь хязгаарлагдмал байгаагийн ирлэл юм.

Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар "Улсын Их Хурал Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг нийт гишүүдийнхээ дөрөвний гурваас доошгүйн саналаар батлах бөгөөд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд нэгэн бүрэн эрхийн хугацаандаа 2 удаа хэлэлцэхэд ийнхүү нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадавч, уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй. Мөн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 6 сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж болохгүй. Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хуулийн адил хүчинтэй байна" гэж заажээ.

Энэхүү журмыг баримтлан 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын шинэ Үндсэн хуульд түүхэндээ анх удаа 2 зүйлд нэмэлт, 5 зүйлд өөрчлөлт оруулсан билээ.

Уг нэмэлт өөрчлөлт нь өнөөдрийг хүртэл онолын хувьд хүлээн зөвшөөрөгдөх, эс зөвшөөрөгдөх эсэх нь маргаантай хэвээр байгаа нь уг харилцааг зохицуулж буй эрх зүйн

зохицуулалтыг боловсронгуй болгох, эсхүл одоогийн эрх зүйн хэм хэмжээгээ нэг мөр ойлгогдохууц хэмжээнд тайлбарлах шаардлагыг бий болгож байна.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар 1999-2007 оныг хүртэлх хугацаанд өдөр тутмын хэвлэлд нийтлэгдсэн өгүүлэл, ярилцлагыг түүвэрлэн авч үзвэл уг асуудлыг хөндсөн, судлаачийн болон олон нийтийн, төрийн алба хаагчдын байр суурийг илэрхийлсэн 150 гаруй өгүүлэл нийтлэл нийтлэгдсэнийг түүвэрлэн авч тодорхой үндэслэлээр ангилан авч үзвэл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эргэн тойронд дараах асуудал хөндөгдөн гарч байна. Үүнд:

- ♦ Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд агуулгын хувьд Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэж багаа эсэх асуудал;
- ♦ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаа нь хуульд нийцсэн эсэх;
- ♦ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавих эрхтэй эсэх;
- ♦ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд Үндсэн хуулийн цэц ямар эрх хэмжээтэй оролцох эсэх;
- ♦ Ер нь Үндсэн хуулийг өөрчлөх шаардлага байсан эсэх зэрэг асуудлыг хөнджээ.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрхийг эдэлнэ.

⁵ Аад нийтийн санал асуулга гэдэг нь:

Төрийн бодлогын асуудлаар явуулсан санал асуулгад сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцон саналаа нууцаар гаргахыг хэлнэ.

ЗОЛИОСЛОХ СЭТГЭЛГЭЭ

Энэхүү "бичил" нийтлэлийг урьд нь Та ямар нэгэн сонин хэвлэлийн булангаас харсан байж магад. Өнгөрсөн онд Улсын Их Хурал 2007 оны Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөг буюу нийт дүнгээрээ 19.0 тэрбум төгрөгийг хуваарилсан нь Үндсэн хууль зөрсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарч, энэ нь Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн "нэрв"-ийг нэлээдгүй хүргэж байсан нь саяхан.

Тухайн үед Улсын Их Хурлаас Цэц өөрт үл хамаарах асуудлыг хэлэлцдээ, Улсын Их Хурлын хууль тогтоох онцгой бүрэн эрхэд бүдүүлгээр халдлаа гэх зэргээр Цэцийг элдвээр буруушааж байсан ч Цэцийн их суудлын хуралдаанаас "хөрөнгө оруулалт" нэртэй Төсвийн тухай хуулийн зарим санхүүжилтийг хүчингүй болгосон юм. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс улбаалан чухам ямар шалтгаанаар энэ их хөрөнгө оруулалтыг Цэц хүчингүй болгов, Цэц яагаад улс орны хөгжил дэвшлийг гацааж, Үндсэн хуулийн нэрийн өмнөөс хэн ч үл нэвтрэх хаалт босгов гэх зэргээр тухайн үед нийгмийн зүгээс, иргэдийн хөдөлгөөнүүдийн зүгээс дээрх шийдвэрийг эсэргүүцэж болох авч "харамсалтай" нь ямар ч үйлдэл хийсэнгүй. Уг нь таны байшингийн элэгдсэн дэвэрийг сольж, хүүхдийн тань сургуулийг засварлаж, орон сууцны гадаа тоглоомын талбай барих зэргээр иргэдэд, нийгэмд чиглэсэн л хөрөнгө оруулалтыг Улсын Их Хурлын гишүүд маань хамтарч хийхийг зорьсон биз дээ.

Улсын Их Хурлын гишүүд "амиа" өгөөд ч болов авч үлдэх гэсэн тэр их хөрөнгө оруулалт, санхүүжилтийг ард иргэд нь авахаас татгалзав уу, эсхүл Төсвийн тухай хуульд тусгасан 19.0 тэрбум төгрөг нь нарийн учир



Үндсэн хуулийн цэцийн ажилтан,
хуульч
Э.ЛХАГВАСҮРЭН

шалтгаантай, "цагаан гартнууд"-ын далд санаа байв уу. Ямартаа ч Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн "дүр зураг" хуульч гэхээсээ илүүтэйгээр иргэн хүнд хэрхэн тусч буйг миний бие бичгээр илэрхийлэхийг зорьж, тухайн үеийн зарим сонин хэвлэлд нийтлүүлж байсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр ажлаа авсны дараахан Улсын Их Хурлын индэр дээрээс шинэ Засгийн газрын дэвшүүлж буй 5 төгөлдөршлийн талаар илтгэхдээ улс үндэстнийхээ эрх ашгийг төлөөлөх учиртай парламентын гишүүдийг аймаг, орон нутгийн аж ахуйн ажлыг хөөцөлдөгч болон хувирч буйг хэлээд авсан. Улс орныхоо эрх ашгийг 76 хэсэглээд, хэсэг бүрийг төлөөлөх нэг нэг хүн тавьчихсан төрхтэй болгосон нь угтаа өнөөгийн сонгуулийн гаж тогтоцоос хамааралтай болохыг, түүнчлэн парламентын гишүүд өөрийн аймагт хуваарилагдах төсөв, хөрөнгө, "тусламжийн бараа"-г нэмэгдүүлэх, өөр аймаг, орон нутагт төлөвлөгдсөн ажлыг булааж, өөрийн тойрог руу шилжүүлэхийн тулд лоббидохоос

хэтрэхгүй, тэдний үндэсний хэмжээний асуудалд бодитой хандах чадваргүй болсныг ч тэрбээр тэмдэглэсэн билээ.

Цэцийн дээрх шийдвэр нь төрийн институц хоорондын харилцан тэнцвэрт байдлыг хадгалж чадсан, дараа дараагийн Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахад Улсын Их Хуралд сургамж болохуйц шийдвэр болсон нь дамжиггүй. "Хууль дээдлэх ёс" сэтгүүл хуульчдын "тогоонд" мэндэлж, хуульчид "өлгийдөн" авч, хэвлэгдсэн цагаасаа хууль зүйн мэдээллийн нээлттэй талбар байсаар ирсэн тул энэхүү нийтлээлээ уг сэтгүүлээр дамжуулан уншигч авхай танд дахин хүргэж буйг минь хүлээн авна уу.

"Би хүнийхээ хувьд хамгийн тогтсон 50 насан дээрээ байна. Надад улс төр харьцангуй онолоос ч хүнд" гэж ХХ зууны аугаа физикч Альберт Эйнштэйн нэгэнтээ халагласан гэдэг. Энэхүү халаглал нь тулгуур физикийн хуулиуд бол хөдөлшгүй ертөнцийн үнэн, харин улс төр бол эрх мэдэл, албан тушаал, хөрөнгө мөнгөнд дөрлөгдсөн хаашаа ч хөлбөрд мэдэх тогтворгүй, тодорхой хугацааны охорхон ашиг сонирхлын төлөөх амь өрсөн тэмцэл байдлыг томъёолсон бололтой. Өнөөгийн Монголд "Их гуравалжин"-гийн Ч.Эрдэнэ тэргүүтэй гарын таван хуруунд багтах эхдэн эрхэм л харьцангуйн онолын нарийн ширийнийг тоймлох байх. Гэтэл тэрхүү ойлгоход нэн хүнд улс төрийн учир начрыг би мэднэ гэж өдгөө толгойтой болгон цээжээ дэлдэх болж. Бидний энэ их хийрхэл нь Монгол Улсыг улс төрчдийн эх орон болгож, Монголд Улс төрөөс өөр хийх ажил олдохгүй мэт сэтгэгдийг ч заримдаа төрүүлж буй нь харамсалтай.

Ардчилсан намаас 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн уриа болгон зарлаж буй "2.6 сая Чингис сэргэ байна" гэснийг харин ч "2.6

сая улс төрч сэргэж байна” гэвэл арвай л үнэнд нийцэх авай. Улс төр ямар бохир заваан болох, өнөөгийн манай “улс төрч” гэх эрхмүүдийн цаана ямар “атгаг” ашиг сонирхол “явуургүй” амбиц халхлагдаж байгаагийн тод жишээ нь Үндсэн хуулийн цэцийг “ялгасан” Улсын Их Хурлын 2007 оны хаврын чуулганы нээлт боллоо. Хуулийн нэрээр халхалсан 250.0 сая төгрөгийн “хулгайн” хэрэгтээ Улсын Их Хурлын гишүүд огтхон ч улайсангүй. Харин ч Үндсэн хууль зөрчсөндөө бантаа уу, эсвэл цагаандаа гарав уу, Үндсэн хуулийн цэцийг боорлож эгээ л “хүний олон нь хүнээ барьж” байгаа мэт үзирлэж, хөхөрч хөшиж, эвшээж аавралзсээр хуралдаан гээчээ өндөрлөв.

Улсын Их Хурлын хуралдаан дээр 2007 оны Төсвийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг танилцуулахдаа “Төсвийг зохиох эрх нь Засгийн газарт байдаг. Улсын Их Хурал үүнийг хэлэлцэж батлах үүрэгтэй. Гэтэл Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо зарцуулах 250.0 сая төгрөгийн сураг дуулаад өөрсдөө төсөв зохиож баталсан нь гүйцэтгэх эрх мэдэлд халдаж, Үндсэн хуулиа зөрчих анхны алхам болсон...” гэдгийг удаа дараа тайлбарласан боловч эрхэм төрийн түшээд маань Улсын төсөв батлах тухай Үндсэн хуулийн суурь зарчмыг умартан Улсын Их Хурал “төсөв баталдаг” гэх онцгой бүрэн эрхдээ хэт “дулдуйдан” Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөг хуваарилуулж, жагсаалт гаргуулан сайр нарын багцан тараан байршуулах замаар гүйцэлдүүлсэн эцнээ зорилгоо л хамгаалан гарахыг урьтал болгож буй нь хэн бүхэнд ойлгомжтой мэт санагдана. Нийгмийн зүгээс үүнийг сайн ойлгосон бололтой.

Анх 10.0 саяар эхэлж, улмаар 100.0 сая, өдгөө 250.0 сая болтлоо өсөн уржих нь хэвийн үзэгдэл, кишиг болон тогтож, Үндсэн хуулийн тогтоосон төрийн эрх мэдэл зуваарилх зарчим ноцтойгоор хөрчигдэж буйг Улсын Их Хурлын ганц нэг гишүүн хэлж

“...улайсан Улсын Их Хурал эцэстээ Цэцийг хэрэгтэн болгох гэж үзэж байна. 250.0 сая бол улс төрийн авлига” гэдгийг ч тэд нуусангүй. Энэ мэт чуулганы танхимд бага ч атугай түнээнийг шулуун хэлэх төрийн түшээд байсанд харин ч баярлууштай.

Улсын Их Хурал болон Үндсэн хуулийн шүүхийн харилцаа байнгын “зөрчилдөөнт” шинжтэй байдаг талаар гадаад, дотоодын хуульч эрдэмтэд, судлаачид бүтээлдээ тэмдэглэдэг ч Үндсэн хуулийнхаа “манаач”-ийг дайрч доромжилж байгаа Улсын Их Хурлын гишүүдийн энэ мэт үйлдэл нь Улсын Их Хуралд өрнөдөг жирийн нэг маргаан, мэтгэлцээнээс тэс ондоо үр дагаврыг бий болгохыг үгүйсгэх аргагүй. Улсын Их Хурал Цэцийн маргаан хүндэрсээр төрийг доройтуулах аюултай ч Улсын Их Хурлын гишүүд ойлгох учиртай. Энэхүү 250.0 саяын хөрөнгө оруулалтыг Үндсэн хуулиар тогтоосон засаг, захиргааны нэгжээр бус зөвхөн сонгууль уухуулахын тулд зохион байгуулагдаж сонгуулийн нутаг дэвсгэрийг баримтлан зарцуулахаар төсөвлөсөн нь 2008 оны Улсын Их Хурлын сонгууль шударга явагдах боломж алдагдах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж, сонгуульд зориулж байгаа хөрөнгө оруулалт гэдэг нь сонгогчдод тов тодорхой болоод байна.

“Гоё” амлаж байж эрхэм гишүүн болсныхоо “гор”-ыг энэхүү 250.0 саяар цайруулах, бас түүнийгээ тонож тайрах эцнээ санаа байгаа нь бүр тодорхой. Улсын Их Хурлын гишүүдийн “хувийн бодлоор” хөрөнгө оруулалтын санал өгөгдсөн тул ижил объектуудыг барихад зарцуулах зардлын хооронд тэнгэр газар шиг зөрөө байгаа нь тун сонин. Тухайлбал, Багийн Засаг даргын конторын барилгыг Дорнод аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр багт барихад 20.0 сая, Сэлэнгэ аймгийн Шаамарт барихад 50.0 сая, Төв аймгийн Бүрэн суманд барихад 70.0 сая төгрөг төсөвлөгдсөн байж жишээтэй.

Сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг Өвөрхангай аймгийн Уянга суманд барихад 250.0 сая, Сүхбаатар аймгийн Уулбаян суманд барихад 25.0 сая төгрөгөөр төсөвлөсөн байх.

Улсын Их Хурлын танхимд ч, “нинжа”-гийн хотхонд ч амьдрал зүгээр л зөнгөөрөө, хүмүүсийн дотоод зөн совингоор үргэлжилж, өсөж дэвжихийг чармайж байна. Энэ бол нийгэмшээгүй, иргэншээгүй нийгмийн бодит дүр зураг. Хотын утаа тортог, хог хаягдал, зам, гэрэлтүүлэг, хүмүүсийн цалин хангамж, ажиллаж өвчин, ханиад томьуу, боловсролын төвшин, гадаадад дүрвэсгэд, үлдсэн нь боломж л гарвал явчих гэсэн санаархлаас үзвэл энэ оронд хүн амьдрах, ажиллах орчныг төр засаг маань тэр бүр бүрдүүлж чадсангүй.

Эрхэм түшээд маань “хувааж идэж, хуйлж түрийлээ”, “сан идэж, салхи залгин”, “улаа цуцааж, ява хоосолж” байгааг сонгогчид аанай л ойлгож авсныг нь тэд зөнгөөрөө мэдвэ бололтой. “Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдээг олохгүй” гэдэг эртний мэргэн үгийг дахин нэг санацгаая. Амьтны зөнгөөр хувиа хичээж, олз ашиг, нэр төрийн төлөө үхэн хатан улайрч, алих хэрэгт хандахдаа төрийн эрх ашгаас илүүтэйгээр хувийн явцуу ашиг сонирхлыг эрхэмлэх нь төрийн хүнд явч ч байсангүй “араншин” гэдгийг ухамсарламаар л байлтай. Харамсалтай нь төрийн төлөө, ард түмнийхээ төлөө л “төрсөн” мэтээр, өөрсдийгөө цаг үеийн захиалга хэмээн PR хийх эрхэм гишүүдийн үнэн нүүр царай өрдөө л энэ.

Ийм л төр, ийм л нийгэмд үнэт зүйл алга болж эцэстээ нийгэм бүхэлдээ хардлага, сөрдлэг, гэмт хэрэг, оюуны бохир урсгалд түрэгдэж, мэдээллийн хэрэгсэл хүртэл бохир үзэл сурталд автагдана. Сул дорой хүмүүс нь амьдрал ахуй, заяа тавилангаа үзмэрч, мэргэч, төлөгч нарт даатгаж, хүч чадал, хөрөнгө зоорь арвинтай хэсэг нь буруу замаар олсон орлогоо уул, усанд

даатган тахих, олны үйл нэрээр наадам цэнгүүн хийх замаар нүглээ наминчлан шинэ аргаа хэрэгжүүлнэ.

Нэгэнт үнэлэмжийн чанараа алдсан учраас Улсын Их Хурлын гишүүн байна уу, хадгаламж, зээлийн хоршооны эзэн байна уу ялгаагүй адилхан л ашиг хонжоо хайгчид мэтээр харагдаж, эрдэмтэй сайн хуульчид гудамжны хөлсөөр жагсагчдад адлагдана. Тэгээд, тэгээд, нийгмээ "зэрлэгштэл"

удирдсан төрийн түшээд маань өөрсдийгөө улс төрийн өндөрлөгөөс "ЗОЛИОСЛОНО". Цаг хугацаа бүхнийг шүүнэ гэдэг юутай үнэн билээ.

Наймдугаар богд Жавзандамба хутагтын нэгэн айлдварт "Хүмүүнийг гэгээрүүлэх гэдэг агуу их ажил буюу" хэмээсэн нь бий. Мэргэд бодьгал хүнийг ухуулан сэнхрүүлэх, гэгээрүүлэх үйлийн чанадыг өргөн олны сайн сайхан, амар амгалангийн төлөө

өөрийн өтөл биеийг "ЗОЛЖ" гэгээрүүлэх гэж сургасан байдаг.

Дорно дахины энэхүү гүн ухааны үүднээс мухарлан бодвоос одоогийн Улсын Их Хурлын эрхэм гишүүд маань Монгол төрийг цэвэршүүлэхийн төлөөнөө иргэний зориг гарган өөрийгөө "золмосолж" байгаагийн нэгэн баталгаа нь Улсын Их Хурлын 2007 оны хаврын чуулган даруй мөн болой.

ТАНЫ ХӨТӨЧ
ХУУЛЬ СҮЙН
1982
ЛАВЛАХ

**Хууль сүйн лавлах 1982 дугаар дараах
Чиглэлээр лавлагаа өгнө**

1. Иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол хэрхэн гаргах талаар;
2. Хэргийн харьяаллын талаар;
3. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актын талаар;
4. Газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар;
5. Гэр бүл, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар;
6. Нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлаар;
7. Компани, нөхөрлөл, хоршоо байгуулах, өөрчлөн байгуулах чиглэлээр;
8. Банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо талаар;
9. Гэрээний эрх зүйн чиглэлээр;
10. Иргэний бүртгэл, мэдээлэлтэй холбоотой асуудлаар;
11. Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны хариуцлагын тухай хуультай холбоотой асуудлаар;
12. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар;
13. Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын асуудлаар;
14. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн талаар;
15. Татвар болон гаалийн хууль тогтоомжтой холбоотой асуудлаар;
16. Төрийн байгууллагуудын утас, хаяг, байршлын талаар;
17. Шүүхийн утас, хаяг, байршлын талаар;
18. Хууль зүйн үндэсний төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар;
19. Өмгөөллийн туслалцаа хэрхэн авч болох талаар болон МӨХ-ны өмгөөлөгчдийн утас, хаяг, байршлын талаар;
20. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйл ажиллагаа явуулж байгаа нотариатчдын талаар лавлагаа өгөх гэх мэт.

ШҮҮХИЙН ЖИШГИЙГ АШИГЛАХ НЬ

Монголын Өмгөөлөгчдийн холбооны орон нутгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга нар, өмгөөлөгч, шүүгчдэд зориулсан "Шүүхийн жишгийг ашиглах нь" сургалтыг 2008 оны 1 дүгээр сарын 23-24-ний өдөр олон тооны жишээ бодлогыг ашиглан хэлэлцүүлгийн хэлбэрээр явуулсан юм.

1. Шүүхийн шийдвэрийг унших арга

Эхлээд жишгийг хэрхэн уншиж ойлгох ба бусад хэрэгтэй хамаарах эсэх талаар замын хөдөлгөөний ослын жишээн дээр авч үзье. Тодорхой жишгийг уншиж ойлголт авах талаар танилцуулья.

Өмгөөлөгч хүлээж авсан хэрэгтэй холбоотой хэргийн жишиг хайж байна гэж үзье. Тэгвэл бид дараах нөхцөлийг тогтоох хэрэгтэй. Үүнд:

а. Эхлээд жишиг маань ямар үнэнийг баталсан байгаа вэ гэдгийг тайлж унших шаардлагатай.

Жишгээс шалтгаалан бодит байдал нь өөрөө маргаан болж байдаг тул "Зохигчдын нотолгоо" болон зарим үедээ "Шийдвэр" дотроос шүүхийн баталгаажуулсан үнэнийг олж унших шаардлагатай. Энэ тохиолдолд аль үнэн нь өөрийн хариуцаж байгаа хэрэгтэй тэстэй ба аль нь өөр байгааг мэдэх хэрэгтэй.

б. Маргаан нь юу вэ гэдгийг мэдэх

Зохигчдын нотолгоо нь хоорондоо таарахгүй байгаа хэсэг маргаан нь болно. Зохигчдын хооронд маргаан гарахгүй байгаа хэсгийн тухайд шүүх шийдвэрлэх шаардлага байхгүй учир маргаан байхгүй. Мөн маргаан нь нэг хэрэгт хэд хэд байх тохиолдол ч байдаг.

в. Шүүх нь маргааныг хэрхэн шийдсэнийг тэмдэглэсэн хэсэг нь шийдвэрийн цөм нь болж байдаг.

Үндсэндээ энэ хэсэг дэх дөрвөн нөхцөлөөс дор дурдсан дөрвөн хувилбарт шийдвэр харгалзан гарна. Үүнийг шийдвэрийн цөм гэх ба шалтгааны тухайд дараагийн



Өмгөөлөгч /Япон/
ТАНАБЭ МАСАНОРИ

шүүхийн үйл ажиллагаанд ихээр нөлөөлж чадахгүй гэж үздэг. Энэ талаар тодорхой жишээ авч тайлбарлана.

г. Шийдвэрийн цөмийг тухайн хэргийн тодорхой үйл явдалд нийцүүлэхэд гарах үр дүн тогтоох хэсэг нь оруулна.

Тогтоох хэсэгс үзэхэд аль үнэн нь тэстэй шийдвэрт хүргэж байгааг мэдэх явдал юм. Нөгөөтэйгүүр энэ хэсэгт гарахгүй үйл явдлын хувьд гарах үр дүнд нөлөөлөхгүй билээ.

Хувилбарт шийдвэр 1: Энэ удаагийн хэрэгт шийдвэрийн үнэний хэсэгт "А компанийн ажилтан Б нь машин жолоодож, ажилтан С нь хажууд нь сууж явсан ба халтиргаатай зам дээр хурдтай явсны улмаас осол гарч, ажилтан С нь гэмтсэн" гэж тэмдэглэсэн байна. Эдгээр нь нотлох баримтаар баталгаажсан байж болох ба зохигчдын хооронд маргаан байхгүй ба нотлох баримтгүйгээр баталгаажуулсан байж ч болох юм.

Хувилбарт шийдвэр 2: "Ажил олгогч нь үйл ажиллагаагаа явуулахдаа ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй" гэж хувьд заасан байна гэж үзье.

Бэртсэн нэхэмжлэл гаргагч С нь "Жолооч Б нь хурд хэтрүүлэн явснаас осол гарсан нь А компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүргийг зөрчсөн" гэж мэдүүлж байна.

Эсрэгээр А компани нь "Хурд хэтрүүлсэн нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэгт хамаарахгүй" гэж мэдүүлж байна гэж үзье.

Тэгвэл энэ хэргийн маргаан нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах гэдэгт "Хурд хэтрүүлэхийг хориглох" гэдэг нь хамаарагдах уу, үгүй юу гэдэг асуудал юм.

"Хэн машин барьж явсан бэ", "Ямар хурдтай явсан бэ", "С-ийн гэмтлийн зэрэг хэр байна вэ" гэдэг нь маргааны цөм нь болохгүй. Эцсийн дүнд зохигчдын хооронд санал нийлэхгүй байгаа зүйл л маргааны цөм нь болно. Энэ шийдвэр нь хэрхэн жолооч, хурд, гэмтэл зэргийн хэмжээг баталгаажуулсан ба гэдэг шийдвэр биш учраас дараа нь шүүхийн жишиг болохгүй гэсэн үг юм.

Хувилбарт шийдвэр 3: Шийдвэрт "Машины бүрэн бүтэн байдал, жолоочийн сонголтыг зөв хийх байсан зэрэг нь компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэгт хамаарах боловч замын хөдөлгөөний дүрмийг баримтлах гэдэг нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэгт хамаарагдахгүй" гэж бичсэн байна гэж үзье.

Тэгвэл уг шийдвэрийн гол нь "Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах гэдэг нь компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэгт хамаарахгүй" гэсэн үг болно.

Хувилбарт шийдвэр 4: Шийдвэрт "Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах гэдэг нь жолоочийн өөрийн үүрэг тул хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэг гэдэгт хамаарагдахгүй" гэсэн шалтгааныг бичсэн байх тохиолдол байдаг. Эдгээр "шалтгаан" нь дараагийн хэрэгт ашиглагдах ба энэ нь өөрөө жишиг биш юм.

Мөн "Машины бүрэн бүтэн байдал, жолоочийг зөв сонгох нь компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүрэгт хамаарна" гэдэг хэсэг нь шууд маргаангүй онол гэж нэрлэгддэг

ба энэ нь бас шийдвэрийн цөм нь болохгүй боловч, дараагийн хэрэгт ашиглагдах тохиолдол байна.

Монгол Улсын дээд шүүхийн тайлбарт "Аюулгүй байдлыг хангах үүрэг" гэдгийн дотор тэмдэглэгдсэн байж магадгүй. Гэхдээ тайлбар нь бүхний агуулж байгаа гэсэн үг биш. Жишээ нь ресторана ажиллуулж байгаа компанийн тогоочин, төмөр замын компанийн зам засварын ажилтны аюулгүй байдлыг хангах үүрэг гэж юу байх вэ? Энэ бүгдийг агуулна гэдэг нь боломжгүй юм.

Шийдвэрийг орлуулахад "Аюулгүй хурдаар явах гэдэг нь замын хөдөлгөөний дүрмийн агуулгад хамрагдах учраас А компанийн аюулгүй байдлыг хангах үүрэг гэдэгт орохгүй тул тус компани С-д хохирлыг төлөх үүрэг байхгүй" гэж бичигдэнэ гэсэн үг юм.

Тэгвэл ослын шалтгаан нь тормос барихгүй байснаас болсон бол компани хариуцлага хүлээх ёстой гэж үзэж болох уу? Машины бүрэн бүтэн байдал нь аюулгүй байдлыг хангах үүрэгт орох тул компани хариуцлага хүлээх ёстой гэж таамаглагдана.

Хэрвээ ослын шалтгаан нь жолооны үнэмлэхгүй ажилтанд машин барилсан бол яах вэ? Жолоочийг зөв сонгох нь компанийн аюулгүй байдлыг хангах үүрэг болох учраас компани хариуцлага хүлээх ёстой гэж таамаглагдана.

Хэрвээ ослын шалтгаан нь жолооч архи уусан байвал яах вэ? Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах гэдэг нь компанийн аюулгүй байдлыг хангах үүрэгт орохгүй тул зарчмын хувьд компани нь хариуцлага хүлээхгүй гэж таамаглагдана. Гэхдээ компани нь жолоочийг архи уусан байсныг мэдсэн хэрнээ жолоо барилсан бол жолоочийг зөв сонгох гэсэн үүргээ зөрчсөн явдал болох тул аюулгүй байдлыг хангах үүргийн дотор орох тохиолдол байж болно.

Иймэрхүү шийдвэрийг бусад хэрэгт ашиглах бол энгийнээр жишээтэй төстэй байна уу, үгүй юу гэдгийг бодож "төстэй байна", "төстэй бус байна" гэсэн шийдвэр гаргахдаа бус "маргааны цөм нь" хаана байна гэдгийг гаргах ирэх нь чухал шаардлагатай байна.

2. Маргааны цөмийг гаргаж ирэх

Гэхдээ маргааны цөмийг гаргах ирэх гэдэг нь тун төвөгтэй байдаг ба шийдвэрийг уншиж байгаа хүнээс шалтгаалан өөрчлөгдөж ирнэ. Эсрэгээр хэлбэл хууль нь өөрийн хариуцаж байгаа хэргийн үйлчлүүлэгчид ашигтай байх цөмийг олж гаргах чадвар шаардлагатай болно гэсэн үг юм.

Маргааны цөмийг гаргаж ирэх талаар сурахад зориулсан жишээ Америкийн сурах бичигт "бусдыг хууль бусаар хоригно байлгах гэмт хэрэг" гэсэн шийдвэрийг ашигласан байдаг. Дашрамд дурдахад бусдыг хууль бусаар хоригно байлгах гэмт хэрэг гэдэг нь хэн нэгнийг "хүчээр", "нэг газар", "тодорхой хугацаагаар" саатуулсан нөхцөлд үйлдэгдсэн гэж үзнэ гэж жишгийн хуульд заасан байна гэж үзье.

"Нэгэн ресторанд эзэн Х нь үйлчлүүлэгч Y-г мөнгөө төлсөнгүй гарах гэлээ гэж бодоод түүнийг саатуулсан ба 20 доллар болон иргэний үнэмлэхтэй түрийвчийг нь аван, тодруулахаас нааш ресторанаас гарахыг хориглоно гэдэг гал зуухны өрөө рүү орсон. Х нь асуудлыг зөвчөөс тодруулахад Y нь мөнгөө төлсөн ба Y-ийн түрийвчийг авсан байгаа тул 20 минутын турш ресторанаас гарч чадалгүй хүлээж байсан" гэсэн жишээн дээр Х нь бусдыг хууль бусаар хоригно байлгасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэсэн шийдвэр шүүхээс гарсан гэж үзье.

Тэгвэл "Нэгэн ресторанд эзэн Х нь үйлчлүүлэгч Y-ийг мөнгөө төлсөнгүй гарах гэлээ гэж сэрдэн Y-ийг үүдэн дээр саатуулан 100 доллар, жолооны үнэмлэхтэй түрийвчийг нь хураан аваад тодруулах шаардлагатай гэж дотогшоо орсон. Х нь зөвчөөс тодруулахад Y нь мөнгөө төлсөн нь тодорхой болсон ба Y нь түрийвчээ хураалгасан тул ресторанаас гарч чадалгүй 30 минут хүлээсэн" бол энэ тохиолдолд жишгтэй харьцуулахад бусдыг хууль бусаар хоригно байлгасан гэмт хэрэг болох нь гарцаагүй болох магадлалтай ба яагаад гэдэг асуулт гарч ирнэ.

Өмнөх жишгийн цөмийг нь хэрхэн тогтоох вэ?

Жишээ нь жишин нь "Түрийвчээ хураалгасан нь хүч хэрэглэсэн" -тэй дүйцнэ, "30 минут нэг газраа хүлээсэн" тул жишин нь бусдыг хууль бусаар хоригно байлгасан гэмт хэрэг болох нь тодорхой юм.

Тэгвэл нэгэн ресторанд "Эзэн Х нь үйлчлүүлэгч Y-г төлбөрөө хийлгүй гарах гэлээ гэж бодоод түүнийг гарах гэхэд нь зогсоож 20 доллартай түрийвчийг авсан ба тодруулах хүртэл хүлээ гэж хэлээд дотогшоо орсон. Х нь зөвчөөс тодруулахад мөнгөө төлсөн нь тодорхой болсон ба Y-ийн түрийвчийг нь авсан тул гарч чадалгүй 10 минут хүлээсэн" бол жишин дээр бусдыг хууль бусаар хоригно байлгасан гэмт хэрэг болох уу? Өмнөх шийдвэрийн цөм нь хаанаа байна вэ?

"Хүчээр" гэдэг нь аль нь вэ? "Тодорхой хугацаагаар" гэдэг нь аль нь вэ? Та үйлчлүүлэгчийн өмгөөлөгч байсан бол эсвэл рестораны эзний өмгөөлөгч байсан бол шийдвэрийн цөм нь хэрхэн өөрчлөгдөх вэ?

Хэрвээ та үйлчлүүлэгчийн өмгөөлөгч нь байсан нөхцөлд, "хүчээр" гэдэг хэсэгт "үнэ цэнтэй эд зүйлийг нь хураан авах гэдэг нь хүчээр гэдэгт тохирч байна" гэдэг нь шийдвэрийн цөм болох бөгөөд "20 доллартай түрийвч гэдэг нь үнэ цэнтэй эд хөрөнгө болох нь тодорхой" гэж маргалдаж болно. Мөн "тодорхой хугацаагаар" гэдэгт "тооцоо хийсэн эсхийг шалгахад хангалттай хугацаанаас хэтэрхий давсан" гэсэн хэсэг ба "10 минут гэдэг нь тодруулахад хангалттай хугацаанаас хэтэрч байна" гэж маргалдаж болох юм.

Эсрэгээр та рестораны эзний өмгөөлөгч байсан нөхцөлд жишээ нь "хүчээр" гэдэгт "хүний хувийн нууцтай холбоотой зүйлийг авах нь хүчээр гэдэгт орно" гэж цөмийг нь гаргаж ирж болох ба "багахан мөнгийг авсан нь уг хүн хувийн нууц мэдээллээ орхисонтой адил зүйл биш тул тэндээс явахад саад болохгүй" гэж заргалдаж болно. Мөн "тодорхой хугацаагаар"

гэдэгт "энгийн үед тэвчээр алдрах хугацаанаас давсан хугацаа" гэсэн цөмийг гаргаж ирүүлж байгаа ба "10 минут-гэдэг нь энгийн хүний хүлээж тэвчээрт хугацааг даваагүй" гэж заргалдаж болох юм.

Тэгвэл "Нэгэн шатахуун түгээгүүрийн газарт эзэн Х нь үйлчлүүлэгч Y-г мөнгөө төлөлгүй зугтах гэлээ гэж бодон Y-ийн машины өмнө хааж зогссон төдийгүй Y-ийн машинаас нь хөргөгч шингэнийг нь аван тооцоо хийсэн үгүйг чинь тодруулах тул явж болохгүй гэж хэлээд ажлын өрөө рүүгээ орсон. Х нь ажилтнаас тодруулахад Y нь төлбөрөө хийсэн нь тодорхой байсан ба Y-ийн машины хөргөгч шингэнийг нь авсан тул 20 минутын турш шатахуун түгээгүүрийн газраас холдож чадалгүй хүлээж байсан" гэсэн нөхцөлд, жишгийн хуулийн дагуу бусдыг хууль бусаар хорьсон гэмт хэрэг болох уу? Энэ нөхцөлд гэмт хэрэг гэдэг нь тогтогдох уу? Хураан авсан нь зөвхөн энэ бөгөөд үнэ цэнтэй эд хөрөнгө ч биш, хувийн чухал мэдээлэл ч биш боловч ямар цөмийг гаргаж ирвэл эзэн Х-ийг буруутай болгож болох вэ?

Жишээ нь "хүчээр" гэдэгт "машины хувьд зайлшгүй байх шаардлагатай үнэ цэнтэй зүйлийг авсан ба явах боломжгүй байдалд оруулсан тул хүчээр гэдэгт орно" гэсэн цөм байх, "хөргөгч шингэн байхгүй бол машин нь эвдрэх тул хөргөгч шингэнийг авсан нь машиныг хөдлөх аргагүйд хүргэж байгаагаас ялгаагүй" гэж үзвэл адилхан жишгээс энэ хэргийн буруутай болгож болох цөмийг нь гаргаж ирэх боломжтой юм.

Иймэрхүү цөм нь ганцхан л байна гэсэн үг биш түүнийг хэрхэн гаргаж ирэх вэ гэдэг нь тухайн хүн болон зорилгоос шалтгаалан өргөн эсвэл явцуу хүрээтэй байдаг. Мөн адил жишиг ч гэсэн цөмийг нь хэрхэн гаргаж ирэх арга нь өөрт ашигтай эсвэл ашиггүй болох ч явдал байна.

3. Жишгийг тодорхой хэрэглэсэн жишээг танилцуулах

Сургалтын төгсгөлд Монголын

оролцогчдоос хэд хэдэн тодорхой жишээг шүүхэд бэлтгэн болгон ашиглаж байсан эсэх талаар санал солилцсон юм. Ингээд Монгол, Америкийн хамтарсан компани нь хамтарсан гэрээнд заасны дагуу нэхэмжлэлийг хариуцсан Нью-Йоркийн шүүхэд гаргасан хэрэг бөгөөд Монголын компани Хан-Уул дүүргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн талаар Монголын өнөөгийн байдалд хамгийн их нөлөөлж байна гэж бодсон тул энд танилцуулья.

Монголын талын өмгөөлөгч нь "Үйлдвэрийн барилга, ажилчид, Америк эзэн болон олон тооны бичиг баримт, гэрч нь Монголд байдаг зэрэг шалтгаанаар Америкийн шүүхэд хамаарахгүй болохыг мөн Колоридыг мөнөөгийн шүүхийн шийдвэр"-ийг танилцуулсан ба Хан-Уул дүүргийн шүүх гарсан шийдвэрийн талаар огтхон ч дурсаагүй бөгөөд Нью-Йоркт харьяалагдахыг зөвшөөрсөн гэсэн утгатай жишээ юм.

Юуны өмнө Монголын шүүх гадаадын шийдвэрийг ашиглах баримт болгон өгсөн нөхцөлд түүнийг харгалзан үзэх нь ховор байдаг бололтой. Энэ нь бусад гадаад улсад ч адил тул энэ нь гол асуудал биш хэдий ч энэ хэргийн тухайд Америк ч гэсэн харьяаллыг нь татгалзвал эцсийн үр дүнд хаа ч нэхэмжлэл гаргах аргагүй болох учраас гадаадын улсын шийдвэрийг харгалзан үзэх нь чухал тохиолдол байдаг. Гэхдээ уг хэрэг нь Нью-Йорк мужийн жишээ бөгөөд ашигласан жишиг нь Колориды мужийн шийдвэр байсан болохоор түүнийг ч гэсэн харгалзан үзэх шаардлагатай.

Жишгийг ашиглах материал болгон шүүхэд өгөхдөө бодит цөмийг нь сайтар гаргаж ирэх нь маргааны нөхцөлийг бүрдүүлж өгөх талтай. Уг хэргийн өмгөөлөгч нь энэ тал дээр сайтар анхаарсан гэж үзэх болохоор байна.

Шүүхийн хувьд өгөгдсөн жишиг нь тухайн хэрэгтэй хэрхэн холбогдож байна гэдгийг бодож үзэх нөхцөлд тухайн хэрэг болон

прецедент маань юугаараа ялгаатай байна вэ?, эсвэл жишиг маань өөрөө оновчтой биш байх зэргийн талаар шийдвэрт тэмдэглэл хийх шаардлагатай.

Монголын шүүгчийн хувьд жишиг нь өрсөлдөгч шүүгчийн гаргасан шийдвэр байх тул түүнийг дагаж мөрдөх шаардлага байхгүй гэсэн санаа байдаг. Энэ талаар жишгийг баримтталдаг үүсгэн санаачлагч улс болох Англид ч бас анхандаа жишгийн өрсөлдөгч гэсэн үзэл байсан ба шүүгч хүний хувьд мэдээжийн хэрэг байж магадгүй. Гэхдээ сохорон жишгийг дагах шаардлага байхгүй ба өрсөлдөгч шүүгчийн гаргасан шийдвэр нь оновчтой байна гэж үзвэл түүнийг ашиглах, оновчтой биш гэж үзсэн бол буруушаах, тухайн хэрэгтэй өөр гэж бодвол юу нь өөр байгааг шийдвэрт бичих нь зохистой бөгөөд холбогдох жишгийг тоомсоргүй орхиж шийдвэрийн дотор ч тэмдэглэгээ хийхгүй орхон ч шүүхийн шийдвэрийн үнэмшилтэй байдлыг өөрийн биеэр үнэлэхгүй байх, гутаасантай адил болох гэж бодож байна.

4. Дүгнэлт

Жишгийн хуулийг баримтлагч улс болох Америк ч маш олон төрлийн хууль батлагдсан байдаг ба эх газрын эрх зүйтэй улс гэж нэрлэгддэг Япон улсад ч жишгийг дагах нь ажил хэрэг дээр төдийгүй эрх зүйн тогтолцоонд ч гэсэн нөлөөлөн орж ирж байна. Япон, Америк ажил хэрэг дээр гарсан ялгаа бараг байхгүй гэж хэлэхэд буруудахгүй. Энэ нь бүрэлдэхүүн хууль төдийгүй жишгийн хуульд ч тэр хуулийн тогтолцоо зохистой бус гэдгийг илэрхийлж байгаа билээ.

Монгол Улс нь жишгийг ашигладаг улс биш хэдий ч урьдын гарсан шийдвэрийг сохорон дагах шаардлага байхгүй ба шүүхийн шийдвэр нь нээлттэй болж идэвхэн болохоор өмгөөлөгч нь элэхвэртэйгээр жишгийг ашиглаж, шүүгч ч идэвхтэйгээр жишгийн шийдвэрийг хөндөн үзэж байгаагай гэж хүснэм. Ингэснээр Монголын шүүхийн тогтолцоо, эрх зүй хурдан хөгжих болов уу.

"Хөөжил ба эрх зүй" оюутны эрдэм шинжилгээний бага хуралд "Оны судлаач оюутан"-аар шалгарсан илтгэл

ГОМДЛЫГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ ХҮРЭЭНД ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭХ ЭРХ НЭЭГДЭХ НӨХЦӨЛИЙГ ҮНЭЛЭХ АСУУДАЛ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан **Б.ЭРДЭНЭХУЯГ**

Сэдвийн бүтэц :

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үндсэн зарчим онолд харьцуулах үүднээс илтгэлийн бүтцийг шүүхэйн шийдвэр хэлбэртэйгээр тодорхойлох.

1/ УДИРТГАЛ

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль /ЗХХШТХ/ ба захиргааны процессын эрх зүйн онол бусад орны сонгодог гэж болох хуулийн зохицуулалтыг харьцуулан үзэж асуудлыг дэвшүүлэхийн өмнө дараах тохиолдлыг авч үзье.

Тэгш эрх

Терийн захиргааны албан хаагч нь Монгол Улсын иргэн Доржийн дэлгүүрийг хаачихсан. Мөн ХБНГУ-д иргэн Шоллерийн дэлгүүрийг Захиргааны актын дагуу хаачихсан байна. Уг захиргааны акт илт хууль бус байсан бөгөөд хоёр иргэн хоёулаа хохирол арилгуулах шаардлага тавьжээ. Шоллер 30 хоногт асуудлаа шийдүүлсэн бол Дорж 90 хоног болж байж хохирлоо Захиргааны шүүхийн шийдвэрээр арилгуулсан байна. Гэтэл хүн бүр тэгш эрхтэй гэсэн эрх зүйт ёсны зарчим үйлчилж байна. Энэ үүднээс дээрх асуудал шударга ёсонд нийцэж байна уу? Монгол Улсын иргэн Доржийн үндсэн эрх зөрчигдөж байна уу? Гэсэн маргааныг дээр тохиолдол араасаа дагуулж болох юм. Гэхдээ итгэчийн гол асуудалтай холбоотой нөхцөл бол чухам иргэн Дорж яагаад ийм байдалд хүрвэ? гэдэгт хариулт олох. Учир юунд байна вэ? гэвэл Тэрээр

асуудлаа шийдвэрлүүлэх гэж зохих хуулийн дагуу /ЗХХШТХ болон Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль/ олон шат дамжлага дамжиж явсанд байгаа юм. Ийм асуудлын талуудыг тодорхойлох хүний эрх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд үүнийг хангах үзэл баримтлал нэхэмжлэгчийн талд, харин 90 хоногт шийдвэрүүлэх нөхцөлийг бүрдүүлээд байгаа хуулийн хэм хэмжээ Захиргааны шүүхийн практик нь хариуцагч тал болох нь мэдээж.

Шинжлэх ухаан бүр өөрийн гэсэн үндсэн асуудалтай. Эдийн засгийн шинжлэх ухаанд хэн? юуг? яаж? гэж хязгаарлагдмал, нөөцөөр хязгааргүй хэрэгцээг хангахад чиглэсэн асуудал байдаг бол Хууль зүйн шинжлэх ухаанд хүний эрхийг яаж хангах буюу эрх зүйн хэм хэмжээгээр хүний эрхийг зохистой хамгаалж, эрхийг эдлүүлэх нь үндсэн асуудал болдог. Үүнийг хэрэгжүүлэх механизм нь эрхийг тодорхойлсон материаллаг хэм хэмжээ хууль болж нөгөө талаас эрх нь зөрчигдөөл үүнийг сэргээж тогтоох хэрэг маргааныг хянан шийдвэрлэх арга зам, журмыг тогтоосон процессын хэм хэмжээ болно. Монгол Улсад 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан ЗХХШТХ нь эдгээр шинжийн аль алиныг нь агуулсан бөгөөд үндсэн эрхийг хангах чухал баталгаа хэрэгсэл болсон ч Захиргааны процессын эрх зүйн салбар дөнгөж бие даан бүрэлдэн тогтох явцад шийдвэрлээл зохих асуудал нэгэнт хуримтлагдсаны¹ нэг нь илтгэчийн тавьж буй Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа /ЗХУША/-г хангасан байдал Захиргааны хэргийн шүүх

/ЗХШ-д нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл болж буйтай холбоотой асуудал юм. Өөрөөр хэлбэл ЗХУША нь Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны нэг үе шат болдгийн хувьд иргэний эрхийг хангахад зарим талаараа саад болдог энэ шаардлагыг хангасан эсэхийг шүүхээс унэлж буй практик нь хуулийн логикийг алдагдуулсан жишиг тогтоож байгаа учраас дээрх асуудлыг дэвшүүлсэн болно. 2004 оноос үйлчилсэн ЗХХШТХ болон ЗХШ-ийг "сонгодог" гэх утгаараа төлөвшсөн зарим орны зохицуулалт онолын үзэл баримтлалтай харьцуулан судлах нь үр дүнтэй юм.

2/ ТОДОРХОЙЛОХ НЬ БҮЮУ АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХОД

Зарчмын хувьд захиргааны хэргийн шүүхийн үндсэн зориулалт бол захиргааны байгууллагын үйл ажиллагаа нөлөөллийн улмаас хөндөгдөж зөрчигдсөн иргэний субъектив эрхийг хамгаалах явдал юм. Үүнийг дагалдаж захиргааг хянах, захиргаанд хууль ёсыг хангуулах гэсэн дайвар зориулалтууд хууль тогтоомжид сууж өгдөг.

Тэгвэл ЗХХШТХ-ийн дагуу субъектив эрх нь зөрчигдсөн этгээд хандахдаа түүнд юуны өмнө шүүхэд хандах эрх байхаас гадна энэ эрх нь нээгдэж байх шалгуур тавигдсан байдаг.

Өөрөөр хэлбэл ЗХШ-д хандахад тус хуулийн 12.1-т заасан үндэслэлийг баримтлах бөгөөд энэ эрх нь бас тодорхой нөхцөл болж агуулдаг. Энэ бол нэхэмжлэлийг шүүхэд хүлээн авах шалгуур авах болсон "Гомдлыг урьдчилсан

¹ Эрдэнэцогт А. Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2005 он, 53 дахь тал

шийдвэрлүүлэх гэсэн нөхцөл буюу шууд шүүхэд хандахаас өмнө иргэн, хуулийн этгээд нь тухайн маргааны дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлүүлэх² гэсэн шаардлага юм.

ЗХХШТХ-ийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад "Захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлэхгүй ба энэ журмыг хэрэглэх боломжтой гэдгийг ЗХУША-г явуулбал нэхэмжлэгч гомдол гаргагчийн эрх ашиг ноцтой хохирох эсвэл энэ нь үр дүнгүй үйл явдал бий болох" гэсэн утгаар шүүгчид хэргийн нөхцөл байдалд үнэлэлт өгч шүүхэд нэхэмжлэх боломжийг /үзэмжээр/ авч үзэх боломж олгожээ.

Нэхэмжлэл гаргагч нь шүүхэд хандах боломж, эдлэх эрхийн нөхцөлийг авч үзвэл:

1. Хуульд тусгайлан заасан;
2. Дээд шатны захиргааны шийдвэрийг эс зөвшөөрсөн, доод шатны захиргааны байгууллага шийдвэрийг биелүүлээгүй. Өөрөөр хэлбэл ЗХУША-нд тавьсан шаардлага биелэгдээгүй;
3. Дээд шатны захиргааны байгууллага байхгүй.

Иргэн, хуулийн этгээд нь энэ шаардлагыг харгалзаж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хайтагдана. Тэгвэл нэгэнт л ЗХУША нь шүүхэд хандах эрх хэрэгжих нөхцөл болдог юм бол ЗХУША-аас гарах үр дүнг судлах шаардлагатай. Хуульд өөрөөр заагаагүй³ бол ЗХУША-аас дараах шийдвэрийг гаргах боломжтой.

Үүнд:

- Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх;
- Маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох;
- Захиргааны акт гаргахыг даалгах⁴;
- Гомдол гаргагчийн шаардлагыг хангахгүй орших.

Үүнээс үзвэл хохирлоо арилгуулах, эрх зүйн харилцаа байгааг хүлээн зөвшөөрүүлж тогтоох төлбөр багасгах гэх мэт өөр нэхэмжлэлийн шаардлагыг агуулж болох шүүхээс гаргадаг шийдвэрийн агуулгыг тодорхойлж өгдөг нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж шийдвэрлүүлэх боломжгүй байгааг ажиглаж болно. Тэгвэл ийм шаардлага тавьсан гомдол нэхэмжлэлийн шаардлагыг тавиад шүүхэд нэхэмжлэл гаргасан бол шүүх үүнийг шууд хүлээн авах уу? аль эсвэл ЗХУША-г хийлгэхээр буцаах уу? гэсэн асуулт тавигдах нь зайлшгүй. Үүнд ЗХХШТ-ийн 34.1.3 дахь заалт хариулт өгөх боломжтой. Харин дээрх байдлыг ЗХШ-ээс хэрхэн шийдэж буй байдлыг практик болон судалгааны түвшинд хэрхэн үзэж буйг жишээ татан судалж үзвэл:

Шүүхийн практик

Жишээ 1: Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2005 оны 12 дугаар сарын 16-ны /ажлаас/ үндэслэлгүй халагдсан бөгөөд ажилгүй байх хугацааны чөлөөг шаардсан буюу хохирлоо арилгуулах шаардлагыг тавьсан хэрэгт Захиргааны хэргийн шүүх ЗХШ-ээс урьдчилан шийдвэрлүүлэх нөхцөлийг шаардсан. Б нь төрийн албанд хандсаны дараа Захиргааны хэргийн шүүхээр хэрэгэ шийдүүлсэн. Гэтэл тэрхүү ЗХУША болох Төрийн албаны зөвлөлөөс⁵ хохирол арилгах шийдвэр гардаггүй. Өөрөөр хэлбэл ЗХШ-ээс тус хэрэгт урьдчилан шийдвэрлүүлсэн байдлыг харгалзан хүлээн авч шийдвэрлэсэн нь иргэний эрхийг хурдан хангасан эсэх нь эргэлзээтэй бөгөөд бусад эрсдэл дагуулсан байдаг.

Жишээ 2: Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2007 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн шийдвэрээр иргэн А-гийн Газрын кадастрын албатай холбогдох

Захиргааны акт гаргуулах тус албанд өргөдлөө гаргасан нь эрх зүйн харилцаа байгааг тогтоох⁶ нэхэмжлэлийг хэрсэгсгүй болгохдоо урьдчилан шийдвэрлүүлсэн эсэхийг үндэслэл болгон хэрэгт авч үзсэн. Гэтэл ЗХУША-аас тухайн захиргааны байгууллагатай эрх зүйн харилцаатай эсэхийг тогтоосон шийдвэр гаргах боломжгүй байдаг тул нэхэмжлэгчийн эрх ашиг сонирхол зөрчигдсэн.

Судалгаа таниулга:

Жишээ 3: ЗХУША-г нэхэмжлэх эрхийн нэгдэх нөхцөл болсон талаар зарим судалгаа таниулган бүтээлд: Захиргааны шийдвэр үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо арилгуулах шаардлагыг хэрэгжүүлэхэд ... орлого төлбөр зэргийг нэхэмжлэн шүүхийн өмнөх шатыг оролцуулан⁷ ЗХШ-д хандахыг хүлээн зөвшөөрсөн. Гомдлыг урьдчилан шийдвэрлүүлэх нөхцөлийг тайлбарлан иргэдэд мэдээлэл өгсөн өгүүлдэл "нэхэмжлэлийг шууд шүүхэд гаргахаар тусгайлан заасан ба харьяалах дээд шатны захиргааны байгууллага албан тушаалтан байхгүйгээс бусад бүх тохиолдолд шүүхийн өмнөх шат буюу дээд шатны захиргааны байгууллага албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлүүлэхийг шаардана"⁸ гэж ярьж, бичиж байна. Энэ нь юутэй холбоотой вэ? ЗХХШТХ-ийн 34.1.3-т ЗХУША нь шүүхэд хандах эрх нээгдэх нөхцөл болохдоо:

■ Хуульд заасан;

■ ЗХУША-г нөхцөл болгон авч үзэхийг ЗХШ-д боломж олгосон гэсэн 2 хэлбэрээр илэрч байна.

Чухам энэ шалтгаанаар Иргэн Дорж нь нэхэмжлэлийн шаардлага хангуулах гэж 90 хоног явсан байна.

Тэгвэл нэхэмжлэгчийн талд буй Захиргааны процессын эрх зүй

² Бусад урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон хуульд заасан шийдвэр Б.3

³ Даалгах шаардлагын хувьд Захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 11.1-д зааснаас бусад үйлдэл хийж гүйцэтгэлийг даалгасан шийдвэр гаргаж болно.

⁴ Эрдэнэцогт А. Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй. УБ., 2005 он 147 дэх тал

⁵ Иргэн А нь газар ашиглах эрх хураасан лиценз олгохгүй байхаар яамнаас шийдсэн тул үүнийг эрх зүйн харилцаа байгааг тогтоологч болсон.

⁶ Эрдэнэцогт А. "Захиргааны шүүхэд гомдол гаргахад тавигдах шаардлага. Эргэлцүүлэг", 2002 он, №16.

⁷ "Захиргааны хэргийн шүүх". Хууль зүйн үндэсний төв, Дэлхийн Банкны Шүүх эрх мэдэл, эрх зүйн шинэтгэл төслийн хамтын бүтээл. УБ., 2004 он, 52 дэх тал

үүнийг сонгодог утгаар агуулсан зарим орны тухайлбал, ХБНГУ, АНУ-д урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь нэхэмжлэх эрх нэгдэх болохдоо ямар онцлогтой шүүхээс хэрхэн үнэлдгийг авч үзье.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 19.4-т "нийтийн захиргааны зүгээс эрх нь зөригдсэн бол түүнийгээ бүрэн сэргээлж хамгаалуулах үндсэн эрхийг заасан байдаг. Үүнийгээ ч захиргааны процессын үндсэн суурь гэж үздэг тул захиргааны байгууллагын зүгээс халдсан бол эрхийг түргэн шуурхай үр нөлөөтэй хамгаалахад ач холбогдол өгч үүнийг хангах эрх зүйн зохицуулалтуудыг бий болгосны нэг нь ХБНГУ-ын Захиргааны шүүхийн тухай хууль⁸ юм. Өөрөөр хэлбэл тус механизмын тэргүүлэх зориулалт дээр дурдсан зорилгод оршдог бол захирагч хянаж хууль ёсны байлгах нь дагалдах зориулалт болдог. Иймээс ч ЗХШ-д нэхэмжлэлийг хүлээн авахад тавигдах шаардлага нь нэхэмжлэлийн төрлөөс хамаардаг. Шүүхэд нэхэмжлэх эрх нэгдэх нөхцөл нь субъективт эрхээ хамгаалуулах нэхэмжлэлээс шалтгаална гэсэн үг. Үүнийг зохицуулахдаа дараах байдлаар томьёолсон:

1. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн байх шаардлагатай нэхэмжлэл;

2. ЗХУША шаардлагагүй нэхэмжлэл⁹ гэж ангилж болох бөгөөд үүнээс нэхэмжлэл гаргах нөхцөл хамаардаг. Тус бүрийг нь тодорхойлбол:

Эхний нэхэмжлэлд хүчингүй болгуулах, захиргааны акт гаргахас татгалзсаныг хүчингүй болгуулж гаргахыг даалгах нэхэмжлэл нөхөн тогтоох нэхэмжлэл /өмнөх үедээ/ хамаарна. Эдгээр нэхэмжлэлийг гаргахыг өмнө ЗХУША хийгдээгүй бол нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэхээс татгалздаг¹⁰.

ЗШТХ зорилго бол хувь этгээдэд эрх зүйн хамгаалал олгох явдал бөгөөд зөвхөн захиргааг хянахад чиглээгүй тул дээрх тохиолдолд ЗХУША явуулж бусад тохиолдолд голмдлыг хүлээн авч ЗХУША явуулдаггүй¹¹.

Дараачийн нэхэмжлэл буюу ЗХУША шаардлагагүй нэхэмжлэлд эс үйлдэхүйгээр илэрч байгаа захиргааны актын эсрэг даалгах¹², хохирлоо арилгуулах /үйлдүүлэх нэхэмжлэлд ордог/ тогтоох нэхэмжлэл зэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдэхээс бусад нэхэмжлэлийн шаардлага хамаарна. Дээр дурдсан ЗХУША-г нөхцөл болгосон байдлыг дүгнээд үзвэл нэхэмжлэх эрх нэгдэх нөхцөл нь нэхэмжлэлийн төрлөөс хамаардаг, ЗХУША нь үүнээс шалтгаалах нөхцөл болдог гэсэн тайлбар гаргаж болохоор байна. Энэ нь ч ЗХШ-ийн үндсэн зориулалтаас улбаатай. Харин АНУ-д Давж заалдах үнэм зүйн шүүхээр хянуулах нэхэмжлэгчид хохиролтой бол шууд шүүхэд хандан хүлээн авахыг шүүх шийддэг¹³ зохицуулалттай. Ийм ч учраас Шоллер хохирлоо арилгуулахдаа ЗХУША-г дамждаггүй шууд шүүхэд хандах хуулийн зохицуулалтын дагуу 30 хонголт эрхээ сэргээлгэсэн байна.

Илтгэлийн тодорхойлох хэсгээс харвал Монгол Улсын ЗХШТХ-ийн зориулалт нь захирагч хянах түүний үйл ажиллагааг хууль ёсны болгохын тулд дотоод хяналт хэрэгжүүлэх ЗХУША-г нэхэмжлэх нөхцөл болгон оруулсан.

Үүнийг ҮНДСЭН ЗОРИУЛАЛТ руу чиглүүлэхэд яах ёстой вэ?

3 ҮНДСЭЛЭХ НЬ БУЮУ АСУУДЛЫГ ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭВЭЛ

ЗХУША-г шүүхэд хандах эрх нэгдэх нөхцөлийн нэг болгон хуульчилснаар захиргаа өөртөө хяналт тавих болон шүүхийн ачааллыг багасгах зорилгыг агуулсан хэдий ч зарим сөрөг үр дагаварыг агуулж байгаа нь түүний үндсэн зориулалт зарчмын үүднээс хандвал нотлогдож байна. Энэ нь чухам юунд байна вэ? гэвэл манай улсад ЗХУША нь захиргааны актын шинж чанар үйлчлэлт түүнд үндэслэх субъективт эрхийг хамгаалах нэхэмжлэлийн шаардлагын дагуу тодорхойлогдох бус давж заалдах шатны шийдвэрлэх боломж шүүхийн үзэмжээр тодорхойлогдох шүүхэд хандах эрх нэгдэх нөхцөл билээ. Энэ нь дарах үндэслэлээр нотлогдоно:

- ЗХШ-д хандахад ЗХШТХ-ийн 34.1.3-т заасны дагуу ЗХУША явуулах эсэхийг шүүх шийддэг. Ингэхдээ хуулийн логикийг анзаардаггүй, тухайн завлтыг буруу хэрэглэдэг;

- ЗХШ-д хандах нэхэмжлэх эрх нэгдэх нөхцөл болсон ЗХУША-ны шаардлагыг нэхэмжлэлийн шаардлагын төрлөөр тодорхойлдоггүй;

- Хохирлоо арилгуулах тогтоох нэхэмжлэл нь бие даасан шаардлагаар нэхэмжлэлд агуулагдаж байхад үүнийг шийдвэрлүүлэхээр ЗХШТХ-ийн дагуу ЗХУША явуулах бололцоотой гэж буцаадаг. Гэтэл УША-аас дээрх шаардлагыг хангасан шийдвэр гардаггүйг 8.1-т заасан байгаа. Эсрэгээрээ ЗХШТХ-ийн 34.1.3-ыг зөв хэрэглэхэд "ЗХУША-г хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг УША-г явуулахыг хуульч шаардсан боловч үүнийг хэрэгжүүлбэл нэхэмжлэгчид сөргөөр нөлөөлөх эвсэл УША-аас үр дүн гарахыг 8.1-т зааснаас өөр шаардлагыг

⁸ Verwaltungsverfahrensgesetz, VwGO Geltung ab 01.01.1964

⁹ Шоллер Х. Хууль зүйн дүгнэлт гаргах болон шүүхийн шийдвэр гаргах зарим асуудал.

¹⁰ Харбию Ю. ХБНГУ-ын Захиргааны шүүхийн тухай хуулийн дагуу хийгдэх ЗХУША. УБ., 2004 он, Захиргааны хэргийн шүүхийн 173 дахь тал далхийн улсуудын тогтоолоор, 173 дахь тал

¹¹ Мөн тэнд

¹² Энэ санааг А.Эрдэнэцогт Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2005 он, 56 дахь талвас

¹³ Гадаад орнуудын Захиргааны хэргийн шүүх. Цуврал №6, УБ., 2005 он.

нэхэмжлэгч тавьсан” гэж тайлбарлах нь зүйтэй юм.

Иймээс захиргааны зарим хэрэгт урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй өнөөгийн практик нь нэг талаас ЗХШ-ийн жигд ачааллыг бий болгоход саад учруулж буй гол хүчин зүйлийн нэг болсон төдийгүй иргэн, хуулийн этгээдийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах нэг нөхцөл ч байж болохгүй тул даруй өөрчлөн боловсронгуй болгох шаардлага тулгамдаад¹⁴ байна гэж үздэг. Могол Улсын ЗХХШТХ-ийг хүний эрхийг хангах эрх зүйт ёсны шаардлагын үүднээс авч үзвэл дараа өөрчлөлт, зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай болох нь тогтоогдож байна.

1. Хууль тогтооцоос ЗХУША –г илүү уян хатан хандаж, нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл болгон зохицуулсан ЗХХШТХ-ийн 34.1.3 дахь заалтыг үр дүнтэй хэрэглэж, УША-с гаргах боломжгүй шийдвэр гаргуулахыг шаардсан нэхэмжлэлийг шууд гаргаж хүлээн авахаар өөрчлөх. Энэ хэсэгт хэрэв Засгийн газар нь нь ЗХУША-ны журмаар доод шатны¹⁵ байгууллагыг хянасан шийдвэрийг ЗХШ авч хэлэлцэх бололцоо хаагдмал тул үүнийг дээрх заалтад оруулсан ЗХУША-ны зорилго алдагдах тул үүнийг ЗХУША-аар зохицуулах боломжгүй гэж өргөтгөн тайлбарлаж болно.

2. Захиргааны процесс нь хэрэг маргааныг шийдвэрлэх журам буюу зөрчигдсэн эрхээ шүүхэд сонсож мэдэгдэх, басхүү шүүх шударга шийдвэрт хүргэх арга замыг заасан зохицуулалт болох тул шүүхэд нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөлийг энэ талаас нь зохицуулж

хүний эрхийг хамгаалах боломжит хувилбараар буюу хүчингүй болгох татгалзлын эсрэг даалгах нэхэмжлэлийг л ЗХУША явуулах болон бусад шаардлагын хувьд шууд шүүхэд хандахаар хуульчлах зэрэг боломж байна.

Тэгвэл энэ боломжийг хэрэгжүүлэх ямар арга зам байна вэ?

4/ ТОГТООХ НЬ БУЮУ САНАЛ ДҮГНЭЛТ

Сэдийг судлах явцад ЗХУША нь шүүхэд нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөл болохын хувьд өөртөө зарим онцлог шинжийг агуулж хүний субъектив эрхийг хамгаалах агуулга бүхий эрх зүйн зөв зохицуулалт шаардсан судлагдахуун болох нь тогтоогдсон юм. Манай улсын Захиргааны хэргийн шүүх түүнийг хэрэгжүүлэгч шүүгчид энэхүү нөхцөлийг иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалах тал дээр нь ач холбогдол өгч, хуулиар олгосон боломжийг зөв ашигладаггүй нөгөө талаас ЗХХШТХ-д хүний эрхийг шуурхай хангаж, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох ач холбогдол бүхий нэхэмжлэлийн шаардлагын хувьд ЗХУША явуулахыг шүүхэд хандах эрх нээгдэх нөхцөл болгон тавьснаараа Монгол Улсын Үндсэн хуулинд заасан шүүхээр эрхээ хамгаалуулах эрхийг хязгаарлаж байгаа нь тогтоогдов.

Илтгэчийн зүгээс “Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөлийг ЗХШ-ээс үндэслэх асуудал” буюу тэр дундаа гомдлыг ЗХУША-аар шийдвэрлэсэн

нөхцөлийг шүүхээс үнэлэх асуудлыг харьцуулсан болон практик судалгаа хийсний үндсэн дээр ЗХХШТХ болон ЗХШ-ийн практикт буй тулгамдсан асуудалд иргэн, хуулийн этгээдийн субъектив эрхийг хамгаалах нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процессын зориулалт мөн гэсэн үүднээс дараах саналыг ТОГТООХ нь:

1. ЗХХШТХ-ийн 34.1.3 дахь заалтыг зөв хэрэглэж ойлгох талаар Улсын дээд шүүхээс тайлбар гаргах. Ингэхдээ 8.1-т заасан ЗХУША-аас гарах боломжгүй шийдвэрийг гаргуулах болоод Засгийн газар нь давж заалдах шатны захиргааны байгууллага болох бол шууд шүүхэд нэхэмжлэл гаргаж байх зэрэг болон бусад агуулгатайгаар тусгаж өгөх;

2. Цаашид ЗХШ-ийн үндсэн зориулалтад ач холбогдол өгч ЗХХШТХ-д заасан УША-н нөхцөлийг бусад улсын жишигт нийцүүлэн нэхэмжлэлийн төрлөөр зохицуулах, ингэхдээ ЗХХШТХ-ийн дагуу хүчингүй болгох татгалзлын эсрэг нэхэмжлэлийг¹⁶ л урьдчилан шийдвэрлүүлэх нөхцөл болгон хуульчлах. Энэ нь ЗХХШТХ-ийн 8,12,34,70 дугаар зүйлд тусгагдах боломжтой.

Дээрх зүйлийг хангасан цагт Дорж, Шоллер хоёр тэгш эрхтэй болж, Монгол Улсын иргэн Дорж жинхэнэ утгаараа эрхээ сэргээгдэх хуулийн зохицуулалт бүрдэх юм.

Эцэст нь **Шударга ёс бол хүний эрхийг хангахаар илэрнэ. Хуулиуд нь шударга ёсны шүтлүүрээр л эрх зүй болдог** гэсэн үгээр илтгэлээ төгсгөө.



¹⁴ Эрдэнэцогт А. Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй. УБ., 2005 он, 56 дахь тал.

¹⁵ Сарантуяа Ц. Үндсэн хуулийн процессын эрх зүйн суурь ойлголт тулгамдсан асуудал. УБ., 2005 он, 168 дахь тал.

¹⁶ Засгийн газрыг ЗХХШТХ-ийн 4 дүгээр зүйлээс хассан тохиолдлыг авч үзсэн.

¹⁷ Энэ нь идэвхтэй үйлдэл тул захиргааны байгууллага дотооддоо хяналт тавих мөн чанарыг агуулдаг.

"Хөгжил ба эрх зүй" эрдэм шинжилгээний бага хуралд "Оны судлаач оюутан"-аар шалгарсан илтгэл

ИРГЭНИЙ НЭР ТӨРИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙГ ШҮҮХ ХЭРЭГЛЭЖ БҮЙ БАЙДАЛ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
оюутан **Б.МЭРГЭН**

НЭГ. Илтгэлийн зорилго

Шүүхэд хандаж буй нэр төр сэргээлгэх нэхэмжлэлийн тоо жил тутам өссөөр байгаа бөгөөд манай улсын шүүхүүд түүнтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ тохиолдол (буюу субъектийн)-ын онцлог шинжийг төдийлөн харгалзахгүйгээр маргаан бүрийг адил зарчмаар шийдвэрлэж байна. Үүнийг шүүхийн практикаас нээн илрүүлж, шүүхээс төрийн өндөр албан тушаалтан, олон нийтэд алдартай хүн болон зигийн иргэдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангахдаа ялгаатай зарчим баримтлах шаардлагатай нотлоход илтгэлийн маань зорилго оршино. Үүний тулд юуны өмнө иргэний нэр төртэй байх эрхийн үндсийг Үндсэн хуулиас тодруулъя.

ХОЁР. Нэр төртэй байх эрхийн үндэс

Хүний эрхэмсэг чанар болон бие хүн болох шинж чанар нь түүнд эрх зүйн этгээд болох шинж чанарыг олгож буй ба хүн зөвхөн оршин байгаа гэдгээрээ л тодорхой эрхийг эдэлдэг. Үүнийг хүний эрх гэдэг. Ийм эрх нь хүний натуртай холбоотой буюу тэдгээр нь заяамал, төрөлхийн эрх байдаг бөгөөд тэдгээрт "тодорхой байх" шинж чанар дутдаг учраас шууд

хэрэгжүүлэх боломжгүй. Энэ дутагдлаас ангижруулахын тулд "тодорхой байх" шинж чанарыг "олгож" амьдралд хэрэгжүүлэх үүднээс тэдгээрийг төрийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулахыг эрмэлзэж, улс орнуудын Үндсэн хуулиудаар бэхжүүлдэг.¹ Хүний болон иргэн хүний эрх зүйн байдлыг хангахад суурь ач холбогдолтой Үндсэн хуулинд бэхжигдсэн эдгээр эрхүүдийг үндсэн эрх гэнэ.

Үндсэн эрхүүдийн суурь эрхүүд нь Бастиагийн хэлсэнчлэн "Хүн бүрт амьдралын шаардлагаас нь үүдэн гардаг өөрийн бие /амь амьдрал/, эрх чөлөө, өмч хөрөнгөө хамгаалах заяамал эрх юм."² /Локк ч бас ингэж үзэж байв/ Эдгээр эрхийн нэгдмэл зүй ёсны байдал нь хүний эрхэмсэг чанараар илэрхийлэгдэж хамгаалагддаг. Энэ ч утгааргаа ХХ зууны үед үндсэн эрхийн үндэс нь хүний эрхэмсэг чанар гэсэн санаа нэлээд дэлгэрсэн ба орчин үеийн либераль ардчилсан төрүүдийн Үндсэн хуулинд уг санаа бэхжигдсэн юм". Тухайлбал,

ХБНГУ-ын Үндсэн хууль (1949) чухамхүү энэ эрхээр эхэлдэг ба түүний нэгдүгээр зүйлд "Хүний эрхэмсэг чанар халдашгүй байна. Түүнийг хүндэтгэх ба хамгаалах нь төрийн бүх эрх мэдэлтний үүрэг мөн"³ гэсэн байдаг бол ОХУ-ын Үндсэн хуулийн (1993) 21 дүгээр зүйлд "Достоинство личности охраняется государством. Ничто не может быть основанием для его

уменьшения" гэж бэхжүүлсэн байна.

Ийнхүү үндсэн эрхийн суурь эрх нь эрхэмсэг чанараар илэрхийлэгдэж хамгаалагддаг юм бол хууль зүйн шинжлэх ухаан өндөр түвшинд хөгжсөн орнууд Үндсэн хуульдаа үндсэн эрх хэмээн бэхжүүлсэн байгийн хувьд нэр төртэй байх эрхийн үндэс нь эрхэмсэг чанар юм.

Монгол Улсын хувьд нэр төртэй байх эрхийг үндсэн эрхийн тоонд оруулж хуульчлаагүй ч Үндсэн хуулийнхаа 17 дугаар зүйлийн 17.1.2-т "Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүргийг ёсчлон биелүүлдэг" хэмээн хүний нэр төртэй байх эрхийг хамгаалжээ.

ГУРАВ. Иргэний нэр төрийг иргэний хуулиар хамгаалсан нь

Эрх зүйн ерөнхий онолын хүрээнд нэр төртэй байх эрхийн үндэс нь эрхэмсэг чанар байж тэр нь босоо түвшинд Үндсэн хуулиар хамгаалагддаг бол Иргэний эрх зүйд хүн зүгээр л оршин байгаагийнхаа хувьд эдлэх ёстой эрхүүдийг нь хамгаалах замаар эрхэмсэг чанарыг хэвтээ түвшинд бэхжүүлдэг. Үүний тулд Иргэний эрх зүйгээр иргэний нэр, дүрс, нэр төр, алдар хүндийг хамгаалдаг. Эдгээрийг товчлон авч үзвэл:

¹ Сарантуяа Ц, Эрх зүй сэтгүүл №1/2. Үндсэн эрх болон хүний эрх: харьцуулалт, онолын эргэцүүлэл. УБ., 2000 он, 19 дэх тал.

² Claude-Frederic Bastiat. The Law. /www.bastiat.com/

³ Сарантуяа Ц, Эрх зүй сэтгүүл №1/2. Үндсэн эрх болон хүний эрх: харьцуулалт, онолын эргэцүүлэл. УБ., 2000 он, 19 дэх тал

⁴ Ведомство печати и информации Федерального правительства. Основной закон Федеративной Республики Германии. С.13

1.Иргэний нэр: Нэр нь хүний салшгүй хэсэг болохын хувьд иргэн бүрийг бие хүн болгон тодорхойлж⁶ буй нэг хэлбэр бөгөөд иргэний эрх зүйн бүх эрхийг зөвхөн өөрийн нэрээр олж авдаг. Тиймээс тухайн субъектээс өөр бусад этгээд түүний нэрийг ашиглан иргэний эрх олж авах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл хийх, ашиг хонжоо олох, олон нийтийг төөрөгдөлд оруулах⁷ зэргээс Иргэний эрх зүй хамгаалж байдаг.

2.Иргэний дүр: Хүний дүрс нь түүнийг хүн болохынх нь хувьд хэлбэр талаас нь тодорхойлж байдаг бөгөөд Иргэний эрх зүйгээр хүнийг гутаах зорилго агуулаагүй ч иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ямарваа нэгэн хэлбэрээр дүрслэн нийтэд тараасны улмаас түүнд гэм хор учрахаас хамгаалж байдаг.⁷

3.Иргэний нэр төр, алдар хүнд: Нэр төр гэдэг бол иргэний ашиг сонирхол, ёс зүй, ажил хэргийн болон мэргэжлийн чадварын эерэг үнэлэмж буюу эрх зүйн унэт зүйл, бусад этгээдээс түүнд өгөх үнэлгээ юм. Харин алдар хүнд нь хүний нэр төртэй нягт уялдаа холбоо бүхий категори бөгөөд нийгэмд эзэлж буй байр суурийн илрэл. Өөрөөр хэлбэл нийгмээс түүнд өгсөн үнэлгээнд үндэслэн түүний өөрийгөө үнэлэх үнэлэмж юм.⁸

Илтгэлийнхээ сэдэвтэй холбогдуулан нэр төртэй байх эрхийг Иргэний хуулиар хамгаалахдаа ХБНГУ-д үйлчилдэг дараах зарчмыг авч үзье.

Хүний нэр төр, алдар хүнд нь амины эрх бөгөөд хүн өөрөө өөрийгөө тодорхойлох буюу тодруулж хэлбэл, тухайн хүн өөрөө өөрийгөө болон бусад этгээдээр хэрхэн үнэлүүлэхээ шийдвэрлэх эрхтэй. Энэ нь бодит байдалд нийцсэн эсэхээс үл хамааран тухайн иргэний зөвшөөрөлгүйгээр тарагдсан мэдээлэл бусад этгээд түүнийг өөрийнх нь хүсээгүй байдлаар үнэлэхэд хүргэсэн нь шүүхээр нэр төрөө сэргээлгэх

үндэслэл болдог гэсэн үг.

Харин манай улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ⁹ 511 дүгээр зүйлийн 511.1-т "Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцж байгааг нотолж чадахгүй бол эд хөргөнийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ"¹⁰ гэж заасан байдаг.

Дээрхээс харахад Германд тарагдсан мэдээ бодит байдалд нийцсэн эсэхээс үл хамааран бусад этгээд өөрийнх нь хүсээгүй байдлаар үнэлэхэд хүргэсэн нь иргэний нэр төрөө сэргээлгэх үндэслэл болно гэсэн зарчим үйлчилдэг бол манай улсад тарагдсан мэдээ бодит байдалд нийцж байвал нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохоор зохицуулжээ.

ДӨРӨВ. Шүүхээс нэр төр сэргээлгэх нэхэмжлэлийг шийдвэрлэх тухайд

Шүүх эрх мэдлийн үндсэн чиг үүрэг нь бусдын дур зорго хийгээд халдлагаас иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах, учирсан хохирлыг арилгуулах, эрхийг зохих түвшинд нь эргүүлэн сэргээх явдал юм. Энэхүү чиг үүргийнхээ хүрээнд шүүхээс нэр төр сэргээлгэхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ талуудын эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байж, тохиолдол бүрийн онцлог шинжийг харгалзан үзэж үндэслэлтэй шийдвэр гаргах нь нэн чухал.

Ийнхүү шүүхээс нэр төр сэргээлгэхтэй холбоотой маргааныг хянан үзэдэг:

1.нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэх;

2.эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг тогтоох гэсэн хоёр асуудлыг давхар шийдвэрлэдэг.

Шүүхээс шийдвэрлэл зохих дээрх хоёр асуудлыг тус тусад нь авч үзье.

4.1.Нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэх

Өдгөө эрх зүйн ямар бүлд харьяалагддагаас үл хамааран АНУ хийгээд Европын зарим улсын шүүх иргэний нэр төр сэргээхтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ нийтлэг хэд хэдэн зарчмыг баримтлах болж энэ нь онолын түвшинд хөгжжээ. Тэдгээртээ илтгэлтэй холбогдуулан дараах зарчмыг авч үзье.

1964 онд АНУ-ын Дээд шүүх "New-York Times v. Sullivan" нарын хэргийг шийдвэрлэсэн бөгөөд энэ шийдвэртээ нэгэн эрх зүйн журмыг баталгаажуулсан нь жижиг европын улсуудын эрх зүйн тогтолцоонд жишиг болон хэрэглэгдэх болсон. Тухайн зарчмын дагуу төрийн өндөр албан тушаалтан хийгээд олон нийтэд алдартай хүмүүст хувийн нууц гэж байхгүй бөгөөд байх ч ёсгүй гэж үздэг.¹¹ Учир нь олон нийтийн анхаарал, хяналтад байнга байдаг, нийгмийн амьдралд голлох үүрэгтэй оролцдог тэдгээртэй холбоотой аливаа мэдээлэл нь хүмүүст ямагт эрэлт, хэрэгцээтэй байдаг. Эл эрэлтийг мэдээлэлгүй орхивол хардалт, цуурхал даамжирч, нийгмийн оюун санаанд тогтворгүй, зөрчилдөөнт нөхцөл байдал үүсдэг. Тиймээс тэдний талаар нээлттэй хэлэлцүүлэг хийх боломжийг нийтэд олгодог. Ингэхдээ тэдний эрхийг хамгаалах нэгэн зохицуулалт үйлчилдэг нь, олон нийтэд алдартай хүний тухай мэдээлэл нь нэр төрийг нь шууд санаатайгаар гутаах,

⁶ Бат-Өлзий Д. Иргэний эрх зүй I. УБ., 2003 он, 56 дахь тал.

⁷ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (өрсний ангил) УБ., 2005 он, 73-74 дэх тал.

⁸ Мөн нэм. 74 дэх тал.

⁹ Осавье К. Харьцуулсан эрх зүй судлал. УБ., 2005 он, 227 дэх тал.

¹⁰ Иргэний хууль. Төрийн мэдээлэл, №7. УБ., 2002 он.

¹¹ Мөн тэнд.

¹² Осавье К. Харьцуулсан эрх зүй судлал. УБ., 2005 он, 215 дахь тал.

ингэснээрээ тэдэнд хохирол учруулах зорилгыг агуулсан бөгөөд түүнийг нь мэдээлэл тараасан этгээд бус хохирогч өөрөө нотолсон тохиолдолд шүүх хэргийг авч хэлэлцдэг. Энэ нь хэрвээ олон нийтэд алдартай хүний тухай мэдээлсэн нь бодит байдалд нийцэхгүй гэж үзвэл тэрээр өөрөө няцаах үүргийг хүлээнэ гэсэн үг юм.

Харин энгийн иргэний хувьд түүний тухай мэдээлсэн нь бодит байдалд нийцсэн эсэхээс үл хамааран нэхэмжлэлийн шаардлагыг хангадаг байна. Үүний тулд мэдээлэл тараагдсанаар тухайн иргэнийг бусад этгээд өөрийнх нь хүсээгүй байдлаар үнэлэхэд хүргэсэн гэдгийг нотлоход л хангалттай.

4.2. Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг тогтоох

Иргэний нэр төрд халдан түүнд эдийн бус гэм хор учруулснаас үүсэх хохирлын хэмжээг нарийн тодорхойлох нь онолын хувьд боломжгүй. Иймээс эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг тогтооно нь шүүгчийн итгэл үнэмшил, дотоод үзэмжийн асуудал бөгөөд тийнхүү шийдвэр гаргахдаа Германы эрдэмтдийн боловсруулсан "Хүрээ хязгаарын онол"-д үндэслэж болох юм. Энэхүү онол нь нийгмийн харилцаанд оролцож буй хүний амьдралыг 5 хүрээнд хуваан авч үздэг. Үүнд:

-**Олон нийтийн** буюу олон нийттэй харилцаж буй хүрээ;

-**Индивидуаль** буюу төрөл төрөгсөд, найз нөхөд, хамт олон, ойр дотны хүмүүстэйгээ харьцаж буй хүрээ;

-**Нууцлын** буюу өдрийн тэмдэглэл, захидал, харилцаа холбоо, эрүүл мэндийнх нь талаарх асуудлын хүрээ;

-**Интим** буюу бэлгийн амьдралын хүрээ;

-**Хувийн амьдралын** буюу гэр бүлийн харилцаанд дахь хүрээ тус тус хамаарна.

Хүрээ хязгаарын онол нь хүний

амьдралын дээрх хүрээнийдийг эрэмбэлсний үндсэн дээр шүүгчид хариуцагч иргэний нэр төрд халдахдаа аль хүрээнд холбогдох мэдээллийг гуравдагч этгээдэд тараасныг нь үндэслэл болгон эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг дотоод үзэмжээрээ тогтооход тусалдаг. Тухайлбал, олон нийтийн хүрээнд халдсаныг гэм хор учруулсанд төдийлэн тооцдоггүй бол интим, хувийн амьдралын болон нууцны хүрээнд халдсан тохиолдолд ноцтой гэм хор учирсан гэж үздэг.

Мөн шүүгч тухайн мэдээлэл санаа болдоо илэрхийлэх замаар тархсан¹² нь илэрхий байвал эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг багасган тогтоох шаардлагатайг анхаарах нь зүйтэй юм.

ТАВ. Монгол Улсын шүүхийн практик¹³

Нийслэлийн 6 дүүргийн шүүхэд 1999-2001 онд зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувь хүн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тухай 79 иргэний маргаан шийдвэрлэгдэж, тэдгээрээс 47 нэхэмжлэлийн шаардлагыг нь хангаж байжээ.¹⁴ Ийм төрлийн нэхэмжлэлтэй иргэний маргааныг шүүхийн практикт хэрхэн шийдвэрлэж байгаа, тэрхүү шийдвэр нь онолын болон хууль зүйн үндэслэлтэй эсэх, эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг тогтооходоо юуг шалгуур болгож байгаа зэргийг шүүхийн шийдвэрүүдээс авч үзье.

№1. Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2004 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 823 дугаар шийдвэр.

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Г: "Иргэн Б намайг 20 гаруй хүний дэргэд 50 сая төгрөг Ж-ээс авсан хэмээн гүтгэсэн. Үүнээс болж сэтгэл санаа хямарч, бие өвдөх болсон. Нэр төрийг минь сэрээлгэж, сэтгэл санааны хохиролд 5 сая төгрөг төлүүлж өгнө үү" гэсэн нэхэмжлэл гаргажээ.

Шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн өмгөөлөгч Ө гаргасан тайлбартаа: Г-ийн нэр хүнд ямар байдалд байдгийг олон түмэн мэднэ.

Иймд нэр алдагттай хүний нэр хундад халдсанаараа хэрэг илүү ноцтой байна" гэжээ.

Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шийдвэрийн ҮНДЭСЛЭХ хэсэгт: "Хариуцагч Б нь Г-ийн талаар ярьсан зүйлийнхээ үнэн зөв болохыг нотлоогүй байна. Эрх нь зөрчигдсөн Г-ийн шаардлагаар уг Алауа няцаах үүрэгтэй. Харин эдийн бус гэм хорыг арилгуулахдаа нэхэмжлэлийн шаардлагын 10 хувьтай тэнцэх хэмжээгээр тооцож, хариуцагчаас гаргуулах нь зүйтэй" гэж бичсэн байна.

Анхан шатны шүүхийн шийдвэр онолын түвшинд авч үзвэл үндэслэлгүй байна. Учир нь Засаг дарга Г төрийн өндөр албан тушаалтан болохын хувьд Б түүнийг Ж-ээс 50 сая төгрөг авсан байж болошгүй хэмээн хэрэгд эрхтэй бөгөөд энэ ч үүднээс иргэн Б шүүхийн өмнө Г-г 50 сая төгрөг авсан болохыг нотлох бус эсрэгээрээ Г өөрөө 50 сая төгрөг Ж-ээс аваагүй болохоо нотлох үүрэгтэй юм. Мөн нэхэмжлэлийн шаардлагын 10 хувийг хангасан үндэслэл нь тодорхойгүй бөгөөд цөөнгүй тооны шүүхийн шийдвэрүүдийг харж байхад эдийн бус гэм хорыг арилгахдаа нэхэмжлэлийн шаардлагын 10 орчим хувиар хэмжээг нь тогтоодог практик манайд тогтсон нь ажиглагдсан.

№2. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 296 дугаар магадлал.

Иргэн Ч Сүхбаатар дүүргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: "Г сонинд нийтлэгдсэн "Б-ийн бас нэг шоу эхэллээ" гарчиг бүхий нийтлэлд иргэн намайг сул дорой, хүний үгэнд автамтгай, ашиглагдаж болох, сэтгэл мэдрэлийн өвчтэй шахуу, оюун ухааны хомсдолтой, хэрэг



¹² Осакве К. Харьцуулсан эрх зүй судлал. УБ., 2005 он.

¹³ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмгэлт. Иргэний хэрэг. УБ., 2006 он.

¹⁴ Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн хэрэг маргааныг шүүхэд шийдвэрлэсэн талаарх судалгааны тайлан. Сэтгүүлч Би хууль. УБ., 2001 он.

түвэгт холбогдож байсан мэтээр нийгмийн дунд өөрийгөө жолоодох чадваргүй гэж дүгнэн бичиж, нэр төрийг минь орон даяар гутаан доромжилсон гомдолтой байна. Иймд миний нэр төрийг сэргээж, сэтгэл санааны хохиролд будг 5 сая төгрөг нэхэмжилж байгааг “Ү” сонини газраас гаргуулж өгнө үү” гэжээ. Хариуцагчийн өмгөөлөгч тайлбартаа: “Нийтлэлд Ч-ийн нэр төрийг гутаасан боловч бодит байдал, албан ёсны эх сурвалжаар нотлогдож байгаа тул хэргийг хэрэгсэхгүй болгож өгөхийг хүсье. Анхан шатны шүүх Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дэх заалтыг буруу хэрэглэсэн болно гэсэн байна. Нийслэлийн давж заалдах шатны шүүх хэргийг хянан дээд хариуцагч нэхэмжлэгчийн талаар үнэн бодит мэдээлэл бичсэн гэж тайлбарласан нь шүүхийн шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгох үндэслэл болохгүй. Эдийн бус гэм хорыг арилгуулахаар 1 сая төгрөгийг хариуцагчаас гаргуулах тухай Анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй байна.” гэжээ.

Нийслэлийн давж заалдах шатны шүүх онолын түвшинд үндэслэлтэй шийдвэр гаргасан байна. Илтгэлийнхээ 4 дэх дэд хэсэгт тайлбарласанчилан энгийн иргэний талаарх мэдээлэл нь үнэн байх эсэхээс үл хамааран түүний тухай бусад этгээд өөрийнх нь хүсээгүй байдлаар үнэлэхэд хүргэвэл нэр төрд нь халдсан гэж үздэг. Давж заалдах шатны шүүгч шийдвэр гаргахдаа чөлөөтэй хөрвөх зарчимн дагуу маргаан хянан шийдвэрлэж буй хуулийнхаа үг үсэгхэн төдийд захирагдалгүй, түүний ерөнхий

зарчим, Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн, эрх зүйн ерөнхий онолын хүрээнд маргааныг шийдвэрлэсэн нь сайшаалтай байна.

Хариуцагчийн өмгөөлөгчийн тайлбар дээрх онолын эсрэг байр суурьтай байгаа нь харагдаж байна. Энэ нь огт үндэслэлгүй зүйл биш бөгөөд тэрээр Иргэний хуулийн 21.2 дахь заалтын “үнэн зөвийг нотолж чадахгүй бол”, 511.1 дэх заалтын “бодит байдал нийцэж байгааг нотолж чадахгүй бол” гэсэн хуулийнхаа хэм хэмжээг үндэслэсэн байна.

Судалгаа хийх явцад Монгол Улсын шүүхийн практикт ихэнх тохиолдолд Иргэний хуулийн дээрх заалтуудыг шууд хэрэглэн маргааныг шийдвэрлэдэг нь харагдаж байсан юм. Үүний нэгэн жишээг доор авч үзье.

№3. УДШ-ийн 2005 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 478 дугаар тогтоол.

Нэхэмжлэгч Н шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: “Нэгэн жагсаал, цуглааны үеэр “О” телевиз надаас ярилцлага авсан. Тэр оройдоо зуралтаар гарган намайг согтоу жагсаалд оролцож байна, архичин гэж доромжилсон. Иймээс нэр төрийг минь сэргээх, сэтгэл санааны хохиролд 10 сая төгрөг нэхэмжилж байна” гэжээ. Хариуцагч “О” телевизийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ө шүүхэд гаргасан тайлбартаа: “Жагсаалд улс төрийн зорилготой, орилж дайрсан согтоу хөлчүү хүмүүс байсан. Н-ээс авсан ярилцлагатай мэдээний эх материал бидэнд байгаа учраас түүний талаар мэдээлсэн зүйлээ нотолж чадна” гэжээ. УДШ

хэргийг хянаж үзээд: “Анхан болон давж заалдах шатны шүүхийн баримталсан хуулийн зүйл, заалт зөв байна.

Н-ийн хяналтын гомдлыг үндэслэн шийдвэр, магадлалыг өөрчилж, хүчингүй болгох хууль зүйн үндэслэл алга” гэжээ.

ЗУРГАА. Дүгнэлт

Хууль зүйн шинжлэх ухаан өндөр хөгжсөн орнуудын шүүх нь нэр төр сэргээлэх нэхэмжлэл бүхий маргааныг шийдвэрлэхдээ баримталдаг зарчмаар олон нийтэд алдартай хүн өөрөө өөрийгөө бусдаар хэрхэн үнэлүүлэхээ шийдвэрлэх аминь эрх буюу нэр төртэй байх эрх нь жирийн иргэнийхээс хязгаарлагдмал байж, өөрийнх нь тухай бодит байдалд нийцээгүй мэдээлэл тараасан гэж үзвэл түүнийгээ нотлох үүргийг өөрөө хүлээдэг.

Харин жирийн иргэний хувьд өөрөө л хүсээгүй бол үнэн эсэхээс үл хамааран өөрийнх нь тухай мэдээлэл тараасныг нэр төрд нь халдсан гэж үзэх давуу эрхтэй байдаг.

Тиймээс шүүх маргааныг дээрх зарчимд нийцүүлэн шийдвэрлэж гэмээн иргэний нэр төртэй байх эрх хамгаалагдах учиртай. Үүний тулд:

1. Иргэний хуульдаа дээрх зарчимд нийцсэн заалт нэмж оруулах;

2. Эсвэл шүүгч шийдвэр гаргахдаа чөлөөтэй хөрвөх зарчмыг хэрэглэн онолын түвшинд маргааныг шийдвэрлэдэг болох шаардлагатай байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ 2007 ОНЫ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Цагдаагийн ерөнхий газраас 2007 онд гэмт хэрэгтэй тэмцэх, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх, иргэд, байгууллагад ажил үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, сургалтын арга, хэлбэрийг боловсронгуй болгож, алба хаагчдын мэдлэг, чадавхийг сайжруулах, цагдаагийн байгууллагын ажлыг иргэд олон нийтэд ойлгуулах, тэдний дэмжлэг туслалцааг авах, оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Манай улсад гэмт хэрэг үүдэн гарч буй шалтгаан нөхцөл нь нийгэм, эдийн засаг, эрх зүй, улс орны хөгжлийн үйл явцтай салшгүй холбоотой бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх асуудал нь аль ч нийгмийн үед төрийн чиг үүрэг байсан, цаашид ч иргэд олон нийтийн амгалан тайван аж төрөх нөхцөлийг бүрдүүлж өгөх нь улс орны хөгжлийн чиг хандлагын нэг хэсэг гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллага, 2007 оны эхний 11 сард иргэдээс гэмт хэргийн шинжтэй 70630 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 21.3 хувиар, манай улсад 19344 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 18.0 хувиар өсч, бүх гэмт хэргийн 82.9 хувийг хөнгөн, хүндэвтэр, 17.1 хувийг хүнд, онц хүнд гэмт хэрэг эзэлж байна.

Статистик мэдээнээс харахад иргэдээс хүлээн авсан өргөдөл гомдол, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг өссөн байгаа.

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах төрийн чиг үүргийг гардан хэрэгжүүлж байгаа цагдаагийн байгууллагаас бодлогоо зөв тодорхойлж, иргэд, олон нийтийн амгалан тайван аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх баталгааг бий



ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвийн дарга, цагдаагийн хурандаа П.ИХЗАЯА

болгох нь нийгмийн тулгамдсан, төр засгийн бодлогын төвд байх асуудал учраас анхаарал төвлөрүүлж, шийдвэрлэвэл зохих арга хэмжээг дэс даравтай авч хэрэгжүүлэх явдал нэн чухал байна.

Цагдаагийн байгууллагын хэнтэй ч хуваалцашгүй үүрэг бол гэмт хэрэг нэг бүрийг илрүүлэх явдал. Энэ үүргээ хэрэгжүүлэхдээ гэмт хэргийн илрүүлэлтийг тооцох аргачлалаа үе үе өөрчилж ирсэн нь ч үүнтэй холбоотой.

Гэмт хэргийн илрүүлэлтийг бүртгэгдсэн бүх хэргээс, нууц далд үйлдэлтэй хэргээс, гэмт хэргийн ангиллаас тооцож байсан аргачлалыг өөрчилж, энэ оноос "Бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг"-ээс тооцож байгаа, тодруулж хэлбэл, илрээгүй хэргээсээ илрүүлэлт тооцдог болсон, дэлхийн бусад орны жишигт ойртуулсан явдал юм.

2006 онд бүртгэгдсэн бүх гэмт хэргийн илрүүлэлт 90 хувь

байсан бол 2007 оны эхний 11 сард бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргээс буюу шинэ аргачлалаар тооцоход илрүүлэлт 28.0 хувьтай байна.

Энэ аргачлалаар илрүүлэлтийг ангиллаар нь тооцож үзвэл, хөнгөн ба хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 25.5, хүнд ба онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 43.4 хувьтай байна.

Дээрх аргачлалыг мөрдөх болсоноор гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр төр, засгаас авч хэрэгжүүлэх бодлого, зорилгоо оновчтой тодорхойлоход дөхөм үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг дээр ажиллах, хүч хэрэгсэлээ оновчтой хуваарилах боломжийг бүрдүүлэх, цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал, ажлын үр дүнг бодитой үнэлж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах боломжтой болж байна.

Манай төвөөс "Монгол улсад гэмт хэрэг үүдэн гарч буй шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйл"-ийн талаар Улаанбаатар хотын 270 иргэнээс социологийн судалгааг авав. Социологийн судалгааны дүнг нэгтгэн дүгнэлт хийж гэмт хэрэг үүдэн гарч байгаа шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлд багцалж тусгасан болно.

Нэг. Архидан согтуурал

Манай орны нөхцөлд архидан согтуурах явдал гэмт хэрэг үүдэн гарах нэг шалтгаан нөхцөл хэвээр байна. Монголын хүнсчдийн холбооноос хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 69.5 хувь нь сард 2 удаа, 26.6 хувь нь сард 4 удаа, 3.8 хувь нь архи байгаа, харин орон нутгийн оршин суугчдын 75.1 хувь нь сард 2 удаа, 21.7 хувь нь сард 4 удаа, 3.0 хувь нь байгаа архи хэрэглэдэг гэсэн статистик гарчээ. Үүний хувьд 3500

төгрөгөөс дээш үнэтэй архийг 38.4 хувь нь, 2000 төгрөгөөс доош үнэтэй архийг 24.2 хувь нь хэрэглэдэг байна.

Дэлхийн бөмбөрцөг дээр 7.0 тэрбум орчим хүн амьдарч буйн 2.0 тэрбум нь архи уудаг гэсэн тооцоо байдаг, Монголчууд энэ үзүүлэлтээр дээгүүрт орж байна.

Манай улсын насанд хүрсэн нэг хүний архины хэрэглээ сүүлийн 3 жилд хурдацтай нэмэгдэж, өмнөх жилүүдийнхээс 43.2 хувиар өссөн байна. 2003 онд насанд хүрсэн хүний нэг жилийн архины дундаж хэрэглээ 7.8 литр байсан бол 2006 онд 9.2 литр болж өсчээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар манай улсын нийт хүн амын 13.6 хувь нь архинд донтох эмгэгтэй, эрэгтэйчүүдийн 39.0 хувь, эмэгтэйчүүдийн 5.0 хувь нь архийг хэтрүүлэн хэрэглэдэг болохыг тогтоогоод байна.

Согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчид нь залуужиж, архинаас үлдэлтэй гэмт хэрэг, осол гэмтэл, хохирлын хэмжээ өсч, эцэг эх, гэр бүлийн гишүүдийн үлгэргүй байдал, архинд согтуурах явдал их байгаа нь гэмт хэрэг, зөрчил үүдэн гарах нэг шалтгаан болсоор байна.

2007 оны эхний 11 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн хэрэг манай улсад бүртгэгдсэн бүх хэргийн 23.0 хувийг эзэлж байна.

Хүнийг санаатай алах хэргийн 60.6, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэргийн 44.7, хүчиндэх хэргийн 55.0, булаах хэргийн 14.3, дээрэмдэх хэргийн 25.9, танхайрах хэргийн 61.1, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих хэргийн 19.6 хувь нь согтуугаар үйлдэгдэж.

Мөн хугацаанд амиа хорлох болон золгүй байдлаар 1584 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 12.1 хувиар өсч, 1319 буюу 83.3 хувийг золгүй байдлаар, 265 буюу 16.7 хувийг амиа хорлох тохиолдол эзэлж байна. Хонгт дунджаар 5 хүн амиа хорлох болон золгүй байдлаар нас барж байна.

Амиа хорлох болон золгүйгээр нас барсан хүмүүсийн 6.6 хувь нь насанд хүрээгүй, 11.1 хувь нь эмэгтэй, 14.7 хувь нь архинд согтуурсны улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон, золгүй байдлаар нас барагсадын 12.3 хувь нь архинд гүн хордсон байна.

2006 оны байдлаар манай улсад спиртийн 35, архины 113, ивондо 22 үйлдвэр, ресторан зоогийн газар 758, баар цэнгээний газар 1458, согтууруулах ундаа худалдаалдаг хүнсний дэлгүүр 5903, бөөний цэг 293 ажиллаж байв.

Спирт 4232.1 мянган литр үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 1.5 дахин, **архи** 8365.9 мянган литр үйлдвэрлэсэн нь 6.5 хувь, **пиво** 9067.3 мянган литр үйлдвэрлэсэн нь 1.9 дахин өссөн байна.

Согтууруулах ундааны импортын хэмжээ 10727.7 мянган литр байгаа нь өмнөх оны мөн өсч 1.4 дахин, үүнээс 10017.0 мянган литр **пиво импортлох** нь 1.4 дахин өссөн байна.

Эх орны үйлдвэрийн болон импортын архи, дарь, шар айргийг хэрэглэхээс гадна шимийн архи, зориулалтын бус спиртаар найруулсан "найрка" гэж нэрлэгдэх хуурамч архи ихээхэн хэмжээтэй байгаа нь нууц бич бөгөөд нийгэм архи, архидалтын байдалд дассан байна.

Үйлдвэрлэлийн хэмжээ их байгаа болохоор борлуулалт, эрэлт хэрэгцээ нь даган өсч, баар цэнгээний газар, дэлгүүрийн ашиг олох ганц бүтээгдэхүүн нь согтууруулах ундаа болжээ.

Архидалтын хор хөнөөлийг бууруулахад гурван чиглэлээр ажиллавал зохих үр дүнд хүрнэ гэж үзэж байна. **Нэгдүгээрт:** архины үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд төрөөс тавих хяналтыг сайжруулах, **хоёрдугаарт:** архидалтын хор хөнөөлийг бууруулах талаар соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, **гуравдугаарт:** архины эмчилгээг зөв зохиостой, жинхэнэ эмчилгээний үйлчилгээ рүү ойртуулах, архинаас хамааралтай буюу архинд донтох өвчтэй болсон хүмүүсийг эмчлэх тал дээр амхарал тавих ёстой.

хэлэлцүүлэг явуулж архины онцгой албан татварын 53.0 тэрбум төгрөгийн нэг хувийг архидалттай тэмцэх ажилд зарцуулах санаачилга гаргасныг цагдаагийн байгууллага дэмжиж байна.

Төр засгийн зүгээс согтууруулах ундааны импортыг хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэл явуулах лицензийг эрх баригсаг асуудлыг дэвшүүлж байна.

Архины үйлдвэрийг аттестатчилж, чанаргүй архи үйлдвэрлэдэг газруудыг нэн даруй хаах арга хэмжээ авах нь шаардлагатай болсон байна. Хүн амын сууршил нягтралтай уялдуулан архины үйлдвэрийн тоог тогтоож өгөх нь зүйтэй юм.

Архинд согтуурч буй залуусыг ажил хөдөлмөрт татан оролцуулж нийгэмшүүлэх арга хэмжээг төрийн зүгээс авах шаардлагатай байна.

Спирт, архи зарж амьдралаа залуугдаж хүмүүсийг амьжиргааны өөр эх үүсвэртэй холбож өгмөөр байна. Төвлөрсөн суурин газарт хэн дуртай нь "найрка"-г янз бүрээр савалж мөнгө олж байгаа нь нууц биш. Бид үүнийг мэддэг ч таслан зогсоож чадахгүй байна.

Улсын хэмжээнд архинд донтох өвчтэй 15 мянган хүн байна. Харин дэлхий дээр ганцхан манайд л эрүүлжүүлэх нь Цагдаагийн байгууллагад үлдэж. Архи уусан хөнгийг эрүүлжүүлнэ гэдэг хүний эрх, эрх чөлөөнд халдаж буй бүдүүлэг ажиллагаа.

Архинд хордох нь эрүүл мэндийн асуудал, харин архи уусан хүн гэмт хэрэг зөрчил гаргавал цагдаагийн байгууллагын ажил.

Жилд дунджаар 130 орчим хүн эрүүлжигдэж байгаа атлаа нэг ч хүн архины эмчилгээ, оношлогоонд орч чадахгүй үргэлжлүүлэн архи уусаар, цагдаагийн байгууллага эрүүлжүүлсээр, ийм л үр дүн багатай гинжин холбоо харагдаж байна. Манай улсад эрүүлжүүлэхийг цагдаагийн байгууллагын харьяаллаас гаргаж Эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх цаг нь болсон гэж үзэж байна.

"Зууны мэдээ" сонинны газраас

Хоёр. Ажилгүйдэл

2007 оны эхний 11 сарын байдлаар улсын хэмжээнд 16187 хүн хэрэгт холбогдон шалгагдсаны 10.7 хувь нь эмэгтэй, 8.1 хувь нь хүүхэд, үүнээс 6.7 хувийг оюутан, сурагч, 0.6 хувийг сургууль завсардсан хүүхэд, 0.5 хувийг тэнэмэл, 61.0 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс эзэлж байна.

Хүнийг санаатай алах хэрэгт холбогдогсдын 74.8, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэгт холбогдогсдын 58.7, хүчиндээ хэрэгт холбогдогсдын 61.4, хулгайлах хэрэгт холбогдогсдын 62.6, үүнээс мал хулгайлах хэрэгт холбогдогсдын 52.3, авто тээврийн хэрэгсэл хулгайлах хэрэгт холбогдогсдын 67.4, булаах хэрэгт холбогдогсдын 73.9, дээрэмдэх хэрэгт холбогдогсдын 67.4, заллиан мэхэлж авах хэрэгт холбогдогсдын 72.6, танхайрах хэрэгт холбогдогсдын 64.5 хувийг тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс байна.

Үндэсний статистикийн газрын 2007 оны эхний 11 сарын "Статистикийн бюллетень"-д тэмдэглэсэнээр улсын хэмжээнд 32058 тодорхой эрхэлсэн ажилгүй хүн бүртгэгдсэн, үүнээс 18394 нь эмэгтэй, 11025 нь 25-34 насны, нийгэмд байр сууриа бэхжүүлэх, хөдөлмөрийн үр шимийг хүртэх насны хүмүүс байна.

Тодорхой эрхэлсэн ажилгүйн улмаас архи уун согтуурч гэмт хэргийн замд гулсан эрхт байгаа эдгээр баримт нь манай улсад байгаа бодит дүр төрх, цагдаагийн болон эрүүл мэндийн байгууллагын ажлыг байнга хүндрүүлдэг нэг хүчин зүйл болж байна.

Гурав. Ядуурал

Төр засгийн зүгээс ядуурлыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч байгаа боловч ядуурлын талаар хийсэн судалгаагаар манай улсын нийт хүн амын 32.2 хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдарч байна гэсэн мэдээтэй байна.

Төлвөрсөн суурин газарт 6 хүний

нэг нь ажилгүй, улсын хэмжээнд ядуу амьдралтай 10 хүний нэг нь ажилгүй байна.

Архидалт, ажилгүйдэл, ядуурал гурав хүйн холбоотой гэж үздэг. Ажилгүйдэл их байгаа газар архидалт их байдаг байна.

Манай төвөөс гаргаж байгаа гэмт хэргийн статистик мэдээний архидан согтууралтай холбоотой болон тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүсийн тухай статистик баримтууд нь **архидалт, ажилгүйдэл, ядуурлын** өнөөгийн түвшинг илтгэсэн манай орны бодит дүр төрх юм.

Дөрөв. Уламжлал, заншил

Монголчуудын уламжлал, заншил их эвдэрч байна. Нийгмийн ёс суртахуун гэдэг ойлголт устаж байна. Иргэд эрх чөлөөтэй гээд дураар авирлаж буй боловч үүрэг, хариуцлагаа ухамсарлахгүй байна. Улс даяар амар амгалан бий болгоё гэвэл хүн бүр өөрийн сэтгэл санаанд болон гэр бүл, орчин тойрондоо амар тайван байдал бий болгох ёстой. Ийм орчинд гэмт хэрэг битгий эрх хэв журам зөрчигдөхгүй тайван орхон үүснэ. Иргэний ухамсарыг дээшлүүлэх талаар олон талт ажил зохион байгуулах шаардлагатай болж.

Өөрийн эрх чөлөө бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагддаг, энэ нь хууль тогтоомжоор зохицуулагддаг гэдгийг бидний олонхи нь үл ойлгох хандлага бий болжээ.

"Шударга хүний цэвэр ёс суртахуун гэдэг хуулийг бүрнээ оролдог юм" гэж нэгэн ухаантаан хэлснийг санууштай, хуулийг орлох нийм ёс суртахуун үгүйлэгдэж байна.

Тав. Хүн амын нягтрал

2006 онд 10.0 мянган хүнд ногдох гэмт хэрэг өмнөх оноос Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд, Хэнтийн аймагт 6-44-өөр өөр өөр, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл аймагт 1-33-аар буурав.

10.0 мянган хүнд ногдох гэмт

хэрэг 2005 онд 101 байсан бол 2006 онд 103 болжээ.

Нийслэл хотын хүн амын нягтралыг харгалзан гэмт хэргийн нехцөл байдал нөлөөлж буй хүчин зүйлийн талаар зарим асуудлыг онцлолцоо байна.

- 2006 оны эцэст манай улсын хүн ам 2.5 сая, 2007 оны 5 дугаар сард Улаанбаатар хот нэг сая хүнтэй хотоор бүртгэгдэж, хоногт дундажаар 100-200 мянган хүн орж, гарч байна.

- Манай орны нийслэл, улс төр, эдийн засаг, соёл, шийжлэх ухааны төв учраас төрийн болон төрийн бус байгууллагуудын шугамаар зохион байгуулагдаж байгаа уулзалт, семинар, зөвлөгөөн, спорт, урлагийн бүхий л арга хэмжээ нийслэлд болж байна.

- 2006 онд Улаанбаатар хотод 10.0 мянган хүнд ногдох гэмт хэрэг 122 байлсан нь харьцангуй өндөр үзүүлэлтэд тооцогдож, бүх гэмт хэргийн 49.4 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.

-Хүн амын нягтрал, төвлөрлийг үндэслэн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр нийслэлийн дүүргүүдийн зарим ОСГ-ны хороог задалж шинээр 11 хороог байгуулж ОСГ-ны хороодын тоо 132 болжээ.

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо 28631, мөн дүүргийн 5 дугаар хороо 22816, Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороо 18690 хүнтэй байгаа нь Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өмнөговь, Өвөрхангай, Сүхбаатар зэрэг аймгийн төвийн болон хүн амын төвлөрөл ихтэй Зүүнхараа, Хархорин сумдын хүн амын тоотой ойролцоо түвшинд байна.

- Үндэсний статистикийн газрын 2006 оны жилийн эцсийн мэдээгээр улсын хэмжээнд шинээр бүртгүүлсэн 60171 ажилгүй хүн байгаагийн 41.9 хувь нь нийслэлд амьдарч байна.

- Улсын хэмжээнд 141.5 мянган авто тээврийн хэрэгсэл тоологдсоны 52.2 хувь нь зөвхөн нийслэлд ногдож байна.

- **Ерөнхий төлөвсөрлийн 742 Сургуулийн 27.9 хувь нь,**

ерөнхий боловсролын сургуульд суралцагч 542.5 мянган хүүхдийн 34.1 хувь нь нийслэлд байна.

- 2006-2007 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежд 142.4 мянган оюутан суралцаж байгаагийн 80 орчим хувь нь нийслэлд төвлөрч байна.

- Дэлхийн том хотуудын жишиг, хот төлөвлөлтийн бодлогоор нийслэл хүрээгээ тэлж, 100.0 мянгаас дээш хүн амтай шинэ хорооллууд нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт байгуулагдах ажил эхэлж байна.

- Улаанбаатар хот дахь төрөлжсөн зах, бөөний худалдааны төв, тоглоомын газрууд, зочид буудал, рестораны, баар, авто засварын газрууд өргөжихийн хэрэг тодорхой төрлийн гэмт хэрэг үүдэн гарах таатай нөхцөл бүрэлдэж, гэмт хэргийн замаар олж авсан эд зүйлийг хялбар борлуулах, өнгө зүс, хэлбэр, маркийг хувиргах бололцоо бий болжээ.

- Гадаадын иргэд олон шугамаар манай улсад ирж, тэдний дийлэнх нь нийслэлд түр болон байнга оршин суухын зэрэгцээ хууль журмын дагуу болон хууль бусаар суралцаж, ажил хөдөлмөр эрхэлж байна.

Нийслэл хотын онцлог, хөгжлийн хандлагатай уялдуулан нийслэл хотын хот төлөвлөлтийн асуудалд онцгой анхаарах шаардлагатай болж байна.

Нийслэлийн болон Сүхбаатар, Баянгол дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл хүнд байгааг харгалзан Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын даргын 1990 оны тушаалаар Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтсүүдийг байгуулах шийдвэр гаргажээ.

Эдүгээ хөндөг дэвшүүлэх асуудал бол нийслэлийн төвийн 6 дүүргийг задалж, шинээр дүүрэг эмхлэн байгуулах цаг нь болсон гэж үзэж байна.

2007 оны 11 дүгээр сарын 22-ны "Өдрийн сонин"-ы 278 дугаарт нийслэлийн Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ц.Эрдэнэбатын "Баянзүрх дүүрэг ачааллаа даахаа байлаа"

ярилцлагад дурьдсан дүүргийн хүн амын нягтрал, шилжилт хөдөлгөөн, цагдаагийн алба хаагчийн ачаалал зэрэг нь бодитой баримтууд юм.

Улаанбаатар хот хүрээгээ тэлэхийн хэрээр Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн цагдаагийн байгууллагаас иргэдэд хүрч ажиллах боломж хязгаарлагдаж, шуудхан хэлэхэд **цагдаагийн байгууллагын хүн хүч хүрэлцэхгүй байна.** Шархад, Дамбадаржаа, Баянхошуу, Яармагт цагдаагийн хэлтсийн хэмжээний нэгжигч зохион байгуулах шаардлагатай болжээ.

Хот төлөвлөлтийн бодлогоор шинээр байгуулагдаж байгаа хороололд цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгийн контор, түүнчлэн хэсгийн байцаагч болон цагдаа нарын ажиллаж байгаа хороололдоо амьдрах нөхцөлийг бүрдүүлэх асуудалд Төр засаг, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал онцгой анхаарах шаардлагатайг онцлон тэмдэглэж, асуудал дэвшүүлж байна.

Оросын холбооны улсын Дотоод явдлын яамны сайд, армийн генерал Нурғалиев.Р.Г-ийн "Известия" сонинд өгсөн ярилцлагад 3 жилийн өмнөөс нийт хэсгийн байцаагч нарыг ажил, амьдралаа нэг дор байж залгуулах бодлого явуулсаны үр дүнд тэдний 67.0 хувь нь ажиллаж байгаа бичиг орчиндоо амьдарч байна. Энэ нь иргэд өөрийн хэсгийн байцаагчид 24 цагийн туршид хандаж тусналцаа авах боломжийг бүрдүүлжээ.

Нэг саяас дээш хүн амтай нийслэл хотод цагдаагийн ажлыг зохион байгуулах зорилт бидний өмнө тулгарч байна.

Зургаа. Хүн амын шилжилт хөдөлгөөн

Төр засгийн анхаарлыг хандуулах өөр нэг асуудал бол манай улсын хүн амын шилжилт хөдөлгөөнийг журамлах явдал юм.

Үндсэн хуульд зааснаар манай улсын иргэд ажиллаж, амьдрах газраа сонгох эрхтэй, шилжилт

хөдөлгөөний асуудал нь тухайн улсын хүн амын төрийн ажлын зохион байгуулалт, төрөөс иргэдэд үйлчлэх, үйлчилгээг оновчтой зохион байгуулахад чиглэгдэх учиртай.

Энэ асуудлыг зөнд нь орхисноос хамгийн наад зах нь ардчилсан улс оронд явагдаг чөлөөт сонгуулийн хууль, журмыг доголдуулж байгаагаас гадна цагдаагийн байгууллагаас самт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг хэрэгжүүлэхэд тодорхой бэрхшээл, хүндэрл учруулж байна.

1990 оноос өмнө Иргэний бүртгэл, мэдээллийн алба цагдаагийн байгууллагад байхад ийм хүндэрл, бэрхшээл байгаагүй юм. Нийслэл хот, түүний дүүргийн орон сууц, гудамжны хороодыг маш яаралтай хаягжуулах, хот төлөвлөлтийн бодлогоор цэгцлэх шаардлагатай байна.

Ингэхгүйгээр цагдаа бүрэн, төрн бусад байгууллагууд иргэндээ хүрч ажиллах боломж хязгаарлагдаж, үйлчилгээ хүргэх боломж хомсдож байна. Хот төлөвлөлтийн бодлого нь цагдаагийн ажил, үйлчилгээг иргэдэд хүргэх, татвар төлөгч нараас цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, цагдаагийн ажлын зуурхай байдлыг хангахад зайлшгүй нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна.

Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс манай улсын иргэдийн хаягийн нэгдсэн ангилал хийхээр төлөвлөж, бэлтгэл ажлууд хийгджээ.

Тус төвийн хүн амын мэдээллийн санд байгаа иргэдийн хаягийг эмх цэгцтэй болгон нэгдсэн ангиллыг /сум, багийн нэр, дугаар, нийслэлд дүүрэг, хороодод тусгайлан код өгөн/ боловсруулсны үндсэн дээр хаягийн судалгаа гаргах буюу компьютерт боловсруулалт хийхэд ашиглагдах юм байна.

Одоогийн байдлаар аймаг, сум, дүүрэг, хорооодоос хаягийн ангиллын судалгааг авч дууссан бөгөөд түүнийг компьютерт оруулах ажил хийгдэж байна.

Тус байгууллагаас бий болгож байгаа мэдээллийн санд тулгуурлан цагдаагийн байгууллага объектыг

судлах, цагдаагийн ажлыг зохион байгуулахад онцгой анхаарч энэ ажилд эхнээс нь оролцож туслалцаа дэмжлэг үзүүлж хамтран ажиллах нь ач холбогдолтой.

Долоо. Гэрэлтүүлэг

Нутгийн захиргааны байгууллагууд, төвлөрсөн суурин газрын орон сууц, гудамжны хороодоос гудамж талбайг гэрэлтүүлэгтэй болгох нь иргэдийн амгалан тайван аж төрөх, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нэн тэргүүний асуудал болж байна.

Төвлөрсөн суурин газраас алслагдсан ОСГ-ны хороодын иргэд гэрэлтүүлэггүйгээс айдаг, түгшүүрийн дунд аж төрж байна. Нийтийн тээврээс бугаадад харих замд гэмт халдлагад өртөх магадлал өндөр, үүнийг нь гэмт этгээдүүд ашиглаж хүчирхийлэх, эрх чөлөөнд нь халдах, эд зүйлийг нь булаах, дээрэмдэх явдал байна гэж цагдаагийн дуудлагыг нэмэгдүүлж байна.

Гэрэлтүүлэгтэй орчинд орой шөнийн цагаар танхайн сэдэлттэй, хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг төдийлөн гараад байдаггүйг иргэдийн дунд хийсэн санал асуулгын дүн, гэмт хэргийн статистик баримтууд давхар нотолж байна.

2007 оны эхний 11 сарын байдлаар гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 23.3 хувиар өссөн байна.

Хүнийг санаатай алах хэргийн 22.7, бусдын бие мөхбөдид гэмтэл учруулах хэргийн 26.8, хүчиндэх хэргийн 13.7, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 6.1, автомашин хулгайлах хэргийн 47.6, булаах хэргийн 73.5, дээрэмдэх хэргийн 69.8, танхайрах хэргийн 36.2, согтуугаар үйлдэгдсэн хэргийн 27.1 хувь нь гудамж талбайд гарсан байна.

Хүнийг санаатай алах хэргийн 66.3 хувь, бусдын бие мөхбөдид гэмтэл учруулах хэргийн 54.6 хувь, хүчиндэх хэргийн 71.6 хувь, хулгайлах хэргийн 60.2 хувь, авто тээврийн хэргэсэл хулгайлах

хэргийн 67.3 хувь, булаах хэргийн 62.2 хувь, дээрэмдэх хэргийн 79.1 хувь, танхайрах хэргийн 85.5 хувь нь оройн 19 цагаас өглөөний 06 цагийн хооронд үйлдэгджээ.

Эдгээр баримтаас үзэхэд төвлөрсөн суурин газрын гэр хорооллуудад орой шөнийн цагаар танхайн сэдэлттэй гэмт хэргүүд зонхилон үйлдэгдэж байна.

Нийслэлийн иргэдийн амгалан тайван байдлыг хангах үүднээс цагдаагийн байгууллага шөнийн хөдөлгөөнд эргүүл бий болгож, шөнийн цагаар хяналтгүй байгаа хотыг хяналтад авах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Найм. Үйлчилгээний газрууд

Шөнийн цагаар байнга ажилладаг баар, зочид буудал, ресторан, дэлгүүр зэрэг үйлчилгээний байгууллага, таксины үйлчилгээний зохицуулалт сулаас гэмт хэрэг үүдэн гарах нэг хүчин зүйл болж байна. Нийслэлийн шөнийн амьдралыг цэгцлэх цаг болсон гэж үзэж байна.

Манай улсын хувьд архидаг согтуурах явдалтай хийх тэмцлийг эрчимжүүлэх зорилгоор архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулах, зар сурталчилгаа болон зөв зохиистой, хэрэглээний талаар иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчилгаа ажлыг шуурхай зохион байгуулж, төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж ажиллах шаардлагатай байна.

Төвлөрсөн суурин газрын баар, ресторан, цэнгээний газар болон дэлгүүрүүд архи, согтууруулах ундаа худалдаалах цагийн хуваарийг мөрдөгдөггүйгээс архидаг согтуурах явдлыг өөшүүлж, хүхээд, залуучууд гэмт хэрэгт өртөх, цагдаагийн ажил, үйлчилгээг хүндрүүлж байгааг Төрийн захиргааны төв байгууллагууд анхаарах цаг болжээ.

Ес. Даатан гэмт хэрэг

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ялтан ял адлахээс чөлөөлөх, Эршөөл үзүүлэх тухай хууль батлагдаж, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын дээд шүүх 2006 оны "Эршөөл үзүүлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хэрэглэх тухай" 30 дугаар тогтоол гаргасан билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээгээр дараах тоог гаргасан байна.

Он	Хорих болон баривчлах ялаар шийтгүүлсэн	Хорих болон ял эдлүүлэх газраас суллагдсан
2005	4292	3202
2006	3143	5048
2007.12.10	3457	2385

Улсын дээд шүүхийн дээрх тогтоолд хамрагдан суллагдсан 3407 ялтнаас дахин гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгэгдсэн 93 хүн одоо ялаас эдэлж байгаа бөгөөд суллагдсан бүх хүний 2.7 хувийг эзэлж байна.

Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүмүүсийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхээр хянан хэлэлцэх шатанд байгаа эрүүгийн хэргүүдийг хэрэгсэхгүй болгосон.

Суллагдсан хүмүүс дээр хараа хяналт хавих, ажил төрөлтэй болгож, хамт олон дотор ороулж нийгэмшүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагуудыг татан оролцуулах шаардлагатай юм.

Манай төвийн мэдээгээр урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс 2005 онд 1512, 2006 онд 1561, энэ оны эхний 11 сард 1626 хүн гэмт хэрэг үйлдсэн байна. Энэ нь нийт гэмт хэрэгт холбогдогч нарын 10 орчим хувийг эзэлж байна. Тэдгээр нь өнөөгийн нийгмийн мэргэшсэн гэмт хэрэгтнүүд юм.

1990 оноос эхлэн нийгэмд "траншейннийхан" гэдэг ойлголт бий болсон. Тэр үеийн траншейнд байсан иргэд 10-15 хүхүүдэд одоо

20-25 насныхан болж нийгмийн анхаарлын гадна орхигдсоноос тодорхой хэсэг нь гэмт хэрэгтэн болж өнөө үеийнхнийг түгшээж нийгэмдээ өсөрсхөн, эцэг эхийн хайр халамж үзээгүй хүмүүс болжээ. Энэ бол манай нийгмийн өөрийн нь л бүтээгдэхүүн юм.

Эдгээр баримтыг дурьдаж байгаа явдал бол эрүүгийн хуулийн ялын бодлогыг эргэж харах цаг болсон гэж үзэж байна. Хорих газар ял эдэлж байгаа ялтны тоо 10.0 мянга орчимд хүрчээ.

Арав. Гэмт бүлэглэлийн хандлага

Гэмт бүлэглэлийн зүгээс эдийн засаг, банк, санхүүгийн байгууллага, хувиар хөдөлмөр эрхэлж буй эзэд давамт шахалт үзүүлэх, өөрсдийн ноёрхлоо тодорхой нутаг дэвсгэр, объектод тогтоох санаархал, эрмэлзлэл бий болж байгаад Эрүүгийн цагдаагийн албад мэдрэмжтэй ханддаг сөрөг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг нөхцөл байдал шаардаж байна.

Манай статистик мэдээгээр бүлгээр үйлдэгдсэн 2428 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 353 хэргээр буюу 17.0 хувиар өсөв.

Бүлгээр үйлдэгдсэн гэмт хэргийн

1.1 хувь нь хүнийг алах, 10.8 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 2.7 хувь нь хүчиндэх, 50.6 хувь нь хулгайлах, 5.5 хувь нь булаах, 9.4 хувь нь дээрэмдэх, 3.0 хувь нь залилан мэхлэж авах, 10.6 хувь нь танхайрах гэмт хэрэг байна. Манай улсад зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн суурь хөрс хэдийн бий болсон байна.

2007 оны эхний 11 сард зохион байгуулалттай бүлэг үйлдсэн 19 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 15 хэрэг буюу 4.7 дахин, урьдчилан үгсэж, тохиролцсон бүлэг үйлдсэн 190 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 27 хэрэг буюу 16.6 хувиар тус тус өссөн байна.

Арван нэг. Гадаадын иргэд

Манай улсад түр болон удаан хугацаагаар оршин суугч, цагаач,

харьяалалгүй гадаадын 102 орны 28.0 мянга гаруй иргэн ажиллаж, амьдарч байна.

Эдгээрээс 8 орны 96 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны дотор БНХАУ-ын 60, ОХУ-ын 20, БНСУ-ын 7, Вьетнам улсын 4, Япон улсын 2, Герман, Австрали, Молдав улсын тус бүр 1 иргэн байна.

Гэмт халдлагад өртсөн 20 орны 181 иргэн байгаагийн дотор БНХАУ-ын 75, ОХУ-ын 35, БНСУ-ын 31, АНУ-ын 8, Япон улсын 5, Герман, Франц, Турк, Чех, Австрали улсын тус бүр 3, Тайвань, Израиль, Армени улсын тус бүр 2, Финланд, Итали, Англи, Австри, Украин, Унгар улсын тус бүр 1 иргэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн, гэмт халдлагад өртсөн дээрх баримтыг дурьдахдаа бусад орны гэмт бүлэглэл манай улсад суурьшин үйл ажиллагаа явуулах, манай эрүүгийн элементүүдтэй нэгдэх, ажиллаж, амьдарч байгаа бусад орны иргэд нь гэмт халдлагын объект болдог гэсэн логикоор гарган тавьж байна.

Түр болон удаан хугацаагаар оршин суугч, цагаач, харьяалалгүй гадаадын иргэд гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргах, гэмт халдлагад өртөх явдал нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Гадаадын иргэдэд тавих хяналтыг сайжруулах, гэмт халдлагад өртсөн гадаадын иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2006 оны "Журам батлах тухай" 224 дүгээр тушаалын дагуу мэдээллийн сан бүрдүүлж байна.

Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, аялал жуулчлал өсч, авто замын олон улсын сүлжээ бодит зүйл болж байгаа өнөөгийн нөхцөлд гадаад орны зохион байгуулалттай гэмт бүлэглэл орж ирэх, хар тамхи, мансууруулах бодис, галт зэвсэг, хүн худалдах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаагийн байгууллага алба хаагчдаа бэлтгэх шаардлагатай болсон байна.

Арван хоёр. Жагсаал цуглаан

Төрийн эрх барих болон хууль

тогтоох байгууллага, институтээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хуулийн бодлогыг мушгин гуйвуулах, эсэргүүцлээ ил, далд хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан илэрхийлэх, төр засгийн огцруулахыг шаардсан иргэний нийгмийн хөдөлгөөнүүд нэгэн үе идэвхижсэн.

Иргэний нийгмийн хөдөлгөөнүүдийн явуулж буй үйл ажиллагааны зорилго, чиглэлийг судлах, тэдний удирдлагатай цагдаагийн байгууллага яриа хэлэлцээр хийж нийгмийн дэг журмад алдагдуулахгүй байх, жагсаал цуглааныг хуулийн хүрээнд явуулах, зарим тохиолдолд Үндсэн хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхэд нь бодитой дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай байна.

Харин дэлхий даяар алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа газар авч дэлблэх, хорлон сүйтгэх ажиллагаа идэвхийн хэрэгжүүлэх арга хэлбэр нь хялбар, хор уршиг их байдагтай холбогдож аль ч улс орон жагсаал цуглаанд, ялангуяа зөвшөөрөлгүй, зохион байгуулалтгүй хэрэгсэл, цуглаанд Төр засгийн зүгээс таагүй ханддаг болсныг бид анхаарахад илүүдэхгүй болов уу. Эдгээр гэмт явдлын хор уршиг улс орны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөгийг харгалзан аливаа зөвшөөрөлгүй жагсаал, цуглааныг албадан тараах, хориглоход цагдаагийн байгууллага бэлэн байх ёстой гэдгийг их үндэс болгож байна.

Арван гурав. Зар сурталчилгаа

Зах зээлийн жамыг дагаж төрөл бүрийн наймаа арилжааг зар сурталчилгаа ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр өргөн сурталчилж, иргэд, олон нийтийг төөрөлдүүлэх хандлага бий болжээ.

Олон нийтийг бүхмидүүлж байгаа хадгаламж зээлийн хоршоодыг тойрсон үйл явдлууд үүний баримт юм.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол жил дараалан өсч байна. 2003 онд 18.5, 2004 онд 23.3, 2005 онд 30.5, 2006 онд 52.1, энэ оны

эхний 11 сард 28.3 тэрбум төгрөгт хүрвэ.

Монгол банкны өхлах нягтлан бодогч Ц.Чимэдцэрэнд холбогдох хэрэг гэхэд л 14.5 тэрбум, "САПУ" худалдааны төвийн Барилга швэтан, хадгаламж эзэлийн хоршоодын 11991 хохирогч иргэний 73.1 тэрбум төгрөгийг хохирлыг дурьдаж болно. Өөрөөр хэлбэл, гэмт бүлэглэлүүд иргэдийн итгэлийг эвдэх замаар бүлгээр нь иргэдийг хохироож тэдний амь, амьдралаар нь тоглож байна. Ийм хэрэг урьд өмнө гардаггүй байсныг бид мэднэ.

Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах хэрэг нь нийт гэмт хэргийн 4 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн 70 орчим хувь Улаанбаатар хотод үйлдэгдэж байна.

Эрүүгийн цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албад залилангийн хэргийн бүрэлдэн бий болж байгаа **механизмыг нарийвчилсан судалж**, дүн шинжилгээ хийх шаардлагатай болжээ.

Энд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн эдийн засаг, санхүүгийн "механици" явагдаж байгаа Эрүүгийн цагдаагийн албад судалж механизмыг илрүүлэх, таньж мэдэх шаардлага бий болжээ. Энэ асуудалд бүх шатны зуучлал голлох үүрэг гүйцэтгэж байгааг анхаарах хэрэгтэй.

Цагдаагийн байгууллага, алба хаагчид өөрт буй мэдээллийн хүрээнд гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс иргэдийг сэрэмжлүүлэх ёстой юм.

Арван дөрөв. Байгалийн байлаг

Манай орны нөхцөлд сүүлийн жилүүдэд байгалийн баялаг дагасан "амьдрах" орчин бий болж байна. Энэ бол урьдаас төлөвлөөгүй суурин газрууд юм.

"Химийн хорт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" ЦЕГ-ын даргын 2007 оны 04 тоот албан даалгавар гарсан.

Энэ албан даалгаварын зорилго нь хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж буй

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдүүдийн сүлжээг илрүүлж таслан зогсоох, химийн хорт бодисыг эрж борлуулдаг хүмүүсийн талаар мэдээллийг төлбөртэйгээр авах, тагнуул, хилийн цэрэг, онцгой байдал, байгаль орчин, мэргэжлийн хяналт, гаалийн байгууллагуудтай хамтран ажиллах, энэ төрлийн хэргийг бүртгэх, мөрдөн байцаах алба хаагчийг томилж, мэргэшүүлэн ажиллуулах, байгалийн баялаг дагасан төлөвлөгдөөгүй суурин газарт тавих цагдаагийн хяналтыг сайжруулах зорилгоор цагдаагийн нэгж байгуулан ажиллуулах боломжийг судлан орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргатай зөвшилцөн шийдвэрлүүлэх. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 192-200, 204-214 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн тухай мэдээллийг статистик мэдээнд оруулан сан бүрдүүлэх, зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулахад чиглэгдсэн юм.

Алт, зэс, жонш, нүүрс зэрэг байгалийн баялаг дагасан төлөвлөгдөөгүй суурин газрууд бараг бүх аймаг, сумдын нутаг дэвсгэрт бий болж, эдгээрт төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зохицуулалт үгүйсгэгдэж байна.

Эдгээр газарт цагдаагийн нэгж байршиж хүрч ажиллах бололцоогүй тул байгаа хүч хэрэгсэлээ **маневрлан** ажиллуулахаас өөр боломж харагдахгүй байна. Хорих газраас суллагдсан хүмүүс амьдрахын эрхээр эдгээр газарт очиж нөхцөл байдлыг хүндрүүлж байгаа нь цагдаагийн байгууллагын хараа хяналтаас гадна байх ёсгүй.

Арван тав. Шинэ төрлийн гэмт хэргийн хандлага

Манай орны нөхцөлд төдийлэн гарч бүртгэгдэж байгаагүй шинэ төрлийн болон галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг гарах болов.

Шинэ төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний таньж мэдэх арга тактикт алба хаагчдаа сургах,

мэргэшүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд нотлох баримт олж илрүүлэх ажлыг хуулийн хүрээнд явуулах, баримтжуулахад анхаарах шаардлагатай. Энэ бол цагдаагийн байгууллага, алба хаагчдын өөрсдийн хүчин чармайлт, мэргэжлийн төвшин, ур чадвараас хамаарах хүчин зүйл юм.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хүчин чармайлтын дүнд иргэдийн гар дээр байгаа галт зэвсгийг илрүүлэх, бүртгэхэд ахиц гарсан юм.

Цаашид галт зэвсэг эзэмших сонирхол өснө, түүнд тавих хяналтыг чангатгах хэрэгтэй болно гэдгийг мартаж болохгүй бөгөөд тэсэрч дэлбэрэх бодисын хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сулруулж болохгүй гэдгийг цагдаа, дотоодын цэргийн бүх шатны удирдлага анхаарвал зохино.

1997 онд батлагдсан Монгол Улсын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Ерөнхийлөгч саяхан санаачилж, УИХ-ын даргад өргөн мэдүүлээд байна. Төсөлд төв, орон нутгаас байнга тавьж байдаг асуудал тусгагджээ.

Бүх шатны Зохицуулах зөвлөлийн эрх хэмжээг өргөтгөж, уялдуулан зохицуулах боломжийг нэмэгдүүлэх энэ ажлын зардлыг төвлөрүүлж, бүрэн гаргуулж, үр ашигтай, хяналттай зарцуулах, иргэдийн олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, харуцлагыг чангатгахад анхаарч төслийг боловсруулан байна.

УИХ энэ хуулийн төслийг батлан гаргаж, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд томоохон дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэж байна.

Санаа тавьж хөрөнгө хүч гаргахгүйгээр нийгмийн дэг журам бэхжүүлэх, иргэдийнхээ амар тайвныг хангах ямар ч боломжгүй юм.



ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОНОЛ, АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ардчилсан төрийн тогтолцоо, зах зээлийн нээлттэй эдийн засаг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн өнөө үеийн хэрэгцээ нь эрх зүйн шинэтгэлийг шаардаж байна.

Эрх зүйн хийгүй тогтолцоо бүрэлдсэн цагт хүний эрх, эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжиж, иргэдийн шударга ёс, эрх зүйн хамгаалалтад итгэх итгэл дээшлэх учиртай. Бид нэгэнт л дэлхий нийтээрээ эдэлж буй эрх, эрх чөлөөг эдэлж байгаагийн хувьд бусад улс оронд мөрдөгдөж буй эрх зүйн хамгаалалт, үндэслэлийг өөрийн хууль тогтоомждоо тусгах нь зүйтэй юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам нь эрх зүйн, зохион байгуулалтын хувьд тэр бүр боловсронгуй биш байгаагаас ирээдүйд олон сөрөг үр дагаврыг бий болгож болох юм.

Гэмт хэргийн хор уршиг, аюулт үр дагаврыг иргэдэд ойлгуулан, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сонор, сэрэмжтэй амьдрах дадал хэвшилтэй болгох замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үзэл хандлагыг төлөвшүүлэх нь зүйтэй юм.¹

2000 онд НҮБ-аас гаргасан конвенцид "Дэлхий нийтэд гол тулгамдсан асуудлын нэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал юм" гэж тэмдэглэсэн байдаг.² Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвшүүлэх арга замыг эрх зүйн хэм хэмжээгээр төгс зохицуулсан, удирдлагын болон хяналтын оновчтой систем



Нийслэлийн цагдаагийн газрын Олон нийтийн харилцааны хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч, магистрант **Л.ЦЭРЭНЖАМ**

бүхий үүрэг хариуцлагын нэгдэл хангагдсан нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын тааламжтай орчин бий болгох замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна. Хэдийгээр төрийн зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх талаар тодорхой системтэй бодлого явуулж, бие даасан хууль гарган, хэд хэдэн хуулиар уг асуудлыг зохицуулж олон улсын гэрээнд нэгдэн орох гэх мэтээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа боловч энэ нь өнөөдрийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц хэмжээнд бус, зарим нэг асуудал байсаар байна.

Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн зарчмын талаар

Социалист системийн үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хүн амын идэвх санаачилга, нам зэвдлийн удирдлага, үйл ажиллагаа, аж ахуй, үйлдвэрлэлийн байгууллагуудын хөдөлмөрийн сахилга бат дээр тогтож байсан учир төрөөс явуулж байгаа үйл ажиллагаа, бодлого чиглэл дээрх хүчин зүйлсэд үндэслэж байсан билээ. Тухайлбал: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн хувийн идэвх санаачилга, нам зэвдлийн удирдлага, үйл ажиллагаа, аж ахуй, үйлдвэрлэлийн байгууллагуудын хөдөлмөрийн сахилга бат дээр тогтож байсан учир төрөөс явуулж байгаа үйл ажиллагаа, бодлого чиглэл дээрх хүчин зүйлсэд үндэслэж байсан билээ. Тухайлбал: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн хувийн идэвх санаачилга, нам зэвдлийн удирдлага, үйл ажиллагаа, аж ахуй, үйлдвэрлэлийн байгууллагуудын хөдөлмөрийн сахилга бат дээр тогтож байсан учир төрөөс явуулж байгаа үйл ажиллагаа, бодлого чиглэл дээрх хүчин зүйлсэд үндэслэж байсан билээ. Тухайлбал: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн хувийн идэвх санаачилга, нам зэвдлийн удирдлага, үйл ажиллагаа, аж ахуй, үйлдвэрлэлийн байгууллагуудын хөдөлмөрийн сахилга бат дээр тогтож байсан учир төрөөс явуулж байгаа үйл ажиллагаа, бодлого чиглэл дээрх хүчин зүйлсэд үндэслэж байсан билээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудаас харахад хуучны дээрх байдал одоо хүртэл (зарим талаар) оршоор байгаа нь харагдаж байна.³

Харин ардчилсан нийгэмд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь санхүү, материал техник, боловсон хүчин, мэдээлэл, шинжлэх ухаан, эрх зүйн хангамжийн үндсэн дээр явагддаг гэдэг нь дэлхий нийтийн жишээс харагдаж байна. Тийм ч учраас хэдгээр нь гэмт хэргээс

¹ www.lawportal.ru. Криминологийн тулгамдсан асуудал, нийтлэл

² www.dalnewspaper.com, нийтлэгдсэн нийтлэлээс

³ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль, УБ., 1997 он. Тус хуульд:

13.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэнийг дор дурдсан хэлбэрээр урамшуулна:

13.1.1. мөнгөн шагнал олгох;

13.1.2. үнэ бүхий зүйл дурсгах;

13.1.3. хүндэт тэмдгээр шагнах;

13.1.4. алдрыг нь мөнхжүүлэх гэж заасан байна.

урьдчилан сэргийлэх үйл онол, арга зүйн үндэс болох нь зүйтэй юм. Баруун европын орнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх энэ зарчим дээр тулгуурладаг.

Өөрөөр хэлбэл тэдгээр улс оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрийн бодлого нь дээрх зарчимд үндэслэгдэн хэрэгждэг юм. Орчин үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн үндэс нь эдийн засаг, газар зүй, хүн ам зүй, нийгэм соёл, угсаатны зүй, хүн амын байршил зэргээс ихээхэн шалтгаалдаг болсныг үндсэн зарчмыг томьёолоходоо анхаарах нь зүйтэй юм.

Пост социалист орнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэдэгт криминологийн урьдчилан сэргийлэх ажиллагааг хамааруулж ирсэн. Энэ нь тухайн улс орны хууль тогтоомжийн агуулга, төр, түүний байгууллагаас явуулж буй үйл ажиллагаанаас илт харагддаг. Өнөө үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэдгийг гэмт явдлыг гаргуулахгүй гэмт талаар янз бүрийн субьектүүдээс явуулж байгаа үйл ажиллагааны цогцолбор гэж ойлгох болсон.⁴ Үүнээс үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн зорилго нь гэмт хэргийг гаргуулахгүй байх, гэмт халдлагаас хүн, нийгэм, төрийг хамгаалахаас гадна учирч болох үр дагавараас сэргийлэх явдал юм. Энэ бүх үйл ажиллагаа нь гэмт хэрэг гарахаас өмнө, хойно аль ч үе шатанд үргэлжилдэг.

Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ял шийтгэлийн талаарх төрийн бодлого⁵

Криминологийн шинжлэх ухаанд

гэмт хэргийг нийгмийн өвчин гэж үзээд биеийн өвчинтэй адилтган уг өвчний эх үндэс уг сурвалжтай нь тэмцэх ёстой гэж үздэг. Хэрвээ гэмт хэргийг өвчинтэй адилтгавал гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажиллагаа бөгөөд энэ нь өвдөлт мэдрэгдэхгүйгээр явагдах учиртай. Гэвч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсээр байтал гэмт хэрэг биеллээ олбол, түүнийг илрүүлж, буруутай этгээдэд хариуцлага ногдуулах нь эцсийн арга зам буюу мэт засал хийж, өвдөлт мэдрүүлж байгаатай ижил юм.

Иймд аль болох гэмт хэргийг үйлдэгдэхээс өмнөх үе шатанд /Бодох, төлөвлөх, бэлтгэх гэх мэт/ илрүүлэх нь ач холбогдолтой бөгөөд мэт засал буюу ял шийтгэл нь төдийлөн оновчтой арга зам биш юм.

Одоо манай улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь өмнөх нийгмийн үзэл санаагаар буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн гол бааз суурь нь ял шийтгэл юм гэсэн үзэл баримтлалд үндэслэгдэж байна. Энэхүү үзэл баримтлал нь ямар нэг хууль эрх зүйн актад тусгалаа олоогүй ч практик нөхцөл байдлаар үүнийг баталсаар байгаа нь бидэнд тодорхой байна. Монгол Улсын эрүүгийн хуульд урамшуулах санжц маш бага байна.⁶

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зарцуулах хөрөнгө мөнгө нь ял шийтгэл эдлүүлэхэд гардаг зардлаас хямд, үр дүнтэй байдаг. Учир нь хууль хэрэгжүүлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ажилладаг байгууллагуудын жийгийн төсөв /Цагдаагийн байгууллага,

Прокуратур, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар гэх мэт/ баггүй бөгөөд энэ нь эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд тодорхой үр дүнгээ өгч буй ч хангалтгүй байгааг өнөөдрийн эрүүгийн нөхцөлөөс харж болохоор байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн тааруу байхын хэрээр гэмт хэрэг өсч байдаг. Үүний зэрэгцээ ял шийтгэл түүн дотроо хорих ялын хугацаа урт байх тусам зардал ихэсгэдэг гадна шууд бус зардал нэмэгддгийг анхаарах ёстой. Шинээр шорон барих, ажилчдын байр, хоол, унаа, нүүдлийн зардал, төрийн албан хаагчдын нэмэгдэл, урамшуулал, тэтгэмж, тэтгэвэр гэх мэт маш их зардал шаарддаг. Түүнчлэн гэмт хэрэг гарсан тохиолдолд түүнийг илрүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, яллах, шүүх явцад асар их зардал гардаг. Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зарцуулах хөрөнгө нэмэгдэх тусам энэ ажил үр дүнтэй байх боломж нэмэгдэж улмаар ял шийтгэл эдлүүлэхтэй холбоотой зардал багасах зүй тогтолтой байдаг. Мэдээж хөрөнгө, мөнгө их үрснээр бүх юм сайхан болчихно гэвэл өрөөсгөл болно. Түүнийг үр ашигтай, зорилгодоо нийцүүлэн зарцуулах нь анхаарах нэг гол зүйл юм. Үүнийг төрөөс анхаарч бодлого, үйл ажиллагаандаа тусгах шаардлагатай байна.

Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд мэдээллийн хангамж, түүний ач холбогдлын талаар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд мэдээлэл чухал ач холбогдолтой байдаг.

⁴ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

⁵ Доктор, профессор С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн альбом, схем гэсэн /2004 он/ бүтээлдээ Төрийн эрүүгийн бодлого гэдэгт: Төр засгийн байгууллагаас нийгмийн дэг журмыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төрт ёсны болон үндэсний уламжлал, зан заншлыг сэргээн хөгжүүлж, нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд хууль тогтоомжийг чанд сахуулах гэмт хэрэг эрх зүйн зөрчилтэй тэмцэх, хууль сахуулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар төрөөс баримтлаж буй чиглэл удирдамж юм гэжээ.

⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл №4, УБ., 2002 он, Уг хуульд урамшуулах санжц нь өрдөө 20 байдаг.

Үүнийг дараах байдлаар томъёолж болно.

Нэг: Гэмт хэрэгтэй тэмцэх талаар баримталж буй төр, түүний байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа нь нийгэмд аль болох нээлттэй хүн бүрт ойлгомжтой байх ёстой. Нийгмийг шуугиулсан гэмт хэргүүдийн шийдвэрлэлт, ял ногдуулсан байдал, мөрдөн байцаалт, шүүн таслах үйл ажиллагааны явц, үр дүн, хууль зүйн үндэслэл, тэдгээрийн эцсийн үр дүнгийн талаар нийтээрээ мэдэж байх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд өндөр ач холбогдолтой байж үр дүнгээ өгдөг.⁷

Мэдээллийн хомсдол байгаа газарт хоосон орон зайг цуу яриа, хов жив эзэлдэг.⁸ Иймд албан ёсны мэдээлэл үгүй байх нь нийгэмд ташаа ойлголтыг бий болгож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сөрөгөл нөлөөлж, уг ажиллагааг амжилтгүй байдалд хүргэдэг. Манай улсад гэхэд 17 чингэлэг спиртийн, Баатарын, Болдхэтийн, Ард банкны, Түмэнжаргалын гэх олон хэргийн шийдвэрлэлт нийтэд түр бүр нээлттэй мэдээлэгдэж чаддаггүйгээс энэ талаарх төрийн бодлого үнэгүйдэхэд хүргэсэн байх талтай. Түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэлтийн талаарх мэдээлэл тэр бүр хүртээмжтэй, үр дүнтэй байж чаддаггүй.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлын мэдээлэл түүний эх сурвалж асар өндөр ач холбогдолтой байдаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны удирдлага нь мэдээлэл дээр тулгуурлан явагддаг бөгөөд тийм тогтолцоог бүрдүүлэх нь нэн тэргүүний зорилт билээ. Энд зөвхөн гэмт хэргийн талаарх мэдээлэл бус тухайн орон нутаг, газар орны онцлог, хүн ам зүйн онцлог, иргэдийн боловсрол, ухамсрын түвшин, тухайн нутаг дэвсгэр дээр байгаа байшин барилга үйлдвэрийн байршил гээд бүх төрлийн цогцолбор мэдээлэл багтах учиртай.

Гурав: Хүнд, онц хүнд, зохион байгуулалттай, албан тушаалын, гааль, татварын гэх мэттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэхэд мэдээлэл, мэдээлэгчийн үүрэг чухал ач холбогдолтой байдгийг анхаарч, зохион байгуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал, мэдээллийг төлбөртэй худалдан авах үйл ажиллагааг боловсронгуй, бодит амьдралд ойртуулан зохицуулах, гүйцэтгэх ажлын бүхий л хүрээнд мэдээлэх үүрэг бүхий туслах ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрх зүй, зохион байгуулалтын үндсийг шинэчлэх шаардлагатай байна.

Дөрөв. Нийгмийн урьдчилан сэргийлэхийг өндөржүүлж, хөгжүүлэх талаар

Гадаад орнуудад түүн дотроо барууныханд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийг нийгмийн урьдчилан сэргийлэх ажиллагаа ба нөхцөл байдлын урьдчилан сэргийлэлт гэж авч үздэг байна. Нийгмийн урьдчилан сэргийлэлт гэдэгт нийгэм, хүн ам зүйн тодорхой бүлэг түүн дотроо хүүхэд залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэлтийг хамруулан авч үздэг.⁹ Энэ хүрээнд: эцэг эхчүүдийн хүүхдээ хүмүүжүүлэх чадварыг дээшлүүлэх, тэдэнд ийм зан үйл, боловсролыг эзэмшүүлэх асуудлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны үндсэн чиглэл болгож, хүүхэд залуучуудын бие, сэтгэл зүй, эрүүл мэндийг анхаарч хамгаалах нь чухал гэж үздэг. Мөн нийгмийн урьдчилан сэргийлэх ажиллагаанд нийгмийн сэтгэлгээг хөгжүүлэх, анхан шатны нэгжийг хөгжүүлэх, тэдний эдийн засгийн асуудлыг шийдэхийг чухал гэж үздэг. Монгол Улсын тухайд нийгмийн урьдчилан сэргийлэх ажилд тэр бүр ач холбогдол өгч, төсөв хөрөнгө гарган төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нь бага байдаг. Иймд энэ чиглэлд илүүтэй анхаарах нь зүйтэй юм.

Дүгнэлт, санал:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь манай орны хувьд ямархуу байгааг судлах нь багагүй цаг хугацаа, мэдээлэл, мөн сайтар боловсруулсан судалгааны арга зүйг шаардсан судалгааны ажлын томоохон объект мөн болох нь ажиглагдсан. Манай оронд ажиллаж буй донорын хөрөнгө оруулалттай эрх зүйн төсөл, хөтөлбөрд нь ач холбогдолтой. Гэхдээ тухайн орны онцлогоос хамаарч боловсронгуй болгоход зохих зарим асуудал байсаар байна.

Цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, арга зүйг шинэчлэх, өөрчлөх, боловсронгуй болгох шаардлагатай байна. Иймээс эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хууль, тогтоомжийг боловсронгуй болгох үндэс чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг хангах шаардлага зүй ёсоор үүсч байгаа юм. Илтгэлд дурдагдсан үзэл санаа, нөхцөл, онол, арга зүйд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна.

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль, хөтөлбөрийн гол үндэс, үзэл санааг цаг үеийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний онол орон нутгийн хэмжээний төслүүдийг Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;

2. Боловсролын болон Гэр бүлийн тухай хуульд нийгмийн урьдчилан сэргийлэх нэг төрөл болох гэр бүлийн хүмүүжлийг төлөвшүлэхтэй холбоотой заалт оруулж, эрх зүйн үндсийг бий болгох;

3. Ялын талаарх төрийн бодлогод өөрчлөлт хийх үзэл санаа, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар шат дараалсан цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд төсөв, санхүүгийн асуудлыг өндөр түвшинд авч үзэж, зарцуулалтыг нь оноцтой байдлаар төлөвлөх.

⁷ www.sansan.ru

⁸ Отгонсүх А. "Цагдаа-иргэдийн харилцаа, уламжлал, шинэчлэл", магистрын дипломн ажил. 2007 он. 40 дэх тал.

⁹ www.mirpravо.ru

ШИНЭ ТӨРЛИЙН ЗАРИМ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ

Шинэ төрлийн хэрэг томоохон улс оронд төдийгүй хн ам цөөтэй манай улсад ч хчээ авч өргөжиж хөндлөгтэй байгаа нь сэтгэл тгшээсэн асуудал болоод байна.

Шинэ төрлийн гэмт хэрэг нь үйлдэгдэж байгаа арга хэрэгсэл, шинж байдлын хувьд урьд үйлдэгдэж байсан гэмт хэргүүдээс цоо шинэ арга, хэлбэрээр илэрч, байдгаараа ялгагдаж, дэлхий нийтэд нэн аюултай гэмт хэрэгт тооцогдон, зохион байгуулалттай гэмт хэрэг ихээр гарах болсон өнөө үед нийгмийн хор аюул нь улам бүр ихэсч байна.

Шинэ төрлийн гэмт хэрэг гэдэгт:

1) Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуульд шинээр гэмт хэрэгт тооцогдохоор тусгагдсан гэмт хэрэг

2) Эрүүгийн хуульд урьд гэмт хэрэг гэж тооцогдсон, шинэ төрлийн аргаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг

3) Монгол Улсын эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж заагаагүй боловч дэлхий нийтэд шинээр гарах болсон гэмт хэргийг хамааруулан авч үзэж болох юм.

Өөрөөр хэлбэл шинэ төрлийн гэмт хэрэг гэдэгт эрүүгийн хууль тогтоомжид шинээр гэмт хэрэгт тооцооход оруулсан, түүнчлэн гэмт хэргийг сүүлийн үеийн шинэ тутам арга хэрэгсэл, шалтгаан, нөхцөлөөр үйлдэгдэж байгаа нийгмийн хор аюулаар их гэмт үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Шинэ төрлийн гэмт хэрэгт 2002 оны Эрүүгийн хуулиар шинээр гэмт хэрэгт тооцогдох болсон дараах гэмт хэрэг хамаарна. Үүнд:

1. Хүн худалдах, худалдан авах /ЭХ-ийн 113 дугаар зүйл/;

2. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэх, гуйланчлалд татан оролцуулах /ЭХ-ийн 115 дугаар зүйл/;

3. Садар самууныг сурталчлах



ХЗҮТ-ийн КСС-ийн эрдэм шинжилгээний ажилтан, Хууль зүйн ухааны магистр Г.ОЮУНБОЛД

/ЭХ-ийн 123 дугаар зүйл/;

4. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэх газрыг зохион байгуулах /ЭХ-ийн 124 дүгээр зүйл/;

5. Мөнгөн тэмдэгт үнэт цаас хуудамчаар үйлдэх, борлуулах /ЭХ-ийн 176 дугаар зүйл/;

6. Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах хадгалах, тэвэрлэх, илгээх борлуулах, /ЭХ-ийн 200 дугаар зүйл/;

7. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах хадгалах тэвэрлэх, илгээх борлуулах болон мансууруулах бодис агуулсан ургамалыг тарих /ЭХ-ийн 192, 194, 195 дугаар зүйл/;

8. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих /ЭХ-ийн 240 дүгээр зүйл/;

9. Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /ЭХ-ийн 226-229/;

10. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх /ЭХ-ийн 175 дугаар зүйл/;

11. Хээл хахууль авах, өгөх, зуучлах /ЭХ-ийн 268-270 дугаар зүйл/;


12. Хориглосон үйлдвэрлэл худалдаа эрхлэх;

13. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэсэн гэмт хэргийг оруулж байгаа юм.

Монгол Улсад гарсан гэмт хэргийн судалгаагаар шинэ төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан гэмт хэрэг цөөн тоотойгоор үйлдэгдэж ирсэн боловч сүүлийн нэг, хоёр жилийн хугацаанд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа юм. Энэ нь тухайн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах, хууль зүйн ойлголтыг улам нарийвчилж, түүнтэй хий тэмцлийг боловсронгуй болгох шаардлага бий болж байгааг харуулж байна. Орчин үеийн гэмт хэрэг үйлдэгчид нь шинжлэх ухааны ололтыг сайн ашигласан, сүүлийн үеийн мэдээллээр хангагдах чаддаг, техник хэрэгсэл нь боловсронгуй болж байгаа нь анхаарал татаж байна.

1. Шинэ төрлийн аргаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Манай улсад тогтмол гарч бүртгэгддэг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах /ЭХ-ийн 148 дугаар зүйл/, Бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах /ЭХ-ийн 150 дугаар зүйл/ гэмт хэрэг нь 2000 оноос тодорхой хэмжээгээр буурч ирсэн байна. Гэвч сүүлийн 2 жилд ихэсч байгаа төдийгүй нийгэмд учруулж байгаа хор хохирол хэдэн зуун тэрбум төгрөгөөр хэмжигдэж, шинэ тутам арга хэрэгслээр үйлдэгдэх болжээ.



Залилан мэхлэх гэмт хэрэг нь онлайн, интернэт хэлбэрээр бусдыг хуурч мэхлэх, хуурамч гүйлгээ хийх, хуурамч байгууллага бий болгох сүлжээний бизнес эрхэлж бусдыг элсүүлэх хэлбэрээр үйлдэгдэж байна. Үүний жишээ:

• Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршоо байгуулж иргэдийг хохироосон 14000 гаруй хохирогчтой Хадгаламж, зээлийн хоршооны /Оюу алт, Цэн алт гэх мэт/ хэрэг үйлдэгдэж энэ гэмт хэрэгээ далдлахын тулд санаатайгаар болон зохиомлоор данпууруулах байдлууд гарч байсан.

• Сүлжээний бизнес, гоо сайхны болон гадаад улсаас уран зураг, эм бэлдмэл оруулж ирэх зэргээр шатлал бүхий сүлжээ үүсгэж, бусдыг их хэмжээгээр хохироосон хэрэг гэх мэт.

Бусдын эд хөрөнгийг завшиж, үрэгдүүлэх гэмт хэрэг нь бусдын дансыг ашиглах, албан тушаалын /сүүлийн үед банк санхүүгийн салбарт/ давуу байдалаа ашиглах, байгууллагынхаа нууц код, тэмдэгтийг хэрэглэх, хуурамч гүйлгээ хийх замаар үйлдэж байна. Жишээ нь:

Голомт, Хас банкны хэд хэдэн ажилтан байгууллагын гүйлгээний дансны дугаар, хэрэглэгчийн хувийн дансыг ашиглан, их хэмжээний мөнгө хувьдаа завшсан, Хадгаламж банкны нягтлан бодогч 14 тэрбум төгрөг завшиж үрэгдүүлсэн, Банкны сүлжээгээр дамжуулан хуурамч байгууллага, гэмт хэрэгтнүүд аялал

жуулчлалын байгууллага, хувь хүмүүст их хэмжээний хохирол учруулсан гэх мэт гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Шалтгаан, нөхцөл:

Эдийн засаг, банк, санхүүгийн салбарын үйл ажиллагаанд тавих эрх зүйн хяналтын сул тал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтын хомсдол, хуулийн хоцрогдол нь ЭДГЭЭР гэмт хэрэг гарах суурь шалтгаан болж байна. /Хадгаламж, зээлийн хоршоодын хэргийг шалгах явцад төрийн байгууллагын хяналт шалгалт, эрх зүйн зохицуулалт илт дутагдсан байдаг. Лүүнчлэн гэмт хэргийн нийтлэг шалтгаан нөхцөл болох нийгэмд гарч байгаа ядуурал, ажилгүйдэл ч ихээр нөлөөлж байна. Сүүлийн үед энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүд нь улам бүр залуужиж, нарийн зохион байгуулалтад орж байна.

Зар сурталчилгаа, түүний хяналтгүй байдал, иргэдийн аж ахуй үйлдвэрлэл эрхлэх боломж, эрх зүйн орчин байхгүй зэрэг нь хохирогчдыг энэ төрлийн гэмт хэрэгт ихээр өртөж, хохироход хүргэж байгаа төдийгүй цаашид бусад төрлийн гэмт хэрэг үйлдэх үндсэн нөхцөл болж байна. Жишээгээлбэл, нэгэн банк бус санхүүгийн байгууллагад мөнгөө алдсан эр тухайн байгууллагын ажилтны биед хүнд гэмтэл учруулсан, байгууллагын өмч хөрөнгийг эвдэн сүйтгэсэн зэрэг хэргийг ч энд дурдах нь зүйтэй болов уу.

2. Эрүүгийн хуульд заагдсан шинэ төрлийн гэмт хэрэг: Хүн худалдах худалдан авах, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэх газрыг зохион байгуулах гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Зах зээл, нийгмийн харилцааны хөгжлийг дагалдан гарч болох нийгэмд аюултай сөрөг үзэгдэл бөгөөд хүнийг бүх талаар хамаалах зорилгын үндэсээ энэ гэмт хэргийг Эрүүгийн хуульд шинээр оруулж өгчээ.

Хүнийг хил давуулан худалдах гэмт хэрэг нь ихэвчлэн хууран мэхлэлт ба гэмт хэрэг үйлдэгчид нь хохирогчдоод өндөр шалин, хөлстэй ажил амлах, амьдралын илүү сайхан орчныг санал болгох, сургуульд суралцуулна, богино хугацаанд гадаадад ажиллуулна, замын зардал даана гэх мэтээр мэхэлж, гадаад оронд авч очоод хүч хэрэглэн дарамтлах, айлган сурдуулах, гадаад паспорт бичиг баримтыг нь хууран авах, хоол хүнс хэрэгцээний мөнгөөр хавчих зэргээр хүнд байдалд оруулан биеэ үнэлэхийг шаардах эсвэл биеэ үнэлэхээс өөр аргагүй байдалд орших арга замуудыг хэрэглэж байна.

• 2006 онд "Хүн худалдах, худалдан авах" гэмт хэрэг 3 бүртгэгдэж, үүнтэй холбоотой 21 өргөдөл нөмдөл хүлээн авч шалгаснаас прокурор 6 материалд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 15 материалд эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Энэ 15 хэргээс 4 эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, 8 хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг гэсэн үндэслэлээр /ЭБШХ-ийн 208.1.1-д заасан үндэслэл/ хэрэгсэхгүй болгож, 1 хэргийн сэжигтэн яллагадаг орлон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлж, 2 эрүүгийн хэрэгт ЭХ-ийн 124 дүгээр зүйл ангийн яллах дүгнэлт бичигдсэн байна.

Энэ гэмт хэрэг 2006 онд 2,3 дахин өсч 17 гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2007 онд 27 болж 4 дахин өссөн² үзүүлэлтэй байгаа нь цаашид энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион явуулах

¹ Цагдаагийн Ерөнхий газар, "Шинэ төрлийн гэмт хэргийн мэдээ", 2002-2007 оны байдалар.

² Цагдаагийн Ерөнхий газар, "Улсын хэмжээнд 2007 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ"

Шинэ төрлийн гэмт хэргийн өсөлт:

Гэмт сарга он	Хүн худалдах, худалдсан өвчтэй гэмт хараг	НХХ-ийг согтуурал, маноурал, биеэ үнэлэх, тэнүүчлэх, гуйлчигчлалд татан өрөөцүүлэх	Саадар саяууныг	Биеэ үнэлэхэд бусдыг татан орлолдуулах, биеэ үнэлэх газрыг зохион байгуулах
2002	3			8
2003	4	3		
2004		1		3
2005	5	1	2	2
2006	3	1	2	5
Нийт	15	6	4	18

шаардлагатай байгааг харуулж байна.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд БНХАУ-ын Эрээн хотод монгол охид, эмэгтэйчүүдийн байрлаж биеэ үнэлдэг баар, зочид буудал, сауны газар, "Гээтэн" буюу янхны газар зэргийг судалж бүртгэн, тэнд биеэ үнэлж байсан Монгол эмэгтэйд тоолж судалгааг гаргахад 152-176 эмэгтэй биеэ үнэлж байжээ.

Урьд өмнө нь биеэ үнэлж байсан болон Хятад, Өвөрмонгол хүнтэй суусан монгол хүүхдүүд монголд ирж амьдралын боломж муутай, ар талвас нь харж хандах хүнгүй, бага залуу насны охид, эмэгтэйчүүдийг судлан өндөр цалин хөлстэй ажил оруулна, бичиг баримт, замын зардал зэргийг нь двана гэх мэтээр хуурч мэхлэн хил давуулан гадаад паспортыг нь хураан авч хүч хэрэглэн дарамтлах, айлган сүрдүүлэх зэргээр гарцаагүй байдлаар оруулан биеийг нь үнэлүүлэх эсвэл гээтэн буюу янхны газрын эзэд 1500-5000 юаниар худалдаж байна.

Эрээн хотод "Гээтэн" буюу жижиг янхны газрууд байрладаг 4 том гудамж байна. Байрны хувьд арай хямд, байнгын үйлчлүлэгч нартай, цаг хугацаа харгалздаагүй, хаашаа ч явж биеэ үнэлэх боломжтой зэргээс шалтгаалан сүүлийн үед дээрх газарт байрлаж, биеэ үнэлэх явдал улам ихссэн байна. Мөн свүдэд ажиллаж биеэ үнэлдэг монгол

охид, эмэгтэйчүүд байна. Хуучин 3-4 сауны газар монгол хүүхнүүд байрлаж биеэ үнэлдэг байсан гэх боловч шалгалтын явцад 2 сауны газар монгол охид, эмэгтэйчүүд биеэ үнэлж байгаа нь тогтоогджээ.

Хүн худалдах, худалдан авах, биеэ үнэлэх газар зохион байгуулах гэмт хэрэг гарч буй шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүд нь :
•Эдийн засгийн асуудал – Манай улс дэлхийн хөгжлийн үзүүлэлтээр нэг хүнд ногдох үндэсний нийт орлогоор 161 дүгээр байрт орж байна. Ажлын үнэлэмж бага, үнийн өсөлтөөс шалтгаалан хүн амын худалдан авах чадвар эрс муудсан. Ихэнх хүнийг олж буй орлого нь дөнгөж амьжиргаагаа хангах төдийд л хүрч байна.

•Ажилгүйдэл – судалгааны дүнгээс харахад 5 хүний нэг нь ажилгүй, 4 хүний нэг нь хувиараа ажил эрхэлдэг. Харин улсын нэгдсэн тоо мэдээгээр ажилгүйдлийн түвшин 3,3 хувьтай байна.

•Ядуурал–2005 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 36,3 хувь нь буюу гурван хүн тутмын нэг нь ядуу, нэн ядуу амьдарч байна. Нэг хүнд ногдох өдрийн 1 доллараас бага хэрэглээтэй хүн амын эзлэх хувь 2003 оны байдлаар 27 хувьтай байгаа нь хүмүүсийн орлогоо нэмэгдүүлэхийн тулд гадаадад гарах боломж хайн, өөрсдийгөө эрсдэлд өртүүлэх нэгэн хүчин зүйл болж байна.

Биеэ үнэлэгч охидын дунд

явуулсан судалгаанд³ «Нийгмийн ямар давхаргын охид биеэ үнэлж байна вэ?» гэсэн асуултад 71,8 хувь нь тэнэмэл, 70,2 хувь нь ажилгүй болон сургууль зөвсөрсдсэй, 44,1 хувь нь оюутан, 27,2 хувь нь дунд сургуулийн суралчид гэж харуулжээ. Энэ гэмт хэргийн шалтгаан нь ядуурал, зохион байгуулалттай гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, амар хялбар аргаар амьдрах гэсэн залуусын сэтгэлгээ, ажилгүйдэл ихээр нөлөөлж байгааг харуулж байна.

3.Дэлхийн дахинд шинэ гарч байгаа шинэ төрлийн гэмт хэрэг: Компьютер, мэдээллийн аюулгүй байллын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл

2006, 2007 онд компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт тус бүр нэг удаа гарч бүртгэгдсэн нь тухайн гэмт хэрэг тогтвортой байгааг харуулж байна. Гэвч техник хөгжсөн өнөө үед манай улсын албан байгуулага болгон интернэтэд холбогдож, тэр хэрээр байгууллага, иргэд кибер гэмт хэрэгт ихээр өртөж хохирч байна. Ялангуяа байгууллагын сүлжээнд байгаа мэдээллүүдийг устгах, худалдаа үйлчилгээ хэлбэрээр эсвэл аялал жуулчлалын салбар, банк санхүүгийн салбарт хуурамч гүйлгээ хийх, гадаад орнуудын хуурамч байгууллага, гэмт хэргүүд захиалга өгч хохироох, хууран мэхэлж, эд зүйл, бэлэн бус мөнгийг шилжүүлэн авах гэмт хэргүүд гарсаар байна. 2007 оны 11 сарын байдлаар л гэхэд банкны салбарт гарсан 54 гэмт хэрэг бүртгэгджээ.

Хэдий ийм боловч гадаад орнуудын хакерууд, кибер гэмт хэрэгтнүүдтэй хийж байгаа тэмцэл манай улсад байхгүй, хохирч ирсэн байгууллага аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн мэдээллийг шалгаж үзээд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгээсээ татгалзан шийдвэрлэж байгаа тохиолдол

³ Хүн худалдах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөхөөллийн зорилгоор шинэлгээс хамагдалах Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-ын Эрээн хотод оршин сууж биеэ үнэлдэг, тэдгээрийг зохион байгуулдаг монгол охид, эмэгтэйчүүдийг судалж тоог нь тогтоох зорилгоор "Шинэ" нэгдсэн арга хэмжээг 2 зохионы хугацаатайгаар зохион явуулсан судалгаанаас.

⁴ Үндэсний Статистикийн газрын мэдээлэлээс.

⁵ 2006 онд МУИС-ийн Хүн ам зүйн сургалт судалгааны төв зарим байгууллагатай хамтран биеэ үнэлэгч охидын дунд явуулсан судалгаанаас.

⁶ Чингэлтэй дүүргийн Прокурорын газрын эрүүгийн хэрэг үүсгээсээ татгалзаж шийдвэрлэсэн материалаас.

цөөнгүй гарсан нь анхаарал татаж байна. Жишээ дурдахад: 2006 онд Монгол Улсын аялал жуулчлалын нэгэн байгууллага Голотм банкаар дамжуулан гадаадын иргэдэд залилуулан удаа дараа интернэтээр хуурамч гүйлгээ хийж, их хэмжээгээр хохирсон¹. Иргэн Б-г гадаад улсаас танилцах нэрээр итгэлийн олж удаа дараа хуурамч гүйлгээ хийж 10 сая төгрөгөөр хохироосон зэрэг баримтуудыг дурдаад байвал дуусгахгүй.

Кибер гэмт хэрэг нь илүү мэргэжлийн, гэмт хэрэгтэн баригддаггүйгээрээ онцлог бөгөөд олон тэрбум долларын үйлдвэрлэлийг ихээр бий болгож эхэлсэн төдийгүй ихэвчлэн онлайн хэлбэрээр буюу интернэтээр дамжин явагдаж байна.

Дэлхийн хэмжээнд 2007 оны эхний 6 сарын дотор 212,101 вирусны программ шинээр бүртгүүлсэн нь өнгөрсөгч 6 сарынхаас 185 хувиар өссөн үзүүлэлт зах зээл улам хурдтайгаар өргөжин тунд хандсан гэмт хэрэг ч бас улам нарийн болж байна.²

Компьютерийн гэмт хэргүүд дотороо нууц үг хулгайлах /phishing/, вирус тараах /virus/, бусдын и-мэйл хаяг руу хэрэггүй захиал олноор явуулах /spamming/, банкны цахим картны дугаар хулгайлах хийгээд өөрчлөх /carting/, хуурамч код тааруулан хууль бус гүйлгээ хийх зэрэг гэмт хэргүүд түгээмэл байдаг байна. Түүнчлэн нууц үг хулгайлах гэмт хэрэг дийлэнхийг эзэлж байна. Үүнийг үйлдэхдээ интернэтээр төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулдаг интернэт банк, интернэт худалдаа зэрэг вэб хуудаснуудыг яг жижигхэнээр дуурайлган хийдэг байна. Нууц үг картны дугаар хулгайлах цахим хуудасны 86 хувийн 30 хувь нь л хаяг нь мэдэгдэх (IP) байрших газар байрлахад нь тэдгээрийг олж илрүүлэхэд хүндрэл үзүүлдэг байна.³

Монгол Улсын хувьд кибер гэмт хэрэг гарахад дараах хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

• Эдгээр ажиллагаа нь ихэвчлэн багахан хэмжээний санхүүгийн

байгууллагын үйлчлүүлэгчид, жижиг нэгдэл, тэдний дайралтыг зогсоох хөрөнгийн боломжгүй банкууд руу чиглэсэн байдаг боловч энэ талаар мэдлэг хангалтгүй, хуулийн байгууллагаас гэмт хэрэг гэж үздэггүй.

• Кибер гэмт хэргээс хамгаалах үндэсний арга хэмжээ, хамгаалалт хангалтгүй, хууль тогтоомжийн хүрээнд тухайн гэмт хэрэгтэй тэмцэх талаар нарийвчилсан заалт, эрх зүйн орчин байхгүйгээс өөр төрлийн гэмт хэрэг гэж үзэн шийдвэрлэж байгаа нь энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахад сөргөөр нөлөөлж байна.

• Иргэдийн дунд компьютер, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар үйл ажиллагаа явуулж хэвшээгүй зэрэг нөхцөл хамгийн ихээр нөлөөлж байна.

4. Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах хадгалах, тээвэрлэх, илгээх борлуулах /ЭХ-ийн 200 дугаар зүйл/ гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Монгол Улс ойролцоогоор 1.56 сая хавтгай дөрвөлжин километр газар нутагтай. Одоогоор нийт газар нутгийн 20 орчим хувь нь эрдэс бүтээгдэхүүний судалгаа, олборлолтын зөвшөөрөл олгогдоод байна. Зөвшөөрөл нь 400,000 хүртэлх га газрыг хамруулах бөгөөд дээд тал нь 7 жилээр Монголын буюу гадаадын иргэд, хуулийн этгээдэд олгогддог бөгөөд нэг хүн буюу хуулийн этгээд хэдэн ч зөвшөөрөлтэй байж болдог, ашигт малтмалын зөвшөөрлийг бүхэлд нь буюу хэсэгчилж бусдад шилжүүлэх, барьцаа болгох боломжтой, компаниуд ихэвчлэн байгаль хамгааллын ажлыг хүлээсний дагуу дуусгах хангалттай чадавхигүй. Ерөнхийдөө байгаль орчны хамгаалалтын заалтуудын хэрэгжилт хүндрэлтэй, байгаль орчны хяналтын тогтолцоо сул байгаа нь тухайн гэмт хэрэг гарах үндсэн нөхцөл болж байна.

Одоогийн байдлаар усаар тээрэмдсэн шламгы цанитын уусмалаар боловсруулах үйл ажиллагаа хууль бусаар явуулснаас үүдэн 10 аймгийн нутагт 10 гаруй га талбай мөнгөн ус, цанигтаар бохирдож, ашиглахыг хязгаарласан онцгой хортой химийн үг бодисыг Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь, Баянхонгор, Булган, Өвөрхангай зэрэг аймгийн нутаг дэвсгэрт ашиглан алтны хүдэр тээрэмдэн аилт гаргаж байсан 145 тээрмийг илрүүлсэн байна. Харин мөнгөн ус ашигладаг дээр дурдсан найман аймагт 200 мянга орчим тонн мөнгөн усаар бохирдсон шлам /шороо/ үүссэнээс 37.35 га талбай бохирдсон байна.⁴

Нийслэлд химийн бодисын хэрэглээ их, хамгийн олон үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг нь Хан-Уул дүүрэг бол химийн хамгийн олон бодистой дүүргээр Баянзүрх 566 бодис тоологдсон байна. Нийслэлийн хэмжээнд:

- онцгой хортой бодис 68,
- онцгой цочроомтгой бодис 187,
- онцгой шатамхай 235,
- тэсрэмтгий бодис 36,
- сэтгэц хямраагч бодис 9,
- онцгой ислдвүлэгч бодис 107 тоологдсон байна.

Харин амьсгал боогдуулагч, онцгой тэсрэмтгий, арьс язлагч зэрэг хичнэ амь насанд хурдан хугацаанд нөлөөлөх бодис тоологдоогүй байна.

1) Нийслэлийн Налайх дүүрэгт иргэн Хишигбаярын мэдэлд байдаг хуучин шилний үйлдвэрийн агуулахад 20 тонн цагаан мышьяк хэмээх химийн хортой бодис хадгалагдаж байна.

2) Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн, тодорхой эрхэлсэн ажилгүй Д.Амарсайхан гэгч 1989 онд үйлдвэрлэсэн "Cs-137" /Цезий-137/ гэдэг Cs-137 цацрагийн үүсгүүрийг хууль бусаар олсон, үүнийгээ өндөр үнээр зарахыг завдаж, Орхон аймаг дахь 13 дугаар дунд сургуулийн баруун урд талд байрлах айлын хашаанд, төмөр агуулахад ил хадгалж байсан байна. Энэ цацрагийн

¹ Cyber Crime: 2007, USA handbook, p. 26

² Интернэт эх сурвалжаас

³ 2007 оны 10 сард Улсын мэргэжлийн хяналтын газрын хийсэн шалгалтын дүнгээс

үүсгүүр нь 80 грамм жинтэй боловч маш хортой, цацрагийн шарлага хүний эд эрхтнийг гэмтээхээс гадна үхэлд хүргэх, байгаль орчныг бохирдуулдаг бодис ба гадуураа ширмэн хамгаалалттай ч мэргэжлийн хүмүүсийн дүгнэлтээр зөвшөөрөгдөх хэмжээнээсээ (0.29 микро зиверт цаг) 50 дахин их буюу 17.3 микро зиверт цаг цацраг ялгаруулж байсныг тогтоосон.

3) Чингэлтэй дүүргийн XVI хороо, Хайлааст дахь Хятад иргэний гэрээс гурван тонн хорт бодис болох давсны хвчил, цайрын ялтас, алт угаадаг тугалган аяга гэх мэт зүйлийг илрүүлжээ. Тус хашаанд оршин суугч хууль бусаар амьдарч буй бөгөөд эдгээр бодисыг алт угаах зорилгоор хадгалж байсан байна.

4) Дархан-Уул аймгийн Хонгор суманд Хятадын хөрөнгө оруулалттай "Мич" компанийн буруутай ажиллагаанаас болж Хонгор сумын иргэд цианит натри хэмээх химийн онцгой хорт бодист хордсон хэрэгт Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл ангийн 263.2-оор Хонгор сумын Засаг даргыг шалгаж байна.

Нийслэлийн эргэн тойронд үйл ажиллагаа явуулдаг голдуу хятадын хөрөнгө оруулалттай тоосгоны үйлдвэрүүдэд химийн бодисын замбараагүй хэрэглээ гардаг тухай хяналтын байгууллагынхан үздэг. Арьс ширний үйлдвэрүүдэд гэхэд л химийн бодис, хвчил, шүлт агуулсан давс их хэмжээгээр ашиглах түүнээс улбаалаад гол ус бохирдохгүй, хүний амь нас эрсдэхгүй гэсэн баталгаа алга байна. Дээрх байдлаас үзэхэд химийн бодисын

хэрэглээнд бодитой хяналт тавих цаг нэгэнт болжээ.

Энэ гэмт хэрэг гарахад дараах шалтгаан нөхцөл тогтоогдож байна. Үүнд:

- Байгууллагуудад химийн бодисын зарцуулалтын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу бүртгэдэггүй, зарцуулалтын тайлан гаргадаггүй, хадгалалтын горим зөрчсөн, химийн бодисуудыг ангилан ялгаж хадгалдаггүй, байгаль хамгаалах төлөвлөгөөгүй байдаг;

- Иргэд химийн хорт бодисуудын хор аюулын талаар мэдээлэлгүй, бодис худалдан авсан газраасаа дагалдах бичиг баримт шаарддаггүй;

- Байгууллага, ялангуяа эмнэлэг сургуулиудад анх байгуулагдахад нь хангаж өгсөн ч ашиглалтын хугацаа нь дууссан, үндсэн шинж чанараа алдсан, нэр хаяггүй, янз бүрийн савлагаатай устгах шаардлагатай бодисууд их хэмжээгээр хадгалж байгаа;

- Үүний зэрэгцээ аюултай хог хаягдлыг бүртгэдэг аж ахуйн нэгж цөөн, хаягдал бүхий химийн бодисоо саармагжуулах, аюулгүй болгох тал дээр хангалтгүй ажилладаг;

- Мэдээллийн нэгдсэн сан байхгүй байгаа зэрэг нь нь энэ гэмт хэрэг гарах гол шалтгаан болж байгаа юм.

Манай улсад Шинэ төрлийн гэмт хэрэг 291 бүртгэгдсэн ба нийт гэмт хэрэг эзлэх хувийн жин 1.4 хувь байна.

Хуурамч бичиг баримт, тамга тэмдэг, хэвлэмэл маягтыг үйлдэх, ашиглах хэрэг 84, Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэг 71,

Татвар төлөхөөс зайлсхийх хэрэг 33, Хээл хахууль авах өгөж, зуучлах хэрэг 31, Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах хэрэг 14, Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах хэрэг 11, Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх, олж авах хэрэг 10, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэх газрыг зохион байгуулах хэрэг 9, Мөнгөн тэмдэгт, үнэт зөс хуурамчаар үйлдэх, борлуулах, хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх хэрэг тус бүр 8, Хүн худалдах, худалдан авах хэрэг 5, Мансууруулах болон сэтгэгдэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах хэрэг 4, Хүн хулгайлах, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацрагт идэвхит, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх хэрэг, Компьютерийн аюулгүй байдлын эсрэг хэрэг тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж байгаа өнөө үед гарч байгаа гэмт хэрэг, үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцөлд ч өөрчлөлт гарч, гэмт хэрэг үйлдэж байгаа арга хэрэгсэл шинэ хэлбэрт шилжих болжээ. Иймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахдаа тухайн хэргийн шалтгаан нөхцөл тус бүрийг анхааралтай, нарийн судлах шаардлагатай байна.



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖИЙН УЛАМЖЛАЛЫН АСУУДАЛД

ОХУ-ын ДЯЯ-ны Их Сургуулийн докторант,
цагдаагийн дэд хурандаа Г.ГАНТӨМӨР

Миний бие Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн уламжлалын талаар сонирхон судалж "Гэмт явдалтай тэмцэх асуудал" сэтгүүлийн 2005 оны №2т "Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн уламжлалын асуудалд" эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэн түүнд 1921 оноос 1926 он хүртэлх үеийн Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн түүхэн байдлын талаар авч үзсэн билээ. Харин энэ удаад дээрх өгүүллийн үргэлжлэл болгон 1926 оноос хойшхи үеийн Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн эх сурвалж, эрүүгийн хууль тогтоомж, түүний тогтолцоо, онцлогийн талаар авч үзсэнээ та бүхэнтэй хуваалцаж байна.

1921-1924 онд Ардын Засгийн газраас хуучин хууль цаазыг халах ардчилсан хувьсгалт ёсонд нийцсэн шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх Эрүүгийн хууль цаазыг шинээр боловсруулах бэлтгэлийг хангах ажлын хүрээнд олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсний нэг нь эрүүгийн хуулийн төсөл боловсруулах хууль цаазын тусгай комиссыг Шүүх явдлын яаманд байгуулан ажиллуулж, Монгол Улсын анхны бие даасан эрүүгийн хууль болох Шүүх цаазын бичгийн Ерөнхий ангийг Засгийн газрын 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн I хурлаар, Тусгай ангийг мөн оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Улсын III Их хурлаар тус тус баталж мөрдүүлсэн явдал билээ.

1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичиг нь Монгол Улсын

анхны төрөлжүүлэн нэгтгэсэн эрүүгийн хууль байсан гэж манай зарим эрдэмтэн, судлаачид үздэг.¹

Харин бидний үзэж байгаагаар 1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичиг батлагдсанаар Эрүүгийн хууль тогтоомжийг төрөлжүүлэх асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй ба Шүүх цаазын бичиг нь тухайн цаг үед эрүүгийн эрх зүйн цорын ганц бие даасан эх сурвалж байгаагүй юм.

1926 оны Шүүх цаазын бичиг батлагдан мөрдөх үеэс буюу 1926 оны 11 дүгээр сараас 1927 оны 3 дугаар сарыг хүртэл Шүүх цаазын бичгээс гадна эрүүгийн эрх зүйн шинжтэй өөр нэг хууль тогтоомж болох "Улс төрийн явдалд холбогдох хэргийг таслан шийтгэх газрын түр дагаж явах дүрэм" үйлчилж эрүүгийн эрх зүйн өөр нэг эх сурвалж болж байв. Учир нь Ардын засгийн газрын 1925 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн XII хуралдаанаар улс төрд онц аюултай гэмт хэргийг таслан шийтгэх эрхтэй цаг зуурын шүүхийг байгуулан 1926 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн I хурлын тогтоолоор Улс төрийн явдалд холбогдох хэргийг таслан шийтгэх газрын түр дагаж явах дүрмийг батлан гаргасан бөгөөд доктор /С.Д./, профессор Г.Совд түүнийг хувьсгалт эрүүгийн эрхийн дотоод томоохон нэг салбарын /төрийн эсрэг гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хуульчилсан Г.Г/ хэм хэмжээг анх нэгтгэн тогтоосон хууль байсан гэж дүгнэсэн байдаг.²

Ардын Засгийн газар 1927 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн VIII хуралдаанаараа тогтоол гарган

"Улс төрийн явдалд холбогдох хэргийг таслан шийдвэрлэх газрын түр дагаж явах дүрэм"-д заасан ямар ч ял шийтгэх онцгой эрхийг өөрчилж улс төрийн гэмт хэрэгт БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичгийг баримтлан ял ногдуулдаг болгосон³ нь үүнийг нотолж байгаа юм.

Ардын Засгийн газрын дээрх шийдвэр гарснаар сая 1926 оны Шүүх цаазын бичиг нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг бүхэлд нь өөртөө багтаасан, төрөлжүүлэн нэгтгэсэн хууль болж чаджээ.

БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичгийг Ардын засгийн газрын 1929 оны 9 дүгээр сарын

23-ны өдрийн XXX хурал, Улсын XIV бага хурлаар шинэчлэн баталсан ба 1929 оны Шүүх цаазын бичиг нь урьдах Шүүх цаазын бичгийн систем, зохион байгуулалтад үндсэн өөрчлөлт оруулаагүй боловч хуулийг дахин боловсруулахдаа түүнийг хэм хэмжээг ойлгож хэрэглэхэд хялбар болгож засан сайжруулсан юм. 1929 оны Шүүх цаазын бичгийг манай эрүүгийн эрх зүйн эрдэмтэд судлаачид 1926 оны Шүүх Цаазын Бичгийн шинэчилсэн найруулга гэж үздэг.⁴

1929 оны Шүүх цаазын бичгийг судалж үзэхэд тухайн цаг үед түүнээс өөр эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомж байгаагүйн зэрэгцээ, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд /1932 онд Уурын тэрэг жолоодогчид сотгуу буюу болгоомжгүй явж түүний улмаас хүний бие ба улсын хийгээд ардын хөрөнгөнд хохирол сүйтгэл учруулагчдыг хүндээр цээрлүүлж байх тухай Шүүх цаазын бичгийн 105

¹ Совд Г. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. Ерөнхий анги. УБ., 1973 он, 56 дахь тал. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997 он, 270 дахь тал

² Совд Г. Мөн бүтээл. 53-54 дэх тал

³ Содовсүрэн Б. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил. УБ., 1971 он, 42 дахь тал.

⁴ Содовсүрэн Б. Дурдсан зохиол. 47 дахь тал. Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1999 он, 54 дэх тал, Жанцан С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (Схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал). УБ., 2004 он, 43 дахь тал

дугаар зүйлд нэмэлт оруулсан, Шүүх цаазын бичгийн "Шашин суртлыг улс төрд хортойгоор хүрээглэх ба төр шашны хэргийг тусгайлан хууль зөрчих нь" гэсэн 30 дугаар бүлгийг 1934 оны 3 дугаар сарын 2-ны өдөр Ардын Сайд нарын зөвлөлийн IV хурлаар "Төр шашныг тусгаарласан тухай хууль дүрэм зөрчих нь" гэж өөрчлөн найруулсан, тус улсын аливаа сургуульд шашны ном заах, шашны явдалд албадан бадарлах, татвар хураах, шинээр дугана, сүм барих, 18 нас хүрээгүй хүмүүсийг лам болгох, улсын ба олон нийтийн зэрэг албан ба үйлдвэрийн газруудад шашны ёслол явуулахад лам нарыг урьж, хурал ном хуруулах явдлыг гэмт хэрэг гэж үзэж ял шийтгэх талаар Шүүх цаазын бичгийн 30 дугаар бүлгийн 223 224, 226, 228 дугаар зүйлд нэмэлт оруулсан, 1932 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн Засгийн газрын X хурлын "Харилцаа холбоонд санаатай саад хийх явдалтай тэмцэх тухай" тогтоолын "...Харилцаа холбооны утас таслах буюу багана модыг хөрөөдөж унагаах ёроолыг цавчих, лонхыг хагалах, угсан дээр юм хаях зэргээс цахилгаан мэдээ ба телефон шугам утсыг санаатай эвдэж гэмтээгчдэд Шүүх таслах газраас эрүүгийн хариуцлага хүлээлгэж байх..." гэсэн заалтын дагуу Шүүх цаазын бичгийн 15 дугаар бүлэгт 122 дугаар зүйлийг нэмсэн гэх мэт" нь Шүүх цаазын бичгийн бүрэлдэхүүн хэсэг болж байсныг холбогдох бүтээлүүдээс харж болно.⁵

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжлийг дагнан судалсан доктор Б. Содовсүрэн "...дээр өгүүлсэн түүхэн баримт бичгүүд нь тус улсын хөгжлийн түүхэн нөхцөл, цаг үеийн амьдралын шаардлагаас Шүүх цаазын бичгийн зарим зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ардчилсан төрөөс нийгмийн шинэ харилцааг хамгаалах хуучин харилцааг халж, өөрчлөх арга хэмжээ болсон..." гэж оночтойгоор дүгнэжээ.

1934 оны 10 дугаар сарын 8-ны өдөр БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газраас Шүүх цаазын бичгийг шинэчлэн баталж мөрдүүлжээ. 1929 оны Шүүх цаазын бичгийг өөрчлөх болсон шалтгаан нь олны дунд "Л.Дандав агсны" гэж нэрлэгдсэн "Монголын эрт эдүүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр"-т тэмдэглэсэнчилэн эрүүгийн хуулийн үндсэн ёсыг туйлын тодорхой бичсэнгүйн дээр элдвийн гэмт хэргүүдийг бүлэг бүрийн зохих зүйлүүдэд хуурдаудан бичсэн буюу хувьсагдд тэрэлсэн гэмт хэргийг хэдэн бүлэг болгон бичсэн болохоос гадна аж ахуй ба албан тушаал хийгээд ялангуяа хурыцын /бэлэгсийн/ гэмт хэргүүдийн ялыг хөнгөн заасан зэрэг дутагдлууд гарсан" явдал байв.

1934 оны Шүүх цаазын бичгийн холбогдох бүлэг, зүйлд улс орны гадаад дотоод аюулгүй байдал, нийгэмд бий болсон бодит шаардлагын дагуу 1939 оныг дуусгал удаа дараа зохих нэмэлт, өөрчлөлт оруулж байжээ. Тухайлбал: 1936 оны Ардын Сайд нарын Зөвлөлийн 1936 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн XX хуралдаанаар Тусгай ангийн "Төрөөс шашныг тусгаарласан тухай хууль дүрмийг зөрчих нь" гэсэн 5 дугаар бүлгийг өөрчлөн найруулсан, 1936 оны 8 дугаар сарын 19-ний УБХ-ын Тэргүүлэгчдийн 39 дүгээр хурлаар Шүүх цаазын бичгийн тусгай ангийн IX бүлэгт Цэргийн гэмт хэргийг шинээр хуульчилсан, 1938 оны Сайд нарын зөвлөлийн VIII хурлаар Тусгай ангийн "Эх орноос урагчдын тухай" гэсэн зүйлийг өөрчилсөн, 1938 оны 5 дугаар сарын 6-ны Ардын сайд нарын зөвлөлийн XVI хуралдаанаар улс төрийн гэмт хэрэг, засаг захиргааны журам зөрсөн гэмт хэргүүдийн бүлгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсан⁶ зэрэг болно.

1934 оны Шүүх цаазын бичиг нь нэгтгэн төрөлжүүлсэн эрүүгийн хууль байгаагүй нь судалгааны явцад тодорхой болж байна.

1940 онд хуралдсан МАХН-ын X Их хурлаас "Ноос бол алт"

уриаг дэвшүүлж, малаас гарях ашиг шийнийг сөйжруулах, түүхийг эд Тухайлбал: ноос бэлтгэлийг нэмэгдүүлэх талгаар компанит ажлыг улс орон даяар явуулсны зэрэгцээ 1941 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор "Ардын аж ахуйтнаас албан журмаар улсад ноосыг заавал бэлтгэн нийлүүлэх тухай" хууль батлан гаргажээ. Энэ хуульд албан журмаар улсад ноос бэлтгэн нийлүүлэх журмыг хуульчлаад зогсохгүй тухайн хуулийг зөргөсгөдөд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тухай эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тогтоож өгчээ. Уг хуулийн 11 дүгээр зүйлд "...Улсын өмнө хүлээсэн өөрийн үүргийг гүйцэтгэх явдалаас санаатай зайлсхийх буюу өөрийн малын жинхэнэ тоо толгойг нуун дарагдуулах явдал гарвал улсад тушааваал зохих ноосыг гаргуулан хураан авч зохихгдг эрүүгийн журмаар авч шүүх таслах газар шилжүүлэн 2 жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулна...Хураан авсан ноосны үнийг улсын орлогод оруулбал зохино...", мөн 8 дугаар зүйлд "...Ардуудын тушаасан ноосыг дутуу хэмжих, дутуу үнэлэх, түүний зэрэг дугаарыг дарагдуулах явдал гарвал гэмт этгээдийг шүүх таслах газар шилжүүлж таван жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулбал зохино..." гэж заасан" нь түүний баталгаа болж байна.

Энэ үеэс эхлэн БНМАУ-ын Бага болон Их Хурлын Тэргүүлэгчид улс, нийгмийн амьдралтай холбоотой тодорхой асуудлаар шийдвэр гаргахдаа Эрүүгийн хуулиас гадна эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон хуульчилсан актууд /зарлиг тогтоол/ -ыг батлан мөрдүүдгдг практик тогтон 1950-иад оны сүүл хүртэл үргэлжилсэн юм.

1940 онд хуралдсан Улсын VIII Их Хурлаас БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг баталсны дараа 1934 оны Шүүх цаазын бичгийг шинэчлэн боловсруулж, 1942 оны

⁵ Совд Г. Дурьдсан зохиол. 61-64 дэх тал

⁶ Содовсүрэн Б. Дурдсан зохиол. 50 дахь тал

⁷ Монголын эрт эдүүгээгийн хууль цаазын түүхийн сэдэвтэр. УБ., 2002 он, 91 дэх тал

⁸ Содовсүрэн Б. Дурдсан зохиол. 52-54 дэх тал

⁹ 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль. УБ., УХГ. 1949 он, 70, 81 дэх тал

1 дүгээр сарын 17-нд Улсын ХХV Бага хурлаар "БНМАУ-ын Эрүүгийн хууль" нэртэйгээр баталжээ.

Энэ үед дэлхийн улс төрийн байдал хурцдаж, дэлхийн II дайны гал дүрэлзэн Монгол Улсын гадаад, дотоод аюулгүй байдалд аюул занал учирсан түүхэн нөхцөлд социалист нийгмийн харилцааг хөгжүүлэх, улс орны батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, улс ардын аж ахуйг дайны байдалд шилжүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Эрүүгийн хуульд зохих нэмэлт, өөрчлөлт¹⁰ тухай бүр оруулж байсны зэрэгцээ Эрүүгийн хуулиас гадна эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийг батлан мөрдүүлсэн байна.

1940-1960 оны Эрүүгийн хууль тогтоомжийн онцлог нь эрүүгийн хуулиас гадна эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бие даан хуульчилсан актуудыг мөрдөж байсан явдал юм.¹¹

Доктор /Ph.D/ Д.Адьяабазар БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуулиас гадна доор дурдсан хуульчилсан акт үйлчилж байсан гэж үзжээ.Үүнд:

1.БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1947 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн V хурлын "Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагын өмчийг хамгаалах тухай" тогтоол;

2. 1947 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн "Энгийн этгээдийн авто машиныг улсад хураан авах тухай" 7дугаар тогтоол;

3. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1942 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн "Үйлдвэрийн газруудаас багаж хэрэгслийг ашиглан хэрэглэх ба арчлан хамгаалах хийгээд мөнхүү үйлдвэрийн газруудын боловсруулан гаргасан үйлдэхүүний тусгай хуваарь баталгаагүйгээр гадагш худалдах явдлыг зогсоох тухай" тогтоол;

4.БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 51 дүгээр хурлын "Улсын нууц болж тусгайлан хадгалагдах мэдээнүүдийн жагсаалтыг батлах тухай" тогтоол;

5. 1953 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан "Алах ялыг өөрчлөх тухай" зарлиг, 1954 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн өөрчлөлтийн хамт;

6. 1954 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн "Энх тайвныг хамгаалах тухай" хууль;

7.Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1955 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Улсын нууцыг задруулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай 120 дугаар зарлиг;

8."Төмөр замын хөдөлгөөнийг аюулаас хамгаалах явдлыг хангах арга хэмжээний тухай" 1955 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 126 дугаар зарлиг;

9."Ард иргэдийн өмчийг хулгайгаас хамгаалах явдлыг чангатах тухай" 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хууль;

10."Улсын ба хоршоолол, олон нийтийн өмчийг ашиглан үрэгдүүлэх явдлаас хамгаалах тухай" 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хууль, 1958 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн өөрчлөлтийн хамт¹² зэрэг болно.

Харин доктор /Ph.D/ Б.Содовсүрэн БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганаар 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр батлагдсан БНМАУ-ын Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх хүртэл хуучин төгөлдөр үйлчилж байсан эрүүгийн хууль тогтоомжид 1942 оны Эрүүгийн хуулиас гадна дараах хууль зарлиг хамаарна гэж үзэж байв. Тэдгээр нь:

1.1953 оны 8 дугаар сарын 5-нд БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан "Алах ялыг өөрчлөх тухай" 93 дугаар зарлиг, 1954 оны 6 дугаар

сарын 9-нд орсон өөрчлөлтийн хамт;

2.1954 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн "Энх тайвныг хамгаалах тухай" хууль;

3.Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1955 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Улсын нууцыг задруулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай 120 дугаар зарлиг;

4."Төмөр замын хөдөлгөөнийг аюулаас хамгаалах явдлыг хангах арга хэмжээний тухай" 1955 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 126 дугаар зарлиг;

5."Ард иргэдийн өмчийг хулгайгаас хамгаалах явдлыг чангатах тухай" 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хууль;

6."Улсын ба хоршоолол, олон нийтийн өмчийг ашиглан үрэгдүүлэх явдлаас хамгаалах тухай" 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хууль, 1958 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн өөрчлөлтийн хамт болно.¹³

Бидийн үзэж байгаагаар 1942 оны Эрүүгийн хуулиас гадна эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон доор дурьдсан хуульчилсан актууд үйлчилж байсан.Тэдгээр нь:

1.1941 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор "Ардын аж ахуйтнаас албан журмаар улсад ноосыг заавал бэлтгэн нийлүүлэх тухай" хууль;

2.БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1942 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн "Үйлдвэрийн газруудаас багаж хэрэгслийг ашиглан хэрэглэх ба арчлан хамгаалах хийгээд мөнхүү үйлдвэрийн газруудын боловсруулан гаргасан үйлдэхүүний тусгай хуваарь баталгаагүйгээр гадагш худалдах явдлыг зогсоох тухай" тогтоол;

3."Ажлын чадвар бүхий ард иргэдийг үйлдвэрийн газар ба барилга, улсын сангийн аж ахуйд

¹⁰ Зарим эрдэмтэн судлаачдын тооцоолсноор 1942 оны Эрүүгийн хуулийг баталснаас хойш түүнд 15 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Болдбаатарж, Лундэжжанцан Д. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997 он, 299 дэх тал.

¹¹ Дурдсан бүтээл. 300 дахь тал.

¹² Адьяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998 он, 102-103 дахь тал

¹³ Содовсүрэн Б. БНМАУ-ын Эрүүгийн эрх. Ерөнхий анги. УБ., УХГ. 1964 он, 50 дахь тал

авч ажиллуулах тухай" БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 94 дүгээр тогтоол;

4. Дайны үед үүрэгт ажлаа дур зоргоор хаясан явдлын хариуцлагыг нэмэгдүүлэх тухай" БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 57 дүгээр тогтоол;

5. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1947 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн V хурлын "Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагын өмчийг хамгаалах тухай" тогтоол;

6. 1947 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн "Энгийн этгээдийн авто машинг улсад хураан авах тухай" 7 дугаар тогтоол;

7. 1953 оны 8 дугаар сарын 5-ны өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан "Алах ялыг өөрчлөх тухай" 93 дугаар зарлиг, 1954 оны 6 дугаар сарын 9-ний өдөр орсон өөрчлөлтийн хамт;

8. 1954 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн "Энх тайвныг хамгаалах тухай" хууль;

9. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1955 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн "Улсын нууцыг задруулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай" 120 дугаар зарлиг;

10. "Төмөр замын хөдөлгөөнийг аюулаас хамгаалах явдлыг хангах арга хэмжээний тухай" 1955 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 126 дугаар зарлиг;

11. "Ард иргэдийн өмчийг хулгайгаас хамгаалах явдлыг чангатгах тухай" 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хууль;

12. "Улсын ба хоршоолол, олон нийтийн өмчийг ашиглан үрэгдүүлэх явдлаас хамгаалах тухай" 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хууль, 1958 оны 7 дугаар сарын 7-ны өөрчлөлтийн хамт зэрэг болно.

Дээр дурдсан хуульчилсан актуудыг судлан үзэхэд 1940-1960 оны эрүүгийн хууль тогтоомж нь хууль зүйн актын төрөл, хууль зүйн

хүчин чадал, цаг хугацааны хувьд өөр өөр үед батлагдсан хууль, хуульчилсан актуудаас бүрдэж байсан онцлогтой байна.

Бидний үзэж байгаагаар уг актуудыг тэдгээр хуульчлагдсан эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний онцлогоос хамаарч:

1. Тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүн, ногдуулах эрүүгийн хариуцлага, ялын төрөл хэмжээг өөртөө шууд заасан;

2. Тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шууд заасан боловч ногдуулах ялын төрөл хэмжээг өөртөө заагаагүй, 1942 оны Эрүүгийн хуулийн зохих зүйлээр эрүүгийн хариуцлага /зохих зүйлийн санхдад заасан ялыг хэрэглэхээр/ хүлээлгэхээр заасан гэж ангилж болно.

Ингээд дээрх хуульчилсан актуудыг нэг бүрчлэн авч үзэж явцад тэдгээрийн шинж, онцлог, дээрх ангиллын алинд хамаарахыг мэдэх бололцоотой юм.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1942 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн V хурлын "Үйлдвэрийн газруудаас багаж хэрэгслийг ашиглан хэрэглэх ба арчлан хамгаалах хийгээд мөнхүү үйлдвэрийн газруудын боловсруулан гаргасан үйлдэхүүнийг тусгай хуваарь баталгаагүйгээр гадагш худалдах явдлыг зогсоох тухай" тогтоолд үйлдвэрлэлийн багаж хэрэгслийг ашиглан хэрэглэх ба арчлан хамгаалах хийгээд захиалан ирүүлэх явдал нь зөв сайнаар зохиогдсон бэйвал улсын үйлдвэрийн техникийн зөвсгөллэл одоогийн байгаагаас ихээхэн дээр хэмжээтэй байхыг дурьдааад үйлдвэрийн газар байгаа багаж хэрэгсэл, тоноглолыг дур зоргоор худалдах хийгээд засварлаад дараа нь ашиглан хэрэглэж болох тоноглолыг хугацаанаас нь өмнө хаях ба мөн ашиглаж болохгүй буюу ажил дээр жинхэнэ хэрэглэх хэрэгцээгүй тоног төхөөрөмжүүдийг захиалан ирүүлэх явдлыг зогсоохыг бүх үйлдвэрийн газрын удирдлагуудад үүрэг болгож тогтоолын 4 дэх зүйлд "...үйлдвэрлэлийн байгууллагын машин тоноглолыг дур зоргоор

худалдах буюу эсвэл үйлдвэрийн газар байгаа машин тоноглолыг хариуцлагагүйгээр ашиглан хэрэглэх ба арчлан хамгаалахгүй бэйвал эрүүгийн хариуцлагад татан нийтийн хөрөнгийг үрэгдүүлэн шамшигдуулсан гэж үзэж эрүүгийн хуулийн зохих зүйлээр шийтгэгдэх болно...", 5 дахь хэсэгт "...Машин тоноглолын зүйлийг үндэс баримтгүйгээр захиалан ирүүлж дараа нь уул захиалан ирүүлсэн нь илүү болох бол зохих этгээдийг эрүүгийн хуулийн зохих зүйлээр гэмт хэргийг хайхрамжгүй гаргасанд үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэн шийтгэж байвал зохино...", 6 дахь хэсэгт "...Үйлдвэрийн газруудаас үйлдвэрлэн гаргасан эд үйлдэхүүнийг хуваарь баталгаагүй худалдаалах буюу өөр хоорондоо солилцсон бол нийтийн өмчийг үрэгдүүлэн шамшигдуулсанд тооцож эрүүгийн хуулийн зохих зүйлүүдээр шийтгэж байвал зохино..." гэж тус тус заажээ.

Дэлхийн II дайны үед улс орны батлан хамгаалах чадварыг нэмэгдүүлэх, улс ардын аж ахуйг дайны байдалд шилжүүлэх, сахилга хариуцлагыг сайжруулах зэрэг цаг үеийн шаардлагаар БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид 1944 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр "Ажлын чадаар бүхий ард иргэдийг үйлдвэрийн газар ба барилга, улсын сангийн аж ахуйд өвч ажиллуулах тухай" 94 дүгээр тогтоол гаргасан ба тогтоолын 13 дугаар зүйлд "...Үйлдвэр, барилга ба улсын сангийн аж ахуйнуудад ажиллах явдалд зайлшгүйсэн ажлын чадвар бүхий этгээдүүд ба түүнчлэн энэхүү тогтоолыг биелүүлэхээс зайлсхийх явдалд ямар нэгэн талаар туслагдсыг эрүүгийн хариуцлагад татаж ардын шүүх таслах газрын тогтоолоор анхны удаад 3 сар хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх ба 2 дахь удаад нэг жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэхээр заасан байна.

Мөн БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн "Дайны үед үүрэгт ажлаа дур зоргоор хаясан явдлын хариуцлагыг нэмэгдүүлэх тухай" 57 дүгээр тогтоолд дайны

¹⁴ Содовсүрэн Б. БНМАУ-ын Эрүүгийн эрх. Ерөнхий анги. УБ., УХГ. 1964 он, 63-64 дэх тал

үед улсын албан үйлдвэрийн ажлыг өөрийн дур зоргоор хаясан хүмүүсийг шүүх таслах газар нэн даруй шилжүүлж, шүүхийн тогтоолоор 6 сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ялыг ногдуулж байхыг тогтоожээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1947 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн V хурлын "Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагын өмчийг хамгаалах тухай" тогтоолд Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагуудын өмч бол бүх ард түмний нийгмийн хөрөнгө болох учраас халдашгүй дархан ариун хөрөнгө мөн бөгөөд энэхүү өмчид халдсан хүмүүсийг ардын дайсан улсын гэмт хэрэгтэн гэж үзэхийн хамт тэдэнтэй шийдвэртэй тэмцэл явуулах нь төрийн бүх байгууллагын нэн түрүүний үүрэг болохыг дурьдаад дараах эрүүгийн эрх зүйн хэмжээг хуульчилжээ. Тогтоолын 1 дэх хэсэгт "...Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагуудын өмч хөрөнгийг онц хортой аргаар буюу зохион байгуулалттайгаар мөн түүнчлэн улсын ба олон нийт, хоршооллын мөнгөн хөрөнгө, үнэ бүхий бусад эд материалыг үлэмжхэн хэмжээгээр хулгайлсан шамшигдуулсан гэмт этгээдүүдийг хуулийн дээд хэмжээ хэрэглэн буудан алж бүх хөрөнгийг хурааж байсугай. Хэрэв хөнгөтгөх учир байвал буудан алах ялыг өөрчлөн арван жилийн хориогоор сольж бүх хөрөнгийг хураавал зохино...", 2 дахь хэсэгт "...Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагын өмчийг хамгаалах, бүртгэх, түнэд хяналт шалгалтыг хийх үүрэг бүхий хүмүүсээс тэрхүү онц хортой аргаар буюу зохион байгуулалттайгаар хулгайлах, шамшигдуулах явдалд элдэв нэгэн талаар дэмжлэг үзүүлэх буюу тэр явдалд боллоцгоо олгож зөнд нь тавьсан, мөн түүнчлэн улсын ба хоршоолал, олон нийтийн байгууллагуудын өмч, улсын бэлтгэл /фонд/-үүдийг дээр дурдсан албан тушаалын хүмүүсээс янз бүрийн луйврын арга хэрэглэж үргэдүүлэн сүйтгэсэн байвал гэмт этгээдүүдийг

хуулийн дээд хэмжээг хэрэглэн буудан алж, бүх хөрөнгийг хураах ба хэрэв хөнгөтгөх учир байвал буудан алах ялыг найман жилээс доошгүй хугацааны хориогоор сольж хөрөнгийг бүгдийг буюу заримыг хураавал зохино..." гэж заасны зэрэгцээ уг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд өршөөл үл үзүүлэх, уг тогтоолыг түүнийг гарахаас өмнө үйлдсэн хэрэгт буцаан хэрэглэхээр тогтоожээ¹⁵.

Түүнчлэн 1947 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн "Энгийн этгээдийн авто машиныг улсад хураан авах тухай" 7 дугаар тогтоолын 7 дугаар зүйлд "...Цаашид энгийн хүнээс авто машинууд буюу түүний запас хэрэгслүүдийг тус улсын Засгийн газрын тусгай зөвшөөрөлгүйгээр амин хувьдаа авч хэрэглэх явдлыг улсын өмчийг хулгайлан сүйтгэсэн хэрэг гэж үзэж авто машинууд ба түүний запас хэрэгслүүдийг энгийн хүмүүст худалдсан хийгээд худалдан авсан буруутай хүмүүсийг 1947 оны 2 дугаар сарын 4-ний өдөр /Улсын ба олон нийт, хоршооллын өмчийг хамгаалах тухай/ гаргасан хуульд заасан ёсоор эрүүгийн хариуцлагад татаж байхаар заасан байна¹⁶.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1951 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн "Энх тайвныг хамгаалах тухай" 9 дүгээр зарлигт "...Шинэ дайн өдөөх тухай суртал нэвтрүүлэг бол энх тайван, улс түмний хоорондын аюулгүй байдлын эсрэг өдүүлж буй хамгийн хүнд гэмт хэрэг болохыг дурьдаад шинэ дайн өдөөх тухай суртал нэвтрүүлгийг амаар буюу бичгийн аль ч хэлбэрээр явуулсан ба мөн энэхүү суртал нэвтрүүлгийг явуулахад туслаж, дэмжлэг үзүүлсэн этгээдийг 10-25 жил хүртэл хугацаагаар ганданд хорьж, иргэний эрхийг эхсэ бүх хөрөнгийг хураахаар заажээ.

1953 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 93 дугаар зарлигаар Эрүүгийн хууль дахь цаазаар авах ялыг хассан байна. Уг зарлигт "... Монголын ард түмнээс өөрийн эх орон, ардын хувьсгалт нам, ардын

засагтаа хязгааргүй үнэнч хайртай бөгөөд түүний соёлын хэмжээ ба эдийн засгийн байдал дээшилж, хөдөлмөрчдийн ялс төрийн ухамсар өндөржсөн явдлыг харгалзаж БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс энх тайван цаг алах ялыг хойшид хэрэглэхийн хэрэггүй гэж үзнэ..." гэж заасны зэрэгцээ эх орноосоо урвах, тагнуул хийх, хорлон сүйтгэхээс бусад гэмт хэрэгт буудан алах ялыг хэрэглэхгүй болгож, эрүүгийн хуульд заасан алах ялтай хэрэг үйлдэгчдийг 25 жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж байхаар тогтоожээ.¹⁷

Уг зарлигт 1954 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 67 дугаар зарлигаар өөрчлөлт оруулж бусдыг санаатай алсан этгээдэд буудан алах ялыг ногдуулахаар болжээ. Энэ зарлигт заахдаа хүнийг санаатай алсан этгээдэд буудан алах ял ногдуулж байх талаар ард иргэдээс ба олон нийтийн байгууллагаас хүсэлт тавьж байгааг харгалзан ард иргэдийн амь биеийг хамгаалах явдлыг хичээж болгох зорилгоор энэ алхмыг хүйт байгаа талаар дурдсан байдаг.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1955 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 120 дугаар зарлигаар БНМАУ-ын нууцыг задруулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэж байх талаар бие даасан эрүүгийн эрх зүйн хэмжээг тогтоосон байна. Уг зарлигт:

1. Улсын нууцад холбогдох мэдээ баримтуудыг өөрт нь итгэмжилсээр буюу өөрийн албан тушаалын байдлаараа эдгээр баримтыг олж авч чадах хүмүүсээс уг нууц мэдээ баримтуудыг задруулсан нь энх орноосоо урвасан, тагнуул хийсэн гэж үзэх үндэслэлгүй /1942 оны Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 56 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол Г.Г./ бол 5-10 жил хүртэл хорьж;

2. Улсын нууцад холбогдох цэргийн шинж чанартай мэдээ баримтуудыг цэргийн албан хаагчаас задруулсан нь энх орноосоо урвасан, тагнуул хийсэн гэж үзэх үндэслэлгүй /1942 оны Эрүүгийн хуулийн Тусгай

¹⁵ 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль. УБ., УХГ. 1949 он, 59-60 дахь тал

¹⁶ Мөн гэнд, 61 дэх тал

¹⁷ Содовсүрэн Б. БНМАУ-ын Эрүүгийн эрх. Ерөнхий анги. УБ., УХГ. 1964 он, 45 дахь тал

ангийн 56 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол Г.Г/ бол 8-20 жил хүртэл хорих;

3. Улсын нууцад холбогдох мэдээ баримтуудыг энгийн хүмүүсээс задруулсан нь эх орноосоо урвасан, тагнуул хийсэн гэх үндэсгүй бол 5-10 жил хүртэл хорих;

4. Улсын нууцад холбогдох мэдээ материал, баримт бичиг, хэвлэлийг албан тушаалтнаас алдаж гээгдүүлсэн байгаад тэр нь шинж чанараараа хүндрүүлэх шалтгаангүй бол 6 сар хорих, хэрэв нууцыг алдаж гээгдүүлснээс хүнд хор хохиролд хүргэсэн бол 5-10 жил хорих;

5. Улсын нууц мэдээ материал, бичиг баримтуудыг цэргийн албан хаагчаас алдаж гээгдүүлсэн байгаад тэр нь шинж чанараараа хүндрүүлэн шийтгэх шалтгаангүй бол 8 жил хорих, Хэрэв нууц алдаж гээгдүүлснээс хүнд хохиролд хүргэсэн бол 6-10 жил хүртэл хорих;

6. БНМАУ-ын иргэдээс улсын нууцад холбогдох шинэ нээлтүүд мөн техникийн нээлт ба сайжруулсан өөрчлөлтийг гадаадад задруулсан буюу шилжүүлэн өгсөн нь эх орноосоо урвасан буюу тагнуул хийсэн гэх үндэсгүй бол 8-15 жил хүртэл хорихоор заажээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид 1955 оны 12 дугаар сарын 1-ний өдөр "БНМАУ-д төмөр замын хөдөлгөөнийг аюулаас хамгаалах явдлыг хангах арга хэмжээний тухай" 126 дугаар зарлиг гаргаж түүнд төмөр замын хөдөлгөөнийг аюулгүй байдлад халдсан үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг хуульчилжээ.

Уг зарлигт тус улсад төмөр замын тээвэр өргөжин хөгжиж байгаатай уялдуулан, төмөр замын аюулгүй байдлыг хангахын чухлыг тэмдэглэдэг дор дурьдсан Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг заасан байна. Үүнд:

1. Төмөр замын шугамаас өөр тийш хориглоосон хэмжээний дотор буюу 500 метр газар бод ба бог малыг хариулах, түүнчлэн тогтоосон зурвасаас бусад газраар

малва төмөр зам дээгүүр гаргасан мал эхний удаад нь малын эзэн, сангийн аж ахуй болон нэгдлийн малчныг 25-250 төгрөгөөр торгох, уг зөрчлийг дахин гаргасан мал буруутай этгээдийг 3 жил хүртэл хорих буюу 1 жил хүртэл албадан ажил хийлгэх, хэрэв уг үйлдэлд сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлийн хийгээд мал эзэмшигч бусад байгууллагын удирдах хүмүүсийн буруу ажиллагааны улмаас гаргасан явдал илэрвэл тэд нарыг дээрхийн адил хариуцлагад татаж байх;

2. Мөн эзэнгүй мал төмөр зам дээр байснаас галт тэрэг онхолдох, эд материалын хохирол учрах, хүний амь бусниход хүргэсэн бол уул малын эзэн буюу сангийн аж ахуйн ба хөдөө аж ахуйн нэгдлийн малчныг 3-10 жил хүртэл хорих;

3. Түүнчлэн зам төмрийн эргийг салгах, зам төмөр дээр элдэв зүйлийг тавих, төмөр замын гүүр, гарц, урьдчилан сэргийлэх тэмдгийг эвдэх зэргээр төмөр замыг эвдэлсэн буюу гэмтээснээр галт тэрэг онхолдох аюулыг санаатайгаар бий болгосон гэмт этгээдийг 15 жилээс доошгүй хугацаагаар хорьж хөрөнгийг бүгдийг буюу заримыг хураах, хэрэв онцгой хүндрүүлэх нөхцөл шалтгаанууд байвал 25 жилээр хорьж, бүх эд хөрөнгийг хураах аргаар тогтоожээ.¹⁸

Ард иргэдийн өмч хөрөнгийг хулгайгаас хамгаалах явдлыг чангатгах зорилгоор БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчид 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдөр 212 дугаар зарлигийг гаргаж түүнтэй холбогдуулан 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн "Эд хөрөнгийн гэмт хэргүүд" гэсэн VIII бүлгийн 173-ын 1, 2, 3, 4, 5 дугаар зүйл /Иргэдийн эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн болон хүндрүүлэх түүнчлэн онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулгайлах гэмт хэрэг Г.Г/ 176 /Иргэдийн эд хөрөнгийг дээрэмдэх/, 176 дугаар зүйлийн 1 онц хэсэг /Дээрэмдэх гэмт хэргийг үл мэдээлэх/-үүдийг хүчингүй болгон дор дурьдсан Эрүүгийн эрх зүйн хэм

хэмжээг хуульчилсан юм.

1. Ард иргэдийн эд хөрөнгийг хулгайлаж 7 жил хүртэл хугацаагаар хорих;

2. Ард иргэдийн эд хөрөнгийг их хэмжээгээр буюу давтан, удаа дараа хулгайлсан, эсвэл зохион байгуулалттайгаар бүлэглэж, бусад хортой арга хэрэглэж хулгайлаж 7 жилээс 20 жил хүртэл хорьж хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах;

3. Хэрэв ард иргэдийн хөрөнгийг дээрэмдсэн байвал 5 жилээс 15 жил хүртэл хорьж, хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах;

4. Хэрэв ард иргэдийн хөрөнгийг их хэмжээгээр буюу давтан, удаа дараа дээрэмдсэн, эсвэл зохион байгуулалттайгаар бүлэглэн дээрэмдсэн байвал 15 жилээс 25 жил хүртэл хорьж хөрөнгийг бүгдийг хураах;

5. Зарлигийн 3, 4 дүгээр зүйлд заасан ард иргэдийн хөрөнгийг дээрэмдсэн буюу дээрэмдэхээр бэлтгэж байгаа мэдээср байгаад улсын байгууллагад мэдэгдээгүй байвал 3 жил хүртэл хорихоор тус тус заасан¹⁹ бөгөөд уг зарлигийн 1957 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрджээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид мөн өдөр "Улс хоршооллын өмчийг ашиглан үрэгдүүлэх явдлаас хамгаалах тухай" 213 тоот зарлиг гарган Улс, хоршооллын өмчийг ашиглагчдад хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тогтоосон бие даасан хуульчилсан актыг баталж мөрдүүлжээ. Уг зарлигт:

1. Улсын хөрөнгийг хулгайлах, хувьдаа ашиглах буюу үрэгдүүлэх зэрэг хэлбэрээр завшвал 10 жил хүртэл хорьж, хөрөнгийн заримыг хураах;

2. Улсын хөрөнгийг их хэмжээгээр буюу зохион байгуулалттайгаар бүлэглэж хулгайлах, эсвэл хортой аргаар ашиглах үрэгдүүлэх, удаа дараагаар буюу дахин давтан хулгайлах, мөн эсвэл улсын ба олон нийтийн өмчийг ашиглаж үрэгдүүлсэн хэрэгт урьд шийтгэгчид 10 жилээс 25 жил хүртэл хорьж хөрөнгийн заримыг

¹⁸ Содовсүрэн Б. Дурдан зохиол. 47 дахь тал

¹⁹ Содовсүрэн Б. Дурдан зохиол. 48 дахь тал

буюу бүгдийг хураах;

3.Нэгдэл, хоршоолол, бусад олон нийтийн байгууллагын хөрөнгийг хулгайлах, хувьдаа завших, үрэгдүүлбэл 8 жил хорих;

4.Нэгдэл, хоршоолол, бусад олон нийтийн байгууллагын хөрөнгийг их хэмжээгээр буюу зохион байгуулалттайгаар бүлэглэж хулгайлах, хортой аргаар ашиглах үрэгдүүлэх, удаа дараагаар буюу дахин давтан хулгайлах мөн эсвэл улсын ба олон нийтийн өмчийг ашиглан үрэгдүүлсэн хэрэгт урьд шийтгэгчдийг 8 жилээс 23 жил хүртэл хорьж хөрөнгийн заримыг хураах буюу хураахгүйгээр шийтгэх;

5.Зарлигийн 2, 4 дүгээр зүйлд заасан улсын ба нийгмийн хөрөнгийг хулгайлсан ашигласан үрэгдүүлсэн, буюу түүнийг бэлтгэж байгааг мэдсээр атлаа улсын байгууллагад мэдэгдээгүй хүмүүсийг 3 жил хүртэл хорьж шийтгэхээр тус тус заажээ²⁰.

Уг зарлиг гарснаар 1942 оны Эрүүгийн хуулийн 128 /Албан тушаалтан олон нийтийн байгууллагаас үүрэг хүлээсэн этгээд бусдын эд хөрөнгийг хувьдаа завших буюу үрэгдүүлэх/, 173 дугаар зүйлийн 6, 7, 8, 9, 10 /Улс, хоршоолол, олон нийтийн өмчийг хулгайлах хулгайсныг үл мэдээлэх/ дугаар хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, /Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах/, БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1947 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн "Улсын ба олон нийт, хоршооллын

байгууллагын өмчийг хамгаалах тухай" тогтоол тус тус хүчингүй болсон юм.

Мөн 1958 оны 7 дугаар сарын 7-ны өдөр БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид 27 дугаар зарлиг гарган 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 213 дугаар зарлигийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан байна.

Ийнхүү бусдын өмчийн эсрэг гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг 1942 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 8 дугаар бүлгийн холбогдох зүйлүүд болон БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1956 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 212, 213 дугаар зарлиг, 1958 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 27 дугаар зарлиг гэх мэт эрх зүйн ижил хүчин чадалтай, хэд хэдэн хууль болон хуульчилсан актуудаар тогтоосон нь хууль хэрэглэх үйл ажиллагаанд тодорхой хүндрэл учруулаад зогсохгүй бусдын эд хөрөнгийг хамгаалах эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний ач холбогдол, үр нөлөөг бууруулахад хүргэсэн алхам болсон гэж хууль зүйн шинжлэх ухааны доктор Р.Гүнсэн тэмдэглэж байв.²¹

1960 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн 1961 оны 1 дүгээр сарын 31-нд БНМАУ-ын АИХ-ын II чуулганаар Эрүүгийн хуулийг шинэчлэн баталж, мөн оны 4 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдүүлжээ.

1961 оны Эрүүгийн хууль нь

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэнд томоохон өөрчлөлт оруулсан ба жинхэнэ утгаараа эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг бүхэлд нь нэгтгэн төрөлжүүлсэн хууль болж чадсан юм.

1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль батлагдан хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр 1942 оны Эрүүгийн хууль болон түүнтэй хамт үйлчилж байсан дээр дурьдсан эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тогтоосон хуульчилсан актуудын хүчин чадал дуусгавар болжээ.

Түүнээс хойш Монгол Улс эрүүгийн хуулиас гадна эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тогтоосон хуульчилсан актуудыг баталдаг гажууд гэмээр практикаас татгалзаж, эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоо нь гагцхүү эрүүгийн хуулиас тогтох Эх газрын эрх зүйн бүлгийн жишигт бүрэн нийцэх болсон билээ.

Эцэст нь тэмдэглэхэд эрүүгийн эрх зүйд харьцангуй бага судлагдсан 1926 оноос хойшхи Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж, түүний дотор эрүүгийн эрх зүйн эх сурвалж болох дээр дурьдагдсан хуульчилсан актууд, тэдгээрийг хэрэглэж байсан шүүхийн практикыг ул суурьтай нарийвчилан судлах, судалгаа шинжилгээний чиглэл болгох шаардлагатай байна.



²⁰ Мөн тэнд, 49 дэх тал

²¹ Гүнсэн Р., Дашков Г. Борьба с преступлениями противосоциалистической собственности (из опыта МНР). М.изд. Юрид-лит. 1979, С. 16-17

ЭРХ ЗҮЙЧ МЭРГЭЖИЛТНИЙГ БЭЛТГЭХ СТАНДАРТ БА “КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛ”

Монгол Улсад эрх зүйч мэргэжилтнийг бэлтгэх эрх зүйн үндэс болох “Эрх зүйч мэргэжлийн стандарт”-ыг Стандарчилал, хэмжил зүйн үндэсийн төвөөс өнгөрсөн онд батлан гаргажээ.

Гэмт хэрэгт Хэрэг бүртгэлт, Мөрдөн байцаалт явуулж буй практикаас харахад хэргийн бодит үнэнийг тогтоохдоо криминалистикийн ухааны мэдлэгийг дулимаг ашиглаж буй нь анзаарагддаг. Хэргийн бодит үнэнийг (хууль зүйн фактыг) шинжлэх ухааны нарийн мэдлэгт үндэслэсэн дүгнэлтээр биш, гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч зэрэг хүмүүсийн мэдүүлгээр голчлон тогтоож, мөрдөн байцаалтын төрөл бүрийн ажиллагааг криминалистикийн аргаар боловсруулсан аргачлал, зөвлөмжөөр биш, хар практикаар ихэвчлэн зүтгүүлдэг явдал нэлээд бий. Энэ нь чухам юунд байгааг хөөн судалбал хуульчдын сургалт, мэргэжлээ эзэмшсэн түвшин, багшийн заах арга зүй яригддаг байлаа.

Гэтэл ирэх хичээлийн жилээс мөрдөгдөх, дээр дурдсан стандартад Криминалистикийн хичээлийг огт оруулаагүй нь одоо эдгээр асуудал дээр “Хуульчдад криминалистикийн талаар ойлголт өгөх” гэсэн зүйлийг нэмэхэд хүрэх нь.

2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан эрх зүйч мэргэжилтнийг бэлтгэх “MNS 5323-39: 2007” стандартад эрх зүйчид тавих нийтлэг шаардлагыг:

▲ “Нийгмийн үзэгдэл, харилцаа, үйл явцыг нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь онол, арга зүйгээр задлан шинжилж, тайлбарлах чадвартай байх



НЦГ-ын Эрэлч нохойн алба,
үнийн лабораторийн эрхлэгч

Б.ЖАРГАЛСАЙХАН

(5.2.1.1.),

▲ эрх зүйн бакалаврын боловсролтой төгсөгчид тавих шаардлагыг: “Эрх зүйн үзэгдэл, харилцааг задлан шинжлэх, дүгнэлт хийх арга зүйг эзэмшсэн байх (5.3.1.4.),

▲ эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх арга ажиллагаанд суралцсан байх (5.3.1.5.) гэж тус тус тодорхойлоод,

Эзэмшсэн байвал зохих чадварт:

▲ “Хэрэг маргаанд эрх зүйн дүн шинжилгээ хийх, хууль зүйн санал дүгнэлт боловсруулах, шийдвэр гаргах” (5.3.2.1.),

▲ Хууль тайлбарлах, сонгох, хэрэглэх арга зүйг эзэмшсэн байх (5.3.2.2.) гэж оруулж өгчээ.

▲ Харин эрх зүйн үзэгдэл, харилцааг задлан шинжилж, тайлбарлахад орчин үеийн шинжлэх ухааны техник-технологийг

эзэмшсэн байвал зохих ёстойг энэ стандартад тусгасангүй. Болж өнгөрсөн үйл явцыг бодитоор тогтоож чадаагүй байж, өөрөөр хэлбэл, гэмт хэрэг мөн эсэхийг нотлоход суралцаагүй эрх зүйч мэргэжилтэн “тайлбарлах”, “дүн шинжилгээ хийх”, “санал гаргах” боломжгүй нь ойлгомжтой. Хэргийн бодит үнэнийг тогтоох арга, хэрэгсэл, аргачлалыг гаргаж боловсруулдаг цорын ганц шинжлэх ухаан – криминалистикийн тухай ойлголтгүй эрх зүйчээс юу шаардаж болох билээ дээ.

Манай хөрш ОХУ-ын дээд боловсролын стандартад “Криминалистик”, “Криминалистикийн экспертиз” хичээлийг сэдэвчлэн, сэдэв тус бүрийн агуулгыг тодорхойлж өгсөн байдаг¹ нь маш авууштай зүйл.

Хэргийн бодит үнэнийг шинжлэх ухаанлаг экспертиз хийсний үндсэн дээр тогтоохыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль шаарддаг. Гэмт хэргийн механизм, мөр үсэх явц зүй, нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, ашиглах технологит суралцаагүй эрх зүйч хүн хууль зүйн фактыг тогтооход зайлшгүй шаардлагатай мөр судлалын, галт зэвсгийн, бичиг баримтын, санхүүгийн, сэтгэл судлалын, сэтгэц-гэм судлалын экспертизийг ч зөв сонгож, тухайн шинжлэх ухааны тусгай мэдлэгийн хүрээнд асуулт тавин нотлох ач холбогдол бүхий асуудлыг тогтоолож чадахгүй.

Орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийн түвшин, экспертизээр шийдвэрлүүлж болох асуултын хүрээг тодорхойлж мэдээгүй эрх зүйчид нөгөө л үгжирсэн хуучин арга – мэдүүлэгт үндэслэхээс өөр сонголтгүй. Мэдүүлгээс хүн хэдийд ч буцаж болно, харин шинжлэх ухааны мэдлэгээр тогтоогдсон бодит баримтаас бол огт өөр

¹ Государственный образовательный стандарт высшего профессионального образования. М. 2000.

хэрэг.

Э Б Ш ажиллагаанд оролцогсодтой сэтгэл зүйн холбоо тогтоох, мөрдөн байцаалтын ажиллагааг үр өгөөжтэй, зөв явуулах тактик, нотлох ач холбогдол бүхий асуултыг шийдвэрлэх экспертизийн төрлийг зөв тодорхойлон хийлгэх, хэрэгт мөрдөн байцаалт явуулах аргачлал зэрэг хамаг нарийн ширийн зүйлийг агуулсан энэ хичээлийг орхигдуулсан нь хууль хяналтын байгууллагын ажиллагааг саармагжуулах үндэс болж мэдэхээр байна.

Иймээс криминалистик, криминалистикийн экспертиз гэсэн хоёр хичээлийг эрх зүйч мэргэжлийг эзэмшүүлж буй бүх сургуульд, мэргэжлийн суурь хичээлээр, дараах агуулгатайгаар зааж судлуулах зайлшгүй шаардлагай. Үүнд:

1. Криминалистикийн болон криминалистикийн экспертизийн өрөнхий онол

-Түүх, шинжлэх ухааны мэдлэгийг тогтолцоонд эзлэх байр, үүрэг, зорилт, тулгамдаж буй асуудал, чиг хандлага;

-Криминалистикийн болон криминалистикийн экспертизийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндэс;

-Криминалистикийн болон криминалистикийн экспертизийн арга зүй бүрэлдэн тогтох зарчим, явц, арга зүйн ангилал;

-Криминалистикийн болон криминалистикийн экспертизийн технологи.

2. Криминалистикийн болон криминалистикийн экспертизийн техник зүй

-Мөрдөн байцаалтын болон экспертизийн тохироо, үе шат, тэдгээрт бүрдэх экспертизийн зорилго;

-Криминалистикийн техник зүйн болон экспертизийн технологи, нотлох баримттай ажиллах ажиллагааны зүй тогтол, үе шат, шалтгаант холбоо, орон зай – хугацаа – үйлдлийн арга судлал, үйл явцын механизм судлал, адилтгал ба оношлол.

3. Криминалистикийн болон криминалистикийн экспертизийн үйл ажиллагааны тактик

-Үйл ажиллагааны субъект ба оролцогчид, зохион байгуулалтын зарчим, тулгамдаж буй асуудал;

-Криминалистикийн болон криминалистикийн экспертизийн үйл ажиллагааг явуулах зарчим, задгай газар, хашаа сэрвэч, орон байр, монгол гэр, гараж, автомашин, эд зүйл, хүний бие, цогцос, мал-амьтан, материал-хийц-бодисын зүйл, объект, бичил ба үнэрийн мөр зэрэгт үзлэг, экспертиз хийх ажиллагааны тактик;

-Мэдүүлгийг шалгах, зөрөөг тогтоох тактик;

-Мөрдөн байцаалтын ажиллагааг явуулах, явц, үр дүнг бэхжүүлэх тактик, технологи.

4. Криминалистикийн экспертиз

- Ойлголт, ангилал, зорилт;

- Экспертизад бэлтгэх, экспертиз явуулахыг даалгах, явуулах тактик;

- Дүгнэлтэд хүрэх үндэс, дүгнэлт

бүрэлдэх, түүнийг үнэлэх;

- Криминалистикийн экспертизийн стандарт, аргачлал, технологи

-криминалистикийн уламжлалт экспертиз

-материал-хийц-бодисын зүйлд хийх криминалистикийн экспертиз;

-наркотик бодисын болон сэтгэхүүд хүчтэй нөлөөлөх бодисын;

-угтаслаг-ширхэглэг материалын -биологийн, түүний дотор үнэр судлалын болон ДНХ-ийн;

-хөрс-ургамал судлалын;

-тэслэгээ судлал, тэсэлгээний; техник-технологийн;

-галын инженер-техникийн;

-автын инженер-техникийн;

-барилгын инженер-техникийн;

-нягтлан бодох бүртгэл-эдийн засаг-санхүү-аудитын;

- а н а г а х у х а а н ы криминалистикийн

-криминалистикийн сэтгэгч-гэм судлалын;

-криминалистикийн сэтгэл судлалын;

-байгаль, хүрээлэн буй орчны;

-бариа судлалын.

Иймэрхүү агуулгатай хөтөлбөрөөр хууль зүйн бүх их, дээд сургуульд бэлтгэж буй эрх зүйчдэд криминалистикийн болон криминалистикийн экспертизийн мэдлэг эзэмшүүлж, барууны орнуудын "forensic science" хэмээн нэрлэдэг шинжлэх ухааныг таниулан, хууль зүйн фактыг тогтооход шинжлэх ухааны мэдлэгийг түлхүү ашиглах цаг нэгэнт иржээ. Алийн бүр бид цусны бүлгээр хүнийг адилтгаж, гэрчийн мэдүүлгийг үндэслэн хэргийг шийдэж явах вэ?



"Хөгжил ба эрх зүй" эрдэм шинжилгээний бага хуралд шалварсан илтгэл

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ДАВТАН ГЭМТ ХЭРГИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ

1. СУДАЛГААГ ХИЙХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ

"2003 оны 3 дугаар сарын 10-ны өдөр иргэн Т нь иргэн А-гийн хүрэн алаг зүсмийн, ланзан тамгатай морийг, эмээл хазваарын хамт хулгайлан 150 мянган төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдон Чингэлтэй дүүргийн 2001 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 295 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 138 дугаар зүйлд зааснаар 50000 төгрөгөөр торгох ялаар, Сүхбаатар дүүргийн шүүхийн 2002 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 451 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2-т зааснаар 6 сар баривчлах ялаар, Баянзүрх дүүргийн шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 209 дүгээр шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт зааснаар 2 жилийн хорих ялаар шийтгүүлж, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн 2004 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 112 дугаар захирамжаар 11 сар, 4 хоногийн хорих ялыг тэнсэж, хянан харгалзсан байжээ.

Т нь Сэлэнгэ аймгийн шүүхэд давж заалдсан бөгөөд Сэлэнгэ аймгийн шүүх гомдлыг хянан үзээд хэргийн зүйлчлэл зөв, ногдуулсан ял тохирсон, анхан шатны шүүх эрүүгийн хуулийн 145

дугаар зүйлийн 145.4-т заасан "энэ хэрэгт хоёр буюу түүнээс дээш удаа шийтүүлсэн этгээд" үйлдсэн гэдэгт хамааруулан ял шийтгэл ногдуулсан нь үндэслэлтэй гэж үзэн сум дундын шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Т-гийн давж заалдсан гомдлыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Сэлэнгэ аймгийн сум дундын шүүхийн шийтгэх тогтоолоор



МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн оюутан
С.ЭНХЦЭЦГ

Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-т зааснаар Т-д 10 жил 10 хоног хорих ял ногдуулж, эдлэх ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэх, цагдан хоригдсон 102 хоногийг эдлэх ялд нь оруулан тооцохоор шийдвэрлэжээ.¹

Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу 150 мянган төгрөг нь 2003 оны байдлаар бага бус хэмжээний хохиролд тооцогдох бөгөөд энэ үндэслэлээр хэргийг зүйлчилбэл Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1 дүгээр зүйл буюу Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэх ёстой байсан боловч Т-д урьд өмнө "хулгайн гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлж байсан" гэсэн үндэслэлээр Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн

145.4-т зааснаар зүйлчилж 10 жил 10 хоногийн хорих ял ногдуулсан байна.

Урьд өмнө гэмт хэрэг үйлдэж түүндээ эрүүгийн хариуцлага хүлээж байсан этгээдэд гэмт хэрэг давтан үйлдсэн гэсэн үндэслэлээр дахин ял ногдуулж байгаа явдал нь Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимтай зөрчилдөж байгаа бөгөөд аливаа хууль нь зарчимдаа нийцэж байх ёстой учраас энэхүү судалгааг хийж байгаа юм.

2. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ШУДАРГА ЕСНЫ ЗАРЧИМ БОЛОН ДАВТАН ГЭМТ ХЭРГИЙН ЗОХИЦОЛ

Эрүүгийн эрх зүй дэх шударга ёсны зарчим нь "NE BIS IN IDEM" буюу монголчилбол үйлдсэн гэмт хэрэг болон ял нь хоорондоо тохирсон байна. Нэг гэмт хэрэгт давхар шийтгэл ногдуулж болохгүй буюу нэг гэмт хэрэгт нэг л удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн үзэл баримтлалыг илэрхийлдэг.

Нэг гэмт хэрэгт хоёр удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглох буюу нэг гэмт хэрэгт зөвхөн нэг л удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн энэхүү зарчмыг Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад DOUBLE JEOPARDY CLAUSE гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг. Энэхүү зарчим нь Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн 5 дугаар нэмэлтэд тусгагдсан бөгөөд тэнд "... Үйлдсэн эрх зүйн нэг зөрчлийн төлөө хэний ч амь насыг хохироох, бие махбодийг зовоох ял ногдуулахаар заналхийлж, хоёр удаа шийтгэх болохгүй"² хэмээн заасан байна.

"Нэгдсэн Улсын Үндсэн хуульд заасан Double jeopardy clause буюу нэг гэмт хэрэгт хоёр удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглох

¹ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл. Эрүүгийн хэрэг. Цуврал 2, 75-77 дахь тал.

² АНУ-ын Үндсэн хууль, V нэмэлт.

энэ заалт нь:

1. цагаатгагдсаны дараа тухайн гэмт хэрэгт нь дахин ял шийтгэх;
2. ял шийтгэгдсэний дараа тухайн гэмт хэрэгт нь дахин ял ногдуулах;
3. тухайн гэмт хэрэгт нь олон ял ногдуулах гэсэн гурван ялгаатай ойлголтоос хамгаалдаг.

Хэрэв ял шийтгэлүүд нь тухайн гэмт хэрэг дээр үндэслэгдээгүй бол олонлог гэмт хэрэг дэх бие даасан ялуудыг Үндсэн хуулийн үүднээс хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл, нэг удаагийн үйлдлээр тус тусдаа бүрдэл төгссөн хэд хэдэн гэмт хэргийг зэрэг үйлдсэн бол үүнийг олонлог гэмт хэрэг гэж үзэн үйлдэл тус бүрд нь ял ногдуулахыг үндсэн хуулиар хориглоогүй байна.³

Харин ОХУ болон манай улсын хувьд энэхүү шударга ёсны зарчим нь тус улсуудын Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлд тусгалаар олсон байна. Монгол улсын эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна.

6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж заасан байна.

Эрүүгийн хуульд заасан энэхүү шударга ёсны зарчмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээх гэмт хэрэг хоёр нь хоорондоо шууд хамааралтай байх ёстой. Өөрөөр хэлбэл хөнгөн гэмт хэрэг үйлдсэн бол хөнгөн гэмт хэрэгт нь тохирсон ялыг, хүнд гэмт хэрэг үйлдсэн бол хүнд гэмт хэрэгт нь тохирсон ялыг ногдуулах буюу ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг гэмт этгээдийн тухайн гэмт үйлдлийнх нь төлөө ногдуулах ёстой гэсэн үг юм.

Гэтэл эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д давтан гэмт хэрэг гэсэн ойлголтыг хуульчилж, гэмт хэрэг үйлдсэн этгээд өмнө үйлдсэн гэмт хэрэгтэйгээ ижил

буюу ойролцоо төрлийн гэмт хэрэг үйлдвэл ийнхүү гэмт хэрэг давтан үйлдсэнийх нь төлөө хүндрүүлсэн бүрэлдэхүүнтэй ялын хэмжээгээр өмнө үйлдсэн гэмт хэрэгт нь дахин шийтгэл ногдуулахаар заасан байна. Эрүүгийн хуулийн Тусгай ангид нийтдээ 49 гэмт хэрэгт уг гэмт хэргийг давтан үйлдвэл хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хэмээн зүйлчлэн нэмж ял ногдуулахаар заасан байна.

Энэхүү тусгай ангид заагдсан давтан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шинжилж үзвэл гэмт хэрэг давтан үйлдсэн тохиолдолд хүндрүүлж байгаа ялын хэмжээ нь уг гэмт хэргүүдийн хүндрүүлэх бүрэлдэхүүнгүй санкцаас 2-10 түүнээс дээш 20 жил хүртэл хугацаагаар илүү хорих ялтай байгаа бөгөөд, мөн түүнчлэн (Эрүүгийн хуулийн 99.2, 103.3, 115.3, 144.2, 145.2, 146.2, 148.2, 150.2, 163.2, 185.2, 223.2, 263.2, 264.2, 265.2, 266.2, 270.2 дахь хэсэгт заасан хөнгөн гэмт хэргүүд нь давтан үйлдсэнээр хүндэвтэр, 108.2.3, 112.2.3, 113.2.3, 126.2.3, 128.2, 149.3, 157.2, 162.2, 166.2, 176.2, 186.2, 194.2.4, 211.2, 261.2, 268.2, 269.2 дахь хэсэгт заасан хүндэвтэр гэмт хэргүүд нь давтан үйлдсэнээр хүнд, 148 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хөнгөнөөс хүнд, 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 188 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хөнгөн гэмт хэргүүд нь давтан үйлдсэнээр онц хүнд, 192 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт, 225 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүндэвтэр гэмт хэргүүд нь давтан үйлдсэнээр онц хүнд) гэмт хэрэг давтан үйлдсэн тохиолдолд гэмт хэргийн ангилал нь хөнгөнөөс хүндэвтэр, хүндэвтэрээс хүнд, хөнгөнөөс онц хүнд, хүндэвтэрээс онц хүнд гэмт хэрэг болж гэмт хэргийн шинж чанар нь өөрчлөгдөж байгаа юм. Өөрөөр хэлбэл 2 удаа хөнгөн гэмт хэрэг үйлдэхэд удаах гэмт хэрэг нь хүндэвтэр, зарим тохиолдолд онц хүнд (145 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 188 дугаар зүйлийн 3 дахь хэсэг), хоёр удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдэхэд удаах

үйлдэл нь хүнд, зарим тохиолдолд онц хүнд (192 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дүгээр заалт, 225 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) гэмт хэрэг болж ижилхэн гэмт хэрэг давтан үйлдсэнээр гэмт хэргийн ангилал өөрчлөгдөж байгаа нь логикийн хувьд алдаатай зохицуулалт болсон гэж үздэх хүргэж байгаа юм. Эндээс үзвэл,

1. Гэмт хэрэг давтан үйлдэж буй явдал нь гэмт хэрэг мөн бөгөөд түүнд нь ял ногдуулж байгаа мэт,
2. Эрүүгийн хариуцлагыг үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө бус харин субъектэд нь буюу гэмт этгээдэд нь ногдуулж байгаа мэтээр ойлгогдохоор байгаа юм.

Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлд гэмт хэрэг давтан үйлдэх гэдгийг "Энэ хуулийн нэг зүйл, түүний нэг хэсэгт заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн байхыг давтан гэмт хэрэг гэнэ." хэмээн тодорхойлжээ. "Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ"⁴ гэсэн зарчмын дагуу урьд нь гэмт хэрэг үйлдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь тус тусдаа бүрэлдэхүүнтэй хоёр гэмт хэрэгт тооцогдох бөгөөд үүний дагуу Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "давтан гэмт хэрэг" гэх бус харин "гэмт хэрэг давтан үйлдэх" гэж нэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Дээр дурьдсан иргэн Т-гийн хувьд урьд өмнө хулгайн гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлж байсан учраас хэдийгээр бусдад 150000 төгрөгийн буюу бага бус хэмжээний хохирол учруулж хөнгөн гэмт хэрэг үйлдсэн ч гэсэн Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-т зааснаар зүйлчлэгдэн гэмт хэрэг давтан үйлдсэнийхээ төлөө 9 жил 9 сар 10 хоноггоор илүү ял шийтгэгдсэн байна. Энэхүү 9 жил 9 сар 10 хоног нь түүний үйлдсэн тус тусдаа бүрдэл төгссөн хөнгөн гэмт хэргийн төлөө бус харин гэмт хэрэг давтан үйлдсэнийх нь төлөө түүнийг цэрэрүүлж буй хэрэг юм. Зарчмын дагуу Т нь өмнө үйлдсэн

³ www.Dealtime.com

⁴ МУ-ын Эрүүгийн хууль, 2002 он.

⁵ МУ-ын Эрүүгийн хууль, 2002 он. 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг

гэмт хэрэгтээ нэгэнт ял шийтгүүлсэн тул дахин үйлдсэн гэмт хэрэгт ял ногдуулахдаа түүний өмнө үйлдсэн гэмт хэрэгт нь дахин ял ногдуулах бус харин ял ногдуулахдаа энэ байдлыг харгалзан үзэх нь зүйтэй юм.

ХБНГУ, ОХУ-ын Эрүүгийн хуулинд давтан гэмт хэрэг гэсэн гэмт хэргийн төрөл байдаггүй бөгөөд харин гэмт хэрэгтэнд ял ногдуулахдаа хэрэв рецидив гэмт хэрэгтэн гэж үзэж байгаа тохиолдолд энэ байдлыг харгалзан үзэхээр хуульчилсан байна.⁶

Хэдийгээр эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д, "Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино" гэж заасан боловч үйлдсэн гэмт хэргийн хүнд хөнгөнөөс ул хамааран 10 шахам жилээр илүү хорих ял ногдуулах байгаа нь "Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна"⁷ гэсэн зарчимтай зөрчилдөж, хэт их цээрлүүлэх хандлагатай байна гэж үзэж байна.

Жишээлбэл, Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлд заасан Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхит тэсээр дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг үйлдсэн этгээд анхны үйлдэлдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгүүлэх бөгөөд харин уг этгээд энэ гэмт хэргээ давтан үйлдвэл Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлийн 188.3-т заасны дагуу 10-20 жил хугацаагаар хорих ял шийтгүүлэхээр байгаа юм.

Гэмт хэрэг давтан үйлдсэнийг

хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт тооцож илүү хүнд ял ногдуулж байгааг буруутгах бас нэг үндэслэл бол зөвхөн нэг төрлийн гэмт хэргийг давтан үйлдсэн этгээдийг асаршгүй этгээд, рецидив гэмт хэрэгтэн гэж үзэж илүү хүнд ял шийтгэл ногдуулж байгаа хэрнээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн өөр өөр зүйлд заасан ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй буюу тусдаа гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхгүйгээр зөвхөн ногдуулж болох ялын төрөл, хэмжээний дотор хүндрүүлэн үзэхээр байгаа явдал юм. Энэ нь мөн л шударга ёсны зарчмыг үгүйсгэж байгаа хэрэг гэж үзэж байна.

Гурав. ИЛТГЭГЧИЙН САНАЛ

1. Эрүүгийн хуульд гэмт хэрэг давтан үйлдсэн тохиолдолд ял хүндрүүлэхээр заасан нийт 46 гэмт хэргийн 49 зүйл, заалтад энэ үндэслэлээр нэмж ял ногдуулахыг болиулж, Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлд заасан шударга ёсны зарчимд нийцүүлэх шаардлагатай байна.

2. Хэрвээ гэмт хэргийг давтан үйлдсэн этгээдийг нийгэмд аюултай, рецидив гэмт хэрэгтэн гэж үзэж байгаа юм бол эрүүгийн хуулийн өөр өөр зүйл ангид заасан хэд хэдэн гэмт хэргийг нэг нэг удаа үйлдсэн этгээдийг ч бас давтан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нь зүйтэй.

3. Ингэхдээ гэмт хэрэг давтан үйлдсэн этгээдэд хүндрүүлэх бүрэлдэхүүнээр нэмэгдэл ял ногдуулах бус, харин зарчимдаа нийцүүлэн ял ногдуулахдаа энэхүү байдлыг нь харгалзан үзэх нь зүйтэй юм. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлд рецидив гэмт хэрэгт тооцох үндэслэлүүдийг заасан бөгөөд мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт "Аливаа гэмт хэрэгт ял ногдуулахдаа рецидив гэмт хэрэг мөн эсэхийг харгалзан үзнэ, ингэхдээ энэ хуульд заасан /тухайн гэмт хэргийн санхсаа/ ял шийтгэлээс аль хүндийг нь сонгож хэрэглэнэ" гэж заасан байна.

4. Шүүгчид хуулийн хүрээнд эрх мэдэл олгох замаар аливаа хэргийг

шударга, үнэн зөв шүүх боловчтой юм. Тухайлбал, тодорхой гэмт хэргийн санхсийн дээд, доод хязгаарыг хол болгож шүүгчид нөхцөл байдлад тохируулан ялыг онцгой сонгох эрх мэдлийг олгох нь зүйтэй гэж үзэж байна.

Дөрөв. ДҮГНЭЛТ

Илтгэгч нь:

1. Яг ижилхэн /хөнгөн эсхүл хүндэвтэр/ гэмт хэргийг давтан үйлдэхэд удаах гэмт хэрэг нь хүнд эсхүл онц хүнд болж гэмт хэргийн ангилал өөрчлөгдөн илүү хүнд ял шийтгэл ногдуулж байгаа нь Эрүүгийн хуулийн 6.1-д заасан "Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна" гэсэн шударга ёсны зарчимтай зөрчилдөж байна гэж үзэж байна.

2. Гэмт хэрэг үйлдсэн этгээд урьд нь үйлдсэн гэмт хэрэгтээ нэгэнт ял шийтгүүлсэн байтал давтан үйлдсэн гэсэн үндэслэлээр түүнд илүү хүнд ял ногдуулж байгаа нь түүний өмнө үйлдсэн гэмт хэрэгт дахин ял шийтгэж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн шударга ёсны зарчимтай зөрчилдөж байна" гэж үзэж байна.

3. Аливаа хууль нь зарчимдаа нийцэж байх ёстой учраас Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр гэмт хэрэг давтан үйлдсэн тохиолдолд ял хүндрүүлэхээр заасан нийт 49 зүйл заалтаас 48 нь 2-20 жил хүртэл хугацаагаар илүү хорих байгаа бөгөөд дээрх зүйл заалтад өөрчлөлт оруулснаар хорих ял эдгэж байгаа хүмүүсийн тоо багагүй буурх болно гэж үзэж байна.

⁶ ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн нэг дэх хэсэг; ОХУ-ын Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

⁷ МУ-ын Эрүүгийн хууль 2002 он. 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг.

ПРОКУРОРЫН БАЙР СУУРИАС КРИМИНОЛОГИЙН АСУУДАЛД ХАНДАХ НЬ

Статистик тоо баримтаас үзэхэд гэмт хэргийн тоо 2007 онд өмнөх оныхоос 16.5 хувиар өссөн байна. Энэ нь гэмт хэргийн гаралт буурахгүй, харин жил бүр өсч байгаа шалтгаан нөхцөлийг нарийвчлан судлан дүгнэлт хийж, гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам, баримталж буй бодлого нь өнөөгийн шаардлагад нийцэж буй эсэхийг зөв тодорхойлох нь шийдвэрлэвэл зохих чухал асуудлын нэг болсныг харуулж байна.

Нийт гарч буй гэмт хэргийн тал хувь нь Нийслэл болон аймгийн төв, суурин газарт үйлдэгдэж байгаа нь анхаарал татаж байна.

Гэмт хэрэг эрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомж, дүрэм заавар батлагдаж, өөрөөр хэлбэл эрх зүйн орчин хангалттай бүрдэж, нөгөө талаас төрөөс багагүй хөрөнгө мөнгө зарж зохион байгуулалтын шат дараалсан арга хэмжээ авсаар байхад яагаад дорвитой өөрчлөлт гарахгүй байгаагийн учир юунд вэ?

Криминологийн чиглэлээр зарим шинжилгээ, судалгааны ажил хийгдэж байгаа боловч тэдгээрийн үр дүн, өгөөжийг төрийн бодлого, шийдвэрт бүрэн дүүрэн оновчтой тусгаж чаддаггүй, зөвхөн гэмт хэрэг зөрчлийн тоо мэдээг ёс төдий дурдаж мэдээлэхээс хэтрэхгүй байгааг хэлэх хэрэгтэй.

Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тоон талаас нь биш эцсийн үр дүн буюу чанар талаас харвал арай өөр дүр зураг гарах ёстой. Улсын хэмжээнд гэмт хэрэг зөрчил, түүнийг шийдвэрлэж байгаа болон урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажлын тухай дэлгэрэнгүй нэгдсэн мэдээллийн сангуй байна. Төрийн захиргааны болон хуулийн байгууллагуудын (шүүх, прокурор, цагдаа гэх мэт) хоорондын уялдаа холбоо сул, хэрэг зөрчлийн талаар гаргасан зөрийн тоо баримтууд нь хоорондоо зөрүүтэй, ойлгомжгүй байгааг нэг мөр журамлах цаг



Сүхбаатар аймгийн прокурор,
Хууль цаазын итгэмжит зөвлөх,
МУИС-ийн докторант
Ц.МӨНХБАТ

болсон байна.

Бодлого, зорилтыг зөв тодорхойлоход холбогдох шинжилгээ, судалгааны ажлыг тууштай хийж, үр дүнг харгалзан үзэх нь чухал.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (1997 он) болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002 он)-д прокурорын байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхой зааж өгсөн байна. Гэхдээ прокурорын хяналтын чиг үүргээр биш бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил оролцох "Оролцоо"-ны тухай юм.

Энэ ажлын хүрээнд прокурор нь тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийх ёстой юм. Орон нутагт гарч буй гэмт хэрэг зөрчил ямар байгааг Сүхбаатар аймгийн жишээн дээр авч үзье.

Тус аймгийн хэмжээнд 2007 онд 223 хэрэгт прокурор эрүүгийн хэргийн дугаар олгосон ба үүнээс 67 буюу 30 хувь нь хөнгөн, 119 буюу 54 хувь нь хүндэвтэр, 37 буюу 16 хувь нь хүнд онц хүнд гэмт хэргүүд эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг-23.7

хувиар өссөн байна.

Гэмт хэргийн гаралтыг нутаг дэвсгэрийн байдлаар хувааж үзэхэд аймгийн төв буюу Баруун-Урт суманд 65 буюу 29 хувь нь, хөдөө сумд 158 буюу 71 хувь нь үйлдэгдэжээ.

Гэмт хэргийн бүтцийн хувьд авч үзэхэд өмчийн эсрэг гэмт хэрэг 127 буюу 57 хувийг, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 66 буюу 28 хувь, Тэвэрийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын эсрэг гэмт хэрэг 17 буюу 8 хувийг тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас нийт 40 хүн нас барснаас 27 буюу 67 хувь нь золгүй учрааар, 9 буюу 23 хувь нь зам тээврийн ослоор, 4 буюу 10 хувь нь бусдын санаатай үйлдэлд амь нас нь хохирсон байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 15.6 хувь нь гудамж, талбайд, 21.1 хувь нь гэр, орон сууцанд, 39.9 хувь нь бэлчээрт, 12.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Тодорхой зарим төрлийн хэргийн хувьд өмнөх онтой харьцуулахад танхайн хэрэг 3 дахин, тэвэрийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг хэрэг 13.3 хувь, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 74.1 хувь тус тус өссөн байна.


Гэмт хэрэгт холбогдогсдын 18.8 хувь нь согтуугаар, 35.7 хувь нь бүлээлсэн, 10.7 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс үйлдэжээ. Мөн зөрчил гаргасан 5874 хүнийг захиргааны журмаар 26.2 сая төгрөгөөр торгож, согтуугаар тэвэрийн хэрэгсэл жолоодсон 72 хэрэг зөрчил илрүүлж, 62 хүний тэвэрийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 2730 хүн эрүүлжүүлэгдэж, 204 хүн баривчлагдсан байна.

Сум дундын шүүх 139 хүнд хобогдох 112 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 15.1 хувиар өссөн байна.

Ял шийтгүүлсэн 139 хүний 49.6 хувьд хорих, 25.1 хувьд баривчлах, 13.6 хувьд албадан ажил хийлгэх, 11.5 хувьд торгох ял


тус тус ногдуулсан бөгөөд хорих ялаар шийтгүүлэгсдийн 40 буюу 58 хувьд (улсын дундаж 48.5 хувь) ялыг биөчлэн элдүүлсэн нь улсын дундажас 9.4 хувь дээгүүр байна.

Сүүлийн 3 жилд гарсан гэмт хэргийн тоо




Гарсан гэмт хэргийг графикаар үзүүлбэл:


Сүхбаатар аймаг 2007 онд гарсан гэмт хэргийг мөрдөхөөс судалгаа



Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт 2007 онд нийт 223 гэмт хэрэг гарсны



Сүхбаатар аймагт 2007 онд гарсан гэмт хэргийн улмаас бусдын биед учирсан гэмтэл



Ийнхүү дээрх судалгаанаас дүгнэлт хийхэд юуны өмнө гарч буй гэмт хэрэг зөрчлийн тал хувь нь төв, суурин газарт үйлдэгдсэн, гэмт хэрэг зөрчил үйлдэгдсэд зохих хууль тогтоомжийн дагуу ял шийтгэл ногдуулж байгаа боловч хэрэг зөрчлийн тоо буураагүй, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журам, хүний амь бие, эрүүл мэндийн болон өмчийн эсрэг гэмт хэргүүдийг согтуугаар бүлэглэж үйлдэх явдал өссөн байна.

Иймд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг сайжруулах, шалтгаан нөхцлийг арилгуулах талаар төр захиргаа, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, явц байдалд нь хяналт тавих ажлыг зөв зохион байгуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.



ХУВЬ ХҮНИЙ НЭР ТӨР, АЛДАР ХҮНДИЙГ ХАМГААЛЖ ХҮНДЛЭХ АСУУДЛЫН МӨН ЧАНАР

Хүний эрхийн тухай ойлголт, онолын томъёоллыг бүр эртний Рим, Афин (МЭӨ V-IV зуун)-аас гаралтай гэж эрдэмтэд үздэг бөгөөд эдүгээ хүртэл олон зуун жилийн туршид янз бүрийн онол, концепци боловсрогдон, үеэс үед дамжиж иржээ. Эдгээр үзэл номлол, онол нь өөр өөрийн урсгал концепцийг үүсгэдэг төдийгүй төр-хуулийн харьцаа, төр-иргэн, иргэн-хуулийн харьцаанд янз бүрээр нөлөөлдөг.

Хүн төрөлхөөсөө эрх, эрх чөлөөтэй боловч хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт, хөдөлгөөн түүхэн үзэгдэл гэдгийг дэлхийн нийт нэгэнт хүлээн зөвшөөрчээ. Түүн дотроос хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд /материаллаг бус баялаг/ нь хүний нийгмийн хувируулсан үнэт зүйл болдгийн хувьд хүн төрөлхтний түүхийн турш нийгмийн үндсэн субъект болох хүнээс салшгүй хамааралтай явж иржээ.

"Хүний эрх" гэж юуны өмнө хүнд өөрт нь байдаг төрөлх шинж, мөн чанар гэсэн утгаар буюу субъектив /эзэнлэг/ эрхийг хэлдэг. Нэр төр, алдар хүндийг дээдлэхгүйгээр бие хүний хувь оршихуйг төсөөлөхөд угаас бэрх. "Нэр хугарахаар яс хугар" гэж товч хэрнээ гүн гүнзгий утга агуулгаар илэрхийлдэг ардын зүйр цэцэн үгийн үндсэн утга санаа нь нэр төрийн үнэ цэнийг Монголчууд эртнээс ихэд дээдэлж ирсний бэлээхэн нотолгоо юм.

Хувь хүний нэр төр, алдар хүндийг хамгаалж хүндлэх асуудал нь нийгмийн бүлэг, хувь хүн болон иргэн, төр хоорондын харилцан хүлээсэн үүрэг хармуцлага, эрх, эрх чөлөөний зарчим, ёс суртахууны болон эрх зүйн хэм хэмжээнд үндэслэсэн шинж чанартай байдаг. Энэ талаар ОХУ-ын судлаач эрдэмтэн С.В.Михайлович "Эрх



МУИС-ийн докторант
Ш.СУХБААТАР

зүйт нийгэмд хувь хүн, иргэн тэргүүн зэрэгт гарч ирдэг, хувь хүний хууль ёсны эрх ашиг, эрх, эрх чөлөө төрөөр хамгаалагддаг. Иргэний нэр төр, алдар хүнд бол ардчилал, эрх зүйт төрийн түшиг тулгуур, нийгмийн соёл, ёс зүйн суурь юм"¹ гэж тэмдэглэсэн нь эрх зүйн хувьд манай улсын хуулиудад ч биелэлээ олжээ.

Иргэний нийгэм нь энэхүү үнэт зүйлийн дамжуулагч юм. Төр нь өөрийн байгууллага ба албан тушаалтнаар дамжуулан иргэдийнхээ нэр төр, алдар хүндийг хамгаалж хангах, тэдгээрийг хэрэгжүүлэх тодорхой үүрэг хүлээдэг.

Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах асуудлыг онолын талаас дүн шинжилгээ хийхэд өнөө хэр бэрхшээлтэй байгаа бөгөөд түүний хамгаалалтын үр дүнгээс нийгмийн гишүүдийн нэр төр, алдар хүндийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалтын шинж чанар шалтгаална. Энэ бэрхшээл нь зүйн ухааны болон эрх зүйн шинж чанартай асуудлыг олон талаас нь онолын үндэслэлтэй хандаж судлан үзэхээс шалтгаална.

"Алдар хүнд, нэр төрийн эрх нь нэг талаас нийт хүн төрөлхтөний үнэт зүйл, нөгөө талаас хүний үндсэн эрхүүдийн нэг юм. Түүнийг хамгаалах нь хоёр талтай:

а.Төрийн зүгээс нэр төр, алдар хүндэд халдахаас хамгаалах буюу төр хувь хүний амьдралд хугалдан орохоос сэргийлэх;

б.Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах нь нийгмийн зүгээс бие хүний алдар хүндийг зөрчсөн тохиолдолд төр оролцох Үндсэн хуулийн шаардлага байх"² тухай М.Л.Гаскаровагийн бичсэнтэй санал нэг байна.

Сүүлийн үед иргэншлийн судалгаанд материаллаг бус үнэт зүйлс, тэдгээрийн дотор нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд ихээхэн анхаарал татах болсон. Үүний хамт тэдгээрийн эрх зүйн шинж чанар одоо хэр нэг мөр шийдвэрлэгдээгүй байна.

Судалгаанаас үзэхэд эд хөрөнгийн биш үнэт зүйлсийг тусад нь зохицуулах нь тэдгээрийг янз бүрийн халдлагаас эрхийн тодорхой салбаруудын арга хэрэгслээр хамгаална гэсэн үг юм. Хувийн энэ бүлэг эрхийн онцлог нь эдгээрт нийгмийн ба хувийн шинжүүд хоорондоо нягт сулжилдаг, үүний учир зохих үнэт зүйлсийн тухайлбал: нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт арай өөр аргуудаар хэрэгжиж байдаг оршдог.

Хууль ёсны ашиг сонирхол хэмээх ухагдахуун субъектив эрх зүйтэй хамгийн ойр байдаг. Амьдрал дээр хууль ёсны ашиг сонирхол тусгагдсан ямар ч норматив акт "хууль ёсны ашиг сонирхол" гэсэн нэр томъёоны өмнө "эрх" хэмээх үг үргэлж бичигддэг.

"Хууль ёсны ашиг сонирхол ба субъектив эрхүүдийг зааглах гол шалгуур нь хууль ёсны ашиг сонирхол, тэмүүллийн шинжтэй эрх зүйн энгийн зөвшөөрөл байдагараа субъектив эрхээс ялгагдтай бөгөөд

¹ Михайлович С.В. "Условия, способы гражданско-правовой защиты чести, достоинства и деловой репутации" Диссертация на соискание ученой степени и кандидата юридических наук. М. 2006. С.3

² Гаскарова М.Л. "Правовая защита чести и достоинства личности. Вопросы теории" М. 1999. С.10

түүнд хуульд хатуу завсны дагуу үйлдэх, бусад этгээдээс зохих зан үйлийг шаардах завлт байхгүй, мөн хууль зүйн тодорхой үүрэг хүлээгээгүй байдаг³ талаар А.Б.Малько бичжээ.

"Хууль ёсны ашиг сонирхол" хэмээх ухагдахууныг хууль тогтоомжид буруу ташаа хэрэглэх нь зохих эрх зүйн хамгаалалтгүй байдаг бие хүний зарим нийгмийн ашиг сонирхлыг хөндөхөд хүргэдэг. Хувь хүний салшгүй үнэт зүйлс болох нэр төр, алдар хүндийг жижээ болгон авч үзэж болно. Салбар хууль тогтоомжийн хэм хэмжээнүүд нэр төр, алдар хүндэд халдсан тодорхой нөхцөл байдалыг заасан байдаг. Үүний хамт хуульд шууд тусгагдаагүй тохиолдлууд ч байж болно. Жишээ нь, хэн нэгний гавьяа зүтгэлийг завших, хүнийг ёсгүй муухайгаар дүрслэх, өөр өөр хүмүүсийг буруу зөрүү адилтгах зэрэг нь хүний нэр төр, алдар хүндэд халдсан хэрэг юм.

"Нэр төр, алдар хүнд бүх тохиолдолд хамгаалагдах ёстой нь яриангүй. Хууль хувийн эрхийг /үнэт зүйлс/ төдийгүй хувийн ашиг сонирхлыг хамгаалдаг учраас энэ нь боломжтой юм"⁴ гэж Г.А.Свердлык, Э.Л.Страунинг нар "Защита и самозащита гражданских прав" номондоо бичсэн байна.

Эрх зүйн хамгаалалтын объект нь, тодруулбал, өөрт нь буй бүх бололцоог хэрэгжүүлэхэд тус дөхөм болдог хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол юм. Тэдгээрийн үндэс нь хүний алдар хүнд байдаг.

"Орчин үед хүний алдар хүндийг зөвхөн Үндсэн хуулийн субъектив эрхүүдийн нэг объект гэж үзэж болохгүй. Хүний алдар хүнд хэмээх үзэгдэл гүн ухаан, шашны сэтгэлгээгээр дамжиж дараа нь төр эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдөж хүмүүнлэгийн бүх ухаан, дийлэнхдээ эрх зүй судлалын тулгуур ойлголт болдог. Хүний алдар хүнд хүнийг хувь хүн болгож, түүнийг амьд байгалиас

ялгаруулж, амьдралын тодорхой жишгийг баримжаалахад түүнд тусалдаг биологийн, ёс суртахуун-шашны, үндэстэн-соёлын, нийгмийн шинж чанаруудын нийлбэр цогц юм"⁵ хэмээн М.П.Анисимова "Достоинство и ничтожество: различие статусы человека в обществе и характеристика личности" бүтээлдээ тодорхойлжээ.

"Алдар хүндийг хамгаалах зарчмыг хууль боловсруулах болон хууль хэрэглэх үйл ажиллагаанд Үндсэн хууль-эрх зүйн шалгуур болгон ашигладаг. Энэ нь норматив актуудыг төдийгүй хууль хэрэглэх байгууллагуудын актуудыг гаргахад хүний алдар хүндийн халдашгүй байдлыг хангах тухай ярьж байгаа хэрэг"⁶ гэж В.В.Невинский "Немецкие граждане в свете основополагающих принципов Конституции" номондоо цохон дурьджээ.

Түүнчлэн хүний алдар хүндийн халдашгүй байх зарчмыг зөрсөн жишээ олныг дэлгэрүүлэн хэлж болох юм. Тухайлбал: хүний нэр алдраар дамжиж тухайн хүний бие махбодь, оюун санаанд учирч буй хохирлууд, хуулийн өмнө тэгш байх хүмүүсийн эрхийн асуудал ч энд хөндөгдөх нь зайлшгүй.

"Нэр төр"-ийн тухай ойлголт нь нэг талаас гадаад буюу объектив /бодит/, нөгөө талаас дотоод буюу субъектив талтай байдаг.

Нэр төрийн ойлголтын гадаад тал нь тодорхой хүний үнэлгээгээс үл шалтгаалах тул агуулгын хувьд объектив бөгөөд тодорхой нийгэм, нийгмийн бүлгийн үнэлгээ, үнэт зүйлийн нэгдсэн ойлголтыг тусгадаг. Түүнчлэн энэ нь бусад хүн, нийгэмээс хувь хүний зан үйл, үйл ажиллагаанд өгсөн улс төр, ёс суртахууны үнэлгээ бөгөөд тэр нь тогтвортой шинж чанартай ба тухайн хувь хүний бүх талыг эсхүл түүний зарим хэсгийг хамаарсан байдаг. Нэр төрийн гадаад үнэлгээ нь "нэр алдар", "нэр хүнд", "сайн нэр" гэсэн ойлголттой салшгүй холбоотой юм. Хэрэв нэр алдар

нь тодорхой хүмүүсийн нэгдэл дунд зонхилж буй хувь хүн болон түүний үйл ажиллагааны үнэлгээний тухай өрөнхий тогтсон үзэл санаа бол, нэр төр нь илүү бага хурз бүхий хүмүүсийн тоогоор хязгаарлагдсан үнэлгээ юм.

Иймээс нэр төрийн объектив тал нь өөрийн агуулгын хувьд тодорхой түүхэн шинж чанартай бөгөөд нийгмийн харилцаан дахь хүний чиг үүрэг, байр суурь, нийгмийн зүгээс хүнд тавих шаардлага, түүний үйл ажиллагааны хувийн болон нийгмийн үнэлгээ илэрхийлж тодорхой нийгмийн өрөнхий ёс суртахууны үзэл бодлыг тусгаж харуулдаг онцлогтой.

Нэр төрийн гадаад буюу объектив тал нь хувь хүний гавьяа зүтгэлийн нийгмийн хэрэгсэл зүгээс зөвшөөрч хүндэтгэх, орчин тойрны үзэл санаагаар илэрхийлэгдсэн түүний нэр алдар, сайн нэр, ёс суртахууны ач холбогдолд оршино. Үүнээс гадна нэр хүнд нь нийгмийн зүгээс эерэг үнэлгээ олж авахад хувь хүний үйл ажиллагааг чиглүүлд түүнд ёс суртахууны ханамж олгодог ёс зүйн баялаг юм.

Нэр төрийн дотоод тал нь хэлбэрийн хувьд субъектив бөгөөд өөрийн нэр төр, алдар хүндийг ухаарч, тодорхой нийгмийн хүрээнд түүний тухай ямар үзэл, санаа бодол тогтсоны мэдрэмжийг харгалзан тухайн хүнээс өөрийн үйлдлийг үнэлэх чадвартай салшгүй холбоотой.

Нэр төрийн ухамсар, мэдрэмж нь хувь хүний чухал шинж чанар бөгөөд түүний хөгжлөөс нийгмийн үзэл бодол, ёс суртахууны төлөвшил шалтгаалдаг.

Иймд дээр дурьдснаас эхлээд нэр төр, алдар хүнд нь объектив, гадаад талаасаа хувь хүний зан үйл, үйл ажиллагааны дотоод сэдэлт болж өгдөг.

"Алдар хүнд" гэсэн ойлголт нь харьцангуй сүүлийн үеэс л өргөн хэрэглээтэй болсон билээ. Хүний алдар хүндийн үзэл санаа нь хүн төрөлхтөний дээд үнэт зүйл болом

³ Малько А.В. "Субъективное право и законный интерес" Правоведение. 1998. № 4, С.63

⁴ Свердлык Г.А., Страунинг Э.Л. "Защита и самозащита гражданских прав" М. 2002. С.76

⁵ Анисимова М.П. "Достоинство и ничтожество: различные статусы человека в обществе и характеристика личности" Тюмень. 1988. С. 125

⁶ Невинский В.В. "Немецкие граждане в свете основополагающих принципов Конституции" Барнаул. 1994. С.120

шалгуурны хувьд Дундад зууны эцэст Гуманистуудын тусламжтайгаар бий болжээ. Хүний үнэт зүйл, дээд зориулалтыг түүний гарал үүсэл, нийгмийн байдал, үндэс угсаа, арьсны өнгөөс үл шалтгаалан хүлээн зөвшөөрөх явдал нь тухайн боловсруулсан онолын чухал тал байсан байна.

Алдар хүнд нь хүмүүнлэгийн онолын үндсэн ойлголт бөгөөд энэхүү шалгарын боловсруулалт нь хувь хүний эрх зүйн байдал буюу статусыг тодорхойлох судалгааны ач холбогдолтой байдаг.

Хүн, бүлэг хүмүүсийн алдар хүнд нь гүн ухааны ном зохиолд хувийн, тусгай, хүний гэж хуваагддаг. Хувийн алдар хүнд гэдэгт нийгмийн хэрэгцээний үзэл санааны үндэснэ үнэ цэнтэй гэж үзэх ёс суртахуун болон оюун ухааны шинж чанарт орших тодорхой нэг хүний амины үнэт зүйлийн нийлбэрийг ойлгодог.

Хэрэв хувийн алдар хүнд тодорхой гэж хүний амины үнэт зүйл болдог бол тусгай алдар хүндийн шалгаварт тухайн алдар хүн тодорхой хүмүүсийн нэгдэлд хамааралтайгаар нөхцөлдөх, түүний хэрэгцээнд нийцэх шинж чанарын нийлбэрийг хамааруулдаг.

Хууль зүй, гүн ухаан, ёс зүйн ном зохиолд ихэнх тохиолдолд хувийн алдар хүндэд хувь хүний бие бялдрын шинж чанарыг хамааруулдаг алдаатай үзэл санаа зонхилдгийг зайлшгүй үзэлдэгх ёстой. Энэ бол буруу ойлголт юм. Хэрэв тухайн хүн бөгтөр, хараагүй, хялар, долир гэх мэт бол алдар хүндийг багаар эзлэх ёстой гэж үү?

Алдар хүндийн төрөл зүйн ойлголт нь амины шинж чанар, нийгмийн гарал үүсэл, нийгмийн байдал, хүйс, үндэс угсаанаас үл шалтгаалсан хувь хүн тус бүрийн үнэ цэнийг тодорхойлсон хүний алдар хүндийн тухай ойлголт юм.

Алдар хүндийн тухай ойлголтод, мөн нэр хүндийн тухай ойлголттой адил, гадаад буюу объектив, дотоод буюу субъектив талыг хамааруулдаг.

Объектив тал нь тухайн хүнийг дээд үнэт зүйл болохыг хүлээн зөвшөөрдөг оршино.

Алдар хүндийн дотоод талын шалгавар нь тухайн хүний дотоод ертөнц, дэлхий ертөнцийг үзэх үзэл, санаа бодол, уг нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны шаардлага, хэм хэмжээнд нийцүүлэн ямарваа үйлдэл хийх чадвартай холбоотой. Өөрөөр хэлбэл нийгэмд өөрийн эзлэх байр суурь, хэрэгцээ, ёс суртахууны үнэ цэнийг ухамсарлаж мэдэрсэн байх явдал юм.

Нэр төр, алдар хүнд нь ёс суртахууны шалгавар мөн боловч нийтийн эрх зүйн шинж чанарыг агуулдаг.

Ёс суртахууны шалгавар нь нэг талаас тухайн хүний нийгэм, бусад хүн, өөрөө өөртөө хандах харилцааг илэрхийлдэг. Нөгөө талаас тодорхой этгээд болох хувь хүнд төр, нийгэм, ялгавар бүхий нийгмийн бүлэглэлүүд яаж хандах харилцаагаар илэрхийлэгдсэн бодит амьдралаар тодорхойлогдсон ерөнхий ойлголт юм.

Ёс суртахууны гол үндсэн шалгавар нь шударга ёс, энэрэнгүй ариун нандин, харамгүй сэтгэл, нэр төр, алдар хүндээ хамгаалах үүрэг хариуцлага гэх мэт байдаг бол, тэдгээрийн эсрэг нь хорон санаа, шударга бус явдал, хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох шунал юм. Эдгээр нь хоорондоо салшгүй холбоотой ба ёс зүй, эрх зүйд салшгүй харилцан холбоо бүхий нэгдсэн хос шалгавар гэж тооцогддог. Эдгээр шалгарын бодит байдлыг илэрхийлсэн нягт харилцаа холбоо нь тэдгээрийн тусгай шинж тэмдэг, ялгааг үгүйсгэдэггүй.

Эдгээр ойлголтын үндсэн ялгаа нь дараах байдалд оршино.

Хэрэв нэр төр нь тухайн хувь хүн нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг биелүүлсний үр дүнд нийгмийн зүгээс түүнийг хүндлэх, хүлээн зөвшөөрөх хэмжээг тодорхойлдог бол, алдар хүнд нь аливаа хүн

бүр энэхүү хүлээн зөвшөөрөлт, хүндлэлийг олж авах тэгш боломжийг хэлдэг.

Үүнээс гадна нэр төрийн утга агуулга нь алдар хүндийн ойлголтос илүү нарийн явцуу хүрээнд хамаардаг. Алдар хүнд нийтэйн, тусгай, ганцаарчилсан шалгаварын нэгдэл болж хүмүүнлэгийн онолын үндсэн ойлголт гэж тооцогддог бол нэр хүнд нь эдгээр ойлголтын хэлэлцүүлэгт ордоггүй.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сайн нэрийн тухай ойлголт нь ёс суртахууны салбарт хамаардаг. Тэдгээр нь хоорондоо хил залгаа байдаг ба утга агуулгын хувьд ойро дотно, заримдаа ижил, нэг нь нөгөөгөө тодорхойлдог онцлогтой.

Нэр алдарын тухай ойлголт нь нэр хүндийн тухай ойлголттой нийлдэг. Нэр алдар нь хүний алдар хүнд, дутагдлын талаарх ерөнхий үзэл санааны илэрхийлэл юм.

Эцэст нь хувь хүний алдар хүнд нь хүлээн зөвшөөрөх гадаад илэрхийллийг шаарддаггүй бол нэр төр нь ихэнх тохиолдолд хүлээн зөвшөөрөх гадаад хэлбэрээр шагнаал, зэргэг, цол зэргээр илэрхийлэгддэг.

Хүн өөрөө өөрийгөө болон бусад нь түүнийг юу гэж бодож, үнэлж байгаагаас үл шалтгаалан түүнийг "эрхэм дээд үнэт зүйл" гэж хүлээн зөвшөөрөх нь алдар хүнд юм.

Алдар хүндийн тухай ойлголт нь хувь хүний өөрийн үнэлэмж, дүгнэлтээс өргөн хүрээтэй. Учир нь тэр өөрийн хувийн алдар хүндийн мэдрэмжээс гадна аливаа хувь хүний үнэлэмжийг түүний өөрийн болон бусад этгээдийн үнэлэмж, хувийн шинж чанараас үл хамааран үнэлдэг. Тухайлбал, бага насны хүүхэд, сэтгэл санаа, бага эрхтний хувьд өөрөө өөрийгөө үнэлж чадахгүй хэн ч байх хүний нэр төр, алдар хүндийн төр хуулийн хамгаалалтандаа байлгагддаг. Үүгээрээ хүн бүрийн эрхэм нэр төр, алдар хүнд нь дээд үнэт зүйлд зүй ёсоор тооцогддог.



ХӨРШИЙН ЭРХ

Оршил

Хэсэг хугацаанд хуулийн салбарт ажиллаж, цөөнгүй мэргэдийн номлол, сургаалийг сонсож, хууль зүйн асуудлын чухлыг багагүй гадарладаг болсны хувьд тодорхой хэмжээгээр үнэлэхүйц мэдээлэл уншсан, сонссон үедээ түүнийгээ та бүхэнтэйгээ хуваалцаж байх нь чухал хэмээн миний бие үзэх болсон. Тэр ч учраас төдийлөн цаг шаардсан судалгааны ажил бус ч Австрали улсад хэвлэгддэг сар тутмын "Hot topic" хэмээх хууль зүйн нэгэн сэтгүүлээс Хөршийн эрх зүйн асуудал хөндсөн өгүүллийг уншсанаа иргэний эрх зүйн сэдвээр судалгаа хийгч оюутан залуусынхаа сонорт "Далайд дусал нэмэр" хэмээх мэргэн үгийг даган хүргэе хэмээн бодлоо.

Австрали угаас суурин иргэншилтэй улс орны хувьд хөршийн эрх зүйн асуудал бүх талаар нарийн судлагдаж, зохицуулалт нь нягт нямбай агаад байж болох бүх л харилцааг хамарч чадсан байна. Хэдийгээр 2002 онд батлагдсан Иргэний хууль эдийн засгийн бус амины суурьт харилцааг хамран зохицуулах үндсэн чиг үүргээ сайн гүйцэтгэж буй боловч түүнийг амьдралд хэрэгжихэд эн тэргүүнд шаардагдах зүйл нь уг харилцааг нарийвчлан зохицуулж, түүнд оролцогч эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгосон, хуулийн хүрч чадаагүй, хүрэх ч боломжгүй жижиг боловч чухал харилцааг хөндсөн дүрэм журмыг батлан мөрдөх явдал юм.



Н.БАЯРМАА

/Хууль зүйн ухааны магистр/

Бидний өдөр тутмын амьдралд элбэг тохиолддог зүйлийн нэг, ихэнхдээ хүмүүс өөрсдийн мэдэх хар аргаараа муйхарлан шийдэхийг оролддог. Сүүлийн үед улам хаягаа тэлж буй дуу чимээ, тэжээвэр амьтантай холбоотой маргаан, кашаа хашлага барих, засварлах, байшин сууцандаа засвар хийх, эзэмшил газартаа хил хязгаар тогтоохтой холбоотой маргаан хөршийн харилцаанд түгээмэл ажиглагддаг.

Дуу чимээтэй холбоотой маргаан, нарийвчилсан зарим зохицуулалт

Энэ харилцааг нарийвчлан зохицуулахын тулд юуны өмнө дуу чимээ болон түүнийг гаргаж буй эх сурвалжийн талаар тодорхой судалгаа шаардлагатай. Дуу чимээ олон янз байхын зэрэгцээ иргэдийн амгалан тайван

байдлыг алдагдуулсан, гомдол гаргахуйц хэвийн бус саадтай, хүний эрүүл мэндэд хортой байж болно. Түүнчлэн энэ нь байнгын эх сурвалжаас тогтмол гардаг, эсвэл түр зуурын шинжтэй байж болно.

Австрали улсын хувьд хөршийн дуу чимээтэй холбоотой харилцааг Орчин тойронд нөлөөлөх үйл ажиллагааны хамгаалалтын тухай 1997 оны актаар зохицуулсан байна. Уг акт "гомдол гаргахуйц дуу чимээ" гэсэн нэр томъёог хэрэглэж энэ нь хүмүүст хортой эсвэл хэвийн бус, саадтай байна гэж тодотгожээ. Дуу чимээг хөндлөнгийн саадтай, хор хөнөөлтэй эсэхийг түүний төрөл хэлбэр, түвшингээр нь тогтооно. Түүнчлэн дээрх шинж бүхий дуу чимээ бүхэн гомдол гаргахуйц гэсэн ангилалд багтахгүй байж болох бөгөөд 2000 онд шинээр нэмэгдсэн зохицуулалтаар зарим төрлийн дуу чимээг ямар цаг мөчид гарч байгаагаас хамааран "гомдол гаргахуйц" хэмээн үзэх эсэхийг заасан. Цаг хугацааны хувьд хязгаарлалт тогтоогддог дараах төрлийн дуу чимээ байж болох юм.



Дуу чимээ гаргагч эх сурвалж	Хязгаарлалт
Багаж хэрэгсэл /ихэвчлэн цаээрлэгийн багаж хэрэгсэлүүд, усан сангийн шахуурга/ Хамаарах зүйл: Зүлэг хадагч Зүлэг тэшлэгч Үлээгч, шүүрдэгч багаж Захлагч, хэлтлэгч, хэрчигч Цахилгаанаар ажилладаг хүчний багаж /зайгаар ажиллах багаж/ Хийн шахуургын хүчний багаж Гинжин зүсэгч Тойргон зүсэгч Хийн болон агаарын шахуурга	20.00-07.00 ажлын өдрүүд болон Бямба гараг 20.00-08.00 Ням гараг болон баярын өдрүүд
Хөгжмийн зэмсэг ба дуу авианы тоног төхөөрөмж Цахилгаан өсгөгч тоноглолууд Компьютер Радио Телевизор Хуурцаг тоглуулагч Гяназ тоглуулагч Диск тоглуулагч DVD тоглуулагч Нийтийн зарлалын систем	24.00-08.00 бүх өдөр
Агааржуулагч	22.00-07.00 ажлын өдрүүд 22.00-08.00 амралтын болон баярын өдрүүд
Оршин суугчдын ойр орчинд буй тээврийн хэрэгсэл/оршин суух орчинд орох гарахаас бусад тохиолдсон хамаарна!	20.00-07.00 ажлын өдрүүд 20.00-08.00 амралтын болон баярын өдрүүд

2000 онд нэмэгдсэн шинэ зохицуулалтаар машины болон орон байрны хамгаалалтын дохионы үргэлжлэн дуугарах хугацаанд хязгаарлалт тогтоосон. Гэвч энэ заалт нь машин осолд орсон болон эвдрэл гэмтэл тохиолдсон үед үйлчлэхгүй.

Хамгаалалтын дохионы хэлбэр	Хязгаарлалт
1997 оны 9 сарын 1-нээс өмнө үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгсэл	Дохио анх удаа дуугарснаас хойш 90 секундээс илүүгүй
1997 оны 9 сарын 1-нээс хойш үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгсэл	Дохио анх удаа дуугарснаас хойш 45 секундээс илүүгүй
1997 оны 12 сарын 1-нээс өмнө суурилагдсан дохиоллын систем	Идэвхижсэнээс хойш 10 минутаас илүүгүй
1997 оны 12 сарын 1-нээс хойш суурилагдсан дохиоллын систем	Идэвхижсэнээс хойш 5 минутаас илүүгүй

Хөршийн харилцан дахь Таны эрх зөрчигдөөл хууль зүйн хамгаалалтын ямар арга хэрэглэж болох вэ?

Хэрэв хөршийн тань гаргаж буй чимээ шуугиан таны амгалан тайван байлдгыг алдагдуулж байвал эрхээ хамгаалуулахаар /чимээ шуугианыг намжаах талаар хөрштэйгөө тохиролцоонд хүрч чадаагүй бол/ цагдаагийн байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллага, шүүхэд /Австрали улсын хувьд/ хандах хийгээд эдгээр байгууллага дараах арга хэмжээ авч болно.

Үүнд:

- Дуу чимээг намжаах зааварчилгаа өгөх

- Дуу чимээ намсгах тогтоол гаргах зэрэг болно.

Эдгээр нь шат дараалсан арга хэмжээ боловч зарим үед гарч буй чимээ

шуугианыг намжаах шаардлага хэр зэрэг тулгамдсан болохоос хамааран шат дараалалгүй авагдаж болох арга хэмжээнүүд юм. Гэвч суурин соёл иргэншилтэй улсын иргэдийн хувьд харилцан тохиролцох, ойлголцохыг урьтал болгож бие биенийхээ эрхийг хүндэтгэн амьдрах зарчим амьдралд биеллээ олж нэг төрлийн зуршил болж чадсан учраас төрийн байгууллагад хандах, тэр ч байтугай бусдад саад болохоор чимээ гаргахаасаа өмнө бие биедээ анхааруулах, уучлалт хүсэх /оройтсон найр наадам зохиох г.м./ маргаан гарсан үед төрийн байгууллагын оролцоогүй шийдвэрлэхийг оролдох нь илүүтэй тохиолддог.

Ийнхүү эвээр, маргаан тэмцэл бололгүй, шүүхийн өндөр зардал гаргалгүй асуудлыг нэг тиш болгоход нааштай нөлөө үзүүлдэг томоохон хүчин зүйл бол Шударга ёсны төв буюу Community Justice Centre хэмээх байгууллага юм. Энд нэгэн хэргийг жишээ болгон авч үзсэнийг дурдъя.

Жишээ: Мэгийн дээд давхарт шинээр нүүж ирсэн оршин суугч бэйрандаа засвар хийж хуучин хивсээ хуулан модон шалаа өнгөлөн засварлажээ. Мэг энэ нь өмнө байснаасаа харьцангуй чимээ ихтэй болохыг тэр даруй анзаарчээ. Өмнө нь тэрээр дээд давхраа гарах бүхий л чимээг мэдэрдээ байсан боловч энэ удаа хүмүүсийн харилцан яриа, зурагт, хүлээн авагчийн чимээг өөрсин гэрт болж байгаа мэт тод сонсох болсон байна. Дээд давхрааг сонсдох хөлийн болон бусад дуу чимээг тэсвэрлэхэд бэрх болсон учраас энэ тухай хөрштэйгөө ярилцахаар шийдсэн бөгөөд энэ нь төдийлэн үр дүнд хүрсэнгүй. Хөрш шалыг өнгөлөн засахад ихээхэн зардал, цаг, ажил орсон учраас дахих хивслэхийг хүсэхгүй байна хэмээн татгалзжээ. Мэг эрх бүхий байгууллагад хандан гомдол гарган, хууль зүйн ажиллагаа эрхлүүлж болох хэдий ч энэ нь ирээдүйн хөршийн харилцаанд нь төдийлэн таатай нөлөөлөхгүйг мэдэж буй учраас ийнхүү хандахын өмнө хөршдөө хууль зүйн эрхээ

тэйлбэрлэж болох гэвэр Шударга ёсны төвд хандан зуучлалын үйлчилгээ авахаар шийджээ. Инээд зуучлалын үйлчилгээ захиалсан ба хөрш нь үндэ оролцохыг зөвшөөрсөн байна. Энэ ажиллагааны үеэр хөрш нь Мэргийн хууль зүйн ажиллагаа эрхлүүлэх боломжтойг ойлгож зарим өрөөндөө хивс дэвсэх зэргээр чимээ шуугианыг намдаах арга хэмжээ авахыг зөвшөөрчээ.

Австралийн хөршийн эрх зүйн харилцаанд Шударга ёсны төв хэмээх энэ байгууллага голлох үүрэгтэй оролцдог бөгөөд манай улсын хувьд ч авч хэрэгжүүлээр чухал ач холбогдолтой байгууллага мэт сангадлаа.

Хэрвээ Та хөрштэйгөө зохицооор оролдох бүртээ ямар ч үр дүнгүй зөрүүл болж хувирах эсвэл түүнтэй уулзалдахад бэрхшээлтэй байх зэргээр таны оролдлого бүтэлгүй болвол Шударга ёсны төвд хандаж болно. Энэ нь хөршүүдийн дунд гарсан маргаанаа шийдэх арга замыг өөрсдөө олоход нь тусалж, зуучлагчаар хангаж өгдөг байгууллага юм.

Тэд хашаа, хашлага, чимээ шуугианаас эхлээд амгалан тайван байдал алдагдуулах, тэр ч байтугай арьс өнгөөр ялгаварлах үзэл гаргах хүртэл бүх төрлийн хөршийн маргаанд зуучлах ажиллагаа эрхэлнэ. Шударга ёсны төв нь Шүүх байгууллага биш, тэд нотлох баримт, гэрчин этгээд, хуульчийн аль алиныг оролцогч талуудаас шаарддаггүй. Энэ байгууллагын зуучлагчдын гол үүрэг нь өөр хоорондоо харилцан ойлголцоход хүндрэлтэй байгаа хүмүүст туслах явдал. Тэд аль нэг талыг барихгүй, ямар ч шийдвэр гаргахгүй, гагцхүү хөршүүдийг өөрсдөө асуудлаа шийдэхэд нь дөхөж үзүүлэх зорилготой ажилладаг. Хэрвээ ажиллагаа амжилттай болж тохиролцож чадвал энэ нь маргалдагч талуудын өөрсдийн гаргасан шийдвэр учраас магадгүй хуулийн байгууллагын гаргасан албадлагын шинжтэй шийдвэрээс илүүтэй ирээдүйд ямар нэг асуудал үүсэхээс сэргийлж чадах сайн талтай.

Гэвч нөгөөтэйгүүр хөрш энэхүү зуучлалын үйл ажиллагаанд оролцох

үүрэг хүлээхгүй, Австрали дахь ийм зуучлалын байгууллагын гаргасан мэдээллээр хөршүүдийн гуравны нэг нь зуучлалын үйл ажиллагааг хүлээж авахаас татгалздаг боловч ийм үйлчилгээ хүлээж авсан хөршүүдийн 80 хувь нь зөвшилцөлд хүрч чаддаг байна. Орчин тойрныг тохижуулах болон барилгын ажил нь дуу чимээний ах сурвалж болдог төдийгүй дээр дурдсан байдлаар хөршийн эрхэд нөлөөлөх бие даасан хүчин зүйл болдоггоороо дуу чимээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын нэгэн адил байр суурийг хөршийн эрх зүйд эзэлдэг. Энэ төрлийн ажил эхлэх тухай хэн нэгний шийдвэр нь тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын болон хөршийн амьдралд томоохон нөлөө үзүүлж болох зүйл. Тухайлбал, хөрш тань хувийн сууцаа 2 давхар болгохоор шийдсэн нь таны гэрт тусах нарны гэрлийг хаах, хэн нэг нь гэрийн тань хакууд зоогийн газар байгуулсан нь таньг шөнө тайван амрахад саад болох эсвэл оршин суудаг гудамжинд тань томоохон худалдааны төв байгуулахаар төлөвлөж байгаа нь тээврийн хэрэгслийн мөргөлдөөнийг ихэсгэж, замын хөдөлгөөний өвд бий болох зэргээр бидний сад бүр тугмын хэвшсэн, тайван амьдралын хэмнэлд нөлөөлж болно. Энгийн иргэд, хөршүүд томоохон барилга байгууламжийн ажлаас шалтгаалан зөргөждөг буй өөрсдийн эрхийг хамгаалах тал дээр байнга хүчин мөхсөдөх сэтгэл зүйн мэдрэмжтэй байдаг. Том жижиг аль ч барилгын ажил орон нутгийн холбогдох засаг захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр явагдах ёстой. Манай улсын хувьд ч нэгэн адил энэ журам үйлчилнэ.

Австрали улсын хувьд энэ талын зохицуулалт нилээд боловсронгуй түвшинд байна. Өөрөөр хэлбэл, ийнхүү зөвшөөрөл өгдөг төрлийн байгууллагууд нь барилгын чанар, аюулгүй байдлыг хянах төдийгүй хөршийн эрх зөрчигдөх эсэхийг давахар хянаж байхаар эрх үүрэг нь зохицуулагдсан байна. Хувийн байшингаа томсгох эсхүл томоохон худалдааны төвийн барилгын ажил эхлүүлэх аль ч тохиолдолд хуульд

нийцсэн нарийвчилсан зохицуулалт үйлчлэх учир юуны өмнө ямар нэг ажиллагаа эхлэхийн урд холбогдох хууль тогтоомжоо судлах нь чухал. Энэ нь барилгын ажил эрхлэгч өөрт тааламжтай байдлыг сонгоход төдийгүй ирээдүйн хөршийн харилцаанд тань элдэв хүндрэл учрахаас сэргийлэх чухал ач холбогдолтой. "Орчин тойрныг тохижуулах төлөвлөгөөний тухай" актад зэвснээр дараах төрлийн барилгын болон засварын ажил байж болох хийгээд тодорхой хэмжээгэр хөршийн эрх зүйн зохицуулах зүйлийн хүрээнд хамаарна:

- Газар ашиглах;
- Газрыг хуваах;
- Байшин барих /шинээр барих, томсгох, сунгах/;
- Ажил гүйцэтгэх /байшин дахин барих, өөрчлөх эсвэл ажилгүйдэх эсвэр гүйцэтгэхийн тулд нийтийн ЗЭМШИЛ газраас тусгаарласан хашлага босгох/;
- Байшин буулгах;
- Орчлогч тохижуулах төлөвлөгөөнд тусгагдсан бусад ажил. Элдэргийг ерөнхийд нь дараах байдлаар 3 категорит хувааж буйг энд дурьдвал:

1. Зөвшөөрөл шаарддаггүй буюу чөлөөлөгдсөн ажлууд;
 2. Орон нутгийн болон улсын шинж чанартай зөвшөөрөл шаардагдах ажлууд;
 3. Хориглосон ажлууд.
- Энэ төрлийн ажлын нарийвчилсан жагсаалт байх бөгөөд ажил эхлэхийн өмнө орон нутгийн байгууллагын холбогдох ажилтантай уулзаж зөвлөгөө авч, өөрийн хийх ажлын талаар эрх зүйн мэдлэгтэй болох нь иргэд, байгууллагын үүрэг болно.

ЗЭМШИЛ ГАЗРЫН ХЯЗГААР БОЛОН ХАШАА, ХАШЛАГЫН ХОЛБОТ ҮҮСЭХ ХӨРШИЙН ХАРИЛЦАА

Зэмшил газрын хил хязгаар гэдэг нь нэг талаас хөршийн харилцаанд үл ойлголцол, бусад асуудал үүсч болох эхлэл цэг байж болно. Хашаа засварлах ажил хийх, гарсан зардлаа хуваарилах, хашааны өндөр нам, загвар, байршил зэрэг асуудлаар

тохиролцоонд хүрч чадахгүй байх нь хамгийн найрсаг хөршийн харилцаанд ч толбо үлдээж болох юм.

Хэрэв хэн нэг нь эзэмшил газрыг нь тодорхойлж буй хашааг засварлах цаг болжээ хэмээн үзэж байгаа бол хөрштэйгөө асуудал үүсгэхээс сэргийлж болох хамгийн анхны алхам мэдээжээр түүнтэй ярилцах явдал. Ихэнхдээ хөршүүд ийм ажилд таатай хандаж нааштай хүлээж авдаг бөгөөд энэ нь тэдгээрийн хооронд ажил үүргээ хуваарилах, баригдах хашааны үнэ, загварын талаар тохиролцоонд хүрэх гэсэн дараагийн ажлын эхлэл болно. Хэрвээ засвар хийхийг хүсэж буй этгээд хил залгасан хэд хэдэн хөрштэй бол мөн тэдгээрийн тоогоор тус тусдаа хэлцэл хийх хэрэгтэй болох ба энэ нь магадгүй түүнийг ялгаатай загварын хашаатай болоход ч хүргэж мэдэх юм. Хэрвээ хөрштэйгээ энэ талаар бүрэн тохиролцож чадсан бол нэн даруй бичгээр баталгаажуулж талууд харилцан гарын үсэг зурах хэрэгтэй. Тохиролцоонд хүрсэн бол маргаан үүсэх магадлал багатай. Харин тохиролцоогүй бол яах вэ?

"Эзэмшил газрын хязгаар тогтоох тухай" 1991 оны Австрали улсын актдаг зааснаар "Хэрэв хөрш нь хашаа

засварлахыг зөвшөөрөхгүй болон засварын талаар түүний гаргасан хариу саналыг анх санал тавьсан этгээд хүлээж авах боломжгүй гэж үзвэл дараагийн алхам нь хөршдөө бичгээр мэдэгдэл өгөх явдал болно. "Бичгээр өгөх мэдэгдэл дараах мэдээллийг заавал агуулсан байх шаардлагатай.

◆ Хашааны ажил эхлүүлэх шаардлагатай байгааг товч дурдах;

◆ Хашааны байрлал;

◆ Хашааны ажлын төрөл;

/шинээр барих, засан сайжруулах, өөрчлөх гэх мэт/;

◆ Ажилд шаардагдах хөрөнгийн тооцоо;

◆ Түүнд оруулах хөрш бүрийн хувь. /Ихэнхдээ энэ нь тэнцүү байдаг боловч зарим үед гүйцэтгэх ажлаас хамааран ялгаатай тогтоогдох тохиолдол байж болно/.

Энэхүү мэдэгдлийг шуудангаар илгээх болон биечлэн гардуулж болно.

Мэдэгдлийн дараа хөрш саналыг хүлээж авахаас татгалзсан хэвээр байвал дараагийн шат нь орон нутгийн шүүхэд хандах явдал. Ийнхүү хандахын өмнө мэдэгдэл өгснөөс хойш нэг сар өнгөрсөн байхыг анхаарах шаардлагатай. Шүүх дараах асуудлуудыг харгалзан

үзэж шийдвэр гаргана. Үүнд:

◆ Хэрэв хуучин хашаа байвал түүний үзүүлэлт;

◆ Хашаа барих зорилго;

◆ Хил залгаа амьдарч буй газар өмчлөгчдийн хувийн байдал, бодол санаа;

◆ Тухайн нутаг дэвсгэр дэх хашааны ерөнхий төрөл байдал

◆ Энэ талаар орон нутгийн захиргааны байгууллагын баримталж буй бодлого, төлөвлөгөө зэрэг болно.

Дүгнэлт

Энэ удаад Та бүхэндээ Австрали улсын хөршийн эрх зүй дэх дуу чимээ болон хашаа хашлагатай холбоотой зохицуулалтын зах зухаас хүргэхийг зорилоо. Дахин тэмдэглэн хэдхэд үүнийг бичигч нь өөрийн орны зохицуулалттай харьцуулан судалгаа хийж дүгнэлт хийхийг бус гагцхүү энэ чиглэлээр судалгааны ажил хийж, буй оюутан залууст бага ч атугай мэдээлэл хүргэхийг зорьсон билээ.

Мэдээллийн эрх зүй дэх зарим нэг сонирхол татсан асуудал хөндсөн өгүүлээр дараа дахин уулзацгаая.

Сидней, Австрали
bamaa_n@yahoo.com



ГАДААД ОРНУУДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ БОЛОН ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ “ЭЗЭМШИЛ”-ИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Аливаа эрх зүйн ойлголтын талаар судлан авч үзэхэд харьцуулсан судалгаа, тэр дундаа гадаад улс орнуудын хууль, эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх нь зайлшгүй чухал билээ. Энэхүү өгүүлэлд сонгон авсан гадаадын дөрвөн орны Иргэний хууль тогтоомжид “эзэмшил”-ийн талаар хэрхэн зохицуулсан байдаг, иргэний эрх зүйд энэ ойлголтыг хэрхэн авч үздэг талаар дурдах болно.¹ Судалгаа хийх улс орнуудыг сонгохдоо судалгааны гол зорилго буюу иргэний эрх зүйн нэг гол ойлголт болох “эзэмшил”-ийн мөн чанар, агуулга, зохицуулалтын онцлогийг тодруулахтай холбоотойгоор нэг талаас эзэмшлийн талаарх эрх зүйн зохицуулалтын тодорхой байдал, нөгөө талаас эрх зүйн бүлгийг харгалзан үзлээ. Дээрх зүйлийг харгалзан судалгаанд нэгдүгээрт, Ром-Германы эрх зүйн бүлд хамрагдах гол төлөөлөгчийн нэг ХБНГУ болон Франц улсыг (БНФУ), мөн дээрх улсын иргэний эрх зүйгээс уламжлал, улбаатай азийн улс орнуудын төлөөлөл болох Япон улсыг, мөн хил залгаа болон өмнө нь эрх зүйн зохицуулалт төстэй байсан утгаар нь ОХУ-ыг тус тус хамрууллаа.

Ром-Германы эрх зүйн бүлийн орнуудын иргэний эрх зүй болон иргэний хууль тогтоомж дахь



МУИС-ийн ХЭС-ийн магистрант
А.ДЭЛГЭРМАА

“эзэмшил”-ийн талаарх зохицуулалт нь эзэмшлийн үндсэн хоёр онолоос улбаатай болох нь харагдаж байна. Эзэмшлийн субъектив онол болох Савиньгийг² онол нь Францын Иргэний хуульд илүү хүчтэй үйлчилдэг бол объектив онол болох Иерингийн³ онол нь Германы хуульд илүүтэйгээр биеллээ олсон байна. Энэ утгаараа орчин үеийн Ром-Германы эрх зүйн системд эзэмшлийн тухай ойлголт, хамгаалалтын асуудлаар хоёр хандлага байдаг байна. Францын Иргэний хууль эзэмшлийг эд юмсын эрхийн төрөлд оруулдаг ба өмчийн эрхийн журмаар

зохицуулдаг. Харин Германы 1900 оны Иргэний хуульд эзэмшил нь бие даасан эд юмсын эрх зүйн институт болдог ба өмчлөх эрхээс илүү өргөн утгатай төдийгүй хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн аль альд нь эзэмшлийн хамгаалалтыг хэрэгжүүлэх боломжтой байдаг.⁴ Эх газрын эрх зүйн системтэй бусад улсад дээрх хоёр үзэл баримтлалын аль нэгийг удирдлага болдог. Жишээ нь, Польшийн Иргэний хуульд эзэмшлийг эд юмсын хязгаарлагдмал эрх хэмээн авч үзсэн. Өмчлөгчийн адил эд зүйлийг бодитоор эзэмшигч буй этгээд нь бодит буюу бие даасан эзэмшигч болох ба бодит эзэмшил нь өмчлөгчийн эрх зүйн байдалд тохирно гэсэн зарчим үйлчилдэг байна. Польшийн Иргэний хуулийн 343 дугаар зүйлд шударга бус эзэмшигч байсан ч түүний эзэмшлийг нь хэн нэгэн этгээд зөрчихгүй байхаар заасан бөгөөд өөрийн эзэмшлийг хамгаалахын тулд эзэмшигч өөртөө туслах аргыг хэрэглэж болдог байна⁵.

Европын холбооны Хүний эрхийн шүүхээс өмчлөгчийн эзэмшлийн эрхийг сэргээх асуудлыг удаашруулах нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг гэж үздэг. Тухайлбал, Итали улс нь 11 жил хүний эрх зөрчсөн гэж гэм буруутнаар тооцогдсон байна.

¹ “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2007 оны 3 дахь дугаарт “Эзэмшил - Иргэний эрх зүйн нэг институт болох нь” өгүүлээр эзэмшлийн тухай, түүний эрх зүйн зохицуулалтын талаар онолын үндэс авч үзсэн. А.Д.

² Friedrich Carl von Savigny (1779 - 1861) - Германы эрх зүйн онолч, Пруссийн эрх зүйн сургуулийг үндэслэгч. 1803 онд “Эзэмшлийн эрх” (Das Recht des Besitzes) бүтээлээ туурвисан. Түүний “Das Recht des Besitzes” бүтээл нь гар бичмэлээр хадгалгагдан үлдсэн бөгөөд интернэтэд дараах хаягаар үзэх боломжтой: <http://dlib-pr.mprner.mpg.de/mfer-cqj/leio/0010MFER/evaxc/books/%22235083%22>

³ Rudolf von Jhering (1818 - 1892) Германы эрх зүйн онолч, судлаач. Ромын эрх зүйн чиглэлээр мэргэжсэн. XIX зууны үед Германы эрх зүйн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан. Эзэмшилтэй холбоотойгоор 1889 оны “Эзэмшлийн хууль зориг” (Der Besitzwille), 1869 онд “Эзэмшлийн хамгаалалтын үндэслэлийн тухай” (Über den Grund des Besitzschutzes) хэмээх бүтээн гаргасан. Түүний “Über den Grund des Besitzschutzes” бүтээл нь гар бичмэлээр хадгалгагдан үлдсэн бөгөөд интернэтэд: <http://dlib-pr.mprner.mpg.de/mfer-cqj/leio/0010MFER/evaxc/books/%22154201%22> хаягаар үзэх боломжтой.

⁴ Галов В. В. “Владение как элемент вещного права” Ростов-на-Дону, Донской юр-ийн инс., 2000

⁵ Мөн тэнд.

Учир нь "Иммуobiliаре Саффи" компанийн үл хөдлөх хөрөнгийн эзэмшлийг сэргээх ба түрээслэгч уг хөрөнгийг чөлөөлөх тухай шүүхийн шийдвэрийг биелүүлж чадаагүйн улмаас ийм дүгнэлтийг авчээ.⁶ Үүндээ харахад эзэмшигчийн эрхийн хамгаалалт нь Европын орнуудад нэлээдгүй хөгжсөн болох нь харагдаж байна.

Нэг. ХБНГУ-ын Эд юмсын эрх зүй болон Иргэний хууль тогтоомж дахь эзэмшлийн талаарх зохицуулалт

XIII зууны үеэс эхлэлтэй Ром-Германы эрх зүйн бүлэг-ийн гол төлөөлөгч болох ХБНГУ нь Европт төдийгүй, дэлхийн хэмжээнд эрх зүйн хөгжлийн харьцангуй өндөр түвшинд хүрсэн улс юм. Тус улсын эрх зүйн тусгал Европ, Азийн нэлээдгүй оронд хүрсэн байдаг. Манай орны иргэний болон бусад хэд хэдэн салбарын эрх зүйд ч эрх зүйн шинэтгэлийн үе эхэлсэн тэр үеэс л тусгалаа олсоор байгаа билээ. Тухайлбал, 2002 оны Иргэний болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хэд хэдэн хуулийг боловсруулахад Германы колбогдох хуулиас харьцуулан судлахын хамт Германы хуульчдын зөвлөгөөг авч байсан байна. Судалгааны ажлын гол сэдэв болох эзэмшлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд эзэмшлийн объектив номлол гэх Р.Иерингийн номлол нь Германы хуульд чухал нөлөө үзүүлсэн байдаг. Эзэмшлийн гол элемент нь эд юмсыг бодитоор захиран зарцуулах явдал гэж хүлээн зөвшөөрдөг байсан ба хүсэл зоригийн элементийг үгүйсгэлгүй эзэмшлийг бодитоор хэрэгжүүлсээр эзэмшигчийн хүсэл зориг илэрч байна гэж ойлгодог байв.

Германы иргэний эрх зүй нь хувийн эрх зүйн үндэс, нэгэн том хэсэг нь гэж тооцогддог. Өмнө нь хувийн болон иргэний эрх зүй нь нэг ойлголт мэт байсан ба хувийн эрх зүйд худалдааны, эдийн засгийн, оюуны өмчийн, хөдөлмөрийн зэрэг тусгай салбар эрх зүйн институтууд бий болж ялгагдаж эхэлсэн байна.⁸ Германы хууль тогтоомжид эзэмшил нь өмчийн эрхэд захирагддаггүй бие даасан институт гэж тооцогдож, илүү нарийн зохицуулагдсан байдаг.⁹ Эзэмшлийн хамгаалалтын хамрах хүрээ өргөн байдаг нь үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ялгалгүй хамруулдагаас шалтгаалдаг байна. Германы иргэний эрх зүйн гол эх сурвалж болох Иргэний төрөлжсөн хууль нь (ИТХ)¹⁰ 1900 онд хүчин төгөлдөр болсон ба нэмэлт, өөрчлөлтүүд хийгдэж, өнөө ч хүчинтэй үйлчилж байна. Судалгааны ажлын гол асуудал болох "эзэмшил" хэмээх ойлголт нь Германы иргэний эрх зүйн, тэр дундаа эд юмсын эрх зүйн гол институт бөгөөд ХБНГУ-ын ИТХ-ийн 854-872 дугаар зүйлд зохицуулагдсан байдаг. Германы ИТХ нь таван дэвтэртэй бөгөөд 3 дахь дэвэрт болох хувь этгээдээс эд хөрөнгөд харьцах харьцааг зохицуулсан "Эд юмсын эрх зүй" гэсэн бүлгийн эхний хэсэгт эзэмшлийн талаар зохицуулсан байна.

Германы эрх зүйд эзэмшлийг хэн нэгэн этгээд аливаа нэгэн эд зүйлийг бодитоогоор эзэмшилдээ байлгаж буйтай холбоотой ойлголт гэж тайлбарладаг. Эзэмшил нь агуулын хувьд өргөн хүрээг хамардаг. Өмчлөлтэй харьцуулахад эзэмшил нь тэр бүр хууль ёсныг байдаггүй, өөрөөр хэлбэл, өмчлөл бол зөвхөн хууль ёсны, харин эзэмшил заавал хууль ёсны байх албагүй. Тухайлбал, хулгайч ч хулгайн эд зүйлийг тухайн үед

өөрийнхөө эзэмшилд бодитоогоор байлгаж байгаагийн хувьд эд зүйл болон хулгайчийн хооронд эзэмшлийн харьцаа үүссэн байдаг бөгөөд хулгайч хэдийгээр эд зүйлийг хууль бусаар олж авсан байдаг боловч тодорхой хэмжээгээр эзэмшилдээ байлгаж байдаг. (Гэхдээ хулгайч нь тухайн зүйлийн эзэмшигч байдаг болохоос бус өмчлөгч нь биш байдаг.) Эндээс харахад эзэмшил нь хууль ёсны болон хууль бус байдлаар үүсэн бий болох боломжтой ба хууль бус эзэмшил нь шударга бус шударга бус эзэмшлийн хэлбэрээр байж болно. Мөнгө, үнэт цааснаас бусад хөдлөх эд хөрөнгийг олж авсан эзэмшигчийн хувьд тухайн эд зүйлийг өмнөх жинхэнэ өмчлөгчөөс, эсхүл эзэмшигчээс хулгайлагдсан, гээгдсэн эргийг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан тохиолдолд тэрээр өөрийгөө тухайн эд зүйлийн өмчлөгч гэж төсөөлдөг. Энэ тохиолдолд түүнийг шударга эзэмшигч гэж тооцож бөгөөд тэрээр эзэмших эрхээ хамгаалуулах эрхтэй байж, эзэмшилд саад хохирол учруулбал арилгуулах, барагдуулахыг шаардах эрхтэй байдаг. Түүнчлэн эзэмшил нь эд юмсын бусад эрх үүсэх болон хэрэгжих урьдчилсан нөхцөл болдог. (хөдлөх эд хөрөнгийг өөрийн мэдэгдэж байгаж, барьцааны эрх гэх мэт)¹¹

Германы эд юмсын эрх зүйн хөгжил нь "эзэмшил"-ийн эрх зүйн онолын хөгжилд асар хувь нэмэр оруулсан гэж үзэж болно. Учир нь эзэмшил болоод эзэмших эрхэд түүхэн үүднээс маргаантай байсан хэд хэдэн асуудалд Германы эд юмсын эрх зүйн зохицуулалт хариу өгч чадсан. Тухайлбал, эзэмшилд хүсэл зориг заавал байх эсэх тухай маргаантай асуудалд буюу хүсэл зоригоос гадуур эзэмшил үүсэх боломжгүй гэсэн Ромын хуульчдын сургаалд Германы Иргэний хуулийн

⁶ Мөн тэнд.

⁷ "... Ром-Герман эрх зүйн бүлийн эхлэл үеийг XIII зуунаар тооцож болох юм ..." Rene David /Gunther Grasmann "Einführung in die großen Rechtssysteme der Gegenwart" 2. deutsche Auflage, Verlag C.H.Beck, München, 1998, Seite 62

⁸ Dr. Hans Brox "Allgemeiner Teil des Bürgerliches Gesetzbuches" 13. verb. Auflage, Carl Heymanns VerlagKG, Köln, Berlin, Bonn, München, 1989, Seite 10

⁹ Гражданское и торговое право капиталистических стран, Юрид. Лит., Москва 1980

¹⁰ Bürgerliches Gesetzbuch

¹¹ Dr.Carl Crellfelds / Dr.Klaus Weber "Rechtswörterbuch", 17. neu bearb. Auflage, Verlag C. H. Beck München, 2002, Seite 218

шинэ төсөл боловсруулагдсан үеэс эхлэн огцом эргэлт гарсан юм. Өөрөөр хэлбэл эзэмших хүсэл зоригийн зайлшгүй шинэ үг хуулийн төслөөр байхгүй болсон. (Германы иргэний хуулийн 854 дүгээр зүйл) Хуулийн анхны төсөл хэвлэгдэх гарах үед зарим судлаач энэ асуудалд нэлээд шүүмжлэлтэй хандаж байсан байна.¹² Гэхдээ Германы Эд юмсын эрх зүйд Иерингийн онолыг илүү суурь болгосон утгаараа эзэмшлийн объектив байдлыг илүү голлож авч үздэг хэдий ч хүсэл зоригийн хүчин зүйлсийг ч бас орхиж дууддаггүй. Өөрөөр хэлбэл, эзэмшил нь хүсэл зоригийн илэрхийлэл ч гэсэн заавал хэлцэл байх албагүй, мөн хууль ёсны ч байх албагүй. Хулгайч ч бусдын юмыг өөрийн болгох хүсэл зоригийн үндсэн дээр эд юмсыг эзэмшилдээ оруулдаг, гэхдээ энэ нь хууль бус эзэмшил байдаг. Эзэмших хүсэл зориг нь заавал эрх зүйн чадамжтай байхыг шаарддаггүй, хүхүүд ч бас эзэмших эрхийг эдэлнэ. Тиймээс ч Германы ИТХ-д эзэмшил үүсэх талаарх тодорхойлолтоо заавал хүсэл зоригтой байхыг шаардаж дурдаагүй байна.

Эзэмшлийн талаарх нарийвчлалсан тодорхойлолт Германы ИТХ-д байхгүй бөгөөд тус хуулийн 854 дүгээр зүйлд "эд юмсыг бодитойгоор мэдэлдээ оруулснаар эзэмшил үүснэ" гэж заасан байдаг. Эндээс үзэхэд эзэмшил бий болгох үндсэн ойлголтдоо хууль ёсны байх асуудлыг тусгайлан тусгаагүй нь мөн харагдаж байгаа бөгөөд эзэмшлийг тогтооходоо зөвхөн эд юмсыг өөрийн мэдэлд байлгаж байгаа фактыг нотлоход хангалттай байна.¹³ Хэдийгээр хуульд нэгдсэн тодорхойлолт байхгүй ч шинжлэх ухааны тайлбаруудад "эзэмшил бол тухайн этгээдэд эзэмших эрх

байгаа эсэхээс үл хамааран эд юмсыг бодитойгоор мэдэлдээ байлгаж буй явдал юм"¹⁴ хэмээн тодорхойлсон байна. Эзэмшлийн объект нь зөвхөн эд юм байхаар төмөөлөгдсөн байна. Эд юмст амьтан ордоггүй бөгөөд зөвхөн биет эд юмсыг энд хамааруулдаг.¹⁵ Биет бус зүйлс, ялангуяа эрх эзэмших тухай ойлголт Германы ИТХ-д байхгүй. Тиймдээ ч эзэмшлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг эрх эзэмших асуудалд хэрэглэх боломжгүй байдаг.¹⁶ Үүнээс гадна бодит бус эзэмшлийн тухай асуудал Германы эд юмсын эрх зүйд яригддаг. Тодруулбал, эзэмших эрхтэй ч бодитой эзэмшил үүсээгүй байж болдог, жишээ нь өв залгамжлалтын тохиолдолд эд зүйлийг бодитойгоор өөртөө байлгахгүй ч гэсэн өв залгамжлагчид эзэмших эрх байж болдог.¹⁷

Германы ИТХ-д эзэмшлийг доорх байдлаар ангилсан байна.
Үүнд:

1. *Эд юмстай харьцах харьцаагаар нь:* Шууд (ИТХ-ийн 854 дүгээр зүйлийн 1, 2 дугаар хэсэг) ба шууд бус эзэмшил (ИТХ-ийн 868 дугаар зүйл);
2. *Эзэмшигчийн эрх бүхий байдлаар нь:* Хууль ёсны болон хууль бус эзэмшил;
3. *Эзэмшигчийн хүсэл зоригийн шинжээр нь:* Өөрийн эзэмшил ба бусдын өмнөөс эзэмших эзэмшил (ИТХ-ийн 872, 855 дугаар зүйл);
4. *Эрх хэмжээний хүрээээр нь:* Дангаар эзэмших эзэмшил болон дундаа эзэмших эзэмшил/ дундаа хэсгээр болон хамтран эзэмших эзэмшил/ (ИТХ-ийн 865, 866 дугаар зүйл);
5. *Эзэмшлийг хэрэжүүлж буй хэлбэрээр нь:* Алдаатай болон алдаагүй эзэмшил (ИТХ-ийн 858 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1)¹⁸

Тухайн эзэмшил нь ямар нэгэн эрх зүйн үндэслэл байгаа эсэхээс үл хамааран эд юмсыг бодитойгоор эзэмшиж байгаагийн хувьд хамгаалагдах ёстой байдаг.

ИТХ-ийн 885 дугаар зүйлд дурдсан эзэмшигч бус этгээд (der Besitztstener)¹⁹ бусдын нэрийн өмнөөс эд юмсыг бодит эрх мэдэлд байлгаж байдаг, өөрөөр хэлбэл үйлдвэрийн газар болон байгууллагад эд юмсыг нь хэрэглэж байгаа этгээдийг ойлгодог. Мөн уг хуулийн 856–857 дугаар зүйлд эзэмшил дуусгавар болох болон эзэмшил өв залгамжлалын журмаар шилжих тухай асуудлуудыг зохицуулсан байна.²⁰

Германы эд юмсын эрх зүй нь "эзэмшил"-ийн зохицуулалтын хүрээнд маргаантай байсан бас нэг асуудалд харин өгсөн. Энэ нь эзэмшлийн хамгаалалтыг эд юмсыг бодитойгоор эрх мэдэлдээ байлгаж буй бүх л этгээдүүд авах эрхтэй юу? гэдэг асуудал байсан. Бусдын нэрийн өмнөөс эд хөрөнгө эзэмшиж буй бүх этгээдүүд эзэмшлийн бие даасан хамгаалалтын эрх эдлэх юм бол "эзэн" нь буюу тухайн нэрийн нь өмнөөс эзэмшиж буй этгээдийн эзэмшил ямар байдалд байх вэ? Өөрийн эд зүйл дэх эзэмшлийн бүх харилцаага агдах уу? Жишээлбэл, түрээслэгчийг эзэмшигч гэж үзэх юм бол түрээслүүлэгч буюу өмчлөгч нь эд зүйлээ эзэмшихээ болино гэсэн үг үү? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирж байгаа юм. Энэ асуултын харимул нь онолын томоохон бэрхшээлийг гаргаж ирсэн бөгөөд Ромын хуульчдын үеэс нэг эд зүйл дээр, нэг цаг хугацаанд хоёр этгээдийн эзэмшил нэгэн зэрэг байх боломжгүй гэж үзэж байсан. Мэдээж хэрэг зохих хувиар нэгэн зэрэг эзэмшиж болно, харин бүхэлд нь бол боломжгүй гэсэн үзэл онол

¹² И.А.Покровский "Основные проблемы гражданского права", Москва 1998, С. 230

¹³ Гражданское и торговое право капиталистических стран, Юрид. Лит., Москва 1980

¹⁴ "Bürgerliches Gesetzbuch" Studienkommentar von Dr. Jan Kroppholler, 7. neubearb. Auflage, Verlag C.H.Beck München, 2004, Seite 808

¹⁵ Мөн тэнд, Seite 25

¹⁶ K.H.Schwab "Sachenrecht", 21 Auflage, Verlag C.H.Beck, München 1987, Seite 11

¹⁷ "Bürgerliches Gesetzbuch" Studienkommentar von Dr. Jan Kroppholler, 7. neubearb. Auflage, Verlag C.H.Beck München, 2004, Seite 808

¹⁸ "Sachenrecht" Band 3 – Allgemeine Lehren, 9. Auflage 1993, Alpmann und Schmidt Juristische Lehrgänge Verlagsges.mBH, Münster, Seite 16

¹⁹ Мөн тэнд, Seite 610

²⁰ Гражданское и торговое право капиталистических стран", Юрид. Лит., Москва 1980

байсан. Ромын хуульчдын хэлснээр нэг этгээдийн сууж байгаа газарт өөр этгээд суух боломжгүй, нэг тухай зогсож буй газарт өөр этгээд зогсох боломжгүйтэй адил хэн нэгний эзэмшил байгаа зүйл дээр өөр хүний эзэмшил зэрэг байх боломжгүй юм хэмээн зүйрлэж байв. Энэ үзлийн үүднээс авч үзвэл хэрвээ түрээслэгчийг эзэмшигч гэж хүлээн зөвшөөрсөн бол логикийн хувьд түрээслүүлэгчийн эзэмшилгүй үгүйсгэж байгаа хэрэг юм. Гэвч энэ нь амьдралын логиктой зөрчилдөж байсан юм. Түрээслүүлсэн эзэмшил газрыг нь гуравдагч этгээд хүч хэрэглэн түрэмгийлэн авсан ба түрээслэгч өөрийн эзэмшлийг хамгаалах боломжгүй буюу хүсэлгүй байвал тухайн газрын эзэн яах вэ? Тэрээр зөвхөн хохирлоо нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргана гэсэн найдлагаар өөрийгөө тайвшруулж суух ёстой юу? Харин Германы Иргэний хууль энэ асуудлыг шийдвэрлэж онолын томоохон хувьсгал хийсэн юм. Юу гэвэл нэг эд зүйл дээр, нэг цаг хугацаанд хоёр этгээдийн эзэмшил байх боломжгүй гэсэн Ромын хуучин номлолыг няцааж, өмчлөгч болон түүний нэрийн өмнөөс эзэмшиж буй этгээдийг аль алиныг нь эзэмшигч хэмээн хүлээн зөвшөөрсөн. Түрээслэгч, барьцаалагч гэх мэт нь энэ хуулийн нэр томъёоны дагуу (Германы ИТХ-ийн 868 дугаар зүйл) шууд эзэмшигч, эзнийг нь шууд бус эзэмшигч хэмээн тодорхойлсон байна. Гуравдагч этгээдийн эсрэг эзэмшлийн хамгаалалтын эрхийг юуны өмнө шууд эзэмшигч эдлэх ба хэрвээ тэрээр хамгаалах боломжгүй юм уу, хүсэлгүй байвал энэ эрхийг шууд бус эзэмшигч эдлэнэ. Хэрвээ дээрх хоёр этгээдийн хооронд зөрчил гарвал шууд эзэмшигчийн эрхийг илүүд үзнэ. Ийм маягаар

давхар эзэмшлийн онолын загвар иргэний эрх зүйн салбарт гарч ирсэн байна.²¹ Энэхүү шинэ онолын загвар нь бусад орны эрх зүйд тийм ч нийтлэгээр тусгалаа олж чадаагүй бөгөөд шүүмжлэгч олон байсан ч Германы эрх зүйд гол нь бодит эзэмшлийн ард хэн нэгэн этгээдийн эрх ашиг байдаг учраас гуравдагч этгээдийн хувьд энэ нь халдаггүй байх ёстой гэсэн үзэл баримтлалыг гол болгосон нь чухал байгаа юм.²²

Хоёр. Франц Улсын Иргэний эрх зүй болон Иргэний хууль тогтоомж дахь эзэмшлийн талаарх зохицуулалт²³

Ром-Германы эрх зүйн бүлийн гол төлөөлөгч улс болох Франц улс нь Наполеон эхийг нь бичсэн хэмээх 1804 оны Civil Code буюу Иргэний хуулиараа алдартай бөгөөд энэхүү хуулийн үзэл санааныг үр нөлөө нь өнөөгийн социал төрийн үндэс суурийг тавьсан гэж үздэг.²⁴ Францын эрх зүйн тогтолцоонд эзэмшлийн субъектив номлол гэх К.Ф. Савиньгийн номлол тусгалаа олон бөгөөд эзэмшлийг ч мөн энэхүү номлолын дагуу эзэмшигч этгээдийн хүсэл зоригоос шалтгаалан эд юмсыг бодитоор цаг алдалгүй захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлэх боломж буюу хэрэгжилт гэж тодорхойлдог. Эзэмшигчийн хүсэл зориг байгаа эсэхээс шалтгаалан эд юмсыг эзэмшиж байгаа болон түр хугацаагаар байлгаж буй эсэх нь тогтоогдог. Хэрвээ эд юмсыг өмчлөгч буюу эд хөрөнгийн эрх бүхий өөр этгээд өөрийн мэдэлд байлгах хүсэл зоригтой бол уг этгээдийг хууль ёсны эзэмшигч гэж тооцно. Харин ийм хүсэл зориг агуулаагүй буюу эд

хөрөнгийг зөвхөн бусад гуравдагч этгээдийн ашиг сонирхлын үүднээс эзэмшиж байгаа тохиолдолд энэхүү этгээдийг энгийн хадгалсан эзэмшигч, тээвэрлэгч, зуучлагч гэх зэргээр тодорхойлодог.²⁵ Энэхүү үзэл баримтлалаас үүдээд Францын Иргэний хуульд эзэмшил (possession) гэж "өмчлөгчийн хувьд өөртөө зориулж" эзэмшихийг, түр хугацаагаар өөр дээрээ байлгах (detention prusaire) гэж "хоёрдогч этгээдэд" зориулж эзэмших явдал гэж хоёр ялгаж авч үздэг байна. Түр хугацаагаар өөр дээрээ байлгахид өмчлөгчийн эд юмсыг өөрийн мэдэлд түр хугацаагаар байлгах байгаа газар түрээслэгч, хадгалагч, барьцаалагч, зузфурт эзэмшигч болон бусад бүх этгээдийг хамруулна.²⁶

Эзэмшил нь Францын Иргэний хуульд бие даасан эрх зүйн институтын утгаар зохицуулагдсан бөгөөд уг хуулийн 2279–2282 дугаар зүйлд тусгагдсан байна. Хуулин дахь эзэмшлийн талаарх тодорхойлолт нь эзэмшлийн субъектив утга санааг илүү гаргаж өгсөн бөгөөд 2282 дугаар зүйлийн дагуу эд юмсыг өмчлөгчийн хувьд, эсхүл эд хөрөнгийн эрх бүхий этгээдийн хувьд эрх мэдэлдээ байлгаж буй этгээд²⁷ гэж ойлгогдож байна. Түүнчлэн 2230 дугаар зүйлд өөр этгээдийн ашиг сонирхлын үүднээс гэдэг нь нотлогдоогүй бол хэн бүхэн яг өмчлөгчийн адил эзэмших эрхтэй эзэмшигч болон гэсэн байна. 2231 дүгээр зүйлийн дагуу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс тухайн эд зүйлийг мэдэлдээ анх олж авсан бол уг байдал өөрчлөгдсөнийг нотлох хүртэл уг этгээд "хадгалагч" байна.²⁸ Эд хөрөнгийг эзэмшигч, хадгалагч аль аль нь эрхээ хамгаалуулах эрхтэй ч хадгалагч нь

²¹ Гражданское и торговое право капиталистических стран", Юрид. Лит., Москва 1980

²² И.А. Покровский. Основные проблемы гражданского права, Москва 1958, С. 224

²³ Франц улс нь эзэмшлийн субъектив онолын болон Ром-Германы эрх зүйн бүлийн гол төлөөлөгч орон тул харьцуулсан судалгаанд сонгон оруулж байна. А.Д.

²⁴ Sonnenberger/Autelier "Einführung in das französische Recht", 3. neubearb. Auflage, 2000, Verlag Recht und Wirtschaft GmbH Heidelberg, Seite 105

²⁵ Гражданское и торговое право капиталистических стран", Юрид. Лит., Москва 1980

²⁶ Гражданское и торговое право капиталистических стран", Юрид. Лит., Москва 1980

²⁷ Sonnenberger/Autelier "Einführung in das französische Recht", 3. neubearb. Auflage, 2000, Verlag Recht und Wirtschaft GmbH Heidelberg, Seite 105

²⁸ Гражданское и торговое право капиталистических стран", Юрид. Лит., Москва 1980

уг эрхийг, өөрт нь эрх шилжүүлсэн этгээдийн эсрэг ашиглаж болохгүй (Францын ИХ-ийн 2283 дугаар зүйл). 1975 он хүртэл эд зүйл хадгалагч нь эзэмшлийг зөрсөний эсрэг бие даасан эзэмшлийн нэхэмжлэлийг гаргах эрхгүй байсан бол өнөөдөр Францын Иргэний хуулийн 2282, 2283 дугаар зүйлийн дагуу энэ эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн байна. Гэхдээ эд зүйлийг хадгалж байгаа нь эзэмшилдээ байлгасан хугацаанаас үл хамааран өмчлөх үндэслэл болохгүй.²⁹

Түүнчлэн Францын Иргэний хуульд эзэмшлийн хамгаалалтын талаар тусгасан ба 2282 дугаар зүйлийн дагуу хууль ёсны эзэмшигч болон эд юмсыг хадгалагч аль нь ч эзэмшлийн хамгаалалтын эрхийг эдлэх эрхтэй байдаг. 1975 онд эд юмсыг хадгалагчид энэхүү эрхийг олгосон явдал эзэмшлийн хамгаалалтын горимыг чангатгасан юм. Учир нь энэ үеэс эхлээд өмчлөгч болон түүний эд хөрөнгийг эзэмшиж буй этгээд зөрчил гаргагчийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхтэй болж байгаа юм. Дээрх байдал нь Франц болон Германы хууль тогтоомжийг хооронд нь улам төсөөтэй болгосон байна. Жишээ нь, Францын хууль тогтоомжийн дагуу хамгаалалтад байгаа эзэмшил нь тасралтгүй, нээлттэй, ил тод байх ёстой байдаг. Шүүх тасралтгүй гэдэгт удаан хугацааны завсарлагагүйгээр эзэмшихийг ойлгодог ба нээлттэй буюу олон нийтэд ил байдлаар эзэмших гэдэгт нууцлаг бус, эсхүл хуурамч бус байдалаар эзэмшихийг ойлгодог. Сэжигтэй буюу ойлгомжгүй байдлаар эзэмших явдлыг эзэмших эрхийн нэхэмжлэлийг тодорхой бус байдлаар гаргасантай холбож үздэг байна. Жишээ нь, хэд хэдэн этгээд эзэмшлийг хэрэгжүүлж байгаа эсхүл эзэмшлийн сэжигтэй үүсэл бүхий байдал гэх мэт. Тайван эзэмшил гэх ойлголт байх ба үүнд эзэмшлийг олж авахдаа хүч хэрэглээгүй байдлаар тогтоогдсоныг тус тус

ойлгодог байна.³⁰

Францад гурван төрлийн эзэмшлийн нэхэмжлэлийг хэрэглэдэг.

Нэгдүгээрт, эрх бүхий этгээдийн эзэмших эрхийг нь дуусгавар болгохтой холбогдолгүй боловч эзэмшлийн эсрэг гомдол бүхий хууль зүйн болон бодит үйлдэл гаргахыг зогсоох нэхэмжлэл (la complainte). Жишээ нь, тариалангийн талбайд эзэмших эрхтэй гэх этгээдийн хийж буй ажлыг зогсоох нэхэмжлэл;

Хоёрдугаарт, эзэмшилд заналхийлж буй этгээдийн үйлдлээс урьдчилан сэргийлэх санхүү буюу ирээдүйд гарч болзошгүй эерчлийн эсрэг нэхэмжлэл (la denonciation de nouvelle oeuvre). Жишээ нь, хөрс газар дээр хийгдэж буй ажил эзэмшилд ямар нэгэн хохирол учруулж болзошгүй тохиолдол;

Гуравдугаарт, хүчээр буюу хууль бусаар булаан авсан эзэмшлийг буцаан шаардах нэхэмжлэл (la reintegrande). Энэ нь эзэмших боломжийг алдагдуулсан үйлдлийг зогсоох зорилготой, алдагдсан эзэмшлийг буцааж олгоход чиглэдэг.

Гурав. ОХУ-ын Иргэний эрх зүй болон Иргэний хууль тогтоомж дахь эзэмшлийн талаарх зохицуулалт

ОХУ-ын Иргэний эрх зүйн нөлөө нь Монгол Улсын урьд өмнөх Иргэний хуулиудад харьцангуй их байсан бөгөөд энэ утгаарвай Монголын Иргэний эрх зүй судлалд ОХУ-ын иргэний эрх зүйн асуудлууд гол байр суурьтай байсан. Хэдийгээр одоогийн Монгол Улсын Иргэний хууль дахь эзэмшлийн эрх зүйн зохицуулалт нь ОХУ-аас өөр авч ОХУ-ын иргэний эрх зүй болон Иргэний хууль дахь эзэмшлийн эрх зүйн зохицуулалтын талаар судлан авч үзэх хэд хэдэн хүчин зүйл байгаа юм.

Нэгдүгээрт, ОХУ бол Монгол Улсын хил залгаа гол хөрш орны

нэг, хоёрдугаарт, Монгол Улсын 1994 оны Иргэний хууль нь Оросын Иргэний хуулиас улбаатай байсан ба одоогийн хуулинд өмнөх хуулиас илүү үр нөлөөтэй зохицуулалт бий эсэхийг судлах, гуравдугаарт, ОХУ-д эзэмшлийн эрх зүйн зохицуулалтын талаар иргэний эрх зүйчид нь сүүлийн жилүүдэд эрх шүүмжлэлтэй хандан маргаан өрнүүлж буй бөгөөд энэ талаар судлан авч үзэх нь Монголын хууль зүйн онол, практикт тодорхой хувь нэмэртэй байх юм.

Эрх зүйн бусад системээс ялгаатай нь зөвлөлтийн иргэний эрх зүйд (хувьсгалаас өмнөх Оросынхонд ч мөн адил) эд юмс эзэмших эрх зүйн систем дахь эзэмшлийн онолд анхаарлаа бага хандуулж байсан явдал юм.³¹ ОХУ-д эзэмшлийг юуны түрүүнд өмчлөх эрхийн нэг элемент болгон авч үздэг байсан ба энэ байр суурь 1994 оны Иргэний хуульд хадгалагдан үлдсэн. Өөрөөр хэлбэл, эзэмшлийг бие даасан эд юмсийн эрхийн ойлголт биш өмчийн эрхийн нэг элемент мэтээр авч үзэхээр ирсэн.³² Оросын иргэний эрх зүйн чиглэлийн онолын ихэнх ном, сурах бичигт эзэмшлийн талаар тусгайлан дурдсан нь туйлын ховор байдаг. ЗСБНХУ-ын 1922, 1964 оны Иргэний хуульд эд юмсын эрхийн хэлбэрүүдийг өмчийн эрхэд хамруулан нэг төрөл болгосон ба зөвхөн "ЗСБНХУ-ын өмчийн тухай" хуулиар эд юмсын эрхийг төрлүүдээр ялгаснаар судлаачдын анхаарлыг эзэмшлийн эрх зүйн асуудал татаж эхэлсэн байна. Энэ нь ихэвчлэн орчин үеийн Ром судлаачид болох Д.В.Дождөв, В.А.Савельева нарын бүтээлд тусгалаа олсон байдаг байна. Түүнчлэн ОХУ-ын эдийн засаг, улс төрд өөрчлөлт орж, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн явцад эзэмшлийн үүрэг нэмэгдэж буйтай холбоотойгоор иргэний эрх зүйчдийн дунд Иргэний хуулиндаа буй эзэмшлийн одоогийн зохицуулалтын талаар болон

²⁹ Мөн гэнд.

³⁰ Гражданское и торговое право капиталистических стран", Юрид. Лит., Москва 1980

³¹ Галов В. В. "Владение как элемент вещного права" Ростов-на-Дону, Донской юр-ий инс., 2000

³² Мөн гэнд.

ээзмшлийн онолын талаар ихээр мэтгэлцэж, маргах болжээ. Энэ нь ялангуяа сүүлийн жилүүдэд гаргасан хуульч судлаачдын ажлаас тод харагдаж байна. Оросын эрдэмтэн К.И.Сковский "Орчин үеийн Оросын иргэний эрх зүй нь одоохондоо эзэмшлийн бие даасан эрхийг хүлээн зөвшөөрөөгүй байна" хэмээн³³ тэмдэглэсэн бол Ю.К.Толстой "ээзмшлийг өмчлөх эрхийн нэг элемент" гэж авч үзсэн байна.³⁴

С.Н.Медведев эзэмшлийн үр дүнд өмчлөх эрхийн үр дүнтэй хамгаалалтыг бий болгож болох юм гэсэн бол, харин Г.Ф.Шершеневич "ихэнх тохиолдолд эзэмшил нь өмчлөх эрхтэй даваацагч" хэмээн тэмдэглэсэн байна. Түүхэн үүднээс авч үзвэл ЗСБНХУ-ын иргэний эрх зүйн номлол нь эзэмшлийн хамгаалалтын асуудалд шүүмжлэлтэйгээр ханддаг байсныг харуулдаг. Сүүлийн үед эзэмшлийн асуудлыг онолын шинэ түвшинд судлах шаардлагатай болсныг Оросын эрдэмтэн түлхүү шүүмжлэн хэлэлцэх болсон байна. Тухайлбал, С.Н.Медведев "ОХУ-ын Иргэний хуульд эзэмшлийн асуудал хөөрхийлөлтэй байдал байна" гэж тэмдэглэсэн байна.³⁵ ОХУ-ын хуульчдын дунд мөн эзэмшил хууль ёсны ба хууль бус байдаг тал дээр маргаантай байгаа юм. Түүнчлэн орчин үеийн иргэний эрх зүйд эзэмшил нь өөрийнхөө эсвэл бусдын нэрийн өмнөөс байх эсэхээс үл хамааран бие даасан хамгаалалт авах эрхтэй байхад, харин ОХУ-ын иргэний хуулиар "өөрийнхөө ашиг сонирхлын тулд эд хөрөнгийг эзэмших хүсэл зориг" байх ёстой гэсэн урьдчилсан нөхцөл хэвээр хадгалагдсаар байна.

ОХУ-ын Иргэний хуульд эзэмшлийн бие даасан институт гэж байхгүй. Хуулийн дагуу эзэмшлийн эрх нь өөр олон төрлийн эрх зүйн

институтын нэг элемент болж явдаг. Жишээлбэл, өмчлөгчийн эзэмшил нь түүнд харьяалагдах өмчийн эрхэд тулгуурлана, харин эзэмших эрх нь өмчлөгчийн эрхийг бүрдүүлнэ. Мөн түүнчлэн ОХУ-ын Иргэний хуулийн 301–304 дүгээр зүйлээр өмчлөгч болон өмчлөгч бус эзэмшигчдэд эд хөрөнгийн эрхийн хамгаалалт олгосон байдаг байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчийн шаардлага гэрээ болон бусад үүргийн харьцаанаас бус өмчлөгч болон нэрлэгдсэн эзэмшлийн зөрчилдөөн эрхээс шууд хүмслэлтэй үед эд хөрөнгийн эрхийн хамгаалалт олгосон байдгийг хэлж байгаа юм. ОХУ-ын Иргэний хуулийн 305 дугаар зүйлийн дагуу эд хөрөнгийг хууль эсхүл гэрээний үндсэн дээр өмчлөгч бус эзэмшигч этгээд нь өмчийн эрхийн эрх зүйн хамгаалалтын эрхийг эдлэх боломжтой байдаг.³⁶ Түүнчлэн ОХУ-ын хуульчид өнөөгийн шүүхийн процесс эзэмшлийн зөрчлийг арилгах, хохиролчийн иргэний болон эд хөрөнгийн эрхийг хангахгүй байна гэж шүүмжилдэг байна. Орчин үеийн ОХУ-ын иргэний эрх зүйд "argumentum a contrario" аргаар гэрээний үндсэн дээр бий болсон эзэмшлийн хоёр төрлийн эзэмшигчийг онцолж авч үзсэн байна. Эхнийх нь өөрийн өмч шиг эд зүйлийг ашиглах, хоёр дахь нь бусдын ашиг сонирхлын үүднээс эзэмших, эсвэл бусдын өмчийг өөрийн юм шиг ашиглаж байгаа этгээд байна.³⁷ Түүнчлэн хууль ёсны эзэмшлийн асуудлыг харьцангуй тодорхой болгохын тулд ОХУ-ын Арбитрын дээд шүүхээс 1998 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа "Өмчийн эрхийг болон бусад эд зүйлийн эрхийг хамгаалах маргааныг шийдвэрлэх практикийн зарим асуудал" сэдвээр шийдвэр гаргасан байна.³⁸

Дөрөв. Япон Улсын Иргэний эрх зүй болон Иргэний хууль тогтоомж дахь эзэмшлийн талаарх зохицуулалт

Энэхүү судалгааны ажилд Азийн төлөөлөл болгон Японы улсыг сонгохдоо тус улс нь иргэний хууль тогтоомжоо боловсруулахдаа Германы ИТХ-ийг түлхүү анхаарч үзсэн байдлыг нь харгалзсан юм. Японы улсын Иргэний эрх зүйн гол эх сурвалж нь иргэний хууль тогтоомж болон зан заншлын хэм хэмжээ байдаг.³⁹

Японы Иргэний хууль нь 1896 болон 1898 онд батлагдсан бөгөөд гол нь Германы ИТХ-ийг үндэс болгосон байдаг. Тодруулбал, Япон улс нь 1800-аад оны сүүлээр реформ хийж, ардчил, зах зээлийн эдийн засаг бүхий нийгмийн тогтолцоонд шилжихдээ Германы Иргэний хуулийг иргэний эрх зүйн хүрээнийхээ гол загвар болгон авсан бөгөөд өөрийн орны нөхцөлд тааруулан тун зохистой байдлаар орчуулан буулгаж, одоогийн Иргэний хуулийнхаа үндсийг боловсруулсан байна. Түүнчлэн 1990-ээд оны ОХУ-ын реформд Японы зүгээс энэ практикаа зөвлөн Германы, эсхүл Францын Иргэний хуулийг загвар болгон авахыг санал болгож байжээ. Японы зүгээс иргэний болоод худалдааны эрх зүйн шинэчлэлдээ Өмнөд Азийн болон Зүүн Европын хуучин социалист орнууд, Хятад, Герман зэрэг улсын эрх зүйн зохицуулалтыг судалж үзээд Германы ИТХ-ийг загвар болгон авсан байна. Герман, Япон хоёрын дайны дараах эдийн засгийн болоод бусад нөхцөл байдалд нэлээдгүй нийтлэг зүйл байсан нь ч үүнд нөлөөлсөн.⁴⁰ Энэ утгаараа эхэндээ Японы Иргэний хуулиаг Германы ИТХ-ийн хуулбар гэдэг байсан ч сүүлийн жилүүдэд японы хуульчид үүнийг үгүйсгэн тайлбарлах болсон. Учир нь тэд

³³ К.И.Сковский "Собственность в гражданском праве", Москва, 1999, С.292

³⁴ "Гражданское право", Часть 1, Издание 2., под Ред. А.П.Сергеева, Ю.К.Толстого, Москва 1997, 326 дахь тал

³⁵ Галов В. В. "Владение как элемент вещного права" Ростов-на-Дону, Донской юр-ий инс., 2000

³⁶ "Защита прав владельца, не являющегося собственником" www.lawref.ru - для заказа - office@lawref.ru

³⁷ Галов В. В. "Владение как элемент вещного права" Ростов-на-Дону, Донской юр-ий инс., 2000

³⁸ Мөн тэд.

³⁹ Kiyoshi Igarashi "Einführung in das japanische Recht", mit Beitrag von Tadao Makino, Wissenschaftliche Buchgesellschaft, Darmstadt 1990, Seite 53

⁴⁰ Henrik Schmiegelow "Why legal transformation assistance from Germany and Japan to former East-block countries?", Abhandlungen/Articles, p. 5–38

Иргэний хуулиа өөрийн орны нөхцөлд нийцүүлж өөрчлөөр ирсэн төдийгүй, шүүхийн практикийн нөлөөг маву тусгах болсноор англо-саксоны эрх зүйн бүлгийн үр нөлөө илүү тусгагдах болсон гэж үзэх буй.⁴¹

Японы ИТХ нь өрөмжй анги, эд юмсын, үүргийн, гэр бүлийн болон өв залгамжлалын эрх зүй гэсэн 5 дэвтэртэй бөгөөд эзэмшлийн асуудлыг эд юмсын эрх зүйн хоёрдугаар дэвтэртээ зохицуулсан байдаг. Уг дэвтэрт 2 дахь бүлэгт эзэмшлийн талаар "Эзэмших эрх" гэсэн нэртэйгээр 180-205 дугаар зүйлийн хүрээнд зохицуулжээ.⁴² Энд 1 дэх хэсэг буюу 180-187 дугаар зүйлд эзэмших эрх үүсэх, 2 дахь хэсэг болох 188-202 дугаар зүйлд эзэмших эрх үүссэнээр бий болох үр дагавар, 3 дахь хэсгийн 203-204 дүгээр зүйлд эзэмших эрх дуусгавар болох, 4 дэх хэсгийн 205 дугаар зүйлд квази⁴³ эзэмшлийн талаар тус тус зохицуулсан байна.⁴⁴

Японы иргэний эрх зүйд эзэмших эрх гэсэн нэр томъёог хэрэглэсэн бөгөөд эзэмших эрхийн тухай, эзэмшил үүсэх болон эзэмшлийн хамгаалалтын талаар түлхүү авч үзсэн байна. Эзэмших эрх үүсэхэд эд юмсыг бодитойгоор мэдэлдээ олж авах болон эд юмсыг өөртөө олж авах хүсэл зориг хангагдсан байх ёстой (ИТХ-ийн 180 дугаар зүйл). Гэхдээ Японы иргэний эрх зүйд Германы нэгэн адилгаар хүсэл зоригийн хүчин зүйлийг багасгахыг эрмэлзэж байгаа юм. Эзэмшил нь төлөвлөгчөөр (ИТХ-ийн 181 дүгээр

зүйл) дамжин илэрч болох бөгөөд үүгээрээ шууд болон шууд бус эзэмшлийг ялган авч үзсэн.⁴⁵

ИТХ-ийн 182 дугаар зүйлд эд юмсыг хүлээлгэн өгснөөр эзэмших эрх үүсч болохыг, мөн хүсэл зоригийн илэрхийлэл байхгүй ч эзэмших эрх шилжиж болохыг заасан байна. Уг хуулийн 184 дүгээр зүйлд зааврын дагуу эзэмших эрх шилжиж болохыг, 186 дугаар зүйлд эд юмсыг хүсэл зоригийн дагуу, шударгаар, саадгүй, нээлттэй эзэмшиж буй этгээдийг эзэмшигч хэмаан тооцохыг тус тус заасан.⁴⁶ Мөн түүнчлэн 188 дугаар зүйлд эзэмших эрх бүхий этгээд нь хууль ёсны үндсэн дээр эзэмших ёстой болон үүнээс улбаалан шударга болон шударга бус эзэмшигч байх тухай зохицуулсан байна.⁴⁷ Гэхдээ шударга болон шударга бус эзэмшигчийн нарийн тодорхойлолтыг өгөөгүй байна. 191 дүгээр зүйлд эзэмшигчийн хариуцлагын тухай, 192 дугаар зүйлд эзэмших эрхийг шударгаар олж авах тухай, 193 дугаар зүйлд хулгайлагдсан болон алдагдсан эд юмсыг буцаан шаардах, 195 дугаар зүйлд амьтныг олж авах, 176 дугаар зүйлд эзэмшигчийн шаардлага, 197 дугаар зүйлд эзэмшлийн нэхэмжлэл, 199-202 дугаар зүйлд эзэмшлийн талаар хэрэгжүүлэх нэхэмжлэл зэргийг зохицуулсан байна.⁴⁸

Японы иргэний эрх зүйн үүднээс эзэмших эрхийг шилжүүлэх хоёр үндэслэл байна. Үүнд:

1. Тухайн эд зүйлийг бодитойгоор эзэмшилд шилжүүлснээр,

2. Тухайн эд зүйлийг шилжүүлэгч өөсөө түүний төлөөлөгч нь эд зүйлийг эзэмшин байх үедээ хүсэл зоригөө илэрхийлснээр эзэмших эрх шилжүүлэх тухай хэлцэн хүчин төгөлдөр болно.

Эзэмшлийн хамгаалалттай холбоотой эзэмшлийг баталгах, хамгаалах, буцаан шаардах эрхүүдийг тусгажээ. Тухайлбал, эзэмшлийг баталгах шаардлагын дагуу эзэмшигч эзэмших эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулбал тэрээр түүнийг таслан зогсоох, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх шаардлагыг гаргаж болно. Энэ үйлдлийг саад учруулж буй үйлдэл үргэлжилж байх явцад, эсхүл тэрхүү үйлдэл зогсооноос хойш нэг жилийн дотор гаргаж болно. Эзэмшигчийн эзэмших эрхээ хэрэгжүүлэхэд саад учирч болох нөхцөл бийдэл үүсвэл, тэрээр тэрхүү саад тогтоороо урьдчилан хамгаалуулах буюу учирч болох хохирлоо сэргийлүүлэхээр эзэмших эрхээ хамгаалах шаардлагыг хэрэгжүүлж болно. Энэ шаардлагыг саад учирч болзошгүй учир байгаа үед хэрэгжүүлнэ. Эзэмшигч нь эзэмшил алдсан бол эд зүйлийг буцаан шаардах, түүнчлэн учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах тохиолдолд эзэмшлийг буцаан шаардах шаардлагыг хэрэгжүүлж болно. Энэ шаардлагыг шударга бус эзэмшил үүссэнээс хойш нэг жилийн дотор хэрэгжүүлнэ.



⁴¹ Kiyoshi Igarashi "Einführung in das japanische Recht", mit Beitrag von Tadeo Makino, Wissenschaftliche Buchgesellschaft, Darmstadt 1980.

⁴² Vermögensrecht des ZGB Japans "Allgemeiner Teil, Sachenrecht und Schuldsrecht" Übersetzung von Shiori Tanura (Stand Juni 2006), copyright 2007.

Seite 39 - 43

⁴³ Бэргэр гэстэй.

⁴⁴ Vermögensrecht des ZGB Japans "Allgemeiner Teil, Sachenrecht und Schuldsrecht" bbersetzung von Shiori Tanura (Stand Juni 2006), copyright 2007.

Seite 39 - 43.

⁴⁵ Kiyoshi Igarashi "Einführung in das japanische Recht", mit Beitrag von Tadeo Makino, Wissenschaftliche Buchgesellschaft, Darmstadt 1980, Seite 76

⁴⁶ Vermögensrecht des ZGB Japans "Allgemeiner Teil, Sachenrecht und Schuldsrecht" Übersetzung von Shiori Tanura (Stand Juni 2006), copyright 2007.

Seite 39

⁴⁷ Мөн төгөд.

⁴⁸ Мөн төгөд.

Ийнхүү мужуудын түвшинд эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэргийн тухай ойлголтдоо хуулиар тогтоосон эрх зүйн хэм хэмжээг зөрсөн үйлдэл, ял шийтгэлийн тодорхой төрлийг хэрэглэх боломж зэргийг тусган бэхжүүлэх хандлага ажиглагдаж байна. Мөн түүний зэрэгцээ зарим мужид гэмт хэргийн тухай ойлголтыг Холбооны улсын хууль тогтоомжид зааснаар тодорхойлсон байдаг.

Жишээ нь, Флорида мужийн эрүүгийн хуулийн 775.01-д зааснаар, эрүүгийн эрх зүйн ерөнхий хэм хэмжээ ямар нэгэн өөрчлөлтгүйгээр үйлчилдэг.

АНУ-ын Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн ангилалд өөр өөрөөр хандсан байдаг бөгөөд энэ нь юуны өмнө муж улсуудын эрүүгийн хууль тогтоомжоос хамааралтай байна. Ихэнх тохиолдолд нийгмийн хор аюулын хэмжээ, ялын шинж чанараас шалтгаалан гэмт хэргийг фелони /хүнд гэмт хэрэг/, мисдиминор /хөнгөн гэмт хэрэг/ гэж ангилжээ. Зарим үед фелони, мисдиминор нь дотроо хэд хэд ангилгдах тохиолдол байдаг.

АНУ-ын Эрүүгийн эрх зүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх урьдчилсан нөхцөл нь Английнхтай адил actus reus /гэм буруутай үйлдэл/ болон mens rea /гэм буруу/ байдаг. Нилээд өргөн дэлгэр тархсан номлолоор mens rea буюу гэм буруу нь actus reus буюу материаллаг элементийг үргэлж дагалдаж байдаг ба гэмт хэрэг бүрийн тухайд тогтоох шаардлагатай сэтгэхүйн элемент юм.³

Хэрэв АНУ-ын номлолоор хүсэл зоригийн үйлдэл ба түүний үр дүн нь actus reus буюу үндсэн бүрэлдэхүүнээр тооцогдож байгаа бол mens rea-ийн талаарх онолын ойлголт нь Америкийн эрүүгийн эрх зүйд ширүүн маргаан өрнүүлсээр байна.⁴

АНУ-ын Эрүүгийн эрх зүйн

номлолд гэмт хэргийн шалтгаант холбооны тухай асуудал нилээд маргаантай асуудалд хамаарна.

Шалтгаант холбоог *sine qua non* буюу "хэрвээ үйлдээгүй бол" гэсэн дүрмээр тодорхойлох хүрээнд авч үзэж шалтгааны "харьцангуй альтернатив", "шууд" шалтгааны концепцийг дэвшүүлсэн байна. Эс үйлдэхүйн үеийн учир шалтгаан, шалтгаант холбооны үе дэх эрсдлийн асуудал зэрэг нь онцгой анхаарал татаж байна.⁵

АНУ-ын хэд хэдэн муж улсын эрүүгийн хуульд *actus reus* /нийгэмд аюултай үйлдэл/ болон *mens rea* /гэм буруу/-ийн элементүүд нь гэм буруугийн тухай хэм хэмжээ болон тусгагдсан байна. Жишээлбэл, Пенсильвани мужийн Эрүүгийн хуулийн 301 дүгээр зүйлд: "сайн дурын үйлдлийн шаардлагын" талаар заасан байдаг. Тухайлбал, хэрэв тухайн этгээд гэмт хэрэг үйлдэх боломж чадвартай байсан боловч гэмт хэрэг үйлдээгүй эсвэл гэмт зан үйл нь тухайн этгээдийн санаатай үйлдэлд үндэслэгдээгүй байвал гэм буруугүй гэж тооцно гэжээ. Энэ хуулийн 302 дугаар зүйлд гэм буруугийн хамгийн наад захын шаардлагыг заахдаа гэмт хэргийн бүрэлдэхүүний материаллаг элемент /*actus reus*/ болон гэм буруугийн санаатай байдал, гэм буруугаа ухамсарласан байдал, хөнгөмсгөөр найдах, хайхрамж болгоомжгүй хандах /*mens rea*/ зэргийг тогтоох шаардлагатай заажээ.

АНУ-ын хууль тогтоомжид гэм буруугийн хэлбэрийг тодорхойлсон хэм хэмжээг зааж өгсөн байдаг. Жишээлбэл, Пенсильвани муж улсын эрүүгийн хуульд дараах байдлаар тодорхойлж өгсөн. Үүнд:

1. Гэмт хэргийн материаллаг элемент болох нийгэмд аюултай үйлдлийн санаатай хэлбэрийг тооцох нөхцөл:

a. өөрийн гэмт зан үйлийн

нийгэмд аюултай шинж чанар болон түүнээс үүсэх хор уршгийг урьдас ухамсарлан ойлгосон байх;

b. өөрийн үйлдлийн улмаас гарах үр дагаварыг ухамсарласан эсвэл тийм нөхцөл байдлыг үүсч болохыг урьдчилан харсан эсвэл найдсан байх.

2. Гэмт хэргийн материаллаг элементийн талаар ухамсарласан байдал гэж үзэх нөхцөл:

a. гэмт этгээд хориотой зан үйлийг хийж байгаагаар ухамсарласан эсвэл түүний улмаас үүсч болох хор уршгийг ухамсарласан байх;

b. гэмт этгээд өөрийн үйлдлээрээ материаллаг элементээр урьдчилан заасан хор уршигт хүргэж болох магадлалтай ухамсарласан байх;

Гэмт хэргийн материаллаг элементийн талаар хөнгөмсгөөр найдах гэж гэмт этгээд өөрийн буруу үйлдлээрээ нийгэмд аюултай хор уршигт хүргэж болохыг урьдас мэдсэн боловч үл тоомсорлосноос эрсдэлд хүргэснийг тооцно.

Гэмт хэргийн материаллаг элементийн талаар хайхрамж болгоомжгүй хандсан байдал гэж гэмт этгээд хор уршиг байгаа болон түүнд хүргэхийг ухамсарласан байхыг хэлнэ, гэжээ.

АНУ-ын Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн сэдэл, зорилгын асуудлыг эцэслэн шийвэрлээгүй гэж болно. Судлаач Э.Денжел гэмт хэргийн сэдэл, зорилго гэсэн нэр томьёо нь өдөр тутам адил утгаар хэрэглэгддэг эрх зүйн талаасаа ялгаатай. Сэдэл нь зорилгоо хэрэгжүүлэхэд хүргэдэг боловч зорилго биш юм. Сэдэл нь гэмт үйлдлийн өмнө үүсдэг бол зорилго нь түүнийг дагалддаг. Сэдэл нь гэмт зан үйлийг өдөөж, хүссэн үр дүнд хүрэхээс аргагүйд хүргэдэг. Ихэнх судлаач нэг ойлголтдоо хүрэхийн тулд гэмт хэргийн сэдлийг янз бүр байдгийг хүлээн зөвшөөрч түүний эрүүгийн эрх зүйн ач холбогдлыг

³ Perkins R. Criminal law New York. 1969. P 9-10

⁴ Еськов Г. А. Mens rea в уголовном праве Соединенных Штатов Америки СПб. 2003. С 335-390

⁵ Fleicher G. Rethinking Criminal Law. Boston. 1978. Chs 6-7

гэмт этгээдийн эрмэлзсэн "ойрын" болон "эцсийн" үр дүнтэй холбож авч үздэг.

АНУ-ын Эрүүгийн эрх зүйд зарим тохиолдолд гэм буруугүйгээр үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг "туйлын" хариуцлагын зарчим гэж байдаг. Энэхүү "туйлын" хариуцлага нь объектив хэрэг хүлээх чадвараар илэрдэг.

Жишээ нь: үйлдвэрийн эзэд өөрийн ажилчин, албан хаагчдынхаа үйлдсэн гэмт хэргийн өмнөөс гэм бурууг нь хүлээснээр "туйлыг" хариуцлагын зарчим үйлчилдэг байна.

АНУ-ын Эрүүгийн хуульд зарим төрлийн гэмт хэрэгт 7 нас хүрсэн этгээдэд, түүнээс бусад бүх төрлийн гэмт хэрэгт 14 нас хүрсэн этгээдэд тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг заасан байгаа. Гэхдээ зарим муж улсын эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны доод хязгаарыг Луизиана мужид 10 нас, Иллиноис мужид 13 нас, Миннесота мужид 14 нас, Техас мужид 15 нас, Нью-Йорк мужид 16 наснаас тооцооор заасан байна. Субъектын зайлшгүй баримтлах шинж нь хэрэг хариуцах чадвар юм. АНУ-ын Эрүүгийн эрх зүй нь Английнхтай адилгаар хуулинд заасан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд эрүүгийн хариуцлага хүлээнэ. Харин хэрэг хариуцах чадваргүй байдлыг Макнотенгийн дүрмээр тодорхойлно. Зарим муж улс энэ дүрэмд irresistible impulse номлолын дагуу нэмэлт оруулан мөрддөг.⁶

АНУ-ын Эрүүгийн эрх зүй нь гэмт хэргийн субъект нь хуулийн этгээд байхыг хүлээн зөвшөөрсөн уламжлалд үндэслэгдсэн байдаг. АНУ-ын хуулиудын 18 дугаар эмхэтгэлийн 18 дугаар бүлэгт хамгийн ерөнхий байдлаар "байгууллага" гэсэн нэр томъёонд хувь хүнээс бусад этгээдийг хамааруулан үзнэ, гэжээ. Муж улсуудын эрүүгийн хуульд гэмт

хэргийн субъект болох хуулийн этгээдийн төрөл, тэдгээрийн хариуцлага хүлээх зааг, шатлалыг тогтооход онцгой анхаарсан байдаг. Тухайлбал, Нью-Йорк мужийн эрүүгийн хуулийн 60.25 дугаар зүйл, Пенсильвани мужийн эрүүгийн хуулийн 307 дугаар зүйлийг дурдаж болно.

АНУ-д хуулийн этгээдэд гол төлөв эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, байгаль орчны эсрэг гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Гэм хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын талаар:

АНУ-ын эрүүгийн хуулиар эдгээр нөхцөл байдалд аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, тушаал, захирамж биелүүлэх зэргийг хамааруулсан байдаг. Аргагүй хамгаалалтын институт нь өөрийгөө хамгаалах, өөр этгээдийг хамгаалах, эд хөрөнгөө хамгаалах гэсэн 3 төрлийн хамгаалалтаас бүрдэнэ.

АНУ-д аргагүй хамгаалалтын тухай асуудлыг хувийн ашиг, сонирхлоо хамгаалахын тулд биеийн хүч хэрэглэхийг хууль ёсны асуудлын хүрээнд авч үздэг. Америкийн хууль тогтоогчид аргагүй хамгаалалтын хууль ёсны байх нөхцөлийг тодорхойлохдоо хамгаалах зорилгоор биеийн хүч хэрэглэх хэмжээ, хязгаарыг нарийвчлан тогтооход онцгой анхаарал хандуулсан.

АНУ-ын эрүүгийн эрх зүйн онол, шүүхийн практикт аргагүй хамгаалалтын улмаас хийсэн үйлдэл нь хууль ёсны байх талаар үнэнцэл, дүгнэлт өгөхөд дараах асуудалд анхаардаг. Үүнд:

- Халдлагын үед довтолгчийн амь насанд гэм хор учруулах хүч хэрэглэхээс өөр аргагүй байсан эсэх;
- Хамгаалах үйлдэл хийж буй этгээд нь биеийн хүч хэрэглэхээ ухамсарласан байх;
- Халдлага нь үнэхээр бодьтой

заналхийлж байсан эсэх.

Хуулиар халдлагын нийгмийн хор аюулын хэр хэмжээтэй хамгаалалтын шинж чанар тохирсон байх хэмжээ, хязгаарыг тодорхойлж өгсөн байдаг. Жишээ нь, Нью-Йорк мужийн эрүүгийн хуулийн 35.15 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт хамгаалалт хийж буй этгээд өөрийн оюун ухаандаа найдж байгаа доорх тохиолдолд бусдын амь насанд гэм хор учруулах, хүч хэрэглэхийг зөвшөөрсөн байдаг.

- халдлага үйлдэгчээс амь насанд гэм хор учруулах хүч хэрэглэж байгаа, эсвэл хэрэглэж эхлэж байгаа;
- хүнийг хулгайлах, хүчиндэх, дээрэмдэх гэмт хэргийг үйлдэхээр завдсан, эсвэл үйлдэж байгаа;
- эд зүйлийг хулгайлахаар орон сууцыг эвдэх /барглар/ гэмт хэрэг үйлдэхийг завдсан эсвэл үйлдэж байгаа;
- галдан шатаах гэмт хэргийг үйлдэхээр завдсан, эсвэл үйлдэж байгаа.

АНУ-ын хууль тогтоомжийн зарим хэм хэмжээ нь орон сууц, өмчөө хамгаалах зорилгоор биеийн хүч хэрэглэх нөхцөлийг зааж өгсөн байдаг. Нью-Йорк мужийн эрүүгийн хуулийн 35.20 дугаар зүйлд үл хөдлөх хөрөнгөө хамгаалах зорилгоор хууль ёсны дагуу хүч хэрэглэх хязгаарыг тодорхойлсон. Тухайлбал, аливаа этгээд ямар нэг үл хөдлөх хөрөнгө, орон байранд нь гэм хор учруулах гэмт хэргийг үйлдэх, үйлдэхийг завдаж буйг ухамсарлан тухайн аюулыг зайлуулах, таслан зогсоохын тулд довтолгоо этгээдэд биеийн хүчийг хэрэглэж болно гэжээ. Мөн галдан шатаах гэмт үйлдлийг таслан зогсоох, аюулыг зайлуулахын тулд довтолгоо этгээдийн амь насанд гэм хор учруулахууц биеийн хүчийг ашиглаж болно гэжээ.

Харин хөдлөх хөрөнгийг хамгаалах зааг хязгаарыг

⁶ Ferguson R.W. Readings on Concepts of Criminal Law. Minneapolis-ST. Paul, 1975. P.543

тогтоохдоо Нью-Йорк мужийн эрүүгийн хуулийн 35.25 дугаар зүйлд дараах байдлаар оруулсан: "Аливаа үл хөдлөх хөрөнгө, орон байрнаас бусад эд хөрөнгөд хуулиар шийтгэгдэхээр заасан хохирол учруулах эсвэл хулгайлах гэмт хэрэг үйлдэж буй, үйлдэхийг завдаж буйг ухамсарлан гэмт хэргийг таслан зогсоож, хор аюулыг зайлуулах зорилгоор, довтлогч этгээдийн амь насанд гэм хор учруулахгүйгээр биеийн хүч хэрэглэж болно" гэжээ.

АНУ-ын Эрүүгийн эрх зүйн гарцаагүй байдлын номлол нь үндсэндээ аюул заналхийллийн тухайн субъектын өөрийнх нь санаа бодолд үндэслэсэн байдаг.

Гарцаагүй байдлын үед бусдад

гэм хор учруулах үндэслэл нь нийтийн эрх ашгийг хамгаалахад үндэслэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тулгарсан аюулыг зайлуулахаар бусдын илүү чухал эрх ашгийг хамгаалахын тулд хэн нэгний хуулиар хамгаалагдсан эрх ашгийг зөрчдөг, "Нийтийн эрх ашгийн үүднээс галыг унтрааж аюулыг зайлуулахын тулд бусдын байшинд нэвтрэн орох нь зөв. Нийтийн сайн сайхны төлөө хийсэн үйлдэл нь түүнээс чухал бус эрх ашгийг зөрчихийг зөвтгөж байдаг"⁷

АНУ-ын эрүүгийн загвар хуулийн 3.02 дугаар зүйлд гарцаагүй байдлын үед хийгдэх ажиллагаа хууль ёсны байх нөхцөлүүдийг зааж өгсөн:

- өөрт болон бусдад бодитой

аюул тулгарсан байх;

• тулгарсан аюулын хэр хэмжээ нь гарцаагүй байдалд хийгдэх ажиллагааны улмаас учруулах хохирлоос их байх;

• эрүүгийн хууль дахь тодорхой нөхцөл байдалтай холбоотой хамгаалалтад хориг тавихгүй;

• хууль тогтоогчид өгөгдсөн нөхцөл байдалд үүсэх хамгаалалтаас өөр хэлбэрээр татгалзлаа илэрхийлэхгүй гэжээ.

Хэрэв тухайн этгээд хөнгөн хуумгай, хайхрамжгүй хандсанаас гарцаагүй байдал үүссэн бол гарцаагүй байдалд тооцохгүй бөгөөд гэм буруугийн санамсар болгоомжгүйн хэлбэрээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.



⁷ Флетчер Дж., Наумов А.В. Основные концепции современного уголовного права. М. 198. С 352

ГАДААД ОРНУУД ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудал хөгжингүй улс орнуудад төдийлэн хурц тавигддаггүй байхад хөгжиж буй орнуудад тухайн асуудлыг нухацтай авч үздэг байна. Хөгжингүй эдийн засагтай улс орон ихэнхдээ гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах салбар тусгайлсан эрх зүйн тогтолцоо байдаггүй байна. Тэдгээр улсад хөрөнгө оруулалтын хангалттай дотоод эх үүсвэртэй байдаг.

Хөрөнгө оруулалтын харилцаанд, тэр дундаа гадаадын хөрөнгө оруулалтын асуудалд онцгой байр суурийг төр эзэлдэг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон ашиглах асуудлыг төрөөс тогтоосон эрх зүйн актаар зохицуулна. Татварын тогтолцоо, хөнгөлөлт, чөлөөлөлтийн систем болон зээлийн аргаар төр гадаад хөрөнгө оруулалтыг татах нэгэн хөшүүргийг бий болгодог. Гадаадын хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудал, татварын тогтолцоо, эрх зүйн бусад холбогдолтой зохицуулалтыг улс орон бүхэн өөрийн онцлогийг харгалзан өөр өөр шийдвэрлэдэг.

Энэхүү судлагааны ажлын хүрээнд Бразиль улс, БНХАУ болон Японы гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт мөн төлөв байдлын талаар авч үзлээ.

Эдгээр улсын хувьд харьцангуй тогтвортой бус, буурай эдийн засагтай, гадаадын хөрөнгө оруулалт төдийлэн хөгжөөгүй эзрэг нийтлэг байдалтай байсан ба зөв зохистой эрх зүй, улс төрийн бодлого, өөрийн орны онцлогт тохирсон уян хатан системийг бүрдүүснээр өнөөгийн нийгэмд хөгжил өндөртэй, баялаг орон болж чадсан юм.

Товчлон дурдвал, Бразиль улсын хувьд байгалийн баялаг нөөцөө ашиглан эдийн засгаа хөгжүүлэх нэгэн хөшүүрэг болгохын



ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан
Ж.СОЕЛМАА

тулд гадаадын хөрөнгө оруулалтын уян хатан эрх зүйн зохицуулалтыг бий болгож амжилтад хүрсэн юм.

Харин БНХАУ-ын хувьд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах бодлогыг хэрэгжүүлж эхэлснээс хойш гадаадын хөрөнгө оруулалт эрчимтэй нэмэгдсэн юм. Уран улс нь дэлхийн II дайны дараа маш буурай, хөгжил багатай улсаас дэвшилтэт техник технологи ашиглаж, мэргэшсэн боловсон хүчнээ бэлтгэж, үүгээрээ гадаадын хөрөнгө оруулагч нарыг татаж чадсан юм.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, эрх зүйн зохицуулалтыг зөв зохистой хийхэд дээрх орнууд нь өөр өөр аргууд ашигласан байна.

БРАЗИЛЬ УЛС

Латин Америкийн улс орнууд аль хэдийнээ гадны хөрөнгө оруулалтын "бус" болсон. Бразиль улс маш их баялаг байгалийн нөөц, харьцангуй хямд ажлын хүч, дотоод зах зээлийн хэмжээгээрээ гадаад хөрөнгө оруулагч нарыг татдаг байна. Гэвч Бразиль улс асар их газар ашиглах, хувийн үйлдвэрлэлийн баазыг байгуулахын

тулд, Бразилийн бүх бүс нутгийг жигд хөгжүүлэх зэрэг асуудлаас улбаалан өнөө хүртэл гадаадын хөрөнгө оруулалт шаардагдаж байгаа.

Тухайн улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах объектив шалтгаан байсан учир тодорхой эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байв. 1945 онд гадаад хөрөнгө оруулалтыг дотоодтой ижил түвшинд эн тэнцүүлж, орлого болон ашгийн шилжүүлгийн хязгааргүй бодомжуудыг олгосон эрх зүйн актуудыг баталсан юм. Бразиль улсын болон гадаад хөрөнгө оруулагч нарын хөрөнгө, удирдах ба зохион байгуулах туршлага зэргийг ашиглан дээрх актууд нь гадаад хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтаас хурдан ашиг олж, анх оруулсан хөрөнгө буцаан авах бодомжуудыг бүрдүүлж байсан юм. Дээрх хийгдсэн арга хэмжээ нь гадны хөрөнгө оруулагч нарыг их хэмжээгээр татаж эхэлсэн юм (ялангуяа АНУ-ын хөрөнгө оруулалт). Мөн дэлхийн II дайны төгсгөлд гадны хөрөнгө оруулагч нарыг бүр ихээр татаж эхэлжээ.

1962 онд гадаадын хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагааг зохицуулсан шинэ хууль батлагдсан билээ. Уг хуулийн дагуу гадаад хөрөнгө оруулалтыг тодорхойлж, уг ойлголтод эдийн засгийн үйл ажиллагаанд ашиглахаар улс руу оруулж ирсэн бүх мөнгө болон бусад материаллаг үнэт зүйлсийг багтаасан тайлбар өгсөн байна. Гадаадын хөрөнгө оруулалтын зайлшгүй шаардлага нь эдгээр нь гадаадын хуулийн этгээд болон иргэний хөрөнгө байх ёстой хэмээн хуульчилсан байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах эрх зүйн зохицуулалтын дагуу гадаадын хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагааг "Мөнгөн хөрөнгийг хянах алба" хариуцах ба гадаад хөрөнгө оруулагч нар

талуудын эрх, үүргийг зохицуулсан тусгай хэлэлцээр байгуулах ёстой байна.

Бразил улсын гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу гадаадын хөрөнгө оруулагч нь тухайн улсын шаардагдах бүх татварыг төлсөн тухай бичгийг мэдүүлсэнээс хойш л өөрийн орсон орлогоо гадагшаа шилжүүлж болно. Мөн жилд шилжүүлэх орлогын хэмжээ анхдагч оруулсан хөрөнгийн 12 хувиас хэтэрч болохгүй буюу хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдэл татвар ногдуулдаг. Орлого шилжүүлэх дүрмийг зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулах буюу эрүүгийн хариуцлагад татах болсон байна.

Мөнгөн хөрөнгө шилжүүлэхэд эдийн засгийн аль салбарт үйл ажиллагаа явуулж буйгаа хамаарч хөнгөлөлт эдлүүлэх боломжтой. Бразил улсад байрлаж буй салбар болон охин компаниуд хөрөнгөө толгой компани руугаа шилжүүлэхийг хориглодог.

Өөрийн үйл ажиллагаандаа оруулж ирж буй машин болон тоног төхөөрөмжийг байршлын онцлогоос хамаарч 30 хүртэл хувиар татвар ногдуулж болно. Гаалийн болон валютын дүрэм журмыг зөрчсөн гадаадын хөрөнгө оруулагч нарыг тухайн мөнгөн хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгодог. Бразил улсын зээлийн байгууллагууд гадаад хөрөнгө оруулагчтай зээлийн харилцаанд оролцоходоо Бразил улсын Засгийн газрын зөвшөөрлийг авах ба дотоодын хөрөнгө оруулалттай байгууллагадаа давамгайлах эрх олгодог.

Бразил улсад гадаадын банк байгуулахыг зөвшөөрдөг ба тэр банк нь харилцан хамаарлын зарчим дээр тулгуурлаж байгуулагдадаг. Өөрөөр хэлбэл байгуулагдаж буй банкны эх оронд нь ямар хязгаарлалт байдаг түүнийг Бразил улсад байгуулагдаж байгаа банк нь ижил хэмжээний хязгаарлалтын үүргийг хүлээх хэрэгтэй байдаг.

Гадаадын хөрөнгө оруулалтын нилээдгүй хатуу зохицуулалт, өндөр татвар /гадаадын хөрөнгө оруулагч орлогынхоо 60-79 хувийг янз бүрийн төрлийн татварт төлдөг/

зэргээс үл хамаарч өнөөдрийн байдлаар Бразил улс гадаадын хөрөнгө оруулагч нарын сонирхлыг татсаар байна.

1991 оны байдлаар Бразил улсад гадаадын хөрөнгө оруулалттай 5000 байгууллага /голчлон АНУ, ХБНГУ, Япон, Швейцари, Их Британи, Итали, Франц зэрэг/ бүртгэгдсэн байна.

Эцэст нь хэлэхэд гадаад хөрөнгө оруулагч нарыг татах зайлшгүй шаардлагаас улбаалан тухайн улс нилээдгүй арга хэмжээ авч ирсэн бол одоогийн байдлаар тухайн харилцааны зохицуулалтыг өөрийн орны хувд ашигтайгаар эргүүлж эрх зүйн хатуу тогтолцоотой болсон.

БНХАУ

1978 онд БНХАУ-ын эдийн засагт хөрөнгө оруулалтын гадаад, дотоод харилцааг зохицуулах, өргөтгөх арга хэмжээ бүхий томоохон бодлого хэрэгжүүлж эхэлсэн байна. 1979 оноос хойш БНХАУ-д гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих буюу татах бодлого бүхий эрх зүйн актууд батлагдаж эхэлсэн юм. 1982 оны БНХАУ-ын Үндсэн хуульд гадаадын хөрөнгө оруулагч нар Хятадын эдийн засагт хөрөнгө оруулж, Хятадын хуулиар хамгаалагдах болно гэсэн агуулгатай заалт нэмэгдсэн.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах нийтлэг салбаруудыг дурдвал: хими болон металлурги, машин, тоног төхөөрөмжийн үйлдвэр, далайн өвролоос газрын тос олборлох, барилгын материал, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, эмийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, холбооны хэрэгсэл зэрэг багтана.

Гадаад хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын нэг онцлог гэвэл, тухайн үйлдвэр, байгууллагууд Хятадын даатгалын компаниудаар үйлчлүүлэх ёстой байна. Мөн гадаадын хөрөнгө оруулагч нарт тавигдах зарим нэг "ашигтай" нөхцөлүүдийг шаарддаг. Тухайлбал, тухайн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь дэвшилтэт болон шинэлэг техник, технологи, удирдлагын шинжлэх ухааны агуудыг ашигладаг, өндөр

чадажтай боловсон хүчинтэй буюу тухайн боловсон хүчин нь хятадын иргэдээс хэсэгчлэн бүрдэх ёстой байна.

Гадаадын хөрөнгө оруулагч нарт олгодог хөнгөлөлт, чөлөөлтийн хууль тогтоомжийн хувьд, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн "Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих" тухай тогтоолыг нэрлэж болно. Тус тогтоолын дагуу гадаадын хөрөнгө оруулагч нарт татвар, гаалийн хураамж, зээл олгох зэрэг асуудалд зарим нэг хөнгөлөлт үзүүлдэг хэдий ч дээд шатны болон орон нутгийн байгууллагууд тус компаниудад маш хатуу яналт тавьдаг юм. Энэ нь Хятадын хөрөнгө оруулалтын бодлогын нэг чухал хэсэг бөгөөд гадаад хөрөнгө оруулагч нарыг хянах бүхэл бүтэн систем үйлчилдэг байна.

1980 онд Гуандун мужид чөлөөт эдийн засгийн онцгой бүс байгуулах" тухай тогтоол гарснаар 80-аад оноос эхлэн Хятад улс эдийн засгийн нээлттэй буюу чөлөөт бүсүүд байгуулж, улмаар энэ нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал зүйл болжээ. Өнөөдрийн байдлаар Хятадад эдийн засгийн тусгай бүс 5, "нээлттэй хотын" статустай 14 хот байдаг.

1979 онтой харьцуулахад 1992 онд эдгээр бүс нь аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 28 дахин нэмэгдүүлж чадсан /нийт бүтээгдэхүүний 50 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын үйлдвэрлэл эзэлж байна/.

ЯПОН УЛС

Дэлхийн II дайны дараа дайнд сүйрсэн Япон улсын эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалт ихэвчэн дутагдаж байсан юм. Тэр үед төрийн эрхийг барьж байсан АНУ нь Япон улсад гадаад хөрөнгө оруулагчдыг татахын тулд төрийн зэмлэмтэй бодлого явуулж эхэлсэн бөгөөд орчин цагийн Япон улсын гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын үндэс болсон юм. Бүхэлд нь Япон улсын гадаадын хөрөнгө оруулалтыг либераль хэмээн нэрлэж болно. Учир нь, байгалийн баялаг нь төдийлэн үржил шимтэй

бус байдгаас болж Япон улс экспортын салбаруудын хөгжлийг дэмжиж, бүтээгдэхүүнээ орлоготой болгохын тулд орчин үеийн техник технологийг ашиглаж, удирдлагын дэвшилтэт бодлогуудыг баримталж, улс орондоо инфра тогтолцоо бий болгох зэрэг алхмуудыг эрчимтэй хийжээ.

Гадаадын хөрөнгө оруулалтын орчин үеийн бодлого нь гадаадын хөрөнгө оруулалттай байгуулагдаж буй хуулийн этгээдүүдийг Япон улсын хуулийн этгээд хэмээн тооцож, үндэсний дэглэмийг хэрэглэдэг байна.

Япон улсад гадны хөрөнгө оруулалттай компани байгуулах нь нилээд хялбараас гадна Япон улсын төв банкинд гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан тухайгаа мэдэгдэж 30 хоногийн хугацаанд санхүүгийн яамнаас автоматаар зөвшөөрөл олгодог байна.

Өнөөгийн байдлаар гадаадын хөрөнгө оруулагч нарыг Япон улс хөгжлийн инфра тогтолцоо, улс төрийн болон эдийн засгийн тогтвортой байдал, техник технологийн өндөр хөгжил зэрэг байдлууд нь татаж байна.

ДУГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын эдийн засгийн хөгжил хөдөлгөөн бие биесээ харилцан хамаарч хувьсан өөрчлөгдөх хандлага улам бүр идэвхжиж байна. Өөрөөр хэлбэл, гадаадын хөрөнгө оруулалтыг татах өрсөлдөөн ширүүсч, эрх зүйн тогтвортой орчинг шаардах боллоо.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудлыг бүх улс оронд өөр өөр талаас авч үздэг бөгөөд өөрийн орны онцлогийг харгалзан зохицуулах механизм нь ч өөр өөр байдаг. Энэ нь Бразиль улс, БНХАУ, Япон улс зэрэг орны жишээнээс харагдаж байгаа болов уу. Газар нутгийн хувьд уужим БНХАУ нь гадаад хөрөнгө оруулагч нарыг татах гол хөшүүрэг нь чөлөөт бус байгуулах явдал болж ирсэн байхад, харин газар нутгийн хувьд хязгаарлагдмал Япон улс нь өндөр дэвшилтэт техник, технологи, орчин үетэйгээ нийцсэн бодлогыг ашиглах замаар гадны хөрөнгө оруулагчдыг татаж байна.

Монгол Улсын хувьд 2006 оны эцсийн байдлаар 1990 оноос хойш 93 орны 6166 компани нийтдээ 1.8 тэрбум гаруй ам. долларын хөрөнгө

оруулахаар бүртгүүлсэн байна.

2006 онд 366 сая ам. долларын гадаадын хөрөнгө оруулалт хийгдсэн нь өмнөх оныхоос 15 хувиар өссөн байна. Гадаадын хөрөнгө оруулалт нь жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь гадаад хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалт, үр нөлөөг шинэчлэн судлах шаардлага өндөржиж байна. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалтыг ашигтай, үр нөлөөтэй болгох, хамтын үйлдвэрийн асуудал, хөрөнгө оруулалтын гэрээ гэх мэт асуудлын эрх зүйн үндэс, үндэсний аюулгүй байдлын талаас судлах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байгааг харуулж байна.

Иймээс ч улс орнуудын гадаад хөрөнгө оруулагч нарыг татах бодлого, зохицуулалтыг нарийвчлан судалж, туршлагыг нь өөрийн орны өнцлөгт нийцүүлэн нэвтрүүлэх нь ач холбогдолтой юм. Дээр дурдсан орнуудын адил Монгол Улс байгалийн их хэмжээний байлаг, өргөн удам газар нутаг, техник технологийг нэвтрүүлэх боломж, бололцоо бүгд байгаа билээ.

ШИНЭ НОМ



Гадаад хэргийн яам, Хууль зүйн үндэсний төв хамтран гаргасан **"НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА БА МОНГОЛ УЛС"** нэртэй номонд Монгол Улс НҮБ-д 1961 онд элсэн орсноос хойших 47 жилийн түүхэн дэх холбогдох чухал, гол материалыг Монгол Улсын Засгийн газрын архив болон Гадаад хэргийн яамны архивт хадгалагдаж байгаа материалаас түүвэрлэн авч тэр хэвээр нь, тухайн үеийн үг хэллэгийг өөрчлөхгүй хэвэлсэн нь залуу хойч үеийнхэндээ эх орныхоо түүхийг үнэн бодитоор судлах, сурталчлах үйлст нь тус нэмэр болохоор ном болсноос гадна Монгол Улсыг НҮБ-д элсэн ороход манай дипломатчид хэрхэн хичээн зүтгэж ажиллаж байсан тухай нийтлэгджээ.

ЯЛ НОГДУУЛАХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Өнөө үед "Шүүх гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хэр хэмжээнд тохироогүй ял ногдуулж байна, хүнд гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтнууд, хөрөнгө мөнгөтэй хүмүүс болон нийгмийн доод түвшний хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, тэдэнд шүүхээс ногдуулж буй ялын харьцаа харьцангуй байна. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдаж байна..." гэх мэт мэдээ, мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж, энэ асуудал олон нийтэд хүрсээр байгаа нь тэднийг хуулийн байгууллагын ажилтнуудыг хардаж сэрдэн бүхэлдээ болохгүй байгаа мэтээр нийгэмд ойлголт төрүүлж байна.

Энэ асуудал нь ял ногдуулах зарчим, ялын бодлого, хуулийн зохицуулалттай холбоотой юу?, эсвэл шүүгчдийн ур чадвар, тэдний хараат бус байдалтай холбоотой юу? гэдгийг судлах нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэгт "Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно..." гэж заасан нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх Үндсэн хуулийн үндэслэл болно.

Эрүүгийн хуульд заасан ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн хуульд нийцүүлэн гаргасан шүүхийн тогтоолоор ногдуулна. Эрүүгийн ял, хариуцлагыг ногдуулахдаа эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлд тусгалаа олсон нийтлэг зарчмыг хариуцлага болгоно. Энэ нь аль ч төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд, ямар ч хэлбэрийн ял хариуцлагыг ногдуулахад удирдлага болгох нийтлэг үндэслэлийг хуульчилсан хэм хэмжээ юм. Ял нь үйлдсэн



Цагдаагийн академийн магистрант, цагдаагийн ахмад **Д.БАТЖАРГАЛ**

хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд тохирсон байх учиртай. (Сүүлийн 5 жилийн хугацаанд шүүхээс ногдуулж буй ялыг харьцуулж үзэхэд хорих ялын хувь буурч, хорихоос өөр төрлийн ял өсөх хандлагатай болжээ.

Хорих, баривчлах болон торгох ялын аль нэгийг сонгож ногдуулахаар заасан.

Энэ тохиолдолд шүүх гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзахаасаа илүүтэйгээр, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төлбөрийн чадварыг харгалзан ял ногдуулж байна.

Эрүүгийн хуульд хорих, торгох санцтай 33 зүйл байна.

Баривчлах ял нь биеэр эдэлдэг ял тул торгох ялаас хүнд тусдаг. Гэтэл мөн л дээрхийн адил гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төлбөрийн чадвараас хамааралтай ял болдог.

Эрүүгийн хуульд баривчлах, торгох санцтай 77 зүйл анги байна.

Шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээнд нийцүүлж,

шударга ёс, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирын хэр хэмжээ, хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан ял ногдуулах хуульд заасан зарчмыг баримтлах ёстой. Гэтэл хуулийн зарим зохицуулалтаас шалтгаалан уг зарчим бүрэн утгаараа хэрэгжихгүй байгаад дүгнэлт хийн арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Торгох ялын хэмжээ хэт өндөр, дунджаас дээшхи амьжиргааны түвшинд нийцдэггүй.

Торгох ялаар шийтгүүлсэн хүмүүс уг ялаас зайлсхийж, баривчлах, бага хэмжээний хорих ялаар шийтгүүлэх, эсвэл Эрүүгийн хуулийн 76.1.1-д заасан хугацааг өнгөртөл бага хэмжээний төлөлт хийж, ялаас чөлөөлүүлэх гэх мэт арга замаар торгох ялаас зайлсхийж байна.

Урьд нь хулгийн гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээдэд хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн этгээдэдтэй адил ял ногдуулж байгаа нь Эрүүгийн хуулийн ялын бодлого хэтэрхий чанга болсныг харуулж байна. Энэ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт болон хүмүүжүүлэн, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ялын зорилгод нийцэхгүй байна.

Жишээ нь: Эрүүгийн хуулийн 145.4.

Эрүүгийн хуулийн 145.4-т заасан этгээд бусдын бага бус хэмжээний эд хөрөнгийг хулгайлсан бол **10-аас дээш 15 жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 91.1-т заасан гэмт хэрэг /хүнийг санаатай алах/ үйлдсэн этгээдийг **10-аас дээш 15 жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Шүүхээс ногдуулж буй ялын харьцаа өөрчлөгдсөн /хорих ялын

биечлэн эдлүүлэлтийн болон торгох ялын хувь буурсан, баривчлах ялын хувь өссөн-ий шалтгааныг тогтоох зорилгоор санал асуулгын болон ярилцлагын аргаар шүүгч, прокурор, өмгөөлөгч нараас судалгаа авсан.

Санал асуулгад оролцогчдын 2.4 хувь нь Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ногдуулахаар заасан ял тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, хэр хэмжээнд нийцдэг, 85.3 хувь нь зарим нь нийцдэг, 12.1 хувь нь ерөнхийдөө нийцдэггүй гэсэн байр суурьтай байдаг ажээ.

Оролцогчдын 63.4 хувь нь ял зарим нь хэт хөнгөддөг, зарим нь хэт хүндэддэг гэж, 36.5 хувь нь ял хэт хүндэддэг гэж хариулсан байна.

Хуульд заасан ял хэт хөнгөддөг гэж үзвэл ямар хүмүүст илүү хөнгөн тусдагийг судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 31.7 хувь нь хөрөнгө мөнгөтэй хүнд;

- 29.2 хувь нь албан тушаалтанд;
- 21.9 хувь нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүнд;
- 19.5 хувь нь насанд хүрээгүй хүнд;

- 14.6 хувь нь гэмт хэрэг үйлдэхээр завдсан хүнд;
- 12.1 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн хүнд ял хөнгөн тусдаг гэж үзжээ.

Ял гэмт хэргийн ямар төрөлд илүү хөнгөн тусдагийг судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 19.5 хувь нь албан тушаалын гэмт хэрэг;
- 12.1 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- 12.1 хувь нь хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- 9.7 хувь нь нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт ял хөнгөн

тусдаг гэж үзжээ.

Хуульд заасан ял хэт хүндэддэг гэж үзвэл ямар хүмүүст илүү хүнд тусдагийг судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 51.2 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн хүнд;

- 46.3 хувь нь ядуу хүнд;
- 41.4 хувь нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүнд;
- 41.4 хувь нь насанд хүрээгүй хүнд;

- 34.1 хувь нь ажилгүй хүнд;
- 26.8 хувь нь гэмт хэрэг үйлдэхээр завдсан хүнд;
- 24.3 хувь нь дундаж амьдралтай хүнд;

- 21.9 хувь нь гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнд ял хүнд тусдаг гэж үздэг ажээ.

Ял гэмт хэргийн ямар төрөлд илүү хүнд тусдагийг судлахад асуулгад оролцогчдын /давхардсан тоогоор/:

- 73.1 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- 51.2 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- 46.3 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- 29.2 хувь нь нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- 9.7 хувь нь хүний эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэгт ял хүнд гэж үзжээ.

Дээрх дүнгээс хөрөнгө мөнгөтэй хүн, албан тушаалтан, мөн албан тушаалын гэмт хэрэгт ногдуулах ял хэт хөнгөн тусдаг гэж судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь үзсэн бол давтан гэмт хэрэг үйлдсэн хүн, хөрөнгө мөнгөгүй ядуу хүн, анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүн, насанд хүрээгүй хүн, гэмт хэрэг үйлдэхээр завдсан, мөн хамтран үйлдсэн хүнд, түүнчлэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг,

тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт ял хүнд тусдаг гэж судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь үзсэнийг анхааран дүгнэх нь зүйтэй байлаа.

Иймээс ял шийтгэлийн тохиромжтой байдлыг хангах зорилгоор дараах чиглэлийн хүрээнд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. Эрүүгийн хуульд тодорхой төрлийн гэмт хэрэгт ногдуулахаар заасан ялын төрөл болон хэмжээ нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, хүнд хөнгөнд болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдалд тэр бүр тохирохгүй байна.

2. Шүүхээс ял, түүний хэмжээг сонгон хэрэглэх боломжийг хязгаарласан нь ялыг уян хатан хэрэглэх боломжгүйд хүргэж, зарим хэргийн шинж чанар, хэр хэмжээнд тохирохгүй хэт хүнд ял ногдуулж байгаа нь уг ялын зорилгод төдийлөн нийцэхгүй байна.

3. Хууль тогтоогч ялыг бодлого муутай хуульчилснаас зарим гэмт этгээд гарцаагүй ял завших, цаашилбал эрх мэдэл, хөрөнгө чинээ, нийгмийн давхаргын ялгаанаас шалтгаалан ял ногдуулах боломжийг бүрдүүлж байна.

Гэтэл хуулийн зарим зохицуулалтаас шалтгаалан уг зарчим бүрэн утгаараа хэрэгжихгүй байгаад дүнэлт хийн арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Иймд шүүхэд ял шийтгэлийг ялгамжтай ногдуулах эрх зүйн боломжийг бий болгож өгөх, хуульчдын хуулийн заалтыг ойлгож хэрэглэх чадварыг дээшлүүлэх, мөн шүүгчдийн ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна.



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН НИЙТЭЭР ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ХЭМ ХЭМЖЭЭ, ЗАРЧМЫГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлд зааснаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим болон Монгол Улсын олон улсын гэрээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг бөгөөд Монгол Улс нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох "гэрээгээр хүлээсэн үүргээ сударгаар сахин биелүүлэх" зарчмыг баримтлах талаар Үндсэн хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэгт тунхаглажээ.

Олон улсын гэрээ нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх гол хэрэгсэл болж, төрийн болон төрийн бус байгууллагын, тэдгээрийн дотор үндэсний эрх зүйн харилцааны субъектуудын оролцоотой олон улсын харилцааг өргөжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах салбарт анхдагч үүрэг гүйцэтгэдэг билээ.

Ийм учраас олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхтэй холбоотой шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3.-т заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ болон Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан.

"Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөөг нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах" эрх нь Үндсэн хуулиар олгогдсон иргэний үндсэн эрхийн нэг тул хүний эрх, эрх чөлөөг хангах, эдлүүлэх асуудал шүүхийн шүүн таслах ажиллагааны үйлчлэлийн хүрээнд нэгэн адил хамаарна. Хүний эрх, эрх чөлөө нь хуулийн утга, агуулга, түүний хэрэглээг тодорхойлж ирэх зэрэгцээ хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн болон нутгийн өөрийн удирдах байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж, шүүн таслах ажиллагаагаар хангагдан хамгаалагдана.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим гэж олон улсын эрх зүйн үндсэн агуулгыг илэрхийлэх, улс хоорондын хэвийн ажиллагааг хангахад чухал ач холбогдол бүхий хууль зүйн дээд хүчин чадалтай, улс орнуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хэлнэ.

Тухайлбал, хүний эрхийг бүх нийтээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэх, олон улсын үүргээ сударгаар биелүүлэх зэрэг нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд хамаарна.

Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ гэдгийг олон улсын хамтын нийгэмлэгээс тогтоож, хүлээн зөвшөөрсөн, хууль зүйн хувьд заавал даган биелэгдэх хүчин чадалтай зан үйлийн дүрэм гэж ойлгоно.

Дээрх зарчим болон хэм хэмжээний агуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагуудын баримт бичигт дэлгэрүүлсэн байж болно.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж заасны дагуу олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болно.

БНМАУ-аас бусад улс оронтой байгуулсан болон нэгдэн орсон олон улсын хүчин төгөлдөр гэрээ Монгол Улсын Үндсэн хуульд харшлагагүй бол Монгол Улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг байна.

Олон улсын гэрээг Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д "Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ" гэж тодорхойлжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газар Монгол Улсын нэрийн өмнөөс улс хоорондын, Монгол Улсын Их Хурал парламент хоорондын, Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар өөрийн нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын, Монгол Улсын яам, агентлаг өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газрын нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын олон улсын гэрээг тус тус байгуулна.

Яам, агентлаг, тэдгээрийн харьяа байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагаас бусад улсын ижил төрлийн байгууллага, хувь хүн, хуулийн этгээдтэй өөрийн нэрийн өмнөөс байгуулсан гэрээ Олон улсын гэрээний тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

3. Олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж уг гэрээнд тусгайлан заагаагүй, Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй, албан ёсоор нийтлэгдсэн олон улсын гэрээний заалт Монгол Улсын нутаг дэвсгэрт шууд үйлчилнэ (өөрөө биелэгдэх шинж).

Харин гэрээний оролцогч улс орнууд энэхүү гэрээнд нэгдсэнээр өөрийн үндэсний хууль тогтоомжид холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар олон улсын гэрээнд өөрт нь тусгайлан заасан бол уг гэрээний заалт Монгол Улсын нутаг дэвсгэрт шууд үйлчлэх боломжгүй юм.

Шүүх эрүүгийн хэрэг, иргэний болон захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ хүчин төгөлдөр болсноор заавал даган мөрдөх шинжийг агуулсан, албан ёсоор нийтлэгдсэн, дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан заалтгүй, Үндсэн хуульд харшлаагүй, үндэсний эрх зүйн харилцааны оролцогч этгээдүүдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

Үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэрээг шүүх эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шууд хэрэглэх боломжгүй. Харин энэхүү заалтын дагуу дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол шүүх үндэсний хууль тогтоомжийг баримталж, хэргийг шийдвэрлэнэ.

4. Шүүхүүд олон улсын гэрээнд тусгагдсан эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ тухайн гэрээ хүчин төгөлдөр болсон эсэхийг анхаарвал зохино.

Олон улсын гэрээ нь гэрээнд заасан, эсхүл хэлэлцээрт оролцсон талуудын тохиролцсон журам болон хугацаанд хүчин төгөлдөр болдог тул гэрээнд ийм заалт байхгүй, эсхүл талууд энэ талаар тусгайлан тохиролцоогүй бол Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн 1969 оны Конвенцийн 24 дүгээр зүйлд зааснаар гэрээнд оролцогч улс орон бүр гэрээг заавал даган биелүүлэхийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлсэн тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр болно.

Монгол Улс бүрэн эрх олгогдсон этгээдээр дамжуулан Олон улсын гэрээний тухай хуульд заасан арга, хэлбэрээр тухайн гэрээг байгуулна. Үүнд:

- гэрээнд гарын үсэг зурах
 - гэрээг бүрдүүлэх баримт бичиг солилцох
 - гэрээг соёрхон батлах
 - гэрээг батлах
 - гэрээнд нэгдэн орох
- зэрэг арга хэлбэрүүд багтана.

Түүнчлэн олон улсын тухайн гэрээ Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон эсэх нь түүнийг хэрэглэхэд онцгой ач холбогдолтой.

Олон улсын гэрээг байгуулсан, эсхүл түүнд нэгдэн орсон улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болох журмыг гэрээнд тусгайлан заасан байвал олон улсын гэрээ өөрөө хүчин төгөлдөр болсон хэдий ч тухайн улс орны хувьд зөвхөн энэ журмын дагуу хүчин төгөлдөр болно. Тухайлбал, гэрээнд гарын үсэг зурж, нэгдэн орсны дараа соёрхон баталсан улс батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гэрээнд заасан хугацааны дараа тухайн улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болох журам олон Конвенц, гэрээнд тусгагджээ.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт **"Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ"**, хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт **"Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно"**, тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан **"Улсын Дээд шүүх, бусад шүүх нь ...албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй"**, Олон улсын гэрээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1-д **"Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээг нийтлэхдээ Монгол Улсын хууль нийтлэх журам, олон улсын бусад гэрээг нийтлэхдээ Засгийн газрын тогтоол нийтлэх журмыг тус тус баримтлана"** гэж тус тус заасныг үндэслэн шүүхүүд хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээнүүдээс зөвхөн албан ёсоор нийтлэгдсэн гэрээг хэрэглэнэ.

Олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон хэдий ч албан ёсоор нийтлэгдээгүй бол шүүх түүнийг хэрэглэхгүй.

Олон улсын гэрээний 25 дугаар зүйлийн 2-т **"олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмтгэл болгон хэвлэж байна"**, Улсын Их Хурлын

тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-т "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ", мөн зүйлийн 43.5-д "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ" гэж тус тус заасны дагуу Гадаад хэргийн яамнаас олон улсын гэрээг албан ёсоор орчуулсан эхийг "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлэн нийтэлснийг "олон улсын гэрээний албан ёсны нийтлэл" гэж үзнэ.

Монгол Улсын олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон тухай мэдээллийг Гадаад хэргийн яам гаргаж өгнө.

6. Монгол Улсын олон улсын гэрээг эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхүүд дараах тохиолдолд шууд хэрэглэнэ:

6.1. Иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд: шүүхийн хэлэлцүүлгийн зүйл болж буй маргаантай харилцааг зохицуулсан материаллаг эрх зүйн дотоодын хуулийн зүйл, заалтаас олон улсын гэрээний зохицуулалт өөр байгаа бол;

6.2. Эрүүгийн байцаан шийтгэх болон иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд: шүүн таслах ажиллагааг явуулах эрүү, иргэн, захиргааны процессын эрх зүйн дотоодын хуулиар тогтоосон журмаас өөр журмыг олон улсын гэрээ тогтоосон бол;

6.3. Эрүүгийн байцаан шийтгэх болон иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд: шүүхийн хэлэлцүүлгийн зүйл болох харилцаа (тэдгээрийн дотор гадаадын этгээдийн оролцоотой) зөвхөн олон улсын гэрээгээр зохицуулагдаж байгаа бол;

6.4. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд: захиргааны хариуцлагын тухай дотоодын хууль тогтоомжид заасан зохицуулалтаас олон улсын гэрээний зохицуулалт өөр байгаа бол.

Ингэхдээ Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоож байгаа олон улсын гэрээг заавал соёрхон батлахаар Олон улсын гэрээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасныг шүүхүүд анхаарвал зохино.

7. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.-д "Үйлдэл, эс үйлдхийг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлоно" гэж заасан тул Эрүүгийн хуульд тусгайлан заасан тохиолдолд л эрүүгийн гэмт хэргийн шинжийг тодорхойлсон олон улсын эрх зүйн хэм хэмжээг шүүхүүд хэрэглэж болно.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 299 дүгээр зүйлд "Олзлогдогсод, энгийн хүн амтай харгис хэргийг харьцсан, хүн амыг оршин суугаа нутгаас нь албадан зайлуулсан, эзлэгдсэн нутагт түүх соёлын үнэт зүйлийг тонон дээрэмдсэн, зэвсэгт мөргөлдөөний үеэр Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон арга хэрэгсэл хэрэглэсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хүн амыг үй олноор нь хөнөөх, устгах зэвсэг хэрэгсэл хэрэглэсэн бол арван таваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан тул энэ зүйлд заасан гэмт хэргийн объектив талыг тодорхойлоход Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай 1968 оны Конвенци, Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (I) Конвенци, Дайд олзлогдогсодтой харьцах тухай Женевийн (III) Конвенци зэрэг олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээний заалтуудыг шүүхүүд шууд хэрэглэх боломжтой байна.

Эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тусгасан хэм хэмжээ бүхий олон улсын гэрээнд үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар гэрээний хэрэгжилт хангагдах талаар заасан байдаг тул Эрүүгийн хуульд заагаагүй гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг шүүхүүд хэрэглэхгүй.

8. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.-т "Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа этгээд болон дагаж мөрдөж байгаа хууль, олон улсын гэрээний дагуу Монгол Улсын шүүхэд эрүүгийн хэргийн талаар харьяалагдахгүй бусад этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ" гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 193 дугаар зүйлд "Гадаад улсын дипломат дархан эрх, эрх ямба эдэлдэг иргэн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд сайн дураар

зөвшөөрснөөс бусад тохиолдолд Монгол Улсын шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарагдахгүй.

Монгол Улсын төрийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллагын урилгаар Монгол Улсад зочилж байгаа гадаад улсын төлөөлөгч, дагалдан яваа бусад хүмүүс Монгол Улсын шүүхэд үл харьяалагдана” гэж тус тус заасныг Дипломат харилцааны тухай Венийн 1961 оны Конвенц болон Консулын харилцааны тухай Венийн 1963 оны Конвенцийн зүйл, заалтын харьцуулан үзэж, эрүүгийн хэрэгт холбогдсон этгээд, иргэний хэргийн зохигч болон хэргийн бусад оролцогч дархан эрх, давуу эрх, эрх яамбын алиныг нь ямар хэмжээгээр эдлэх ёстой болохыг тодорхой тохиолдол бүрт шүүхүүд зааглан ялгаж байвал зохино.

9. Монгол Улсын олон улсын гэрээнд хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөхөөр Иргэний, Гэр бүлийн, Хөдөлмөрийн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиуд болон бусад хуульд заасныг Үндсэн хуулийн арвдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасантай уялдуулан зөвхөн соёрхон баталсан олон улсын гэрээ дотоодын хуулиас дээгүүр хүчин чадалтай байна гэж ойлгоно.

Өөрөөр хэлбэл хууль хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээ л дотоодын хуулиас илүү хүчин чадалтай байх буюу олон улсын гэрээний зохицуулалт хуулийн зохицуулалтаас өөр байвал олон улсын гэрээний заалт үйлчилнэ.

Монгол Улсын хуулиар соёрхон батлагдаагүй олон улсын гэрээ түүнийг байгуулсан төрийн тухайн байгууллагын хууль тогтоомжийн эрхийн аргуудаас дээгүүр хүчин чадалтай байна.

10. Олон улсын гэрээг тайлбарлахад Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн 1969 оны Конвенцийн зохицуулалтыг шүүхүүд баримтална. (III анги, 31 – 33 дугаар зүйл)

Олон улсын гэрээг тайлбарлахад хүндрэл учирвал Нэгдсэн Үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын болон олон улсын бусад байгууллагын шийдвэр, эрхийн актыг ашиглах, олон улсын гэрээний хүчтэй байх хугацаа, гэрээнд оролцогч улсын бүрэлдэхүүн, гэрээг хэрэглэж буй олон улсын практик зэрэг асуудлаар Гадаад хэргийн яамны гэрээ, эрх зүйн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас павлагаа авч байвал зохино.

11. Гадаад улсын шүүхийн даалгаврыг биелүүлэх, гадаад улсад шүүхийн даалгавар явуулах иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхүүд хэрэгжүүлдэхдээ гадаадын тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцаа үзүүлэх Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээ, ийм гэрээ байхгүй бол Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенцийн зүйл, заалтыг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хамт баримтална.

Иргэн, гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээ нь нарийвчилсан зохицуулалттай, харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенц нь ерөнхий зохицуулалттай гэрээ болно. Хоёр талт гэрээгээр тусгайлан зохицуулсан асуудалд Конвенцийн энэ талаарх заалтыг баримтлах шаардлагагүй ба харин хоёр талт гэрээнд тусгайлан зохицуулаагүй асуудлаар Конвенцийн заалтыг баримтална.

12. Гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу нэгдэн орсон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлогдоно.

Монгол Улс тухайн гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх асуудлыг тусгасан бол гэрээний уг заалт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт зааснаар шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай эрх бүхий этгээдийн хүсэлтээр шийдвэрлэнэ.

Монгол Улс тухайн гадаад улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй, эсхүл уг гэрээнд шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай асуудлыг тусгаагүй бол гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах асуудлыг шүүх шийдвэрлэхгүй.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенцийн III бүлэгт шүүхийн бүх шийдвэрийг гүйцэтгэх талаар бус харин шүүхийн зардал төлүүлэх шийдвэрийг биелүүлэх талаар тусгасан байх тул шүүхийн зардал төлүүлэх тухай гадаад улсын шийдвэрийг албадан гүйцэтгэх асуудлыг шүүхүүд Монгол Улс тухайн гадаад улстай хоёр талт гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран Конвенцийн заалтыг баримтлан шийдвэрлэнэ.

Гадаад улсын шүүхийн шийдвэр гэдэгт тухайн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн

шийдвэрийг ойлгоно. Албадан гүйцэтгүүлэх шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон, шийдвэрийн үнэн зөв байдал нь түүнийг гаргасан шүүхээр баталгаажсан, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг тухайн шүүх зөвшөөрөн дэмжиж байгаа, шийдвэрийн эх албан ёсоор орчуулагдсан, зохих журмын дагуу ирүүлсэн бөх шаврдлагатайг шүүхүүд анхаарвал зохино.

Гадаадын арбитр буюу арбитрын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай хүсэлтийг Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Конвенцийн зүйл, заалтын дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт зааснаар шүүхүүд шийдвэрлэнэ.

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэснээр Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй, Монгол Улсын нийтийн эрх зүйн дүрэмд харш, эсхүл зохигчдын хоорондох тухайн маргааныг Монгол Улсын шүүх хянан шийдвэрлэж, шүүхийн хүчин төгөлдөр өөр шийдвэр гарсан, эсхүл иргэний хэрэг үүсгэгдэн, хянан хэлэлцэгдэж байгаа, тухайн хэрэг Монгол Улсын шүүхийн онцгой харьяалалд хамаардаг, эсхүл гадаад улсын шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болоогүй буюу хүчин төгөлдөр болсон эсэх нь тодорхой бус, шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх талаар шаардлага тавих хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаа сэргээгдээгүй зэрэг нөхцөл байдал тогтоогдвол гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай сонирхогч этгээдийн хүсэлтийг шүүх хангахаас татгалзаж, энэ талаарх үндэслэлийг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд тодорхой заана.

13. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Дээд шүүхийн Тамгын Газарт даалгах нь:

13.1. Хүний эрхийн Үндэсний комисс, Гадаад хэргийн яамны гэрээ, эрх зүйн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран Монгол Улсын олон улсын гэрээний албан ёсны орчуулга, гэрээний жагсаалт, тэдгээрийн хүчинтэй байх хугацаа, хүчин төгөлдөр болсон хугацаа, Монгол Улсын нэгдэн орсон хугацаа, албан ёсоор хэвлэн нийтлэгдсэн байдал зэрэг асуудлаар нийт шүүх, шүүгчдийг үнэн, зөв мэдээллээр цаг алдалгүй хангаж байх.

13.2. Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвтэй хамтарч шүүгчдийн болон шүүхийн ажилтнуудын үргэлжилсэн, давтан сургалтад олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ болон Монгол Улсын олон улсын гэрээг судлах, сургалтын материал гарын авлагаар хангах, сургалтын хөтөлбөрт оруулах зэрэг асуудлыг онцгой анхаарч ажиллах.

13.3. Улсын Дээд шүүхийн Эрүүгийн, Иргэний, Захиргааны хэргийн танхимууд болон Судалгааны төвтэй хамтран олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж буй шүүхийн практикийг судлаж, нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны хүрээнд судалгаа, сургалтын ажил зохион байгуулах.

14. Энэ тогтоолын 1, 2 дугаар хэсрэлтийг лавлагааны журмаар ашиглахыг нийт шүүх, шүүгчдэд мэдэгдсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Ц.АМАРСАЙХАН

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Б.БАТСАЙХАН

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

О.ЗАНДРАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 3 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН 33 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль /цаашид хуулийн гэх/-ийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан **“Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч ...”** гэдэгт онцгой байдлын асуудал эрхэлсэн төв, орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа төрийн тусгай болон үйлчилгээний нийт албан хаагчид хамаарна.

2. Мөн зүйлийн 33.7-д заасан **“Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч ...”** гэдэгт хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 32 дугаар зүйлд заасны дагуу тангараг өргөж, ажил, мэргэжлийн онцлогт тохирсон цол, дүрэмт хувцас хэрэглэдэг, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг хамааруулан ойлгоно.

3. Мөн зүйлийн 33.12-т заасан **“Аврах ажиллагаанд оролцдог албан хаагч ...”** гэдгийг онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч гэж ойлгох бөгөөд тэдгээрт хуулийн 33 дугаар зүйлийн 33.12.2, 33.12.3, 33.12.4, 33.12.5, 33.12.6-д заасан нэмэлт хөнгөлөлтийг эдлүүлнэ.

Харин тэдгээрээс аврах ажиллагаа явуулсан тохиолдолд хуулийн 33 дугаар зүйлийн 33.12.1-д заасан урамшууллыг холбогдох байгууллагаас гаргасан журамд зааснаар олгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

П.ЦЭЦЭГЭ

ЭЖЭРЭХТЭЙ ҮЙЛЭЖИЙ БАЙГУУЛЛАГА



Д.ТОГТОХЖАРГАЛ

Хууль зүйн албаны тэргүүний ажилтан, Монголын ахмадын холбооны болон Нийслэлийн хүндэт тэмдэгт, Өмгөөлөгчдийн коллегийн Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Шүүх яамны Эрхийн үйлчилгээ, Өмгөөллийн хэлтсийн даргаар ажиллаж байсан. Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, Хүндэт өмгөөлөгч. Тэрээр Монголын радио, телевиз, сонин сэтгүүлд 600 шахам өгүүлэл, нийтлэл "Хууль зүйн 500 ба 600 асуулт, хариулт" болон Хууль зүйн асуулын цуврал 3 дэвтэр ном бичсэн, Германы "Ное-Юстиц" сэтгүүлд "БНМАУ дахь хууль зүйн алба" гэсэн өгүүлэл нийтлүүлж, Монголын анхны хууль зүй бичигчийн талархал авчээ.

Монголын Өмгөөлөгчдийн байгууллагын 80 жилийн ой энэ онд тохиож байна. Алдаж эндсэн ч бай, арсалдаж тэмцэлдсэн ч бай, амь насанд хүрсэн ч бай төрийн хууль цаазад харш хэрэгт холбогдон ялд унасан хэнд боловч энэрэнгүй сэтгэлээр хандан:

Эрдэнэт хүний эрхийг хамгаалан

Энэрэл шударгын эрхийг дээдлэн

Төртэй тэрсэхээс эмээхгүй зүтгэдэг

Төвөгтэй хэцүү албатай хүмүүсээс' бүрдсэн өвөрмөц байгууллагын үүсэл хөгжил сонин түүхтэй билээ.

Манжийн дарлалд олон жилээр нухлагдсан эрх чөлөөгүй байсан Монгол оронд Ардын хувьсгал ялсан нь нийгмийн амьдралыг цоо шинээр өөрчлөх шинэ ажлын эхлэл байв. Энэ үед буюу хувьсгал ялсны 3 жилийн дараахан 1924 оны найм, есдүгээр сард хуралдсан

Монгол Ардын Намын III Их Хурал улс орныхоо цаг үеийн байдалд бүтээлч дүн шинжилгээ хийж, нийгмийн амьдралын олон талт асуудлыг нухацтай авч хэлэлцэн, чухал шийдвэр гаргасан байна.

Намын III Их хурал 1924 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн XV хуралдаанаараа "Хуулийн байгууллагын ажлын тухай" авч хэлэлцэх явцдаа уг асуудалд маш нухацтай, шүүмжлэлтэй хандаж байсны дотор хүний эрхийг зөрчсөн олон асуудлыг сөхөж тавьж байсны нэг нь "Мөрдөн байцаах явдлыг шүүн таслахаас тусгаарлах хэрэгтэй. Туршлага олсон байцаагч нарыг даруй бэлтгэж, ардын төлөөлөгч хийгээд ӨМГӨӨЛӨГЧ-тэй болох хэрэгтэй" гэсэн үг төлөөлөгчдийн анхааралд сонин содон хүрч байсан нь лавтай. Тэгээд ч хурлын тогтоолд "... Шүүх таслах газрын хэргийг удирдах зөвлөл байгуулж, бүх хэргийг жолоодон удирдуулах дүрэм хэмжээ тогтоож гүйцэтгэвэл

зохино гэх буюу аливаа шүүх таслах газруудын дүрэм, байдлыг үндсээр хувьсгаж, шүүх таслах хэрэгт ардын төлөөлөгч нарыг оролцуулан жинхэнэ ардын шүүн таслах газрыг шинэчлэн байгуулахад цагийн байдалд нийцүүлж, зүй ёсоор эрхлэн явуулбал зохино" гэсэн заалтын жинхэнэ утга нь шүүн таслах үйл ажиллагааны бүх шатанд оролцогчдыг боловсронгуй хэлбэрээр бий болгож шинэ дүрэм, журмын дагуу ажиллуулах тогтоох тухай төрийн бодлогыг илэрхийлжээ.

Шүүх таслах үйл ажиллагааг ардын эрхэт ёсонд нийцүүлэн явуулах үйл ажиллагааны явцад хүний эрхийг тууштай ханган хамгаалах үүрэг бүхий "Өмгөөлөгч"-ийг шүүн таслах ажиллагаанд оролцуулах эхлэлийг тавьж практик хэрэгжүүлж эхэлсэн байна.

Түүхэн баримтаас үзвэл 1924 оны 9 дүгээр сарыг хүртэл таслан шийдвэрлэсэн эрүүгийн 21 хэргийн 11-д нь

яллагч оролцож, түүний зэрэгцээ Намсрай, Сэржхүү, Жамсран, Санжматов, Цэвэгжав нар хуралд өмгөөлөгчөөр оролцож байжээ.

Манай улсад мэргэжсэн буюу өмгөөлөх дадлага туршлагатай хүн ховор байснаас өмгөөлөх үйл ажиллагааг эрхэлсэн өмгөөлөгчдийн байгууллага тэр даруй байгуулагдаагүй боловч өмгөөлөх үйл ажиллагаа нь амьдралын шаардлагаар хэрэгжиж эхэлсэн байна.

1926 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Нийслэл хүрээний Хятад шийний газрын байранд Монгол цэргийн эсрэг байлдаж явсан Бароны цэргийн дарга Санжаа-Галдановын хэргийг таслан шийдвэрлэхэд өмгөөлөгчийг оролцуулсан түүхийн баримт бий¹.

Хэрэгтэн С.Галданов өөрийн өмгөөлөгчөөр Цогт-Бадамжав эсхүл Бадамцэрэн Балсановыг томилж өгөхийг хүссэн байна. Харин Цогт-Бадамжав нь ажил ихтэй байгаа учраас чөлөөлж өгөхийг хүсч байжээ. Шүүх хурлыг Монголын анхны нэрт хуульчдын нэг Ц.Гүрсэд даргалж, гишүүн Дэлгэрсүрэн, Хаянхярваа нар нарийн бичгийн даргаар Дорлигжав оролцсон цаг зуурын шүүхийн энэ хуралд өмгөөлөгч оролцсон нь лавтай юм.² Энэхүү түүхэн баримтыг үндэслэн дүгнэлт хийж үзвэл тус улсын эрүүгийн шүүн таслах ажиллагаанд яллагч өмгөөлөгч оролцуулан таслан шийдвэрлэсэн анхны процесс Санжаа-Галдановын хэрэг байж ч болох юм. Энэхүү шүүх хурал дээр улсын яллагч ялын шүүмжлэлдээ "Галданов бол харгис цагаан намын Барон Унгерны цэрэгт итгэгдэн зэрэг дэвшиж, их бага тушаалыг удаа дараагаар хүлээж ардын

хувьсгалын цэрэгтэй байлдсан хүнд хэргийг үйлдсэн учир шууд буудан алахаар шийтгэн хойшид цэрлээл болговол зохино"³ гэжээ.

Харин Санжаа-Галдановын өмгөөлөгч шүүх хурал дээр хэлсэн үгэндээ:

"Галданов бол угаасаа хөдөө талын нэгэн бүдүүлэг ард, санамсаргүйгээс... нутгийн газар анх удаа улаан цэрэг ирэхэд аль ч учрыг мэдэхгүй амь зугтаж яваад цагаан намын этгээдүүдэд хүчирхэгдэн баригдаж, аясыг дагалдан явсан бөгөөд харин ч эцэст нь... харгис Барон болоод Речукин нарыг алж устган, ард олонд тусыг хүргэх хэргийг үүсэн үйлдсэн төдийгүй бусдын амийг хилс үхлээс хэлтрүүлж явсан зэрэг зүйл зохиогчдын өчиг мэдүүлэгт тодорхой байхын дээр Онон голын хошуунд 4 жил суухдаа харштай хэрэг өдүүлсэнгүй хэвийг сахиж ардын сонгуулийг эдэлж явсан... тул даруй ялыг хэлтрүүлэн тавьж, ардын эрхийг хүндэтгэх болов уу?"⁴ гэжээ.

Шүүх хурлаас Санжаа-Галдановт 3 жил хорих ял ногдуулж тал хувийг баярын өршөөлөөр хэлтрүүлэн урьдчилан хоригдсон 16 сарыг хасч, үлдэх 2 сарыг тэнсэн сулласан байна.

Монгол орны нийгмийн амьдралыг цаашид хэрэгжүүлэхэд эрх зүйн гол үндэс болсон анхны шинэ Үндсэн хууль 1924 онд батлагдан гарсан нь онцгой чухал болсон юм.

1924 оны анхны Үндсэн хуулийн үзэл санааны дагуу 1926 онд батлагдан гарсан "Монгол Улсын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль"-ийн 65 дугаар зүйлд "Аливаа хэрэг байцаан шийтгэхэд яллагчийг оролцуулахаар

тогтоож, хэрэгтэн хүмүүс хүсвэл төлөөнөө заалдагч хүнийг шүүн таслах газраас томилж буюу хэрэгтэн хүний хөлсөөр урьж ирүүлэн суулгаваас зохино" гэж заасан нь Монгол Улсад өмгөөлөх үйл ажиллагаа үзэх хууль зүйн үндэслэлийг анх удаа хуульчлан тогтоожээ.

Өмгөөлөх үйл ажиллагаа хууль зүйн дагуу явагдах нийгмийн шаардлага бий болж, хэрэг ялд унасан хүмүүс өмгөөлөгчийн тус дэмжлэг авахыг хүсэх болсноор Шүүх яам болон Улсын дээд шүүх таслах газраас (дарга Гүрсэд) "Шүүх таслах тухай олон ардад тусламж үзүүлэх бүлгийн дүрэм" хэмээх 5 бүлэг, 28 зүйлтэй эрх зүйн актыг боловсруулан Засгийн газарт оруулснаар Монгол Улсын 18 дугаар оны (1928 он) 5 дугаар сарын 28-ны өдөр болсон

БНМАУ-ын Засгийн газрын хуралдаанаар уг дүрмийг хэлэлцэн 15 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд зөвшөөрөн Улсын Бага хуралд өргөн мэдүүлснээр тэр даруйдаа Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 70 дугаар хурлын тогтоолын 1 дүгээр зүйлд батлагджээ.

Олон ардад тусламж үзүүлэх бүлгэмийн дүрмээр уг байгууллагын хийж гүйцэтгэх ажлыг тодорхойлохдоо:

1. "Олон ардын дотроос аливаа эрүүгийн ба иргэний хэрэг заргын зүйлд тохиолдсон этгээд хэрхэн хаана очвоос зохих ямар янзын хэрэг болох, хэрхэвээс тусыг олох, бас учир утгыг тайлбарлаж зөвлөл (зөвлөгөө)-ийг өгнө;

2. Аливаа засаг захиргааны газар буюу шүүн таслах газруудад мэдүүлэх өргөдөл бичиг, хуудас зэргийг хүссэн ёсоор бичиж өгөх;

3. Ямарваа нэгэн хүн хэргийн

SE-1E ЗЭВДҮҮГ 2 ХИТ АРС ДНОФ АЖКӨС НИЙГЭМТ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ
 БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААН АРДЫН ТАСЛАХ ГАЗРЫН ХУУЛЬ
 ТӨТ АЖАД БЭГ 05 НИХ АБЭЭ ДНОФ АЖКӨС ВЕТ НИЛЭГ
 ДНСТ НӨМ!

учир шүүх таслах газраар заалдах тухайд төлөөнөө заалдах өмгөөлөгчийг хэрэглэх аваас тус бүлгэмээс тусгай хүнийг томилон явуулж таслах;

4. Аливаа худалдаа наймааны буюу ард олны хоорондоо харилцан тогтоох гэрээ бичиг зэргийг зохион бичиж өгөх;

5. Мөн Орос, Хятад зэрэг гадаад улсын харьяат нарын аливаа газруудад мэдүүлэх өргөдөл, хуудас зэргийг монгол хэл бичиг орчуулж өгөх;

6. Тус улсын Засгийн газраас нийтэлж бүхий цааз хууль ба заавар дүрмүүдийн утга чанарыг ард олонд тайлбарлан таниулах явдлыг дашрамд хичээвээс зохимой" гэжээ.

Олон ардад тусламж үзүүлэх бүлгэм нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулах бөгөөд орон нутагт салбартай, тэмдэг, дугаартай, дарга, орлогч, нарийн бичгийн даргатай байх мөн гишүүн элсүүлж, чөлөөлөх, орлогоороо санхүүжих зэргээр үйл ажиллагаагаа явуулж байхаар заажээ.

Ийнхүү өмгөөлөгчдийн үйл ажиллагааны анхны дүрэм гарсны дараа орос, хятад олон хүн өмгөөлөгчийн туслалцаа авч байсан гэх боловч, тодорхой байгууллага бий болж ажилласан баримт хараахан олдоогүй байна.

Харин олон ардад тусламж үзүүлэх бүлгэм хэмээх энэ байгууллагын анхны даргаар их зохиолч Дашдоржийн Нацагдорж ажиллаж байсан гэх нэр бүхий хүмүүсийн аман мэдээ байдаг боловч түүнийг нотлох баримт мөн олдоогүй байгаа юм.

Түүнчлэн олон ардад тусламж үзүүлэх бүлгэмийн даргаар Дорлигсүрэн гэдэг хүн ажиллаж байсан гэх мэдээлэл ч бас бий.

Хүн ардад эрх зүйн туслалцаа үзүүлж, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах байгууллага жинхэнэ ёсоор байгуулагдаж чадаагүй, олон нийтийн үүсгэл, санаачилгын хэлбэрээр ажиллаж байсан үед түүнийг эрхэлж байсан зарим хүн хэлмэгдэлд өртсөн буюу орон даяар хэлмэгдэл газар авч эхэлсэн үед хүний эрхийг хамгаалах өмгөөлөл нэгэн хэсэг зогссон бололтой. Энэ нь хэлмэгдлийн үед шүүн таслах хэрэгт өмгөөлөгч оролцож байсан нь нэн ховор байгаагаас ийнхүү дүгнэлт хийхэд хүрсэн юм.

1940 оны 6 дугаар сарын 30-нд хуралдсан Улсын VIII Их хурлаар батлагдсан үндсэн хуулийн 55 дугаар зүйлд:

"Шүүн таслах газар бүхэнд хэргийг таслахдаа илээр явуулах бөгөөд хэрэгтэн хүнд өмгөөлүүлэх эрхийг эдлүүлнэ" гэж зааснаар өмгөөлөгчдийн үйл ажиллагаа нь Үндсэн хуулиараа баталгаажин шүүн таслах үйл ажиллагааны нэгэн субъект болсон байна.

Шүүн таслах ажиллагаанд оролцогч субъектийн нэг нь болсон "өмгөөлөгч" хэмээх албаны хүмүүс бий болсноор энэ ажлыг эрхлэх байгууллагыг Шүүх яаманд "Өмгөөлөх хэлтэс" нэртэйгээр байгуулжээ. Энэ нь Монгол Улсад өмгөөлөх ажлыг эрхлэх албан ёсны байгууллага гэж хэлж болох бөгөөд тус хэлтсийн даргаар ахмад ажилтан

Донхойн Ханд томилогдон ажиллаж байсан байна. Д.Ханд гуай Өмгөөлөх хэлтсийг тэргүүлж байсан болон анх удаа өмгөөлөл явуулж байсан зэрэг хэрэг заргын асуудлын талаар бичсэн дурсамж нь 1967 онд өмгөөлөх байгууллагаас анх удаа гаргасан "Зөвлөгч" хэмээх бичмэл сэтгүүлд нийтлэгдсэн байдаг. Төв орон нутагт салбартай, гишүүнчлэл бүхий Олон нийтийн байгууллага байхаар байгуулагдсан өмгөөлөгчдийн байгууллага нь ийнхүү төрийн байгууллагын бүтцэд орж нилээд хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байсан байна.

Төрийн захиргааны байгууллагын бүтцэд байгуулагдсан өмгөөлөх байгууллага нь 1959 онд Шүүх яамыг татан буулгах үед "Улсын өмгөөлөх коллеги" нэрээр бие даан ажиллах чиглэлээр төрийн ивээл тэтгэлэгт үлджээ. Харин энэ үеэс төрийн байгууллагын хэлбэртэй боловч өөрийн үйл ажиллагааны үндсэн шинжээрээ олон нийтийн байгууллагын хэлбэрийг хадгалан ажиллаж байсан байна.

Монгол орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн үр дүнд үйлдвэр, аж ахуйн салбар газрууд олширч тэдгээрийн үйл ажиллагаанд хууль ёсыг нарийн чанд сахиулах, эрх зүйн асуудлаар мэргэжлийн зөвлөгөө туслалцаа үзүүлэх шаардлага тавигдсантай холбогдон энэ ажлыг өмгөөлөгчдийн байгууллага эрхлэн явуулж эхэлжээ.

ШИНЭ НОМ



"БАЙГАЛЬ ОРЧИН, БАРИЛГА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ" /Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл/ ном нь Төрийн бүх шатны байгууллагын ажилтнууд болон байгаль орчин, барилга, геодези, зураг зүйн чиглэлээр ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд гарын авлага болох юм.

Энэхүү эмхтгэлд Монгол Улсын хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргасан тогтоол, тушаал, захирамжийг нийтэлжээ.



Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Хууль зүйн үндэсний төв хамтран "МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ" номыг Монгол-Англи хэлээр хэвлүүллээ. Энэ номд:

- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай;
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль нийтлэгдсэн нь эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад төдийгүй иргэдэд зориулагдсан чухал эмхтгэл болжээ.



Хууль зүйн үндэсний төвөөс эрхлэн "ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ"-ийг А6 форматаар хэвлэсэн нь хаана ч аваад явахад нэн тохиромжтой юм.